



# БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

199 I оны II  
сарын 16 өдөр

Дугаар 6

Улаанбаатар  
хот

Ардын Их Хурлын хуралдааны 6 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9<sup>00</sup> цагт эхлэв.

Хуралдааныг Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан даргалав. Хуралдааны ирц 92/392/ хувь байв.

9<sup>02</sup> цагт байгууллага, хамт олон, иргэдээс ирсэн захидал, утас, цахилгааны тоймыг Ардын Их Хурлын орлогч дарга Ц.Лоохууз депутатуудад уншиж танилцуулав.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан Их цаазын төсөл дээр ажиллах депутатуудын хороо байгуулах тухай тогтоолын төслийг танилцуулж, санал хураалт явуулах замаар уг асуудлыг шийдвэрлэе гэв. Зөвшөөрсөн 301/96%/, татгалзсан 4/1%/, түдгэлзсэн 8/3%/, бүгд 313/73%/. Санал хураалтад депутатууд бүрэн оролцоогүй тул дахин санал хураалт явуулав. Зөвшөөрсөн 347/87%/, татгалзсан 5/1%/, түдгэлзсэн 6/2%/, бүгд 358/84%/.

Депутатуудын хороо байгуулах тогтоолын төсөл батлагдав.

Их цаазын хавсралт хуульд эксперт хийж санал боловсруулах групп томилж шалгуулах талаар депутат О.Дашбалбарын гаргасан саналыг нийт депутатуудын санал хурааж шийдвэрлэе гэсэн санал Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан гаргахад 45-р тойргийн депутат М.Энхсайхан эксперт томилох шаардлага юу вэ? гэсэн асуулт тавив. 10-р тойргийн депутат О.Дашбалбар өөрийн саналыг тайлбарлаж ярив. 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар, 408-р тойргийн депутат Ц.Ганбаяр, 85-р тойргийн депутат К.Сайраан, 426-р тойргийн депутат Ж.Барамсай, 41-р тойргийн депутат Н.Пүрэвдорж, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 360-р тойргийн депутат Д.Найдан, 39-р тойргийн депутат Д.Ламжав, 56-р тойргийн депутат Р.Гончигдорж, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 429-р тойргийн депутат Д.Рэнцэннацаг нар энэ талаар горимын санал хэлэв. 10-р тойргийн депутат О.Дашбалбар саналаа дахин тодотгож тайлбарлав.

56-р тойргийн депутат Р.Гончигдорж эксперт томилж ажиллуулах чиглэлийн томьёоллыг хэлэв. 396-р тойргийн депутат О.Дашбалбарын гаргасан саналын агуулгыг шүүмжилж ярив. 369-р тойргийн депутат Д.Пүрэвдорж, 9-р тойргийн депутат С.Зориг, 6-р тойргийн депутат Б.Нямбуу, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 354-р тойргийн депутат Ш.Бороодой, 178-р тойргийн депутат Д.Энхбаатар, 280-р тойргийн депутат Г.Нороврагчаа, 86-р тойргийн депутат С.Харжаубай, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, депутат О.Дашбалбарыг шүүмжилж, зарим зүйлийг өөрт нь анхааруулж өгөв.

✓ Монгол улсын Их цаазын хавсралт хууль дээр ажиллах эксперт томилох уу? гэсэн асуудлаар санал хураалт явуулав. зөвшөөрсөн 130/36%, татгалзсан 193/54%, түдгэлзсэн 36/10%, бүгд 359/84%,

Депутатуудын 54 хувийн саналаар эксперт томилох шаардлагагүй гэж үзэв.

Монгол улсын их цаазын төслийн талаар явуулах санал шүүмжлэлдээ оров.

58-р тойргийн депутат С.Рэнцэнбал, 360-р тойргийн депутат Д.Найдан, 185-р тойргийн депутат Д.Жанцан, 429-р тойргийн депутат Д.Рэнцэннацаг, 311-р тойргийн депутат Д.Баяр, 286-р тойргийн депутат Д.Чулуун, 17-р тойргийн депутат Т.Очирхүү, 11-р тойргийн депутат Ж.Бямбаа нар санал гаргав.

Хуралдаан II<sup>00</sup>-II<sup>20</sup> цагт завсарлаж, ажиллагаагаа үргэлжлүүлэв. 41-р тойргийн депутат Н.Пүрэвдорж, 59-р тойргийн депутат Ч.Пүрэвдорж, 141-р тойргийн депутат Ж.Авхиа, 267-р тойргийн депутат Р.Таванжин, 328-р тойргийн депутат Б.Дашзэвэг, 341-р тойргийн депутат П.Бямбажав, 347-р тойргийн депутат Ч.Пунцаг, 45-р тойргийн депутат М.Энхсайхан, 139-р тойргийн депутат И.Гүлхүү, 96-р тойргийн депутат Н.Сэндэнжав, 86-р тойргийн депутат С.Харжаубай, 388-р тойргийн депутат Б.Энхтуяа, 305-р тойргийн депутат Ж.Бямбаноров нар саналаа нэмж гаргав.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан Их цаазын төслийн талаар 54 депутат үг хэллээ. 59 депутат бичгээр саналаа ирүүллээ. Ерөнхий шүүмжлэлээ таслах уу? гэсэн санал гаргахад Д.Тангад, Ц.Элбэгдорж, Ш.Гүрбазар, Д.Дамбийжанцан нарын зэрэг депутатууд бодсон санасан үгээ хэлцгээе гэсэн санал гаргацгаав.

Хуралдаан 13<sup>00</sup> цагт завсарлаж 15<sup>00</sup> цагаас ажлаа үргэлжлүүлэв. Ерөнхий санал, шүүмжлэл үргэлжилж 430-р тойргийн депутат Д.Тогооч, 374-р тойргийн депутат Т.Санжаа, 346-р тойргийн депутат Ч.Дэмбэрэлням, 33-р тойргийн депутат Д.Мөнхөө, 44-р тойргийн депутат Ш.Сүрэнжав, 156-р тойргийн депутат Ж.Гантөмөр нар үг хэлсний дараа 15<sup>38</sup> цагт Ж.Уртнасан, депутат Р.Барсболдын байгууллагынх нь ажилтны 6 хүүхэд ослоор нас барсан тул үг хэлэх дараалалыг урагшлуулж өгөх, Ардын Их Хурлаас энэ явдалд эмгэнэл илэрхийлж өгөх хүсэлт ирүүлжээ гээд н.Уртнасан Ардын Их Хурлын депутатуудын өмнөөс эмгэнэл илэрхийлж, дараа нь 3-р тойргийн депутат Р.Барсболд үг хэлэв.

Дараа нь 82-р тойргийн депутат А.Сарай, 232-р тойргийн депутат Б.Цэрэндорж, 151-р тойргийн депутат Б.Алагаа, 367-р тойргийн депутат Ү.Цэдэнбал, 370-р тойргийн депутат В.Цамба, 107-р тойргийн депутат Л.Баяндалай, 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 287-р тойргийн депутат Ч.Хурц, 98-р тойргийн депутат Д.Марав, 61-р тойргийн депутат Д.Дамбийжанцан, 355-р тойргийн депутат Х.Баянмөнх нар ерөнхий санал шүүмжлэлтэй холбогдуулан үг хэлэв.

Хуралдаан 17<sup>00</sup> цагт завсарлаж 17<sup>21</sup> цагаас үргэлжлэв.

266-р тойргийн депутат Д.Цэвэгдорж, 333-р тойргийн депутат Д.Батсүх, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ, 317-р тойргийн депутат Д.Мандах, 35-р тойргийн депутат В.Бямбаа, 259-р тойргийн депутат Ш.Ялалт, 104-р тойргийн депутат Д.Жагварал, 60-р тойргийн депутат Ё.Давааням, 354-р тойргийн депутат Ш.Бороодой, 183-р тойргийн депутат Ч.Намсрай, 398-р тойргийн депутат Д.Шагдар, 336-р тойргийн депутат Ө.Ганхуяг, 319-р тойргийн депутат Ю.Дашпунцаг, 304-р тойргийн депутат Х.Намсрайжав нар ерөнхий санал шүүмжлэлтэй холбогдуулж үг хэлэв.

БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Т.Тогоо, /203/, Ж.Адъяа/202/, Р.Батсүх/345/, Ч.Чулуунбаатар/421/, Н.Адъяажав /228/, Г.Дандэв/20/, Л.Ханд/310/, С.Исхан/78/, С.Намсрайжав/343/, Д.Доржготов/253/, Б.Батмөнх/201/, Б.Авирмэд/130/, А.Рашитхан/152/, С.Цэрэннадмид/252/, З.Адъяа/263/, С.Балсанжамц/364/, Л.Чулуунбат/361/, Б.Дашпунцаг/237/, Д.Сумъяа/127/, Г.Банди/158/, И.Бадарч/293/, Ж.Буд/260/, Б.Баасанхүү /227/, Л.Дамдинсүрэн/400/, Г.Дамдиндорж/250/, Б.Даваасүрэн/115/,

Ш.Насанбуян/162/, Ц.Баахүү/363/, Т.Нэргүй/419/, Г.Жагай/194/,  
 Д.Дамдин/275/, Л.Шархүү/357/, Ц.Отгон/356/, М.Моёор/207/, С.Ёндон-  
 жамц/114/, Д.Баатарсүрэн/410/, Ц.Ишцэрэн/409/, Л.Хээшиг/404/,  
 Ш.Цэндбаяр/280/, Н.Дэриймаа/403/, О.Долгорсүрэн/216/, Д.Цэдэнбал  
 /196/, Ц.Бямба-Очир/193/, Л.Ишдорж/155/, Л.Лхагвасүрэн/397/ нар  
 саналаа бичгээр өгсөн болно.

18<sup>41</sup> цагт Ардын Их Хурлын хуралдааны нэр дээр байгууллага,  
 хамт олон, иргэдээс ирүүлсэн захидал, утас, цахилгааны тоймыг Ардын  
 Их Хурлын орлогч дарга Н.Батбаяр уншиж танилцуулав. Дараа нь  
 ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөлийн дарга Хасбулатоваас БНМАУ-ын Ардын Их  
 Хурлын дарга Ж.Уртнасангийн нэр дээр ирсэн баярын цахилгааныг  
 уншихад депутатууд алга ташин хүлээж авав. Мөн 119-р тойргийн  
 депутат Д.Цэен-Ойдовын сонгуультай холбогдсон асуудлаар Булган  
 аймгийн туслах прокурор Хадбаатар, Их цаазын төсөлтэй холбогдуулан  
 "Дархан хилийн төлөө хөдөлгөөн"-нөөс ирүүлсэн гомдол, саналыг  
 уншиж депутатуудын сонорт хүргэв.

Ж.Уртнасан 86 хүн үг хэлж, 101 хүн бичгээр санал ирүүлж, 16  
 хүн ерөнхий санал, шүүмжлэлийг таслах санал ирүүлсэн, депутатуудын  
 7 бүлэг байгуулагдсан тухай мэдээлээд 27-р тойргийн депутат  
 Л.Пүрэвдорж хэсэг депутатуудын нэрийн өмнөөс мэдээлэл хийх хүсэл-  
 тэй байна гэв. Депутатууд зөвшөөрч Л.Пүрэвдорж нэр бүхий 70 гаруй  
 хүн "Ардчилсан эвсэл" бүлэг байгуулсан тухай товч мэдээлэл хийв.

24-р тойргийн депутат Р.Хатанбаатар анхдугаар хуралдаан  
 дээр байгуулагдсан МСДН-ын бүлэг оршин тогтнож байгаа бөгөөд  
 албан ёсоор бүртгүүлэх шаардлагагүй гэж мэдэгдээд МСДН-ын депу-  
 татууд яагаад энэ бүлэгт орох болсон тухай тайлбар хүссэн боловч  
 депутатууд Дэгээ барьж завсарлахыг шаардав. Р.Хатанбаатар үгээ  
 дуусгаж чадалгүй, МАХН-ын гишүүд, депутатууд Намын Төв Хорооны  
 Тэргүүлэгчдээс тараасан лавлагаанд бичигдсэн зүйлийг дахин дахин  
 давтан яриад байгаа тул, хэрвээ өөрийг нь сонсохыг хүсэхгүй  
 байгаа бол түүнийг хэвлэл, мэдээлэлээр тараах болно гэв. Үүгээр  
 хуралдаан 19<sup>09</sup> цагт ажлаа дуусгав.

11-р сарын 17-ны Ням гаригт хуралдаан завсарлах болов.  
 Депутатуудын хэлсэн үгийн соронзон бичлэг, ирцийг хавсаргав.

АРДЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
 ОРЛОГЧ ДАРГА

ТЭМДЭГЛЭСЭН

Ж. УРТНАСАН

Н. БАТБАЯР

Г. ЖАГАЙ

Ц. ДООХУУЗ

Д. МООНЦОЙ

Г. ХҮРЭЛБААТАР

А. ЮНДЭНДОРЖ



5

АРДЫН ИХ ХУРЛЫН 1991 ОНЫ II ДҮГЭЭР САРЫН  
16-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ИРЦИЙН БАЙДАЛ

Ирвэл зохих: 427

Хуралдаанд ирээгүй /шалтгааныг дурдана/:

Депутат С.Баяр /I/, Г.Чингэл /339/, Т.Батмөнх /376/,  
Ц.Охинтогтох /254/, Н.Сампилноров /199/, Хүзкей /83/, Г.Дамдин-  
дорж/250/, Дэлгэрмөрөн /306/, Д.Лхагважав /171/ нар өвчтэй.

Депутат Г.Сүрэнжаргал гадаадад яваа, Ч.Бямбаа /270/ гачигд-  
лаар хөдөө явсан.

Хуралдаанд хоцорч ирсэн: Депутат С.Баярцогт /288/, Д.Мандах  
/317/, Ю.Дашпунцаг /319/, Ц.Ганбаяр /408/, Ч.Даваажид /411/,  
Г.Баярсайхан /412/, Б.Сумъяа /340/, Н.Жанцан /273/, С.Билэгсайхан  
/184/, Г.Баасанжав /57/, Д.Баттулга /148/, Л.Дашням /22/,  
Ж.Бямбаа /11/, С.Лхагвасүрэн /17/, Ч.Аюурзана /236/ нар үдээс  
өмнөх хуралдаанд хоцорч ирсэн.

Депутат Д.Энхбаатар /178/, С.Зориг нар үдээс хойшхи  
хуралдаанд оролцоогүй.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

Ж. Уртнасан:— Эрхэм депутатуудын өглөөний амгаланг айлтгая. Хуралдаанаа үргэлжлүүлье. Одоо өнөөдрийнхөө хурлын ирцийг бүртгэе. Ирц бүртгэхэд бэлтгэнэ үү. Ирвэл зохих 427 депутатаас 392 депутат буюу 92 хувийн ирцтэй байна. Хурал хүчин төгөлдөр байна. Хурлаа үргэлжлүүлье. Одоо хөдөлмөрчдөөс ирсэн захидал мэдээлэл, санал хүсэлтийн тоймыг Ардын Их Хурлын орлогч дарга Лоохууз гуай танилцуулна.

Ж. Лоохууз:— 1991 оны II дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны өдөр бичгээр 12, цахилгаанаар 5, утсаар 16, хүлээн авах байраар 2 хүн ирж санал хүсэлт тавьсан байна. Ховд аймгийн ОСГ-ны 6 дугаар хорооны иргэн, Монголын байгаль орчны холбооны Ховд аймаг дахь байцаагч Сэнгэдорж, Найрамдлын районы I дүгээр хорооны иргэн Галсандаш, мөн Октябрийн районы 10 дугаар хорооны иргэн, өндөр настан Дорлиг, Бавуу, Архангай аймаг дахь МоАН-ын зөвлөлдөх төв, Дорноговь аймгийн Зүүнбаянгийн хорооны Ардын хурлын тэргүүлэгчдийн гүйцэтгэх захиргааны хамт олнуудаас цахилгаан утсаар баяр хүргэсэн байна.

Завхан аймгийн Их-уул сумын Уранмандал компанийн ерөнхий захирал Дагийрагчаа хүлээн авах байраар ирж Ардын Их Хурлын II хуралдааны аюулгүй байдал, тав тухтай хуралдах асууцлыг хуралдааны сүүлийн өдрүүдэд онцгой анхаарахыг сануулсан байна.

Говь-алтай аймгийн Жаргалант сумын гүйцэтгэх захиргааны ажилтнууд цахилгаанаар мэдэгдэхдээ Ардын Их Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсээд Их цаазын төсөлд ард түмний саналыг тунгаан тусгаж амьдрах чацвартай, алс ирээдүйгээ олж харсан хууль гаргана гэдэгт итгэж байна гэж бичсэн байна.

Увс аймгийн Бөхмөрөн сумын өндөр настангууд цахилгаанаар та бүхэн улс эх орноо төвхнүүлэх, Үндсэн хууль батлах, өмч хувьчлах зэрэг хариуцлагатай ажлууддаа хүч хөдөлмөр, мэдлэг

мэргэжлээ дайчлан ажиллаж байгаад өндөр настан бид баяртай байна гэж бичжээ. Бид амьдралд тохиолдож байгаа бэрхшээлүүдийг даван туулахын хамт хатуужилтай туулж ирсэн түүхтэй хүмүүс юм гэдгийг анхаараарай гэсэн байна.

Сүхбаатарын районы 9 дүгээр хорооны иргэн Баатар, Октябрийн районы 4 дүгээр хорооны өндөр настан Пүрэвдорж утсаар мэдэгдэхдээ хууль боловсруулаан хүмүүсүүд, депутатуудын хэлсэн үгийг хүлээж авахгүй, харуу тайлбар тавьж, өөрсдийн үзэл бодлыг тулгах хандлагатай байгааг анхаараарай гэсэн байна.

Октябрийн районы 25 дугаар хорооны иргэн Индрээ утсаар хэлэхдээ орон нутгийн зарим депутатууд төслийг хангалтгүй судалжээ. Мэцээллийн зүйлийг мушгин гуйвуулж марган их цаг авч байна. Иймд хурлын товлосон хугацаанаас илүү гарсан зардлыг депутатууд өөрсдөө хариуцах нь зүйтэй. Хууль олон жилийн настай байх явдлыг гол болгож анхаараарай гэсэн байна.

Октябрийн районы 27 дугаар хорооны иргэн Асрал утсаар мэдэгдэхдээ ард түмний итгэл хүлээлгэж сонгосон Улсын Бага Хурлын гишүүд 20 дугаар тогтоолын нууцыг задалсан явдлыг уучлал гуйж депутатаасаа огцрох хэрэгтэй. Ийм хүмүүс төр барилцаж байгаад гомдож байна. Депутатууд ард түмний нэр барьж яриад байна шүү. Энэнийг зогсоогоорой гэсэн байна.

Эрдэнэт хотын Орхон хоршооны орлогч дарга Бадарч 18 хүнийг төлөөлж утсаар хэлэхдээ депутатуудын саналыг Очирбат, Гончигдорж нар яагаад эсэргүүцэж байна вэ гэж асуусан байна.

Техникийн их сургуулийн багш Нанзад утсаар хэлэхдээ Үндсэн хуулийн төслийг боловсруулахад нэрт эрдэмтэн оролцсон түүхийн материал судалж үзсэн, жил шахам ажиллаж их цаг зарсан болохоороо үндэслэлтэй юм хийсэн гэж боцож байна. Иймд эдгээр хүмүүсийн хөдөлмөрийг үнэлэх нь зүйтэй шүү гэдгийг анхааруулжээ.

## 3.

Сүхбаатарын районы 5 дугаар хорооны иргэн, хуульч Сандагдорж утсаар хэлэхдээ 281-ийн бүлгийн Дашбалбарын мэдэгдэлд шашныг төрийн шашин болгоно гэснийг эсэргүүцэж байна. Ингэх юм бол шашны дайн гарна. Шашин бол нийгэм, эдийн засгийг удирдах хөшүүрэг биш ээ. Харин ард түмнийг буруу, зөв, нүгэл, буян ялган оалгаж ойлгоход туслах хүмүүжүүлэх хүмүүжлийн нэг хэлбэр юм. Төржүүлж болохгүй. Тэгэхдээ үгүйсгэж байгаа юм биш гэдгийг анхааруулсан байна.

Сүхбаатарын районы 8 дугаар хорооны иргэн Д. Самбуу бичгээр ирүүлэхдээ хурлын эхний хоёр өдөр олон хүн босч уг хэлж байгааг телевизээр харлаа. Ингэх нь зүйн хэрэг. Зарим депутат ялангуяа намын ахмад гишүүд, хувьсгалт намын ахмад гишүүд, коммунист зарим депутатууд дахин дахин босч ажил хэрэгч, оновчтой биш санал тавьж цаг барж байгааг анхааруулъя гэсэн байна.

Сүхбаатарын районы 33 дугаар хорооны иргэн, Монголын ардчилсан намын гишүүн Асрал Ардын эрх сонины II дүгээр сарын 13-ны өдрийн дугаарын "Дэг хэлэлцэж байна" гэсэн материалц олон депутат Улсын Бага Хурлынханд төдийлөн таатай биш сэтгэгдэлтэй ирснээс Их цаазын төслийг хэлэлцэхтэй холбогдсон асуудал бүхэнд зөвхөн энэ талаас нь хандаад байх шиг санагцлаа гэдгийг уншаад бухимдахгүй байхын аргагүй байлаа. Шууцайнд хийсэн үхрийн эвэр шиг байвал хуралдааны үр дүн дүнгүй төгсөхөд та бүхэн ард түмнээсээ хүлээлгэх хариуцлага бий гэдгийг санаж ажиллацгаагаарай гэнэ ээ.

Цаашлаад Их цаазын төслийн талаар Баруун-урт хотын 5 дугаар хорооны иргэн Начин, түүх – соёлыг судлаач, яруу найрагч Балдандорж, Сүхбаатарын районы 28 дугаар хорооны иргэн Маналжав, Норовбадам, Анз, Долгор, Сүхбаатарын районы 7 дугаар хорооны иргэн Чулуунхүү, Хөвсгөл аймгийн Хатгал хорооны иргэн Ням-очир, Октябрийн районы 32 дугаар хорооны иргэн Цэвэг, Сүхбаатарын районы 27 дугаар хорооны иргэн Тогоохүү, Сүхбаатарын районы 27 дугаар хорооны иргэн

4.

Халзан, Октябрийн районы 4 дүгээр хорооны өндөр настан Пүрэвдорж, Найрамдлын районы I дүгээр хорооны иргэн Галсандаш, Октябрийн районы 25 дугаар хорооны иргэн Индра, Сүхбаатарын районы 5 дугаар хорооны иргэн, хуульч Сандагдорж, Найрамдлын районы 8 дугаар хорооны иргэн Шархүү, Ховд аймгийн Мянгад сумын Арцын хурлын депутат Дэмбэрэл зэрэг хүмүүсүүдээс Үндсэн хуулийн нэр, төрийн сүлд, далбаа, газар нутгийг түрээслүүлэхийг зогсоох ийм асуудлуудаар Үндсэн хуулиндаа тодорхой санал гаргаж ирүүлсэн байна.

Улсын Бага Хурал, Засгийн газрын үйл ажиллагааны талаар холбогдсон санал, шүүмжлэлүүдийг Эрдэнэт хотын Орхон хоршооны орлогч дарга Бадарч, Сүхбаатарын районы 5 дугаар хорооны иргэн, хуульч Сандагдорж, Сүхбаатарын районы 27 дугаар хорооны иргэн Халзанхүү, Сэлэнгэ аймгийн Тэшиг сумын хөдөлмөрчид, багш нар, Баруун-урт хотын 5 дугаар хорооны иргэн Начинмөнх, Сүхбаатарын районы 28 дугаар хорооны иргэн Маналжав, Норовбадам зэрэг хүмүүсүүд Засгийн газар, Бага Хурлын ажиллагаатай холбогдсон нэлээд тооны санал, гомдол, шүүмжлэлүүдийг ирүүлсэн байна. Эдгээрүүдийг Засгийн газар, Бага Хурлын тайлан хэлэлцэхэд мэдэгдэх юм.

За үндсэндээ иймэрхүү зүйлүүд ирсэн байна. Эдгээр зүйлүүдийг мэдэгцлээ.



Ж.Уртнасан:—За одоо бид өчигдөр нэг асуудлыг шийдсэн. Тогтоол гаргаагүй байсан.Энэ бол хуралдааны дэгийн 12 дахь заалт Ардын Их Хурлын депутатуудын нутаг дэвсгэрийн бүлгийн саналыг үндэслэж депутатын хороо байгуулсан.Энэ тогтоол байгаа юм.Хорооны хийх ажлын үүргийг тогтоолд тусгая гэж депутатууд санал өгсний цагуу тогтоолын төслийг танилцуулж санал хураалт явуулья.

Депутатуудын хороо байгуулах тухай.БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны дэгийн 12 дахь заалт Ардын Их Хурлын депутатуудын нутаг дэвсгэр, намын бүлгийн саналыг үндэслэн

5.

тогтоох нь нэг. БНМАУ-ын Бага Хурлаас өргөн барьсан Их цаазын төслийг хэлэлцэх үед зарчмын асуудлуудаар бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд зохих саналын дагуу уг төслийг найруулан засч эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй депутатуудын хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга —Жамбын Гомбожав 326 дугаар тойргийн депутат

Нарийн бичгийн дарга —Данзангийн Лүндээжанцан 15 дугаар тойргийн депутат

Гишүүн —Манчивдоржийн Альяа

—Жарантайн Авхиа

—Жагваралын Буд

—Дамдинжавын Гомбожав

—Лувсандамбын Дашням

—Чулууны Дэмбэрэлням

—Дамдингийн Дэмбэрэл

—Юлтын Жаргал

—Данзангийн Жагварал

—Наваанпэрэнлэйн Жанцан

—Санжаасүрэнгийн Зориг

—Кунтуганы Мизимхан

—Баярхүүгийн Мижид

—Гуррагчаагийн Нороврагчаа

—Нэмэхийн Пүрэвдорж

—Шаравын Сүрэнжав

—Шаравдоржийн Цэнджаргал

—Самдангийн Чулуунбаатар

—Цэрэндоогийн Энхбат

Хоёр. Депутатуудын хороог дараахь үүрэгтэй байхаар тогтоосугай:

1. Депутатуудаас гарсан саналыг нэгбүрчлэн нягтлан үзэж зохих өөрчлөлт оруулан Их цаазын төслийг эцэслэн боловсруулсан тухай илтгэлийг Ардын Их Хурлын хуралцаанд оруулж хэлэлцүүлэх.

2. Их цаазын төслийг эцэслэн боловсруулахдаа шаарцлагатай

21  
6.

ажлын хэсгүүдийг байгуулж холбогдох эрдэмтэд, мэргэжлийн хүмүүсийг энэ ажилд татан оролцуулж ажиллах.

3. Их цаазын төслийг эцэслэн боловсруулахдаа холбогдох зарчмын асуудлаар уултөслийг Ардын Их Хуралд өргөн мэдүүлсэн БНМАУ-ын Бага Хурал, Ерөнхийлөгчтэй санал солилцон тохиролцож ажиллах.

За ийм тогтоолын төсөл байна. Тогтоолыг батлах талаар санал хураалт явуулъя. Санал байна уу?

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ  
ТУЛГАЖ НИЙЛСЭН

П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

Уртнасан:

-Ийм учраас тогтоолыг батлах талаар санал хураалт явуулахад бэлтгэнэ үү.

Депутатын хороо байгуулах тухай санал хураалт явуулж байна. Санал хураалт эхэллээ.

-За баярлалаа, Депутатуудын хороо байгуулах тогтоолыг санал өгсөн депутатуудын .

Уучлаарай, энэ техникийн алдаа гарч байгаа юм уу, аль эсвэл манай депутатууд санамсаргүй хандав уу. Энэ өнөө өглөөний ирцээр 427 хүнээс 392 депутат байгаа. Гэтэл санал хураалтад 313 хүн оролцох юм. Ийм учраас санал хураалтыг дахин явуулъя. Анхааралтай байхыг санал болгож байна. Депутатуудын хороо байгуулах тухай талаар санал хураалт, тогтоолын төслийг батлах санал хураалт явуулах гэж байна, санал хураалтад бэлтгэнэ үү. Санал хураалт эхэллээ. Санал хураалтад нийт депутатуудын 84 % нь оролцлоо, 358 хүн, санал өгсөн депутатуудын 347 буюу 97 % нь тогтоолын төслийг зөвшөөрч баталж байна. Тогтоол батлагдлаа. Татгалзсан хүн 5, түдгэлзсэн хүн 6 байна. За баярлалаа.

Өчигдөр та бидэнд, өчигдрийн хуралдаан дээр депутат Дашбалбар нэг санал оруулсан, санал хураалт явуулж өгөөч гэж. Их цаазын хавсралт хуульд эксперт хийлгэх, эксперийн групп томилж өгөөч гэж, иймд экспертийн групп томилох шаардлагатай юу, үгүй юу гэдэг талаар депутатуудаас санал авмаар байна. Ийм учраас Дашбалбарын томъёоллоор Их цаазын хавсралт хуульд эксперийн групп томилбё гэсэн ийм томъёоллоор санал хураалт явуулах гэж байна. Тайлбар депутат Энхсайхан, Депутат Дашбалбар дахин тодотгол хийнэ.

10-р тойргийн депутат:

О. Дашбалбар: - Тэгэхээр бага хурлын байнгын хороон дарга Энхсайхан хилэгнэж байх шиг байна. Бага хурал хилэгнэх нь арга байхгүй. Яагаад гэвэл их хурлынхаа эрхийг хууль бусаар булааж авах гэсэн учраас. Тэгэхээр би АИХ-ын депутатуудыг өчигдөр хэлсэн, үндсэн хуульдаа анхааралтай хандаасай, сонор сэргэг байгаасай гэж, ноён Энхсайхан бол яахав бага хурлын эрх ашгийг

хамгаалж байна. Дашбалбар бол өчүүхэн хүн , тэгэхдээ их хурлын эрх ашгийг хамгаалж байна, эксперт томилох нь зүйтэй гэж үзэж байна. Яагаад гэвэл бага хурал хууль бус замаар АИХ-ын бүрэн эрхийг булааж, өөрөөр хэлбэл цэргийн эргэлт, ордны эргэлт, төрийн эргэлт гэж байдаг, цэргийн эргэлт, ордны эргэлт, үндсэн хуулийн эргэлт, үндсэн хуулийн эргэлт бол 2 замаар явагдана. Нэг нь бол үндсэн хуулийн төгс төгөлдөр бусыг ашиглаж, 2 дахь нь бол үндсэн хуулиас үндсэн хуульд шилжих тэр сиймхийг ашиглаж явагддаг. УБХ бол БНМАУ-ын АИХ-ын бүрэн эрхийг үндсэн хуулийн сиймхийг ашиглаж үндсэн хуулийн төгс төгөлдөр бусыг ашиглаж, булааж авах гэсэн оролдлого хийлээ гэж би ингэж үзэж байгаа, зүгээр энэ бол санаатай юм уу, санаагүй юм уу гэдгийг би мэдэхгүй, тэнийг эксперт тогтоох ёстой. Зүгээр миний хувьд гэвэл парламент дээр уг хэлснийхээ төлөө парламентын гишүүн хариуцлага хүлээхгүй нь тодорхой, энэ нь урьдын явдлуудаас харагдаж байгаа, бие биенээ доромжилсны төлөө хариуцлага хүлээхгүй байж, хуульд байгаа алдаа завхралыг хэлсний төлөө хариуцлага хүлээхгүй нь бол тодорхой. Гэхдээ ямар ч байсан эксперт томилох ёстой, нөхөр Энхсайхан үгээ хэлнэ байх, тэхдээ намайг эсэргүүцнэ байх гэдэгт би итгэж байна.

45-р тойргийн депутат М. Энхсайхан: -Гэхдээ яахав асуудал ийм байгаа юм л даа. Депутат Дашбалбарын хэлсэн үгэнд төрийн эргэлт энэ тэр гээд ер нь хүмүүсийн хооронд хардлагын тухай асуудал яригдаад байгаа юм. Ер нь төрийн эргэлт гээд ярих юм бол хуулийн хүрээн дотор төрийн эргэлт явагдана гэсэн ойлголт хэзээ ч байдаггүй. Хэрвээ энэ асуудлаас нь яривал, үндсэн хуулийн хүрээнд төрийн эргэлт хийнэ гэдэг чинь өөрөө өөртэйгөө зөрчилдсэн өгүүлбэр явагдаад байгааг ойлгож байгаа болов уу гэж бодож байна. Зүгээр энэ хавсралт хуулийг их хурал өөрөө хэлэлцээд өөрсдөө шийдвэрлээд батална. Өөрсдөө энэ улсууд чинь хэлэлцнэ гэдэг чинь өөрсдөө эксперт болно. Түүнээс биш бие биендээ ингэж хардлага болгож нэгнийхээ хийсэн ажилд экспертийн групп томилж ингэж шүүх хуралдаан маягтай явах юм бол уур амьсгал эвдэрчиж магадгүй гэж санаа зовж байна. Бид бол өнөөдөр нэг л уур амьсгалаар, нэг л юмны төлөө сууж ажиллах хэрэгтэй байна гэсэн



Уртнасан:

-Горимын санал гаргаж байна гэж үзэж байгаа шүү, депутатууд аа.

24-р тойргийн депутат Р.Хатанбаатар: - Сая энэ депутат Дашбалбарын уг хэлсний дараа би өчигдрийн депутатуудын хорооны гаргасан нэг шийдвэрийг эсэргүүцэхээс өөр замгүй боллоо. Депутатуудын хорооны гаргасны шийдвэрийг би эсэргүүцэж байна. Тухайлбал үндсэн хуулийн эрх баригчаар депутат Чимид, Лундаажанцан нарыг томилсныг би эсэргүүцэж байна. Энэ 2 бол тэгж ярих юм бол 2-уулаа бага хурлын 2, багш шавь 2, 2-уулаа Улаанбаатарынх, 2-уулаа хуульч, гэх мэтээр бид маш олон янзын юм ярьж болно. Ингэхээр энэ 2 хүний нэгийг сольё, гэсэн санал хэлж байна. Хоёулаа эрхтэй гэж үзсэн ч болно.

Танхимаас:

-Тус группийг байгуулахаар санал гаргасан Дашбалбарын үндэслэлээр сонслоо, энэ ийм групп байгуулах шаардлагагүй гэж үзэж байна. Энэ дээр дахин дахин хэлэлцүүлэг явснаас санал шууд хураачихвал яасан юм бэ гэсэн саналтай байна.

85-р тойргийн депутат К.Сайраан: -Энэ экспертийн групп байгуулах шаардлагагүй. Ийм хардалт сөрдөлт явуулахыг зогсоё. 2-рт нэг хүн босоод хэлэхээр бага хурал ухрахыг бас больё. Өчигдрийн тэр товлосон ямар нэгэн асуудлаар Хатанбаатарын хэлсэн саналыг дэмжихгүй байна. Цаашдаа энэ нэг ийм Үндсэн хуулийн төслийг ер нь хэсэг бүлэг дээрэмчид монгол улсыг устгах гээд байгуулсан юм шиг л нэг оруулж ирж байгаа юм шиг бодсон тийм бодлоосоо салъя. Энэ нийт ард түмний томилсон, сонгосон, Ерөнхийлөгч тэргүүтэй УБХ-ын гишүүд, бусад эрдэмтэд оролцсон ийм манай монголын хамгийн шилдэг, улсуудын боловсруулсан төсөл юм. Харин тэрнийг хэлэлцүүлж, сайжруулах үүрэг бидэнд байгаа. Тийм учраас энэ хардалт сөрдөлтийг больё. Экспертийн групп томилох шаардлагагүй.

426-р тойргийн депутат Ж.Барамсай: -Дашбалбарын саналыг бодож байна л даа, яахав энэ одоо нэгэнт зөвхөн ганцаараа ингэж

зүтгээд байгаа биш байгаа. Тэр хуулийн заалтанд но-той юм бий. Хуулийн мэддэг хүмүүс яриад байгаа юм. Эний нь яахав үзээд өг л дөө, тэр эксперт томилоод л одоо юу яая л даа. Тэрэнд чинь одоо тэрийг томилох уу, яахав ийхэв гээд байх юм, томилоод л өгнө биз. Тэгээд л үзнэ биз, тэгээд л зөв юм уу, буруу юм уу гэдгийг нь гаргаад л ирнэ биз. Тэгээд л энийг томилох уу, яахав гээд хартай юм байхын хэрэггүй л дээ. Би бол томилох нь зүйтэй гэж бодож байна.

41-р тойргийн депутат Н. Пүрэвдорж:

-Депутат нөхөд өө, ийм асуудал байна л даа, бид ухаан нь хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй нь үнэн боловч хариуцлагагүй юм ярьж таарахгүй гэж бодож байна. Энэ үндсэн хуулийн хавсралтын тухай хуулийг депутат нөхөр Дашбалбар буруу ойлгосон гэж би бодож байна. 1-рт одоогийн их хурал, бага хурал 2-уулаа бүрэн эрхээ хадгалахаар заасан байгаа. Ийм нөхцөлд яахлээрээ улсын бага хурал нь төрийн эрх авах гэдэг ийм ойлголт гардаг юм бэ, онцгой эрх нь тэр чигээрээ байж байгаа. Тэрийгээ эдэлнэ гэсэн хууль зүйн үндэслэл нь байж байгаа. Хамгийн гол нь хуулийн төсөл явж байна шүү дээ. Төслийн хэмжээнд төрийн эрх авна гэж арих үнэхээр утгагүй бидэнд. Ямар төсөл юу гэж батлахаа мэдээгүй байж, танин мэдэхүйн зөрүүн дээр ингэж тоглож болмооргүй байна. Энэ надыг эмзэглүүлж байна, хуульчийн хувьд, ер нь зүгээр одоо асууж, сураглаж болох л доо. Энийг үгүйсгэж болохгүй. Тэгэхээр бид чинь эксперт томилъё гэж бодъё л доо. Энэд маш тодорхой үндэслэл байх ёстой. Зүгээр уг, үсгийн учрыг ойлгоогүй үндсэн дээр, танин мэдэхүйн чанартай ийм, үндэслэл зааж бид нь эксперт томилж болохгүй шүү дээ. Энэ чинь түүхэнд үлдэнэ. Бид ч гэсэн томъёолсон энэнийхээ төлөө хариуцлага хувьхэд бэлэн байна. Ийм эвгүй уур амьсгал битгийг гараасай гэж бодож байна.

55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн: -Би одоо ерөөсөө сүүлийн үед ямар хуралд сууж байгаагаа ойлгохоо байлаа. Төрийн эрхийг барьж байгаа АИХ-, депутатуудын АИХ юм уу, аль эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн хэргийг таслах гэж байгаа шүүх хуралд сууж байгаа юм уу, сүүлийн үед ерөөсөө зарим юман дээр мэдэгдэхгүй болоод байна. Бие биенийхээ хардсан, сэрдсэн, Нэг үг үсгийн хойноос хөөцөлдсөн, тэрэн дотор нэг ийм ч юм болохоо больчихлоо,

тийм ч юм болохоо больчихож, гэсэн ийм уур амьсгалтай байдлаар энэ хуралдаан ерөөсөө болохгүй байхаа. Ийм учраас бид нар бол тодорхой бие биэндээ итгэж итгэл найдвар өгч хуралдаж сурмаар байна. Нэгэнт Улсын бага хурлыг ноднин итгээд байгуулчихсан юм бол, тэд нарын оруулж ирсэн зүйлд нэг их хардаж сөрдээд байх хэрэг юу байсан юм бэ. Тэр экспертиз байгуулна гэдэг чинь эцсийн эцэст бид өөрсдийгөө маш их доорд хэмжээнд үзэж байгаа хэрэг. Бид нар нэгэнт төрийн эрх барьж байгаа депутатууд юм бол өөрөө өөрсдөө тэнд экспертиз хийгээд тэр хуулийг хэлэлцэх үедээ шийдэж болдоггүй юм уу, ийм учраас, энэ асуудлыг таслан зогсоох саналтай байна.

360-р тойргийн депутат Д.Найдан: Энэ хавсралтын тухай хуулийн асуудал бол үндсэн хууль буюу их цаазын төслийг хэлэлцэж дууссаны дараагаар хэрэв тавигдсан асуудлыг яаж шийдсэнээс ургаж гарах учраас анхныхаа асуудлыг шийдээгүй байж, 2 дугаар асуудалд экспертиз томилно гэдэг болбол ажлын арга барил, шат дарааллын хувьд болохгүй байна. Хэрвээ үндсэн хуулийн тавигдсан асуудал хавсралт хуультай зөрчилдөж гарах юм бол энийг мөн I-рт хорооны хэмжээнд ч гэсэн авч үзээд, үндсэн хуулийн үргэлжлэл хэмээн ойлговол мөн тэр ажлын хүрээнд энэ асуудлыг шийдэх ёстой. Шийдэхдээ цөөн тооны экспертизууд биш их хурлын депутатууд шийдэх ёстой гэж бодож байна.

Д.Ламзав: /39-р тойргийн депутат/

-Тэгэхээр депутат Дашбалбар өөрийнхөө эрхийн дагуу асуудал санал хураалгахыг хүсч байна. Би тэр эрхий нь эдлүүлэх ёстой гэж байна. Ёстой гэж үзэж байна. Энэ бол ардчилал юм. Тэгэхдээ зүгээр Дашбалбар депутатуудын эртүүдээс хойш 2 удаа хэтэрхий зарчимгүй явдал гаргасныг би депутатуудад хэлье гэж бодож байна. Эртээд нэг депутатыг үмхий хасаг гэж хэлсэн, сая Чимид гуайг ч ард түмний дайсан гэж хэлж байна, хүндэт дарга аа, би ийм байдал гаргаж байгаа депутатад сануулга өгөх хэрэгтэй, дэгд заасны дагуу сануулга өгөх хэрэгтэй гэж үзэж байна. Депутатууд хоорондоо ингэж харьцаж болохгүй. Харин тэр саналы нь хураалгаад өг. Би бүр нэрээр санал хураахсан гэж бодож байна.

Нэрээр санал хураахыг санал болгож байна.

56-р тойргийн депутат Р.Гончигдорж: -Хурлаас гарч байгаа болон хурлаас тогтоож байгаа баримт бичгийн талаар нэг талаас бас жаахан санаа зовж байгаагаа илэрхийлмээр байна. Саяхны баталсан Тэр хороо байгуулсан тухай тэр тогтоол дээр ажил үүрэг, чиг функцы нь тодорхой зааж өгөх хэрэгтэй байна. Энэний гол зорилго нь бол анхны хэлэлцүүлгийн үр дүнд 2 дахь хэлэлцүүлэгт оруулах их хурлын төслийг хянан боловсруулж, депутатуудаас гарсан депутатуудын дунд зарчмын асуудлуудаар санал хураасны үр дүнд тогтоон асуудлуудыг тусган найруулан засах ийм л үүрэг чиг үүрэгтэй байх учиртай байх. Тэр энэ төрийг тодруулж, сая жишээлэхийн бол ойлгосонгүй, экспертийн хэсгийг байгуулья гэж, юуг яаж ямар үүднээс, хэний нэрийн өмнөөс хийх экспертийн тухай ярьж байна, энэ нь тодорхойгүй ч гэлээ ч экспертийн бүлэг байгуулья, за байгуулья, энэ бол ерөөсөө хууль тогтоох байгууллага болохынхоо хувьд ч гэсэн өөрдөө хууль тогтоомж, ямар нэгэн ийм шийдвэр, ямархуу бүтэц зохион байгуулалттай, ямархуу агуулгатай байх ёстой вэ гэдгийг бид бодохгүй бол болохгүй. 2-рт эрхэм депутатууд төлөөлөгчдийн дээд байгууллага их хуралдаа улсын бага хурал өөрт оногдсон үүрэг, түүнээс үүдэгдсэн эрхийнхээ үүднээс монгол улсын их цаазын хавсралт хуулийн төслийг өргөн барьсан байгаа. Энд бид илтгэлээ тавьж илтгүүлж, эрхэм депутатуудад энийгээ хэлэлцүүлнэ. Энд бага хурал дээр барьсан үндсэн зарчим бол үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулинд Улсын их хурал, АИХ, бага хурлын хооронд хууль тогтоох болон төрийн дээд эрхийг барихынхаа хувь дах бүрэн эрхийг хуваасан тэр хуваалтыг бол энд огт хөндөгдөхгүй байх I-р зарчмыг баримтласан. Тэр ч үүднээсээ энд АИХ-ын онцгой эрхт нь букуу өөрөөр хэлэх юм бол тэрнээс өөр хэн ч итгэхгүй байх, тэр онцлон оноосон өчигдөр онц эрх гэдгийг маш хазгайгаар гуйвуулж, ойлгож нөгөө через зачение гэдэг утгыг оруулж яриад байна лээ. тийм биш, зөвхөн үүнд олгогдсон эрх гэдэг утгаар нь онцгой гэдэг ийм хэллэг энд байгаа шүү. Тэр утгаараа бол энд бүгд байгаа. Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, огцруулах, бага хурлын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, их цаазын 25-ын I- дэх 5,6,9 ерөнхий сайдыг томилох, огт өөрчлөх, огцруулах, эрхэм депутатын

гомдол тавиад байгаа гол зүйл, улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, 60-ын 2 дахь хэсэгт зааснаар бол улсын ерөнхий прокурорыг томилох, еерчлөх, түүнчлэн их цаазын 69 дэх зүйлд заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлнэ гээд тов тодорхой заачихсан байгаа. Их хурлын онцгойлсон эрх мэдэлд нь. Тийм учраас энэ бол үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг хуучин бидний хуучин АИХ-ын тэргүүлэгчдээс хуучин АИХ-ын өмнөх сонгуулийн АИХ-ын хуралдаанаар баталсан үндсэн хуулийн нэмэлтийн хуулинд еерчлөлт оруулах тухай асуудал ярьж байгаа бол энэ бол еер хэрэг. Ийм байдалаар манай I-рт манай депутатуудыг 2-рт, хэвлэл мэдээллээр энэ бүх зүйлүүд гарч байгаа учраас тэдгээрийн сэтгэл санаанд өнөөдөр дэгэлзүүлээд байхын шаардлагагүй байна. Үнэхээр ямар нэгэн төрийн эргэлт гаргах гэж байгаа мэтээр сэтгэгдлийг төрүүлж байна. Ингэснээрээ их хуралд ямар нэг дарамт шахалт, гадна талын уур амьсгалд нөлөөлөх дотор талдаа нөлөөлөх, түүнээс гадна аргачлалын хувьд оруулж ирж байгаа иргэдийн санал, цахилгаан, захидлыг уншиж танилцуулахдаа ч гэсэн өмнө нь уламжлал болчихсон баяр хүргэсэн цахилгаан мэдээнууд ирдэг байсан, тэрнийг уншиж депутатуудынхаа сэтгэл урмыг сэргээдэг байсан, байх, тэр үед депутат байсангүй. Өнөөдөр депутатуудын үйл ажиллагаа хууль тогтоох үйл ажиллагаанд шахалт үзүүлчих гэсэн тийм зүйлүүдийг тухайн депутатын нэрэн дээр тэр депутатын нэр энэ танхим доторх нэр хүнд болоод түүнтэй холбогдсон бусад нэр хүндэд шахалт үзүүлчих гэсэн ийм зүйлүүдийг энд тодорхой уншиж байхын шаардлага хууль тогтоох үйл ажиллагаанд оролцож байгаа энэ үе дэх ёс зүйд бол үл нийцнэ гэж бодож байна. Тэрч үүднээс энэ депутатуудын бүрэн эрхийн асуудалд депутатуудчуулж байх үед тэгэх нь байтугай тэдгээрийн онцгойлсон хамгаалагдах эрх зүйн хэм хэмжээ байдаг шүү. Энэ болгоных нь хувьд бид бодож бүх юмыг бодохгүй бол I-рт дотроо, нөгөө талдаа гаднаа бол бас нэг тийм эвгүй уур амьсгал үүсэх төлөв хандлага байна. Их цаазынхаа хувь заяаны төлөө санаа зовж байна.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

 Ш. БУРМАА



1991. XI. 16.  
Кассет № 78  
9.33-9.46.

27 дугаар тойргийн депутат Л. Шүрөвдорж: -Төгөхээр Их Хурлын депутат дашбалбар санал тавьлаа. Энэ эрхийн ёсоор бид санал хураах ёстой. Гэхдээ монгол улсын төрийн эрх одоо энэ танхимд байж байна шүү. Бид монгол улсын төрөө барьж байгаа. Тийм учраас бид буурь суурьтай байж жаахан уужуухан байж ингэж асуудлыг шийдэж баймаар байна. Олон хүн ярьчихлаа. Төгөхээр би ийм нэг санал хэлье гэж бодож байна. Дашбалбарын саналыг хураалгүй энэ юг байгуулах уу, үгүй юу гэж эхлээд санал хураах нь зүйтэй. Гэхдээ бид хэлэлцэж байгаа асуудлаараа явъя.

Төгөхээр дашбалбарын санал бол хавсралт хууль, өөрөөр хэлбэл, шилжилтийн үеийн хуультай холбогдсон ийм асуудал байгаа. Тийм учраас би дашбалбарт ч гэсэн хүсч байна. Тийм учраас Бага Хурлын тайланг хэлэлцэхийн өмнө юмуу, үгүй бол хавсралт хууль хэлэлцэхийн өмнө өөрөөр хэлбэл Их цаазаа хэлэлцсэний дараагаар уг асуудалтай холбогдох цаг үе нь хүрээд ирэхээр тэнд нь эксперт байгуулах уу, үгүй юу гэдгийг санал хурааж шийдвэл яасан юм бэ? Өчигдөр дашбалбар хэлэхдээ 16-нд санал хураа гэж хэлээгүй шүү. Тийм учраас тэр үед нь санал хураавал яасан юм бэ? Энэ асуудлыг байгуулах уу, үгүй юу гэдгийг. Тэгээд энэ дээр эхэлж ярилцах юм байвал ярилцъя. Одоо бид энэ танхимынхаа уур амьсгалыг Монгол улсын хэмжээний улс төрийнхөө уур амьсгалыг бодож Их цаазаа хэлэлцье. Тийм учраас би дашбалбарыг цаг үеийн энэ асуудлыг санал хураах цагийг, миний тавьж байгаа саналыг зөвшөөрөөсэй гэж бодож байна.

Ж. Уртнасан: -Асуултыг нээлттэй орхье, санал хураалтыг нээлттэй орхье гэсэн санал байна.

10 дугаар тойргийн депутат О. Дашбалбар: -Уртнасан гуай, би өөрийнхөө санал бодлыг хамгаалж цөөнхийн хувьд уг хэлэх эрхтэй гэж бодож байна.

Ж.Уртнасан: -Уучлаарай, дашбалбар гуай. 6 дугаар микрофонд зөвшөөрөл өгсөн, дараа нь та. Ингээд энүүгээрээ саналаа тасалъя.

429 дүгээр тойргийн депутат Д.Рэнцэннацаг: -Хамгийн гол нь цаг дээр би их харамсч байна. Өглөөнөөс хойш үндсэн асуудлаа шүүмжилж ярьсан бол даруй 4, 5 хүн үг хэлэх байв. Гэтэл энэ сайхан цаг дээрээ ерөөсөө өглөө бүр нэг өөр асуудлаар бие халаадаг асуудлыг зогсоомоор байна гэж бодож байна.

Зарим депутатууд ч гэсэн бодож байгаа, хэлж байгаа үгээ бас жаахан бодож хэлэх нь зүйтэй байх. Би энэ дээр депутат дашбалбарт хандаж ярих гэж байна. Засгийн газрыг аажуухан замаар авах гэж байна. Ер нь болохоо байсан маягийн юм яриад байгаа юм. Тэгэхээр бидний энэ үйл ажиллагаа чинь бол дэлхий дахинд биднийг хараад сууж байна. Өнөөдөр ч дэлхий дахины хэвлэл, радио мэдээгээр монголд төрийн эргэлт гарах гэж байна. Засгийнхаа эрхийг тайван замаар авах гэж байна гэсэн юм л явагдаад байгаа юм биш байгаа гэсэн юм төрөөд байгаа юм.

Хоёрдугаарт, нэг үгээ их бодож үнэн юм яримаар байна. Нөгөө нь энэ үнэн юмуу, худлаа юмуу гэдгийг бас сайн дүгнэж байж босмоор байх юм. Нэг хүн үг хэлэхээр ялангуяа Бага Хурлын гишүүд бөөн бөөнөөрөө зэрэг зэрэг босоод ирэхээр хаашаа ч юм гэсэн юм бодогдоод байх шиг байгаа юм.

Сүүлийн үед энэ бие халаалтын юман дээр Бага Хурлын гишүүд зэрэг зэрэг босч ирээд, дээрээс нь Бага Хурлын дарга ингээд нэмэрлээд ирэхээр бас л бие халаалт ширүүсч болзошгүй болчих гээд байгаа юм шиг санагдаад байгаа юм. Энэ бүхнийг жаахан бодолцвол яасан юм бэ гэдгийг би хэлье гэж бодож байна. Үндсэн асуудлаа яривал яасан юм бэ? Цаг маргасаар байгаад дуусах нь байна шүү дээ.

10 дугаар тойргийн депутат О.Дашбалбар: -депутат нөхдийг анхааралтай сонсоосой гэж хүсч байна. Үндсэн асуудал, ерөнхий асуудлаар бид ярьж байгаагаа мэдэж байна. Тэхдээ миний ярьж байгаа юм бол дэгэнд заагдсаны дагуу ерөнхий

асуудлаар ярьж байгаа юм аа.

Хамгийн гол нь та бүхэн анзаарч байгаа байх. Хэрвээ би буруу ярьсан бол намайг Бага Хурлын байнгын хорооны гурван дарга, дэд ерөнхийлөгч бүгдээрээ эсэргүүцэхгүй байсан. Тэгэхээр энд ямар нэг "но" байгаа учраас бүгдээрээ яаравчлан эсэргүүцэж байна гэдэг бол тодорхой.

Хоёрдугаарт, социал демократ намынхан бүлгээрээ босож эсэргүүцэж байна. Социал демократ намаас 3-4 хүн энэ Их Хуралд байгаа. Өнөөдөр дөрвүүлээ бослоо. Тэгээд тэр ч байтугай миний зарчмын дагуу тавьж байгаа үзэл бодлыг мушгиж үмхий хасаг гэж хэлсэн гэж хэлж байна. Би үмхий хасаг гэж хэлээгүй. Үмхий үгтэй хасаг вэ гэж хэлсэн. Тэгэхээр энэ бол үндэсний үзлийг дэвэргэж биднийг дунд нь байлдуулах гэсэн ийм санаа юм шиг санагдаж байна. Миний хажууд ганцхан ламжав биш олон хүн байсан, санаж байгаа байх гэж санаж байна. Харжаубай бид хоёрыг байлдуулан гэж бодож байгаа бол бид хоёр байлдахаасаа өнгөрсөн. Бид хоёр уудгаа уугаад ярьдгаа яриад үнэндээ ойлголцсон. Хасагийн үндэсний үзэлтэн, халхын үндэсний үзэлтэн хоёр аль аль нь үндсэрхэг үзлийг өөртөө баримтлах эрхтэй гэдгээ ойлгосон. Тийм учраас ийм замаар бол амжилт олохгүй гэдэг нь тодорхой. Би энд нэг юмыг хатуу хэлбэ гэж бодож байна. Би заавал хэн нэгийг дайсан болгох гэсэн юмуу, хэн нэгийг буруутгах гэсэн тийм юм надад байхгүй.

Бид Үндсэн хууль хэлэлцэж байгаа учраас туйлын сонор сэргэг байж асуудалд ултай куурьтай хандаасай гэдгийг санал болгосон. Үнэхээр Үндсэн хуулийн хавсралтын хууль, Үндсэн хууль, Их цаазын төсөл гурав бол тусдаа байгаа. Манай депутатууд бол хуулиа сайн уншиж байгаа. Гэхдээ тус тусад нь нарийвчилж уншаад байгаа учраас гурван хуулийг дунд нь гурвууланг нь холбож үзэхгүй байгаа. Холбоод үзэх юм бол үнэхээр тайван замаар төрийн эргэлт хийх гэсэн оролдлого байгаа, энэ бол миний үзэл бодол, би бусдад тулгахгүй. Хамгийн гол нь цэргийн эргэлт, ордны эргэлт, Үндсэн хуулийн

замаар эргэлт гэж байдаг. Үндсэн хуулийн замаар ямар эргэлт байдаг юм бэ гэхээр Үндсэн хуулийн төгс төгөлдөр бусыг ашиглаж эргэлт хийдэг. Үндсэн хуулиас Үндсэн хуульд шилжих тэр зааг дээр эргэлт хийдэг ийм зам байдаг. Энэ зам манайд бүрдчихээд байна. Депутатууд энийг анхаараасай. Хоёрдугаарт, Ардын Их Хурлын бүрэн эрхийг автоматаар байхгүй болгож байгаа учраас би энийг эргэлт хийх гэсэн оролдлого гэж үзэж байгаа юм. Би "эргэлт" гэж хэлээгүй байна шүү дээ. Оролдлого гэж үзэж байгаа. Хоёрт, энийг бид санаатай юмуу, санаагүй юмуу гэдгийг би санаатай гэж хэлж чадахгүй. Санаатай, санаагүй нь ч хамаа байхгүй гэмт хэрэг бол санаатай ч байсан, санаагүй ч байсан гэмт хэрэг гэж үздэг. Ийм учраас би зориуд депутатуудын комисс томилох нь зайлшгүй энэ бол хуулийн дагуу үйлдэл юм гэж бодож байгаа юм. Ийм учраас та бүхэн өөрсдөө анхааралтай хандана биз. Хэрвээ би алдсан байвал буруугаа хүлээх тийм эр зориг надад байна. Хэрвээ би алдаагүй бол ямар ч байлаа гэсэн хуулийн дагуу экспертиз томилж буруутай этгээдүүдийг тодруулах ёстой. Тэгхдээ бид тэр хүмүүсийг шүүхэд өгөхгүй нь тодорхой. Надад ч тэднийг шүүхэд өгье гэсэн зорилго алга.

Хамгийн гол нь хуулинд ийм хариуцлагагүй битгий хандаасай гэдгийн үүднээс бид ийм санал тавьсан юм. Та бүхнийг ойлгоно гэдэгт найдаж байна.

Ж. Уртнасан:

-Санал сонслоо. Байдал ойлгомжтой

байна. Бид харилцан ойлголцох, танин мэдэхүйн ач холбогдолтой санал сонслоо. Тэгэхээр депутатуудын уур амьсгалыг би ингэж ойлгож томъёолж байна. Ер нь Үндсэн хуулиа хэлэлцэх дэгийнхээ дагуу ажлаа үргэлжлүүлбэ. Энэ асуудлыг нээлттэй орхье гэсэн бодол уур амьсгал байна гэж бодож байна. Тэгэхээр санал хураалт, бид нэгэнт депутатыг хүндэтгэж зарим асуудлаар санал хураалт явуулдаг зарчимтай, тэгээд тасалдаг. Хэрэв ингэх юм бол ерөөсөө ганцхан санал хураалт явуулаад шийдчихэж болмоор байна.

Энэ нь эксперт томилъё гэдэг дээр санал хураалт явуулаад томилохгүй гэвэл ... Томъёоллыг дахиад хэлье.

Ийм томъёоллоор санал хураалгаж өгөхийг депутат дашбалбар хуссэн. Үүнийг дахиж танилцуулъя. Их цаазын хавсралт хуульд эксперт хийж санал боловсруулах экспертийн группийг томилъё гэж.

56 дугаар тойргийн депутат Р.Гончигдорж: -Уртнасан дарга аа, тэгэхээр эрхэм депутатын бүрэн эрхийг хүндэтгэх ёстой. Энэ хүний тавьж байгаа зорилгыг энд экспертдээ тусгах ёстой. Тэгэхээр энэхүү Үндсэн хуулийн хавсралт хуулиар төрийн эрх мэдлийг Улсын Бага Хуралд бүрэн авахаар тусгагдсан явдалд гэмт хэргийн шинж байгаа эсэх талаар судалгаа хийх экспертийг байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй гэсэн ийм томъёоллоор асуудлаа тавьж байна шүү дээ.

Тэгэхээр ийм томъёоллоор нь томъёолоод одоо депутатынхаа бүрэн эрхийн дагуу шийдэх хэрэгтэй гэж бодож байна. Миний ойлгож байгаа томъёолол ийм байна. Хэрэв буруу бол уучлаарай. Ийм тодорхой байх хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол хуулинд эксперт тавина гэдэг чинь өргөн утгатай шүү дээ. Бүх зүйл ангиар нь байх юмуу, эсвэл энэ хуулийн тодорхой ямар чиглэлд нь байх юм. Эксперт гэдгийг би гадаад үгийг сайн ойлгохгүй юм. Гэхдээ эксперт болгон тодорхой чиглэл зорилготой эксперт хийдэг. Ийм л юм байх хэрэгтэй байна. Тэгэхгүй тийм тодорхой биш хэлэх юм бол тэр экспертүүд яаж ажиллах нь ч мэдэгдэхгүй, бид нар яаж эксперт байгуулах гэж байгаа нь ойлгомжгүй, ийм л санал байна.

596 дугаар тойргийн депутат В.Чимид: -Асуудлыг ингэмээр байх юм. Урьдаар сайн томъёолж байж санал хураалгахгүй болбол болохгүй байна. Юмыг ерөөсөө багтаамжийг бүрэн гаргаж бичих ёстой, хуулинд. Мишээ нь: түрүүчийн хороо баталсан тогтоолд үндсэн төслийг еөрчилж оруулахыг гэж тийм үг байна. Тэгэхээр хороо бол ямар ч гэсэн энэ төслийг еөрчлөх үүрэгтэй болдоо. Би еөрчлүүлэх гэж үгүй гэж байгаа юм биш ээ.

депутатуудын саналыг л тусгаж оруулах ёстой. Тэгэхээр энэ хоёр үг чинь маш их ялгаатай. Ийм юман дээрээ мэргэжлийн хүмүүсийн үгийг сонсож баймаар байна. Ийм юм уншаад батлах уу, яарч байгаа улсууд шууд ингээд баталчих юм. Тэгээд сүүлд нь




тэр үгэн дээр маргаад чи, би-дээ хүрэх юм. Ийм учраас үгийг сайн томъёолуулж баймаар байна. Энэ бол та бүхний өөрсдийн чинь албаны хариуцлагын асуудал шүү. Хоёрдугаарт, би хоёр жил болсон ганц үгээ хэлье. Практикаас үзэхэд надад ийм /би зохиолч биш/ улс төрийн хардлага төр улсаа сүйтгэнэ, эр эмийн хардлага гэр бүлээ сүйтгэнэ гэсэн үг орж ирээд байгаа юм, надад. Тэгэхээр хий ингэж хардаж юугаа хийх юм бэ? Энэ дотор чинь дайснууд орсон биш.

Туравдугаарт, би нэг юм хэлмээр байна. Төрийн эргэлтийг ингэж хийх гэж байна гэж зарлаж хийдэггүй. Харин ийм төсөл оруулж байна, яах вэ гэж асуугаад байхад чинь эргэлт хийх гэж байна гэж яриад байх юм. Ийм жирийн логикгүй юм ярьж ард түмнийхээ сэтгэлийг үймүүлмээргүй байна. Энэ чинь ойлгомжтой шүү дээ. Ойлгомжтой юмыг ингээд байх юу байдаг юм бэ?

Та нар өөрсдөө шийдээч ээ, тэр ч байтугай өөрчилсөн ч бий. Дрөөсөө нуух юм алга. Хэзээ, би ийм юм хийх гэж байна гэж очиж хэлээд эргэлт хийж байсан юм бэ? Түүнээс гадна Үндсэн хуулийн эргэлт гэж байхгүй. Энийг хэн яриад байгаа юм бэ? Төрийн эрхийг зөвхөн Үндсэн хуулийн аргаар авахыг зөвшөөрдөг юм. Ардын дайсан гэнэ үү, Чимидийг юу гэж хэлэх нь хамаа алга. Миний цол бол бараг гүйцэж байгаа байх. Булхинаас авахуулаад дайсан, тэнэгээс авахуулаад "изм" хүртэл бүх цол байх шиг байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

зөвшөөрөл өгөх үү, дарга аа.

Уртнасан -За зургаа.6 дугаар микрофоноор таслая гэж бодож байна.

369 дүгээр тойргийн депутат Д.Пүрэвдорж - Дашбалбарын тавьж байгаа асуудалд эргэж анхаарлаа хандуулах ёстой гэж бодогдож байгаа юм. Улсын их хурлын бүрэн эрхийг УИХ байгуулагдаж эрхээ эдлэх хүртэл Ардын Их Хурал, Улсын бага хуралд хувааж тавихдаа хаана нь ямар хэмжээний эрх мэдэл үлдээх вэ гэдэг асуудлаар депутатууд одоо манай депутатуудын хороо анхаарах ёстой асуудал мөн. Гэхдээ асуудлыг ийм хэмжээнд авч ярих байсан уу, үгүй юу гэдэг дээр бид бас бодох ёстой. Ер нь би танхимын уур амьсгалтай холбогдуулж хоёрхон өгүүлбэр хэлбэ гэж бодож байна. Танхимын уур амьсгалд бол Дожоодоржийн басамжлал, жишээлбэл багийн хурлыг мэдлэггүй удирдах ёстой гэж мэдэгдэл хийснийх, Бат-Үүлийн сануулга 3 сарын дараа, дөрвөн сарын дараа 3 дугаар сард юу болохыг хараарай гэж хийсэн сануулга, магадгүй би хүн доромжилж байгаа бол уучлалт гуйя. Би Бадраа гуай тэргүүтэй видео кино бүтээгчдийг аугаа их соён гэгээрүүлэгч байнгын ажиллагаатай парламентын үнэнч сурталч гэж хэлэх гэж байгаа юм. Энэ нөхдийн явуулж байгаа үйл ажиллагаа 281-ийн холбооны Дашбалбар болон мэргэжлийн холбоодуудаас өгөөд байгаа анхааруулга гэх мэтийн зүйлүүд бол танхимын уур амьсгалд мэдэгдэхүйц нөлөөлж байна. Тэгэхлээр парламентад үг хэлснийхээ төлөө депутатууд хариуцлага хүлээдэггүй юмаа гэхэд асуудалд хариуцлагатай хандаж байхыг депутатуудад уриалж байна.

Уртнасан -За 2 дугаар микрофон.

9 дүгээр тойргийн депутат Зориг -Хүндэт депутатуудад хандаж нэг юм хэлмээр байгаа юм. Зарим нөхдөд өөрийнхөө мунхагийг битгий гайхуулаач ээ. Юм ярья гэвэл жаахан ном уншиж байгаад яриач. Тэгэж өөрийнхөө сонгогчдын өмнө тийм маягаар өөрөө гарах ямар шаардлага байдаг юм бэ. Би түрүүн хэлсэн шүү дээ. Дотоод яамны сэтгэлгээнээс гарцгаагаач ээ гэж. Хэдий болтол

бие биенээ хардаад, ингээд төр улс байгуулна гээд дэмий юм битгий яриад байгаач. Бие биендээ итгэхгүй байж яаж байгуулах гээд байгаа юм бэ.

Уртнасан -9-р микрофон Нямбуу гуай.

6 дугаар тойргийн депутат Нямбуу -Дашбалбарын тавиад байгаа энэ зүйл бол тухайн үедээ хэлэлцэхэд анхаарч болмоор зүйл байгаа юм. Тэгэхдээ Дашбалбар үүнийгээ гаргаж тавихдаа их эвгүй байдлаар гаргаж тавиад байна. Энэ нь тун тусгүй байна. Ерөөсөө энэ дээр би боссоньх, би босоо ч үгүй хүн, би нэг юм хэлчихье. Хурлын уур амьсгалыг би хэвийн явагдаж байна гэж үзэж байна. Гэхдээ энэ дээр элдвийн юм ярьж хооронд үймүүлээд байх явдал хэрэггүй нэгдүгээрт. Хоёрдугаарт, Дашбалбарын ер нь сүүлийн үед яриад байгаа тун эвгүй эвгүй юмнууд байгаа. Монгол улсын тусгаар тогтнол тун удахгүй алдагдах гээд байгаа ч юм шиг, гадаадын элдэв цагаачлал орж ирээд манайхыг уусгачих гээд байгаа ч юм шиг, төрийн эргэлт ер нь хэзээ хэзээгүй нэг талаас гараад ирэх гээд байгаа юм шиг ийм олон түмний тархи толгойг эргүүлсэн ийм эвгүй уур амьсгалтай юм яриад байдаг болоод байна. нэгдүгээрт. Хоёрдугаарт, еерөө хүнийг дайрлаа, доромжиллоо гэж загнадаг мөртлөө еерөө бас зүй бусаар авирлаад байх явдал байх юм. Зуны чуулган дээр манай Ардын их хурлын дарга, ерөнхийлөгчийг та нар юу юм бэ, яах гээд байгаа юм бэ, битгий энэ жүжгээ тогло, хурлаа тараа, хаа гэсэн ийм хүртэл шаардлагыг тавьж байсан. Тэгээд энэ залуу хүн байна, яруу найрагч хүн, хүндтэй болж байгаа хүн, ярих хэлэх юмаа жаахан учиртайхан ярьж байгаа ч ээ гэж Дашбалбарт би өвгөн настай хүний хувьд зөвлөчихмөөр байна.

Уртнасан -3 дугаар микрофон.

Бат-Үүд -Би зүгээр депутатуудынхаа сонорт хандаж ганц юм хэлэх гэсэн юм. Миний ойлгож байгаагаар бол Дашбалбар бол үнэнхүү сайн эх оронч мөн л дээ. Үнэхээр сайн эх оронч. Гэхдээ энэ хүний зүгээр энэ хүний нийгмийн харилцаа өөрчлөгдөх дээр зэрэг энэ хүний эх орон гэж ойлгож байсан хуучин ойлголт алдагдаад ирэхийн цагт энэ хүн бол миний зүгээр ажиглаж байхад

сүүлийн үед эрүүл саруул ухааныхаа хязгаарыг давсан ийм алхмуудыг хийдэг болсон. Яагаад үүнийг хэлээд байна вэ гэхлээр цуглаан дээр очоод харахад Дашбалбар ингээд ярьж байна лээ л дээ. Дашцэрэн гэдэг аугаа их ид шидтэн аварна гэж, ганцхан тэр хүн аварна гэж. Энэ чинь яг 17 онд Николай хаан /сонсогдоогүй/ гэж балмад хүнийг гаргаж ирж байсан шүү дээ. Тэр чинь ийм хачин эрүүл саруул биш ухаанаар яригдаж байгаа энэ зүйл харамсалтай нь өнөөдөр депутатуудын хэлэлцэх асуудлын гол чиглэл болчихоод яваад байдаг. Тэгээд зарим нэг депутатууд нь энэ дээр босоод Бат-Үүл гурав, дөрвөн сарын дараа түүхийн хариуцлага гэж. Депутатуудад хандаж хэлэхэд энэ Үндсэн хууль дээр хүний эрхийг баталгаатай гаргаж чадах юм бол Монголын түүхэнд хэзээ ч хэлмэгдэл гарахгүй. Улс төрийн хариуцлага гэдэг чинь өөр асуудал. Энэ бол сонгогчдын асуудал. Тэгэхээр эрүүл саруул биш ухааныг хүлээж авдагаа болимоор байна. Энэ чинь бид бүхэн өөр өөрийн бодолтой, улс орныхоо хувь заяаг шийдэх гэж байна. Үүнийгээ л яамаар байна.

354 дүгээр тойргийн депутат Бороодой –Би Дашбалбарын хэлж байгаа, тэр хэллэгийн хувьд нь дэмжихгүй байна, гол санаа нь бол бодож үзүүштэй зүйл байна гэж үзэж байна. Яагаад гэвэл шинэ цаазын төсөлд маань Улсын их хурлын гишүүд, түүний эрх үүргийн тухай дурдсан байгаа. Шилжилтийн хуулинд бол Ардын их хурал гэж томъёолсноос биш түүнийг гишүүд, депутатууд гэж ямар нэгэн үг байхгүй ээ. Өөрөөр хэлбэл АИХ-ын депутатуудын бүрэн эрхийн хэмжээ өөрөө автоматаар алга болж байна. Энэ дунд ийм зүйл бий. Тэгэхлээр энд эмзэглэж байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхлээр бид нар нэгэнт Их цаазын төсөлд Улсын их хурлын гишүүдийн эрх үүргийн тухай оруулсан юм, шилжилтийн хуулинд АИХ-ын энэ депутатууд дараачийн сонгууль хүртэл ямар эрх, үүрэгтэй байх вэ гэдэг дээр үг үсэг алга байгаа. Үүнийг оруулах нь зүйтэй болов уу гэсэн ийм юм. Өөрөөр хэлбэл депутатуудын хууль шинэчлэгдээгүй, депутатуудын эрх үүрэг гэдэг юм нь тодорхой бус байгаагаас энэ асуудал гарч байгаа байх аа гэж бодож байна аа. Тэгэхлээр үүнийг тодруулж, оруулж, ингэж хянаж хэлэлцэх нь зүйтэй байх аа гэж бодож байна.

—Их хурлын даргаа ийм юмаа таслан зогсоож болиулбал дээр байх аа. Ямар ч утгагүй санал гаргачихаад тэрэн дээр бүтэн цаг үрлээ. Энэ асуудлыг чинь Их хурал өөрөө хэлэлцээд өөрөө шийднэ, үнэхээр муухай юм байгаа бол засаад явуулчихна. Их хурал өөрөө шийдэх юмыг чинь яагаад байх юм. Тэмээн жин явж л байна, нохой хуцаж л байна гэдэг шиг хуцаж л байг л дээ, хэдүүлээ Их цаазаа хэлэлцэж л байна л даа.

Уртнасан —Энэ саналыг эцэс болгоод санал хураалт явуулна. Та үгээ хэлчих үү.

289 дүгээр тойргийн депутат Нороврагчаа — Би энд уг хурлаас гадна өнөөдөр монголын ард түмний байдлыг хэлэх гээд байна. Бид энд тэр барилцаж байгаа улс төрийн зүтгэлтнүүд гээд яриад байгаа. Бид нар өчнөөн ард түмнээр тоглох гээд байгаа юм бэ. Монгол ард түмэн чинь нилээн уужуухан, хүлээцтэй улсууд байдаг юм. Тэгэхэд л нэг хэсэг бүлэг хүн гарч ирээд л байхгүй дайсныг гаргаж ирээд энд тийм аюул гарах гэж байна, ингэх гэж байна гэж яриад, тэгээд тэр гадаа байж байгаа ард түмэн чинь яадаг вэ гэхлээр тэр дотор чинь тийм явуулга, тийм дайсан бүлэг болчихсон байна гээд ингээд туйлшруулаад эхэлдэг. Тэгсэн хойно нь эргээд монголчууд ёстой туйлширдаг, балладаг улсууд гээд. Ингэж битгий баллуулаад байгаа ч ээ. Тэгээд өөрсдөө чуулган чуулах гэж байгаа юм бол үүнийгээ чуулах шиг чуулъя. Дашбалбар хэлж байна, би буруу байдаг юм бол сүүлд нь хүлээчихнэ гэж. Хүлээх цаг нь хожигдчихдог юмаа. Ард түмнийг нэг битгий хэл тэгээд үймүүлээд хөдөлгөчихсөн хойно оо, дараа нь энэ чуулганы хажуугаас нөлөөлсөн барьсан гээд элдэв юм ярих болно шүү дээ. Болиоч ээ, одоо улс төрийн ноён нуруугаар энэ хэлэлцэх асуудлаа хэлэлцээ, тэрнээс биш дайсан илрүүлэх гээд байдаг гавьяагаа болъё л доо.

Уртнасан —Тайвуу, уужуу ухаантайгаар Үндсэн хууль буюу Их цаазаа хэлэлцэх ажилдаа орёё.

86 дугаар тойргийн депутат Хоржаубай -Би ганц минут уг хэлээдэх үү. Би нэг их босдоггүй шүү дээ та нар уучлаарай. Нэг ийм юм байна аа та нар зөв ойлгооч ээ. Энэ шилжилтийн хуулийн 4,5 дугаар хуудсанд ингэж бичсэн байгаа. Би уншаад өгчихье. Улсын бага хурал энэхүү хавсралт хуулиар АИХ-ын онцгой эрхэд хамааруулснаар бусад асуудлаар монгол улсын хууль тогтоох дээд байгууллагууд Их цаазаар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Тэгэхээр энд тодорхой байна шүү дээ. Ерөөсөө Их цаазаа батлангуут АИХ-ын депутатуудад огт хэрэг байхгүй болчихоод байгаа юм. Миний ойлголт бол, буруу ойлгож байгаа бол уучлаарай. Тэгээд энд нэг асуудал байгаа юм л даа. Зарим улсууд яахав Дашбалбар бид хоёрыг хагаралдуулах гэж оролдож байх шиг байна. Тийм бишээ. Асуудал ийм байна. Ерөөсөө АИХ-ын депутатууд бол ямар ч байсан эрх байхгүй болчихоод байгаа юм. Энэ эрхийг баталгаажуулах өгөх хэрэгтэй юм шиг байгаа юм. Тэгэхээр үүнийг ярих үед нь ярья.

Уртнасан -Эрхэм депутатууд аа,бид энэ асуудлыг цэглэе. Энэ уур амьсгалыг еерчилсөндөө би харамсаж байна.Нэгэнт эхэлсэн ажлаа дуусгачихъя.Ийм томъёоллоор санал хураалт явуулаад энэ асуудлыг эцэс болгоё гэж бодож байна.Монгол улсын Их цаазын хавсралт хуулиар төрийн бүх эрх мэдлийг Улсын бага хурлаар авах гэсэн оролдлого,түүнээс уялдсан гэмт хэргийн бүрдэл байгаа эсэх талаар экспертийн группийг томилно гэсэн томъёоллоор санал явуулья.Тэгээд энэ асуудал шийдэгдэнэ гэж бодож байна.Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Дашбалбар -Уртнасан даргаа.Та миний өгсөн томъёоллыг уншихгүй,еерсдийнхөө бий болгосон томъёоллыг уншиж байна.Би өчигдөр яг хуулийн дагуу ямар ямар үндсэн хуулийн заалтууд хийгээд хурлын дэг зөрчигдөж байгаа тухай бүх юмыг өөрөө томъёолж бичиж өгсөн.Энэ заалтыг уншихыг хүсч байна.

Уртнасан -Уучлаарай.Хэрэв таны томъёолол гэвэл энд өрөөсөө томъёолол алга байна.Гэхдээ таны бичиж өгснийг депутатуудын сонорт хүргэх нь зүйтэй гэж үзэж байна.Манай Дашбал-

бар депутат ингэж бичсэн байна л даа.

-Их цаазаар олгосон бүрэн эрхийг зөвхөн Бага хурал дангаар хэрэгжүүлэх ажээ.Ийм учраас депутат нөхөр Нэмэхийн Пүрэвдорж, Чагнаагийн Пүрэвдорж, Сэндэнжав, Гаравсүрэн, Ёндон-дэмбэрэл нарын бүрэлдэхүүнтэй эксперт томилъё гэсэн ийм томъёолол байна.Энэ томъёоллоор нь санал хураалт явуульа гэдэг зөв болов уу гэж бодож байна.Уучлаарай, дахин нэг анхааруульа. Тэгээд энэ асуудлыг шийдэж болмоор юм шиг байна. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

*Баяндүүрэн*

/Д.БАЯНДҮҮРЭН/

Бичээч Д.Энэбиш



1991-ХI-16  
Кассет № 80  
10.00-10.14

Депутат Дашбалбарын бүрэн эрхийг хүндэтгэж оруулсан саналынх нь дагуу санал хураалт явуулах гэж байна.

Санал хураалтанд бэлтгэнэ үү.

191 дүгээр тойргийн депутат Д.Лханаасүрэн:

Үгүй.Ийм утгаар санал хурааж явуулж болохгүй.Гэмт хэргийн шинжтэй гэдэг ийм асуудлаар санал хурааж явуулж болохгүй.Та тогтоолоо хэлэлцүүлэх ёстой.Их Хурлын гаргаж байгаа шийдвэр шүү дээ.Энэ бол онцгой хариуцлагатай асуудал.Ингэж санал хурааж болох.Би гэмт хэргийн шинжтэй ч гэж ерөөсөө хэлээгүй.Ийм асуудал оруулахыг би үймээн дэгдээсэн хэрэг гэж үзэж байна.Гэмт хэрэг гэж хэлж болохгүй, төрийн эргэлт хийх гэсэн оролдлого байна уу, үгүй юу гэдэг талаар.

Тэгэхдээр миний саналыг сонсож болгооно уу.Депутатууд аа. Сонсож болгооно уу.

Тэгэхдээр Их цаазын төслийн хавсралт хуулинд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах депутатын хэсэг гэдэг юмуу, групп гэдгиймуу ингэж томилж болно.Тэрнээс таны томьёоллоор санал хурааж хэрхэвч болохгүй.Энэ бол та ноцтой асуудал өөрөө оруулж ирлээ. Тэгж хурааж болохгүй.

Уртнасан:

Депутат Лханаасүрэн бид Дашбалбар депутатын өөрийнх нь оруулсан саналыг хоёр дахин уншлаа.Одоо гуравдахаа уншаад санал хураалт явуулахыг хүсч байна.

Уншилтгүй юу.За тэгвэл баярлалаа.Санал хураалтад бэлтгэнэ.Дашбалбарын өөрийнх нь оруулсан санал, бүрэн эрхийг хүндэтгэж бид санал хураалт явуулах гэж байна.Санал хураалтад бэлтгэнэ үү.

Ганц үг байна.Зургаад.Даргаа.

Цөөнхөөс ганцхан үг байна.

2.

За баярлалаа.

Экспертийн групп томилъя гэсэн хүмүүс 130 буюу 36 хувь нь байна, татгалзсан хүн 193 буюу 54 хувь нь олонхи нь боллоо. Түдгэлзсэн хүн 36 буюу 10 байна.

За одоо та бүгдийн уужуу тайвуу ухаанаар хэлэлцэж байгаа үндсэн асуудалдаа орж Их цаазынхаа төслийн ерөнхий хэлэлцүүлгийг үргэлжлүүлье. Одоо бид гуравдугаар микрофон дээр 58 дугаар тойргийн депутат Рэнцэнбалыг урьж байна.

58 дугаар тойргийн депутат С.Рэнцэнбал: Шинээр батлах хуулийн төслийг боловсруулахад төсөл боловсруулсан комисс Улсын Бага Хурлаас ихээхэн хүч хөрөнгө зарцуулж шинэ хуулийнхаа ноён нурууг зөв зүйтэй гаргасныг үнэлж хэлэх нь зүйтэй гэж үзэж байна. Их Хуралд өргөн барин хэлэлцүүлж байгаа төслийн дотор зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай зүйл, заалтууд байгааг өөрийн сонгогчдын санал дээр үндэслэн саналаа хэлье.

Улсын нэр, хуулийн нэр, сүлд гурвыг хуучин нэрээр нь үлдээх саналтай байна. Улс орны хэмжээнд улс нийгмийн маань гол баялаг мал сүрэг маань байсан, одоо ч байгаа, цаашдаа ч байх ийм нөхцөлд улс орон даяар билэгдэл болгон сүлдэндээ дээдэлсэн халуун хушуут молор эрдэнэ морьт сүлдээ монголчууд малаа бараагүй цагт солих ёсгүй гэдэг үзэл баримтлал дээр үнэхээр малчин ард маань бол хатуу зогсож санал бодлоо илэрхийлсээр байгааг өнөөдрийн Их Хурал анхаарахгүй өнгөрч болохгүй байхаа гэж үзэж байна. За малчин ард маань эвэр хушуутай махчин шувуугаар очиж очиж сүлд хийгээд байдгийн учир юу билээ гэж ихээхэн цочирдон гайхаж байгаа. Сумдыг нэгтгээд хошуу болгоно гэдэг маань ч малчдын маань бас гайхлыг төрүүлж байна. Одоогийн байгаа сумдаас гэрээ, түрээс хийгээд жалгын нэг болсон өрх айлдаа хүрч үйлчлэх үйлчилгээ байхгүй, зай, тэжээл байхгүйгээс радио, сонсгол муу болсон, бензин шатахуунгүйгээс шуудан хүрэхээ больсон, хувцсаа хийж өмсөх гээд даалимба олдохоо больсон, орон ярээ дулаалж, дусаал, жавраас хамгаалах гээд эсгий, брезент олдохгүй

3.

ядаж байгаа биднийг харж үзэх нь байтугай хэдэн сумаар нь нийлүүлж хошуу болгож орхиод, удирдлага, үйлчилгээнээс нь улам холдотгож, улс орноосоо гаргуунд нь гаргах нь уу. Тэгэхдээрээ хүрвэл хэдэн малынхаа хойдохыг нь хөөж орхиод хот, суурин бараа-дана шүү гэж байгаа малчин олширох байхаа. Ямар ч бодлого, сэтгэл зүйн бэлтгэлгүй гээд бүхнийг кампанчлан шинэчлэх байдлаар Үндсэн хуулиа баталчихвал энэ Үндсэн хууль маань улс даяар хүндэтгэн дээдлэгдэж, сахин биелүүлэх хууль бус, харин ард түмнийхээ бухимдал дургүйцлийг дэвэргэж, эргээд ард түмнээрээ цаазаар авахуулах нэг ч жилийн насгүй цаас болно гэдгийг бодож тунгаах ёстой болов уу.

Хуучинсаг зүйлүүдээ шинэчлэх, сайжруулах нь зүй ёсны хэрэгээ. Гэхдээ уламжлал болгон үлдээх, заавал солих шаардлагагүй зүйлийг өнөөдөртөө яарах хэрэггүй болов уу гэсэн саналтай байна. Тэр болгоныг сольж өөрчлөнө гэхэд хэдий хэрийн хөрөнгө зардал орох билээ, улс орны эдийн засаг, хүчин чадал ямар байгаа билээ, эдгээрээ бодолцож шийдвэрлэх нь чухал байна. Энэ мэтээ бодохгүйгээр юм болгоныг шинэчлэнэ, хөгжилтэй орнуудын асуудлаа шийдвэрлэдэг шиг шийдвэрлэчихнэ гээд байх юм бол ёстой галуу хэрэг дуурайж хөлөө хөлдөөв гээчийн үлгэр болох бий гэж эмзэглэж байна.

Газар нутгийг өмчлүүлэх, мөн гадаадын иргэдэд түрээслүүдэн эзэмшүүлнэ, эзэмшүүлж болно гэсэн төслийн заалтыг сонсуугаа сонгогчид маань ёстой л эвэртэй туулай үзсэн мэт эргэлзэж буй сонгогч олон байгаа. Манай Бага Хурал чинь одоо юу хийх гээд байгаа нь энэ билээ гэж бодлогошрон үүх, түүхээ дурсаж, өвөг дээдсийнхээ захиас сургамжаа хүртэл ярьж байна. Үүн дээр ч Их Хурал маань гаргах шийдвэртээ бас л бодож тусгах ёстой болох уу. Миний бодлоор бол гадаадын харьяалалгүй иргэнд түрээсээр эзэмшүүлнэ гэдгийг хасах нь зүйтэй гэсэн саналтай байна. За өнөөдрийн цагийн өнгө аясыг дүгнэж үзвэл хувийн ажил үйлдвэрлэл эрхэлж байгаа нэг хэсэг нь цалин хангамж нь өөрчлөгдөж, дамын худалдаа хийж ард түмнээ шулан баяжаад, улс эх орондоо ажиллаж, зүтгэж яваагаа доог тохуу хийх хэмжээнд очоод байна. Гэтэл шинэ хуулийн маань төсөлд хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж оруулсан

4.

нь бүгдээрээ ажлаа хая, чадсан ч, чадаагүй ч дамын панзчин болоод үз гэсэн уриа дуудлага болохоор болжээ. Үүнийг өөрчилж хөдөлмөрийн насны хүн бүрийг тодорхой ажил хөдөлмөр эрхлэх үүрэгтэйгээр тусгаж, дамын худалдаа хийж ард түмнээ шулагч нартай шийдвэртэй тэмцэл явуулж, тохиролцооны нэртэй хохиролцооны дэлгүүрүүдийг хааж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахаар тодорхой нэр заан зээл аваад уг ажил үйлдвэрлэлээ явуулаагүй дамын худалдаа хийгчдийн асуудлыг яаралтай, журамлан шийдвэрлэх хэрэгтэй байна. Энэ асуудлыг удаашруулвал энэ жилд улсын хэмжээгээр 20 сая мал ч тоолуулж чадахгүйд хүрэх нээ.

За засаглалын хувьд цөөн хүн амтай манай оронд дээд шатны хурал нь 152 гишүүнтэй, доод шатны хурал нь 20-оос илүүгүй гишүүнтэй хурлын үйл ажиллагаагаа явуулдаг байвал манай нөхцөлд илүү тохиромжтой байх болов уу гэсэн саналтай байна. Хурлын хоёр шатны танхимтай байх нь боловсруулж байгаа асуудлыг бүрэн хянаж, түргэн түүхий болгохгүй байхад үнэхээр ач холбогдлоо өгнө байх гэж үзэж байна.

360 дугаар тойргийн депутат Найдан: БНМАУ-ын Үндсэн хуулийн шинэ төсөл буюу Их цаазыг хэлэлцүүлэх, бэлтгэх энэ явцад манай улсын Бага Хурлын гишүүд үндсэн хуулийн комиссоос асар их ажил хийснийг дээрх депутатуудын хамт дэмжиж, талархан тэмдэглэж байна. Энэ ажлын дотор бас анхаарч үзвэл зохих, эргэж хармаар зүйл бас байгааг би хэлэхийг хүсч байна.

Улсын Бага Хурлын дарга Гончигдоржийн асуулт, хариултаас үзэхэд: Нэгдүгээрт манай авсан санал хураалт бол нийт ард түмний олонхийг хамарч чадаагүй мэтээр тайлбарласан.

нь зөвхөн нэр томъёоны хувьд тэгж үзэх талтай боловч манай Ерөнхийлөгчийн тавьсан тайлан илтгэл, урьд сонин хэвлэлд мэдээлснээс үзэхэд Үндсэн хуулийн төслийг хэлэлцэхэд манай санал өгөх ёстой иргэдийн ихэнхийг хамарсан буюу 900 мянга гаруй иргэд орж, 222 мянга орчим, 200 мянга гаруй санал гарсныг аваад үзсэн. Тэр санал яаж гарсан бэ гэвэл хөдөө орон нутагт бүх хүмүүс уулзалт, цуглаан, ярилцлага хийгээд санал давхардсаныгаа дэмжээд, тодорсон санал гарвал хэлсэн учраас энэ бүх нийтийг

хамарсан санал хураалт биш юмаа гэхэд олонхийг хамарсан санал гэдэг нь ойлгомжтой байгаа юм. Ийм учраас энийг нэр томъёоны хувьд шүүмжилж анхаарч үзэхгүй байх явдал бол үндэслэл багатай юмуу гэж энэ дээр Гончигдорж даргатай санал нийлэхгүй байна.

Хоёрдугаарт манай энэ Үндсэн хуулийн асуудлаар ярилцаж байгаа ерөнхий зүйл гэдэг дотор хэдхэн ерөнхий зүйл байгаа. Мөн тэр дээр, зарим зүйл дээр санал хэлье гэж бодож байна.

Хамгийн их анхаарал татсан асуудал Үндсэн хуулийн сүлдийн тухай асуудал, нэрний тухай асуудлууд байна. Энэ нь бол явц дундаа депутатуудын олонхийн саналаар шийдэгдэх юм гэж ойлгогдлоо. Тэгэхдээ би цагаан шонхорын тухай тайлбарыг сонслоо. Өөрийнхөө үзэл бодлыг хэлье гэж бодож байна. Аливаа улс гүрэн цагаан шонхорыг гарсан цагаас хойшооноо бүтэн долоон үеийг дамжиж, хөгжлийн хол алхмыг туулжээ. Тэгэхээр энэ үеийн түүх бол шонхор шувууны түүхэнд Монголын анхны гэдэг нь бол түүхэнд тэмдэглэгдээд хан ч маргахгүйгээр хоцорсон нь гайхамшигтай бөгөөд сайшаалтай. Харин тэр үед шонхор шувуугаар юмуу манай ард түмний хамгийн анхны сэтгэлгээнд буудаг махчин шувуугаар бодоод үзэхэд энэ үеийн сүлд далбаагаа хийсэн эзэн Чингисийг сэрүүн ахуй цагт одоо энэ байранд авчраад тавих юм болбол долоон зуун жилийн соёл иргэншлийг эзэмшсэн манай энэ эрин үеийн түүхэнд энэ тохирно гэж бодохсон байсан болов уу, энэ соёл иргэншилд энэ тохирохгүй нээ, өөр ард түмнийхээ зан, дадал заншил, энэ ёс суртахуунд тохирсон өөр сүлднүүд авах нь зүйтэй гэж үзэхсэн байсан болов уу гэдгийг бас нэг бодмоороо. Нөгөө талаас авч үзэхэд соёл иргэншил, хүн төрөлхтний болоод манай Монгол орны соёл иргэншил одоогоос долоон зуун жилийн урьд орой хадаж хөгшнийхээ дээдсийг хүрээд тэрнээс хойшооноо буурч байгаа мэтээр ч ойлгогдмоор бас нэг талын үзэл бодол, гутрангүй үзэл байх шиг энүүнд санагдах юм. Энэ нь бол гутрангүй үзэлдээ биш, хэтэрхий үндсэрхэх талаасаа авч үзсэн бас ийм зүйлтэй ч бас холбоотой юмуу гэсэн ийм санал байна.

Энд анхаарч үзэх нэг зүйл бол төрийн тогтолцооны тухай асуудал байна. Энэ дээр миний хувьд болоод манай ард түмний сон-

гогчдын маань санал бол хоёр танхимтай байх асуудлыг дэмжиж байгаа. Үнэхээр манай одоогийн ярьж байгаа юмуу, хэлэлцүүлж байгаа төслийн дотор авч үзэх юм бол бага хурлыг өргөтгөх замаар их хурлыг шууд устгачихсан ийм байдлыг тэндээс олж харж болж байгаа. Энэтэй ч холбогдуулаад бас янз бүрийн үзэл бодол, саналыг л хэлэх гээд байгааг харж үзэх нь зүйтэй.

Үндсэн хуулийн дотор дараачийн хөдөлмөрчдийн анхаарал татаж байгаа нэг асуудал бол газрын тухай асуудал. Газрыг ямагт төрийн мэдэлд, улсын өмчөөр үлдээх нь зүйтэй гэсэн ийм саналыг дэмжиж байна.

Уртнасан:

За баярлалаа.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

*В.Муса*

ЭНХТУЯА

Бичээч

В.ОКУН

Д.Жанцан / 185 дугаар тойргийн депутат/-Эрхэм депутат нараа.Би Улсын Бага Хурлын гишүүн ч гэсэн Их цаазын төсөлд зарчмын зөрөөтэй зарим асуудлаа Ардын Их Хурлын депутатын хувьд хэлэх гэсэн юм.Та бид юуны өмнө шинэ төр, засгийн тогтолцоонд амьдралд хэрэгжиж байгаа, цаашид боловсронгуй болгох шаардлагатай асуудлыг Их цааз болон энэ бусад хуулинд тусгах асуудал бол өнөөдөр хамгийн чухал асуудал гэж үзэж байна.

Энэнтэй холбогдуулж Монгол улсын төрийн байгууллын эрх мэдлийг хуваарилах талаар хэдэн санал хэлье.

Нэгдүгээрт, Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиар Улсын Бага Хуралд хууль тогтоох, хянан шалгах+бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллуулсан.Энэнээс Улсын Бага Хурал хянан шалгах үүргийг механизм нь сайн тогтоогүй хуулинд арга барилаа ч олоогүй юм уу энэ үүднээс хянан шалгах үүрэг хангалтгүй хэрэгжиж ирсэн юм.Ийм учраас Улсын Их Хурлын эрх үүрэгт зөвхөн хууль тогтоох эрх мэдлийг өгнө гэж томъёолсны хажууд би ийм хянан шалгах, төрийн дээд эрх үүрэг бол хамт байх ёстой гэдэг зүйлийг зайлшгүй оруулах шаардлагатай гэж бодож байна.

Энэ хянан шалгах үүрэг бол дотор нь байгаа боловч ерөөсөө улсын дээд хууль тогтоох, хянан шалгах үүрэгтэй байх асуудал бол зарчмын чухал асуудал.

Хоёрдугаарт, улсууд ярилаа.Зүгээр Улсын Их Хурал хоёр танхимтай байх шаардлагатай гэж би үзэж байгаа юм.Дээд танхим нь 150 гишүүнтэй, доод танхим нь 43 гишүүнтэй.Манай Бага Хурлын дарга өчигдөр тайлбарласан.Зэрэгцээ хоёр танхим байхаас биш дээд, доод танхим гэж байж болохгүй юм шиг тайлбарлалаа.Дээд, доод танхим бол монгол улсад илүү зохимжтой гэж бодож байна.Зэрэгцээ хоёр танхим байх юм бол хууль тогтоох



## 2.

үйл ажиллагаа хэтэрхий сунжирна. Өнөөдөр Бага Хурлаас гарч байгаа хууль 8-10 хоногт гарч байгаа бол, хоёр зэрэгцээ танхим зэрэгцээ орших юм бол сард ч гарахгүй байх гэж бодож байна. Ийм учраас энэ дээд, доод танхим байх нь илүү зохимжтой болов уу гэж бодож байна.

Гуравдугаарт, Ерөнхийлөгчийн төрийн тэргүүний хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалыг уялдуулан зохицуулж байх асуудлыг бид тэгж байх ёстой гэж ойлгодог боловч энийг Үндсэн хуулийн заалтад оруулж өгөх асуудал хэрэгтэй байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бол ард түмэн чухам Бага Хурал нь энийг уялдуулж зохицуулж байдаг юм уу, Ерөнхийлөгч нь уялдуулж зохицуулж байдаг юм уу гэдэг талаар тодорхой ойлголтгүй байсан учраас олон асуудлууд гарч байлаа. Энийг ард түмэнд ойлгомжтой болгох үндсэн дээр Үндсэн хуулинд тусгах ёстой гэж үзэж байна.

Дөрөвдүгээрт, Ерөнхийлөгчийг нэг бол ард түмнээс тусгадаг, эсвэл Улсын Их Хурлаас сонгодог энэ журмыг дэлхийн жишиг байгаа, энийг дундын хувилбар маягаар оруулахгүй, би ард түмнээс сонгох нь зайлшгүй гэж бодож байна. Их Хурлаас сонгох юм бол Их Хурлын эрхшээлд орохгүй гэх баталгаа байхгүй юм уу гэсэн ойлголттой байна.

Тавдугаарт, Ерөнхийлөгчийн эрх мэдэлд Засгийн газартаа чиглэл өгч байх, Засгийн газар түүнийг биелүүлж, эргүүлж тайлагнаж байхаар тусгах асуудал зүй зохистой гэж үзэж байна.

Зургадугаарт, Улсын Их Хуралд олонхийн суудал авсан нам дангаараа Засгийн газраа байгуулах хэрэгтэй. Өнөөдөр чухам эвслийн Засгийн газар гэдгээр аль нам эцэст нь хариуцлага хүлээх нь тодорхойгүй байна. Нөгөө талаар Ерөнхий сайд нь тухайн намын төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга байх асуудал зайлшгүй гэж бодож байна. Өнөөдөр нам нэг тодорхой хөтөлбөр гаргачихдаг, гэтэл Засгийн газар тэр хөтөлбөрөөс өөр асуудал тавигдаад байдаг. Улс төрийн намуудын тэмцэл бол эцсийн эцэст

3.

засгийн эрхийн төлөө тэмцэл, Засгийн эрхэнд гарч тэр намынхаа бодлогыг хэрэгжүүлэх асуудалтай нийцэхгүй байгаа юм. Ийм учраас энийг хууль зүйгээр Үндсэн хуулинд зайлшгүй тусгах хэрэгтэй. Үндсэн хуулинд тусгахгүйгээр тухайн намын дарга Ерөнхий сайд тухайн намын дарга байж байхад болох ёстой гэсэн ойлголтыг би зөвшөөрөхгүй байгаа. Энийг хууль зүйгээр баталгаажуулж өгөх ёстой гэж бодож байна.

Долдугаарт нь өнөөдөр болон ирээдүйд төрийг хүчтэй байлгаж гэвэл язгуур үндэс бол орон нутгийн засаг захиргааг бэхжүүлэх асуудал байгаа юм. Энэн дотор онцгой анхаарах ёстой асуудал нэг жилийн хугацаанд бид ярьсаар байгаад энийг бэхжүүлж чадсангүй. Ийм учраас орон нутагт төр засаг бол хүчтэй ажиллаж чадаагүйг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Энэнтэй холбогдуулж юуг хэлэх гэсэн юм бэ гэвэл төрийн албан хаагчдын тухай ажиллах нөхцөлийг нь баталгаажуулна гэж байгаа юм. Энэн дээр би дээр нь ерөөсөө төрийн албан хаагчийн, ялангуяа дунд, доод шатны албан хаагчдын эрх зүй, эдийн засгийн баталгааг онцгойлон тусгай хуулиар зааж өгөхийг энэ Үндсэн хуулинд нэмж тусгаж гэсэн ийм саналтай байгаа юм.

Наймдугаарт нь нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарийг боловсронгуй болгох асуудал бол нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, экологийн ихээхэн ач холбогдолтой, зайлшгүй хийх ёстой асуудал гэдгийг хүн бүхэн ойлгож байгаа байх. Гэтэл өнөөдөр энэ нөхцөл бололцоо бүрэлдээгүй байхад хөрс суурь нь бий болоогүй асуудлыг Их цаазад тусгаж болохгүй гэж бодож байна. Эндээс ихээхэн хохирол ч үзэж магадгүй гэсэн ийм ойлголттой байна.

Тухайлбал,

Нэгдүгээрт, өнөөдөр улс төр, эдийн засгийн бужигнаан намдаагүй байна, тэгэхэд газар нутгийн маргаан нэмэн үүсгэж би болохгүй гэсэн саналтай байгаа юм. Хоёрдугаарт, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн асуудал ястны хоорондын тэмцэл ч үүсэж магадгүй. Гуравдугаарт нь энэ өнгөрсөн эдийн засгийн хэвшлүүдийг бий болгосны үндсэн дээр энэндээ тохируулж засаг, захиргааны нэгжийг өөрчлөх юм уу, засаг захиргааны нэгжийг

өөрчилж хаячихаад эдийн засгийн нэгжүүдээ энэнд тохируулах юм уу гэдэг асуудлыг бодож үзүүштэй юм гэсэн ийм саналтай байгаа юм.

Шүүхийн засаглалын хувьд бол их маргаантай байгаа. Шүүхийн засаглалыг цогцос нэг асуудал гэж үзэх ёстой гэсэн би ийм саналтай байгаа юм. Гэтэл шүүхийн засаглалын хажуугаар хоёр дахь шүүхийн засаглал Үндсэн хуулийн цэц гэж гурван засаглалын толгой дээр нь суусан онцгой эрхтэй дахиад нэг шүүхийн засаглал бий болгох гэсэн асуудалтай би санал нийлэхгүй байгаа юм.

Өнөөдөр хуулийн байгууллагуудыг маш их олшруулж байгаа. Энэ хандлагыг ч би зөвшөөрөхгүй байгаа юм. Өнөөдөр Үндсэн хуулиар аягүй бол Дээд шүүх, Улсын прокурор, мөрдөн байцаах алба бол цаашдаа тусгайдаа гарах, Хууль зүйн яам, Үндсэн хуулийн цэц, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар гэдгээр уялдаа зохицолдоо муутай, олон хуулийн байгууллагууд бий болох төлөвтэй болж байгааг анхаарч үзэх нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа юм. Ийм учраас энэ Үндсэн хуулийн ерөнхий цэцийг цэц гэж нэрлэхгүйгээр Дээд шүүхийн дотор Иргэний шүүн таслах ажиллагааг явуулдаг шүүх, нөгөө хэсэг нь бол Үндсэн хуулинд хяналт тавьдаг шүүх гэсэн хэлбэрээр байх нь зайлшгүй чухал юм гэсэн ийм саналтай байна.

Д.Рэнцэннацаг /429 дүгээр тойргийн депутат/ -Өнөөдрийн бидний хэлэлцэж байгаа хуулийн төсөл улс орны маань өнөөгийн болон алс ирээдүйн хөгжлийн хувь тавиланг зохих ёсоор тусгасан, ард түмнийхээ саналыг авсан, цаашдаа хөдөлмөрчид манай хүндэт депутатуудын оюун санааг соргоогоор тусгавал мөрдөж болох ийм хууль байна гэдгийг би депутатын хувьд үзэж байна. Энэ талаар Ерөнхийлөгчийн илтгэлд тодорхой дурдсан.

Тэгэхдээ улсынхаа хуулийг улам чанартай, сайн хууль болгох үүднээс би тойргийнхоо нийт хөдөлмөрчид, эрдэнэтчүүдээ төлөөлж хэдэн зүйлийг шүүмжлэлтэй ярьж гэж бодсон юм.

## 5.

Хамгийн нэгдүгээрт Үндсэн хуулийн төсөл боловсруулахдаа юуны өмнө манай ард түмнийхээ санал сэтгэлийг төдийлөн сайн тусгаагүйг энэн дээр хэлэх хэрэгтэй. Юуны өмнө хуулийн төслийг хэлэлцэж байхад манай ард түмэн улсынхаа нэрийг хэвээр байлгах, төрийн сүлд, далбааг бүгдийг хуучнаар нь байлгая гэсэн ийм зүйлүүдийг олон хүн гаргасан. Гэтэл өнөөдөр хуулийн төсөл дээр энэ санаа тусгагдаагүй, ер нь тусгасан гэсэн үгээр зарим хүмүүс тайлбарлан ярьж байна.

Хоёрдугаарт, хуулийн төсөлд манай улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, гадаадын хүмүүсийн харьяалалд түрээсээр өгөх тухай олон хүмүүс хилэгнэн ярьж байсан. Гэтэл өнөөдөр хуулийн төсөл дээр энэ мөн тусгагдчихаад, одоо зарим хүмүүс ярихдаа энийг дараа хуулиар зохицуулна гэж ингэж тайлбар өгч байх юм.

Гуравдугаарт, хуулийн төслийг хэлэлцэж байхад ард түмний ихээхэн санал сэтгэл үймж байсан нэг асуудал бол энэ олон намын тогтолцооны асуудлуудыг эргэж харж тусгах нь зүйтэй гэсэн ийм санал бас яригдаж байсан. Өөрөөр хэлбэл, өнөөдөр манай улсад тогтсон энэ олон намууд, энэ олон эвсэл, холбоодууд улс орны хүнд байдлыг өөд нь татаж, ард түмнийг энэ хүнд байдлаас гаргахад төдийлөн үр дүнгээ өгөхгүй байна гэдгийг шүүмжлэн ярилцсан асуудал ч гэсэн энэн дээр тусгагдаагүй байна. Ийм учраас би дараахь хэдэн саналыг энэн дээр оруулья гэж бодсон юм.

Хамгийн нэгдүгээрт, манай орны хөдөлмөрчдийн ихэнх нь сэтгэл санаа нь зовж байгаа, энэ чуулганы үеэр олон хүмүүс элдэв төрлийн хэлбэрээр өөрсдийнхөө саналыг илэрхийлж байгаа улсын нэр, хуулийн нэр, төрийн далбаа, тамга, энэ бүх зүйлүүдийг хэвээр нь байлгах энэ саналыг оруулж байна.

Ер нь энэнтэй холбогдож ярихад бид ерөөсөө урагшаа явъя гэж яриад байгаа. Төр засаг ч ярьж байгаа, түмэн олон ч ярьж байгаа. Гэтэл өнөөдөр ярихдаа ерөөсөө одоо бид нар чинь 1206

## 6.

оны үеэс юмаа эхлэх гэж яриад байгаа асуудал ирсэн, би эргэлзэж байна. Тухайлбал, ечигдрийн кинон дээр 1206 оны туг далбаанаасаа эхлэх гээд байгаа шиг бид өнөөдөр гараагаа стартыг одоо эндээс эхлэх юм уу гэдэг асуудал дээр эргэлзэж байгаа.

Хоёрдугаарт хуулийн төсөл дээр энэ газар түүний гол гол баялгуудыг төрийн өмч байлгана гэж төсөлд дурдаад энэ төрийн өмч болсон энэ гол ой мод, баялаг, ан амьтдаар гадаадын хүмүүст түрээсээр өгч болох тухай тодорхой бичсэн байгаа. Ингээд биччихсэн байхад зарим хүмүүс ярихдаа энийг хуулиар зохицуулдаг гэж ярьж байгаа. Ийм учраас би энэн дээр юу ярих гэж байна вэ гэхээр ерөөсөө миний нутгийн ариун хөрсөнд харийн хүн шигдэн хорогдож, миний нутгийн баялгийг харийн хүмүүс ашиглаж байх эрх байхгүй гэдгийг би энэн дээр хэлэх хэрэгтэй байна.

Гуравдугаарт би энэ төрийн байгууллагын тогтолцоон дээр хоёр гурван саналыг хэлье гэж бодож байна. Энэн дээр би олон намын системийн асуудлыг ч гэсэн эргэж харвал яасан юм бэ гэж бодож байна. Өнөөдөр албан ёсоор бүртгэгдсэн манайд 6 нам байна. Цаашдаа Баасангийн нам, Зоригийн нам гээд гараад ирэхээр нэлээн хэд болно. Гэтэл энэ олон намууд чухамдаа яг амьдрал дээр өнөөдөр ямар байдалтай байна вэ гэвэл ард түмний энэ тулгамдсан асуудал, энэ хүнд ачааллаас гаргах талаар тодорхой юм хийхгүй байна. Харин тэрэн дээр намууд хоорондоо маргалдаж, төрд асуудлыг тулгаж, ард түмний санал сэтгэлийг зургаа долоон хэсэг хувааж, ийм байдлаар энэ байдлыг хүндрүүлж байгаа учраас төрийн тогтолцоон дээр намын асуудлыг ч гэсэн эргэж харвал яасан юм бэ гэсэн ийм саналыг оруулж байна.

Дөрөвдүгээрт, төрийн тогтолцооны талаар хоёр зүйлийг ярьж гэж бодож байна. Манай энэ Их цаазын төсөл дээр ийм л байгаа юм. Ерөөсөө нэг болохоор зэрэг Ерөнхийлөгч бол Их Хурлыг тайлангаа Их Хуралд тавих болчихсон байж байдаг. Гэтэл ерөөсөө Их Хурал нь эргээд Ерөнхийлөгчийн ажилд хяналт тавина. Ийм хоо-

рондоо зохицолдоогүй ийм зүйлүүд байгаа юм. Энийг бас цаашдаа харж үзэж, ер нь энэн дээр Их Хурлын гишүүдийн тоог 100-150-иар болгож, хоёр танхимтай Ерөнхийлөгчийн засаглалтай ийм л байвал болох байх гэж ингэж бодож байна. Энийг цаашдаа бодох нь зүйтэй байх. Тэрнээс биш ерөөсөө ийм 76 хүн ингээд гараад ирдэг, хаана ч захирагддаггүй ийм байж таарахгүй.

Хоёрдугаарт, энэ Их Хурлын 76 хүн гэдэг чинь бол ерөөсөө ард түмнээсээ тасарсан, ард түмэн төр хоёрыг хооронд нь холбож чадахгүй нэг ийм л хэдэн хүн гарч ирнэ. Өнөөдрийн дөрвөн зуун гучин хэдэн депутат энэ тойрог, засаг төрийг хооронд нь бид холбож чадахгүй л явж байгаа. Гэтэл хүн нь, тоо нь цөөрөөд ирэхээр зэрэг бол байдал хүндэрнэ. Энийг бодож үзэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Хамгийн төгсгөлд нь би энэ хуулийн төсөл дээр хүний үүрэг тодорхой туссангүй, маш олон эрхтэй, үүрэг ерөөсөө байхгүй. Гэтэл өнөөдөр сахилга, хариуцлага ийм суларсан үед энэ үүрэггүй олон хүмүүс олигтой юм хийж өгөхгүй байхаа. Тийм учраас хүмүүсийн үүргийг маш тодорхой болгох нь зүйтэй гэсэн ийм юмыг би хэлж гэж бодож байна.

Хуулийн төсөлд ороогүй, би дээр хэлчих байсан даа, газар эзэмшлийн асуудал дээр ч гэсэн энэ ард түмний бухимдаж байгаа зүйл бол энэ Цагаачлалын хуулийн асуудал яригдаад байгаа. Энэ хуулийг ерөөсөө гаргах хэрэг байхгүй. Хэрэв гаргавал гадаадаас цагаачлал авах хэрэг байхгүй. Ийм юмыг ч гэсэн бас энэн дээр эргэж харвал яасан юм бэ гэсэн ийм санал байна. Хамгийн төгсгөлд нь нэг ийм санал байна. Энэ хавсралт илтгэлд байгаа юм, 1992 оны 6 дугаар сард сонгууль явуулъя гэж байгаа юм. Энийг би эсэргүүцэж байгаа юм. Яагаад эсэргүүцэж байна вэ гэвэл, өнөөдрийн энэ сахилга суларсан байдал, энэ эдийн засгийн байдал доройтож байгаа байдал, энэ ард түмний амьдрал доройтож байгаа байдал, өмч хувьчлал задарчихаад байгаа энэ олон асуудлуудыг зэрэгцүүлж хаячихаад, дээрээс нь энэ асуудлаа шийдээгүй сон-

гууль болоод ингээд явчих юм бол эдийн засаг босохгүй.

Өмч хувьчлалыг бужигнуулаад хаячихлаа. 1992 онд ид бужигнаж байна. Гэтэл одоо дээрээс нь дахиад сонгууль явуулах юм бол ингээд сонгуулиар засаг, төрийн байдалд өөрчлөлт орох юм бол энийг хариуцах эзэнгүй болно. Ийм учраас энийг ч гэсэн эргэж харууштай юм шиг байгаа юм. Ер нь ингээд цаашаа бас хараад үзэхэд монгол улс бол 2000 он хүртэл дагнан сонгууль хийдэг нэг ийм сонгуулийн орон болох юм шиг байна билээ дээ. Ийм учраас энэ сонгуулийнхаа тоо юмыг ч гэсэн хараад, энэ өмч хувьчлалын асуудал нэг жигдрээд, засаг захиргааны байгууллага нэг жигдрээд, энэ ард түмний бүхимдал жаахан намдаад, энэ хүнд байдлаасаа нэг жаахан гайгүй болоод ирэхэд нь сонгуулиа хийвэл юм юмны тохиролцоо нэлээн таармаар юм шиг байгаа юм.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*А. Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

ЗII дүгээр тойргийн депутат Л.Баяр:

Халалцэж байгаа төслийн ерөнхий рам, бүтэц, бүлгийг зөвшөөрч байна.Энэ раманд л халэлцэхээс өөр арга байхгүй.

Хоёрдугаарт, манай шинэ Үндсэн хуулийн хамгийн гол улс орны амьдралыг эргэлтийн шинж чанартай, өөрчлөх заалт бол энэ 5 дугаар бүлэг байгаа юм.Хэдийгээр хүний эрх, ардчилал, тусгаар тогтнол энэ бүхэнд суурь болох үндэстэй хувийн өмч оролцоо, өмчийн бүх хэлбэр, хүдээн зөвшөөрөгдөж дэлхий нийтийн жишигт, жам ёсонд нийцсэн ийм хөгжлийн эдийн засгийн замд орох нь гарцаагүй байна.Гэхдээ үүнийг хүлээн зөвшөөрч батлах нь иргэний ардчилсан нийгмийн эдийн засгийн дүр төрхийг одоо төсөөлж бүрэн чадахгүй байгаагаас хамаарахгүйгээр ингэхээс өөр арга байхгүй гэдэгт л тулгуурлаж байна.Үүнийг нийтээрээ нухацтай хэлэлцэж шийдэх хэрэгтэй юм.Энэ бол тэр хуулийн нэрийн тухай асуудал, улсын нэрийн тухай асуудлыг бодох юм бол харин бүр тулгын чулуу асуудал юм.Бид ойлгож байна.Эрхээ баталгаажуулах, амьдралын баталгаа бий болгох, энэ бүхэн бол асар өргөн хүрээгээр тусгагдлаа ч гэсэн хэрэгжүүлэх болохоор зэрэг мөнгөтэй очоод л тулчихна гэдгийг.

Тэгэхээр хүний амьдрах эрхийн баталгаа, хүний эрхийн баталгаа эцсийн эцэст үндсэн хуулиндаа түүнийг хэдий хэр өргөн тунхагласнаар биш, түүнийг хэрэгжүүлэх, эдийн засгийн баталгаа өөрөөр хэлэх юм бол нийгмийн материал баялгийг үйлдвэрлэж чадах, чадвараас хамаарах нь ээ.Тоймлож ойлгох юм бол мөнгөнөөс л хамаарах нь ээ.Ийм эргэлтийн шинжтэй энэ тулгуур асуудлыг ухамсартайгаар зөвшөөрөн батлах хэрэгтэй байна.Сүүлд нь үүнийг ач холбогдлыг нь дутуу ойлгож, ухамсар муутай батлах юм бол энэ дээр очоод ихээхэн хариуцлагатай асуудалтай тулгарна. Үүнээс өөр зам байхгүй.Гэхдээ л ухамсарлаж байж батлах хэрэгтэй.



Хоёрдугаарт, шинэ үндсэн хуулиа хэлэлцэж батлахдаа хэдийгээр бүх ард түмний санал асуулга явуулж, санал аваагүй боловч бүх ард түмнээр хэлэлцүүлж байх явцад ирсэн саналыг санал асуулга явуулсны дайтай ач холбогдол өгч, санал асуулгаар нийт ард түмнээс гарсан саналын олонхи байж магадгүй гэдэг талаас нь харгалзаж үзэж тусгах нь зүйтэй юм.

Наад талаасаа хар харагдаж байгаа, тэнд харагдаж байгаа хонь бол, /тэнд харагдаж байгаа/цаад тал нь хар л байх нь магадлал ихтэй байдаг. Монгол хонь, монгол хун л харж байгаа бол. Ийм учраас үүнийг олонхийн санал нь нийт ард түмний санал асуулга явуулсны олонхийн санал байх магадлал илүү байгаа учраас ингэж л авч үзэхээс өөр арга байхгүй ээ, манай депутатууд Их Хурал. Энэ нь ард түмнийг төрийн эрх барих, төрийн хууль тогтооход, сонгосон депутатуудаараа дамжуулж оролцох буюу өөрснөө саналаа шууд хэлж орох гэсэн энэ ардчиллын Үндсэн хуулиндээ бидний тунхаглах гээд байгаа, урьд нь тунхаглаж байсан энэ үнэнийг бодит байдал болгож байгаа хэрэг юмаа.

Гуравдугаарт нь, Үндсэн хуулийг манай монгол улсынхаа тусгаар тогтнолын баталгаа болох нь уу? үгүй юу гэдэг шүүлтүүрээр сайтар шүүх хэрэгтэй юм шиг байна. Ингэж үзвэл газрыг хувьд өмчлүүлэх тухай асуудал, гадаадын хүнд түрээслүүлэх тухай асуудал дээр ихээхэн болгоомжтой хандах хэрэгтэй. Газрыг хүнд өгөх амархан, эргүүлээд авах бол хэцүү. Манайхаас илүү ардчилал хөгжсөн, эдийн засгийн хүчтэй, том том орнууд энэ газраа өгчихөөд түрээслүүлчихээд авч чаддаггүй тухай асуудал хэвлэл дээр явж байх юм байна. Манайх өгөх бол амархан, авах хэцүү.

Монгол улсын газар нутаг л юм бол захаасаа алга дарам цөмрөх ч адилхан, голоосоо алга дарам өмрөх ч адилхан шүү. Улаанбаатар төв суурин газрын газар монгол улсын газар, хилийн овооны наад талд байгаа газар ч монгол улсын газар. Энэ утгаараа бол энэ дээр нэлээн бодлоготой хандах, миний санал бол газрыг монгол улсын уугуул харьяат иргэндээ өмчлүүлсэн

шиг адилхан нөхцөлөөр шахуу түрээслэх саналтай байгаа. Энэ тусгаар тогтнолын шуултуурээр шуугээд үзэх юм бол хүний эрхийн асуудал дээр ч гэсэн анхаарч үзүүштэй юм байна.

Жишээ хэлэхэд 16-гийн 2-т, гадаадаас монголд цагаачилж ирсэн иргэнд эрхийг олгохдоо, монголоос гадаад оронд цагаачилж очсон, тэр оронд очсон иргэнд өгсөн иргэнд өгсөн эрхийг л өгнө гээд байгаа юм, тэнцүүлж, хэрвээ манайхаас цагаачилж очсон иргэнд тэр орон буу зэвсэг үйлдвэрлэх эрх өгсөн байвал тэндээс ирсэн иргэнд, цагаачинд буу зэвсэг үйлдвэрлэх эрх л өгөх нь, энэ мэтчилэнгээр тэндээ хэрэгжихэд, тэндээ тусгаар тогтнолд нь акулгүй мөртөө энд болохгүй тийм бодож үзүүштэй юмнууд байх юм биш үү. Үүнийг энэ 16-гийн 2 дугаар заалт бол ийм бүтэхгүй болов уу гэсэн санал байна.

Дараагийн нэг санал бол тэр засгийн бүтэц, зохион байгуулалтын тухай саналбайгаа юм. Одоогийн бидний энэ явуулаад байгаа нэрнээсээ сонгогддог хоёр шаттай, нэг танхимтай энэ хэлбэр маань ойрын хэдэн жилдээ ирээдүй байна, одоогийн нөхцөл байдалд үүнээс нэг их үсэрч, шууд ганц танхимтай сонгодог хэлбэр рүү орох нь цаг үеэ ойлгоогүй ийм шийдвэр болох болов уу гэсэн санал байна.

Үүний үндэслэл нь бол манай хууль тогтоогчид тэр, гүйцэтгэн захирамжлах ч тэр, ер нь дээд тэр засгийн байгууллагууд, ард түмнээс бодит амьдралаас ер нь жаахан тасрах гээд байдаг гэм манай онцлог байх байдаг. Үүнийг засах гол арга бол одоогийн энэ хоёр шаттай нэг танхим байгаа юм. Үүнийгээ ажиллуулах механизмыг улам боловсронгуй болгох хэрэгтэй юм шиг байгаа юм. Ард түмэнтэй холбодог байдал, Бага Хурлаа холбодог, Их Хурлыг ашиглах хэрэгтэй байна. Бид шийдвэр боловсруулахдаа Их Хурлын саналыг, ард түмний саналыг Их Хурлын гишүүнээр, одоогийн депутатуудаар дамжуулж хурдхан авах хэрэгтэй байна. Үүнийг шийдвэртээ тусгах хэрэгтэй байна. Ингээд Их Хурлын депутатуудын тоог боломжтой хэмжээгээр цөөлж, Бага Хурлынхыг ч гэсэн, энэ

одоогийн бүтцээр нь байлгах саналтай байна. Шүүх эрх мэдлийн тухай асуудал бол ихээхэн бүдэг байгаа. Үүнийг уншаад, уншаад учир тийм сайн ойлгогдохгүй байгаа. Хоёр шүүх байгаа, хоёр шүүх эрх мэдэлтэй юм шиг байгаа юм.

Ж.Уртнасан: Таны цаг дуусч байна.

Л.Баяр: Ер нь эцэст нь хэлэхэд шүүх засаглал бол нэг л юман дотроо байх хэрэгтэй. Үндсэн хуулийн цэц нь дээд шүүхийнхээ бүтцэд байх нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна.

286 дугаар тойргийн депутат Д.Чулуун:

Одоогийн бидний хэлэлцэж байгаа энэ төслийнхөө талаар сонгогчдоосоо санал хүсэлт авлаа. Тэгэхээр тэд нар маань өмнө нь бидний хэлсэн саналыг энэ төсөлд тусгалт муу байнаа гэдгийг хэлээрэй гэсэн энэ үгийг хэлэх хэрэгтэй байна.

Гэхдээ нэгэнт ард түмний санал бодлыг авч хуульд тусгаж байгаа болохоор давхардсан ч гэсэн сонгогчдынхоо санаа бодлыг илэрхийлье гэж бодож байна.

Тэдний маань санал бодол янз бүр байна. Гэхдээ олонхийн давамгайлсан саналаас ярья. Монгол улсын нэрийн хувьд хуучин хэвээр, Үндсэн хуулийн хуулийн нэр бол хуучин хэвээрээ. Хэрвээ Үндсэн хууль гэж нэрлэхгүй юм бол Их засаг<sup>хууль</sup> гэсэн нэрээр нэрлээрэй гэсэн ийм захиасыг өгч байна.

Газрыг гадаадын иргэдэд түрээслүүлэхийг бол ердөө зөвшөөрөхгүй байна. Төрийн сүлд, далбааны хувьд хуучнаар нь байлгаарай гэсэн энэ саналтай байгааг илэрхийлж байна.

17-гийн 8-д оршин суух газраа өөрөө сонгох эрхтэй гэсэн сайхан заалт орсон. Гэхдээ алс бөглүү, хөдөө суманд хошуунд ч юм уу мэргэжлийн хүмүүсүүд, ялангуяа эмч, багш нар хэр зэрэг

очиж ажиллах дуртай байдаг бол? Үүнийг зохицуулах талын тийм тогтолцоо бас цаашид гаргаж өгөх байх гэж бодогдож байна.

Иргэний үүрэгт миний санахад хөдөлмөрлөх үүргийн талаар оруулмаар бодогдож байх юм. Одоогийн байдлаар ямар ч тийм хөдөлмөр хийхгүйгээр материаллаг баялаг, бүтээхгүйгээр л хөнгөн амьдралтай яваад байвал, энэ эх оронд маань хэн нь юуг бүтээх, жинхэнэ улсаас хараат бус амьдрах билээ гэдэг талыг бас бодолцооор байна.

Парламентын бүгд найрамдах улс байна гэж бодогдож байна. Гэхдээ хоёр танхимтай, Их Хурал нь 100-гаад гишүүнтэй, Бага Хурал нь 30--40 гишүүний хооронд ингэж ажиллавал ямар вэ гэсэн бодолтой явдаг юмаа. Сонгогдох хугацаа бол 4 жил. Ерөнхийлөгчийн нас 50 гэж орсон байгаа. Арай ч өндөр нас юм шиг, 40-өөс дээш настай гэж оруулбал зүгээр санагдана.

Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн таалал төгсөхгэдгийг оруулмааргүй байна. Арай өөр байдлаар оруулбал ямар юм бол доо гэж бодогдож байна.

Шүүх эрх мэдлийн талаар манай сонгогчдоос мэргэжлийн хүмүүсүүдээс бас нэлээд саналуудыг хэлж байсан. Үүнээс би хэлье гэж бодож байна.

Тэнд Дээд шүүхийн шийдвэр, хуульд харшилбал түүнийг Дээд шүүх өөрөө хүчингүй болгоно гэсэн нь тийм ойлгомжтой биш санаа юм. Нэлээн бодож үзүүштэй санаа юм байна.

55-ын 3-т мэргэжлийн 10-аас доошгүй жил ажилласан гэдгийг мэргэжлийн шүүхэд, шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан гэж оруулах нь зүйтэй болов уу гэж бодогдоно.

Өөр нэг юм бол шүүх үйл ажиллагаанд иргэдийн төлөөлөгчдийг оруулна гэсэн байгаа. Гэхдээ одоогийн байдлаар энэ нөхцөлд ардын төлөөлөгч нь тэр шүүх ажиллагаанд идэвхтэй бус

байдлаар аялдан дагалдах байдлаар оролцдог. Тэгэхээр иргэдийн төлөөлөгч нь байх нь хэрэгтэй юм уу? аль эсвэл мэргэжлийн 1-2 шүүгч уг хэргийг хянаж үзэж байх нь хэрэгтэй юм уу гэдэг талаар бас бодолцох нь зүйтэй гэсэн тийм саналтай байна.

Засаг захиргааны нэгжийн хувьд бол аймаг, сум, багийг хэвээр нь байлгах нь зүйтэй гэсэн тийм сонгогчдын санал давамгайлж байна. Хошуу болсноороо энэ нөхцөлд, одоогийн байдалд хямралаас түргэн гарах арга замд нөлөөлөхгүй байхаа. Харин цаашдаа хошуу болж болох юмаа гэсэн ийм бодолтой байна.

прокурорын хяналтын ерөнхий хяналтын үйл ажиллагаа тусгагдаагүй байгаа их цаазын төсөлд үүнийг бас цааш нь бодуштай зүйл юм болов уу?

Мөн прокурорт насны талаар бас бодолцох нь зүйтэй юм уу? гэсэн тийм санал байна. Ингээд бүлэг бүрээр нь ярих үед цаашдаа саналаа хэлнэ.

Ж. Уртнасан: Өчигдөр тохирсон ёсоор энэ голоор сууж байгаа улсуудад төв микрофон буюу, 9 дүгээр микрофон нээж байгаа. Депутат Очирхүү.

17 дугаар тойргийн депутат Т. Очирхүү:

Баярлалаа. Тэгэхээр ийм юм байна. Ерөнхий санал шүүмжлэл тавих шаардлагагүй гэж би түрүүн санал гаргаж байсан. Түүн дээрээ өчигдрөөс хойш ер нь зүйтэй байжээ гэж бодож байна. Миний хувьд бол одоо хэлэх үг алга. Тухайн зүйл анги, бүлэг дээр очиж өөрийнхөө үзэл бодлыг хэлээд, тэгээд цөөнх болбол тэнд Үндсэн хуульд өөрийнхөө үзэл бодлыг өөрийнхөө томъёоллыг тодорхой хэлж оролцох нь илүү үр дүнтэй гэж бодож байна.

Ийм учраас ингэсхийгээд ерөнхий шүүмжлэлээ зогсоогоод зүйл бүлэг бүрээр тодорхой яриад явбал одоо илүү үр дүнтэй гэсэн саналаа, горимын шинжтэй саналаа дахин хэлж байна.

II дүгээр тойргийн депутат Ж.Бямбаа: Их цаазын төсөл дээр уншиж үзэхэд ер нь одоо энэ депутатуудын энэ ерөнхий шүүмжлэл дээр яриад байгаа зөрөөтэй саналуудаас бусад зүйлүүд нь зүйлчлэл, бүлэглэлээр нь хэлэлцсэн тохиолдолд болохуйцаар, хүлээж авахаар нэлээн жигдэрсэн ийм боломжийн сайн төсөл гарсан байна гэж хувьдаа үзэж байна. Энд Бага Хурлынхан үнэхээр их ажиллажээ. Ингээд үгээ хэлье.

Өнөөдөр ер нь Монголд, монгол биш тийшээгээ явж байгаа. Энэ бол юунаас болоод ийм болж вэ гэхээр эрчүүд бүхэн нь хутгатай явдаг мөртөө хүний урдаас хутганы үзүүр харуулж яваагүй монголчууд, мал адгуус байтугай, нэг нэгийгээ алах хутгалах бол наад захын хэрэг болжээ.

Хоёрдугаарт монголчууд архинд маш их хэмжээгээр автагджээ. Ах зах, эцэг, эхээ хүндлэхээ больжээ. Ажил хөдөлмөрт бол дургүй хүн элбэгтэй болжээ. Энэ бүхэн юунаас болов гэхээр шашнаа хаясан, монгол бичгээ хаясан хоёроос болсон байна.

Шашнаа хаяснаас болж, нигүүлсэх сэтгэлээ гээсэн, хайрлах сэтгэлээ гээсэн, газар дэлхийгээ хайрлахаа байсан, хүн хүнээ хайрлахаа байсан, үүний нүх цоорхойг мөн өөрийн ц зан заншил, шашин суртлаа хаясан, оросын коммунизмын тэр эвдэрсэн хүмүүсийн юунаас адилхан манай нөхөд экспортын маягаар орж ирж монгол хүний зан заншил эвдэрсэн байна.

Гуравдугаарт, монгол бичгээ хаяснаас түүхээ мэдэхээ байсан, соёлоо мэдэхээ байсан, ингээд зан заншлаа мэдэхээ байсан, ийм бэрх байдалд хүрчээ. Ийм учраас өнөөдрийн бидний байдлаас ч харсан, цааз гэдэг үгийг толгой авах утгаар нийт хүмүүс ойлгодог болсон явдал ч бас үүнтэй холбоотой юм.

Ингэж ойлгосон хүмүүсийн буруу бишээ. Энэ орчуулгын юугаар аваачаад, цаазаар аваач гэдгийг цаазлах гэж ярьсаар байгаад

ингээд энэ үгнээс хүн жигшихээс аргагүй, өнөө үеийнхэн ийм болсон. Үүнийг үгүйсгэхгүй.

Ингээд монгол болохын тулд, бид бол өнөөдөр улс орноо гадаадын орнууд манайхыг одоо ямар Үндсэн хууль гаргаж ирэх нь вэ? ямар улс болохыг харж байна. Түүнээс гадна Тува, Халимаг, Буриад, Өвөрмонгол, Уйгар, Шинжааны торгууд, Хөх нуурын монголчууд гээд, бүх монгол туургатнууд өнөөдөр биднийг манай орныг ямар байхыг харж байна. Тэр ч байтугай одоо төвдүүд ч харж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Иймээс би жинхэнэ ардчилсан, их гүрний дарангуйллаас бүрэн салсан, дэлхийн олон улсын холбоонд нэгдэн орсон мөнхөд оршин тогтнох, хойч үеийн үеийнхний эзэн суух ийм цаг үеийн, мөн түүхэн салхи таардаг юм бол монгол туургатнууд нэгдэх завшаан олдсон цагт нэгдэж болох тэр үеийн хойч хойчид олон зуунаар үргэлжлэх ийм үндсэн хуулийг батлах ийм хувь заяа бидэнд оношгджээ. Ийм учраас депутат бүхэн үүнд маш нухацтай хандаж байгаа нь ойлгомжтой байна.

Монгол улс гэж нэрлэвэл яасан юм бэ гэдэг ийм саналтай байгаа. Бидний өвөг монгол улс бол хүннү байсан. Хүннү бол Хүннү улс гэж явж, Чингисийн үе ч монгол улс нэртэй байсан. Мөн II оны Үндэсний хувьсгалын дараа ч монгол улс байсан. 21-24 он хүртэл монгол улс байсан. Ингээд гадны хатгаас явуулгаар Бүгд найрамдах монгол ард улс гэж бүгд найрамдах гэдэг республик гэдэг үгийг нэмж гаднаас орж ирсэн ийм нэр томъёотой болжээ.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

Ч.ЧУЛУУНШЭЦЭГ

1991.11.16.  
Кассет № Ш.3.  
10.48-10.55.

-Үүнтэй уялдан

Монгол улс гэж нэрлэвэл сүлд, далбаанд мэдээж ямар нэгэн засвар хийх хэрэгтэй юм. Тиймээс тодорхойлолтыг нь сонсоход тийм ч их хөрөнгө гармааргүй юм. Тэхээр бид хойч ирээдүйгээ бодож улсын нэр, сүлд зэргийг зоосны нүхээр харах биш, ирээдүйгээ бодож хандвал зүйтэй юм биш үү гэсэн бодол төрж байна. Гэхдээ сүлд дээр уриалаад байгаа шонхор шувуу нь үнэхээр Чингисийн далбаан дээр шонхор шувуу байсан уу, үгүй юу гэдэг нь нотлогдохгүй байгаа шүү дээ.

Түүнээс гадна өнөөдөр энд сууж байгаа депутатууд ухааны хомсдолтой хүмүүс гэж яруу найрагч Бадарч хэлсэн. Тэхээр ухааны хомсдолтой 430 хүн сонгосон монголын ард түмэн цаана нь бас давхар доромжлогдож байна гэж бодож байна.

Сүлд дээр морь байх нь зүйтэй. Монгол морь нь дэлхийг эзэлсэн морь, хоёр дахь удаагаа европ орсон ийм дөрвөн хөлтэй адгуус дэлхий дээр байхгүй. Надад энд ийм санал байна.

Мөн Ерөнхийлөгчийн засаглал байвал яасан юм бэ гэсэн санал байна. Яагаад ингэж байна вэ гэвэл Засгийн газар, Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн тамгын газар, мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын Бага Хурал, Бага Хурлын тамгын газар гэсэн маш олон газрууд бий болоод, хуучин орон тооноосоо хоёр, гурав дахин нэмэгдсэн.

Депутатын хувьд гэвэл 150 депутат байгаад, гурав, дөрвөн сумын дундаас нэг, аймгийн төвөөс нэг, олон хүнтэй хотуудаас 20 мянган хүнээс нэг байвал яасан юм бэ гэсэн саналтай байна.

Бурхны шашин нь монголын гол шашин байна гэдгийг Үндсэн хуулинд аа оруулъя. Монгол бичиг Монгол улсын албан бичиг байна гэдгийг мөн оруулъя гэсэн саналтай байна. Үүнд заавал хугацааг заах алба бидэнд байхгүй.



Улаанбаатар хотын тухайд орон сууцны хороололд 20 мянган хүнд нэг хороо, гэрийн хороололд нөхцөл байдлыг харгалзан 10 мянган хүнд нэг хороо гэж бодож хороонуудыг байгуулах саналтай байна.

Би үгээ минутандаа багтааж хэллээ. Монгол бичгийн ардын хүрээлэнгээс надад цагт орохгүйгээр даалгавар ирсэн байна. Үүнийг депутат нөхдүүддээ сонгож өгөөч гэсэн хоёр хуудас юм байна. Үүнийг хоёрхон минут унших юм байна.

БНМАУ-ын төрийн далбааны төсөл, загварын тайлбар. Манай оронд улс төрийн тогтолцоо, эдийн засгийн хэвшил үндсээрээ өөрчлөгдөн, шинэчлэгдэж байна. Ангич байр сууринаас хандаж, бусдыг хуулбарлан дууриаж бүтээсэн төрийн бэлэгдэл, сүлд, далбаа шинэчлэгдэх учиртай боллоо гэдгийг ойлгож байна.

Олон зуун жилийн түүхтэй төрт ёсны их уламжлал, Монголын ард түмний соёл, эрцэм, зан заншил, аж төрж амьдрах монгол ухааны шилдэг сайн бүхнийг сэргээн авч Монгол улсаа мандуулъя хэмээн сэтгэл зориг нийлүүлэн Их цаазын бичгийг БНМАУ-ын Ардын Их Хурлаас батлах гэж байгаа энэ бүхнийг бодолцож төрийн далбааны талаар өөрийн санал, төсөл загвараа та бүхэнд танилцуулахыг хүсч байна.

Төрийн далбааны дэвсгэр хөх байх нь ард түмний санаа, сэтгэл нийлэмжтэй байх гэж санаж байна. Мөнх хөх тэнгэрийн дор мянга, мянган жил нүүдэллэн амьдарч, даян дэлхийд хөх тугт Монгол Чингисийн Монгол, Хөх Монгол гэж нэрлэгдсэн бид үнэхээр байгалаас хайрласан хөх тамгатай улс билээ. Энэ бүхнийг харгалзан хөх өнгийг сонгосон юм.

Монголчуудын төрт ёсны уламжлалыг бэлэгшээж, эзэн Чингисийн ёсөн хөлт цагаан тугийг ёсөн цагаан зурвасаар төлөөлж далбааны гуравны хоёрын зайг эзлүүлэн баруун хэсэгт байрлуулав. Одоогийн далбааны хөх, улаан, шар өнгө шинэ далбаанд уламжлагдлаа.

Ардын Их Хурлын 41 дүгээр тойргийн депутат Н.Пүрэвдорж: Тэгэхээр би сая ерөнхий хэлэлцүүлгийн явцад нэг л зүйлийг өөрийнхөө сэтгэлээр мэдэрч, ойлголоо. Нийт депутатуудын гол санаа зовж байгаа асуудал бол Их цааз гэж бид хэлэлцэн баталж шийдвэр гаргаснаар эх орны хувь заяа, аюулгүй байдал хаашаа явах гэж байна вэ гэдэг ганцхан асуудал дээр анхаарал төвлөрч байна. Тэгэхээр бид бол аливаа шийдвэр гаргахын өмнө хариуцлагатай шийдвэр гаргахын өмнө өнгөрснөө ганцхан өгүүлбэрээр бодох ёстой л доо. Энэ асуудал дээр. Бид боолын нийгмийн алгасаад, капиталист нийгмийг алгасаад коммунист нийгэм уруу харайж яваад өнөөдөр хар ангал нүх уруу ойччихоод сууж байгаа. Дахиад өнөөдөр ямар үе явагдаж байна гэвэл хуучин ойлголтоороо бол социализмаас капитализмд шилжих шилжилт огцом бий болж байна. Энэ юу гэсэн үг вэ гэхлээр энэ огцом шилжилт чинь бид, энэ Их цаазыг баталснаар бид эх орноо ямар муу үр дагавар гарах уу, ямар сайн үр дагавар гарах вэ гэдгийг депутатууд маань ул суурьтай хэлэлцэж байна гэж бодож байна.

Бид огцом харайж болохгүй. Зүгээр одоо Их цаазын төслийг товчхон дүгнэж хэлэх юм бол өндөр хөгжилтэй, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник технологийн хувьд асар өндөр хөгжилтэй орнуудын хуулийн заалтуудыг нэлээд оруулчихсан байсан, энэнийг бол анхаарах ёстой. Ер нь нийт депутатуудын саналыг ингээд бодоод үзэхэд хэдэн асуудал дээр анхаарал төвлөрөөд байна. Эх орны хувь заяа, аюулгүй байдал юунээс хамаарах вэ гэхлээр нэг хүний гарт Засгийн эрхийг төвлөрүүлж өгөж үү эсвэл Засгийн эрхийг хорь гучин хүний гарт олгосноор эх орны хувь заяа зөв буруу шийдэгдэх үү, эсвэл Засгийн эрхийг 120-150 хүний гарт төвлөрүүлвэл бид зөв зам дээр зогсож чадах уу гэдэг энэ дээр л төвлөрөөд байх шиг байна. Тийм учраас Их цаазын Цэцийн гол асуудлууд дээр тун нухацтай хэлэлцэх нь зүйтэй. Чухам бид хаашаа явах гээд байгаа юм бэ. Энэнийгээ ойлгох хэрэгтэй байна л даа. Их цаазыг батлан гаргаснаар бид хаашаа

Соёмбо бол Монголчуудын төрийн сүлд, тусгаар тогтнолын бэлэгдэл болж ирснийг үгүйсгэх нь үнэн байдалд үл нийцэх бөгөөд ард түмний нэн эрхэмлэдэг соёл эртний тэмдэг мөнөөс мөн билээ. Ийм учраас төрийн сүлд соёмбыг төрийн далбаанд алтан шаргал өнгийн гал, наран, саран гурваар төлөөлүүлэн, далбааны ишин талын дээд хэсэгт тавилаа.

Чингис хааны бэлэг сургааль, улс юугаан хайрлагтун!  
 Алд биеэ амарсу хэмээвээс ахуй төр минь алдруузай!  
 Бүтэн биеэ амасу хэмээвээс бүрэн улс минь алдруузай!  
 Алд биеэ амасу алжаат хэмээвээс ахуй төр минь бүү алдартугай!  
 Бүтэн биеэ зовоовоос бүрэн улс минь сандруузай хэмээвээс  
 бясалган бодож их хааны ахуй төр мину хэмээвээс улс юугаан хайрлах гүн их санаадралыг энэ үгэнд залбирал болгон үлдээж байна.

Ахуй төр мину гурван үгийг монгол үсгээр бичгийн учир гэвэл эртний их соёлоо уламжлахын санаа, түүнийг улаан өнгөөр ялгах, цаад санаа нь манай ард түмний оюун санаа, эрдэм чадал, галын дөл мэт хурц тод, гэрэлтэн бадрахын бэлэгдэл болно гэж үзэж байна. Төрийн далбаа, шинэ загварыг боловсруулж бүтээвэл өчүүхэн төдий санаа, агуулга байж магадгүй хэмээн та бүхний мэргэн оюунд өргөн толидуулъя. Монгол бичгийн Ардын хүрээлэнгийн ерөнхийлөгч, профессор Түмэнбаярын Дашцэдэн гэсэн байна. Ийм юм ирүүлсэн байна.

Ж. Уртнасан -Завсарлага 20 минут, хоёрдугаар микрофон дээр Пүрэвдорж үг хэлэхэд бэлтгэж байгаарай.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн



Ц. БАЯРМАА

Бичээч

С. ТУУЛ

2.

явах гээд байна. Том ангал дээгүүр харайгаад лунц нь ойччих гээд байгаа юм уу, өндөр хөгжилтэй техник технологийн түвшинтэй орнуудыг дуурайж байгаад, машинтай, хөрөнгөтэй улсуудыг цагаж яваад хөрөнгө мөнгөгүй, ядуу улсууд чинь тэгээд ходоод нь гүйцэхгүй шүү дээ. Ингээд байгаа юм уу, эсвэл бид үнцэснийхээ онцлогт тохирсон тийм онолын үндсэн дээр энэ Их цаазаа боловсруулах гээд байгаа юм уу гэдэг чинь бас зүйтэй асуудал. Хэд хэдэн тодорхой асуудал тавья. Хаашаа явах фээд байна гэдэгт.

Тэгэхээр Засгийн эрх бол одоогийн Их цаазын төсөлд хэд хэдэн гол үндэслэлүүдийн гарт төвлөрсөн байна.

Нэгдүгээрт, Ерөнхийлөгчийн гарт. Яах вэ энэ дээр ёс төдий ерөнхийлөгч гээд тунхаглачихсан байна л даа. Тэгэхдээ цаад агуулга, утга санаа, зорилгоороо бүр анхааралтай бодоод үзэх юм бол.

Хоёрдугаарт, шүүхийн гарт.

Гуравдугаарт, Их Хурлын гарт.

Дөрөвдүгээрт, Засгийн газрын гарт ч байдаг юм уу.

Тавдугаарт, Их цаазын гарт. Тэгэхээр энэ чинь яах вэ гэхлээр бид өнөөдөр зөв тогтолцоогоо бүрдүүлж чадахгүй юм бол зөрчилтэй засгийн тогтолцоог бий болгочих юм бол харин Үндсэн хуульд маань өөрчлөлт оруулах болохлоор дараа нь бүр зөрчилтэй заалтууд хямралын үед их орох болно. Тэгэхлээр өнөөдөр бид тогтолцоон дээр анхаараад байдаг чинь гол асуудал л даа. Тэгэхээр энэнийг ойлгож байгаа юу үгүй юу гэвэл депутатууд бол ойлгоод байна. Энэ заалтыг та бүхэн анхааралдаа аваачээ. 68 дугаар зүйл. Их цаазад нэмэлт өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Их цаазын Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ юу гэсэн үг вэ гэх-

## 3.

лээр Их цаазын Цэц чинь нөгөө Улсын Их Хурлын дээр чинь 9 хүн чинь гараад ирчихсэн байна гэдгийг ойлгоочээ. Хуучин бидний хэлцгээр хуучин улс төрийн товчоо гараад ирсэн гэдгийг ойлгож байна уу үгүй юу, бид ойлгох ёстой байна. Тийм учраас ингэж засгийн эрх мэдлийг хуваарилах асуудлаас би татгалзаж байна. Аяндаа дээд, доод танхимтай болчихлоор бодлого боловсруулдаг дээд танхим, хяналт шалгалт явуулдаг дээд танхимд бол аяндаа тэр хуулиа батлах, хуулиндаа нэмэлт, өөрчлөлт оруулах эрх нь байна шүү дээ. Тэгэхгүй бол Их цааз яах вэ гэхлээр Их Хурлын гишүүнийг чиний оруулсан санал чинь Их цаазад харшилж байна гээд ингээд байна. Миний оруулсан санал Их цаазад харшилж байгаа учраас бид энэ Их Хуралд чинь оруулахгүй гээд ингээд байж магадгүй. Тэгэхээр энэ аюултай зүйл л дээ. Хэрвээ өнөөдөр Их цаазын гарт Засгийн эрх бүрэн төвлөрчих юм бол яах вэ гэхлээр Засгийн газрын шийдвэр чинь Их цаазад харшилдаад байна шүү. Засгийн газрын үйл хэрэгт оролцож эхэлнэ. Дараа нь Ерөнхийлөгч өө таны гаргасан зарлиг чинь Их цаазад харшилдаад байна. Ерөнхийлөгчийн дотоод асуудалд оролцож эхэлнэ.

Дараа нь Их Хурлын гишүүний бүрэн эрхийг зөрчиж эхэлнэ. Их Хурлын гишүүн нөхөр! Таны гаргасан шийдвэр чинь Их цаазын, одоо Их цаазад харшилдаад байна гээд. Тэгэхлээр юу юу болох вэ гэхлээр есөн хүний гарт Засгийн бүрэн эрх төвлөрөөд улс орныг бол хааш нь ч эргүүлж болох ийм айхтар аюултай байдалд тулгарчихаад байна. Харин бүр Их цааздаа юмуу эсвэл хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж байх ёстой эрх бүхий хүмүүсийн эрх нь хязгаарлагдчихаад байна. Зарим депутатуудын яриад байгаа нь үнэн. Хүний эрхийг тунхаглаад заачихсан мөртлөө хүний жирийн иргэн битгий хэл, Ерөнхийлөгч, Засгийн газар, тэр Их Хурлын гишүүдийн чинь эрх чинь баталгаажаагүй байна шүү дээ.

Тэгэхээр ийм ийм бодлогын асуудлыг анхаараачээ. Бодлого, Их цаазын гол, өнөөдрийн ерөнхий хэлэлцүүлгийн асуудал бол энэ хуулин дотор ямар бодлого явагдаад байна. Нэг хэсэг бүлэг

## 4.

хүн засгийн эрхийн төлөө тэмцэл хооронд явагдаад байна уу, эсвэл засгийн эрхийг чинь ард түмний төлөө зөв тогтолцоонд бий болгох гээд байна уу, энэ асуудлыг тун хариуцлагатай бодоочээ. Эх орны хувь заяа, эдийн засгийн аюулгүй байдал бол эцсийн эцэст хэрхэн зөв тогтолцоо тогтоохоос хамаарна. Өөр юунээс ч хамаарахгүй. Зарим улсууд хэлж байсан. Мафи гарах үндэслэл бий болчихоод байна шүү гэж. Тэгэхээр энэ үндэслэл байгааг байгаа юм. Яагаад вэ гэвэл манай эдийн засгийн хямрал асар хурдацтайгаар шинэ системд орж байна. Нөгөө талаас асар хурдацтайгаар унаж эхэллээ. Эдийн засгийн шинэ тогтолцоо, шинэ хуулиудийг бий болгож чадаагүй байна. Тэгэхээр хэсэг бүлэг хүний гарт засгийн эрх төвлөрвөл бас ямар аюул байх вэ? ийм зүйл байна. Гол санал бол ерөөсөө хоёр танхимтай тогтолцоонд шилжихээс бид нарт өөр арга байхгүй. Хэрвээ эх орноо зөв хөгжүүлбэ гэж бодож байгаа бол. Бусад асуудлын талаар тодорхой зүйлүүд дээр саналаа өгье.

Ардын Их Хурлын 59 дүгээр тойргийн депутат Ч. Пүрэвдорж:  
 Улсын Бага Хурлын өргөн барьсан Үндсэн хуулийн шинэ төсөл-Их цаазыг аваад үзэхэд бол ардчиллын замаар явах, бидний эргэж буцахгүй ардчиллын замаар явах, хамгийн гол нь хүнийг төвдөө тавьсан, хүний эрх чөлөө, эрхийг тунхагласан ийм Үндсэн хуулийн төсөл болсноороо бол энэ үнэхээр сайн зүйл болжээ. Энэнээс бид ухрахгүй. Энэ бол олон улсын нийтлэг зүй тогтол, өнөөдөр зах зээлд шилжсэн сонгомол хэлбэрүүдийг Үндсэн хуулийн төсөл боловсруулахад сайн харгалзаж үзсэн гэсэн үг юм аа. Энэ дээр нөгөө нэг харгалзаж үзэх ёстой зүйл юу вэ гэвэл нийтлэг зүйлээс гадна, ерөнхий зүйлээс гадна тусгай буюу онцгой зүйл байх ёстой. Энэ бол мэдээжийн хэрэг Монголын тухай асуудал энэ. Энэ дээр би бол энэ талыг жаахан дутуу харгалзаа юу даа гэсэн ийм бодол төрөөц байх юм. Энэ бол хэд хэдэн үндэслэлтэй юм аа.

Энэ дээр юу монголын талаасаа дутуу бодогдоо вэ гэхлээрээс би ойлгохгүй байж болно. Энд бол монгол төрийн бодлого гэдэг юм байдаг болвч уу гэж би ингэж боддог. Манайд ямар ч төрийн хэлбэр тогтлоо гэсэн хаант засаг ч байлаа гэсэн, дарангуйлагч ч

## 5.

байлаа гэсэн, дарангуйлагчийн засаглал ч байлаа гэсэн, ардчилсан засаг ч байлаа гэсэн, парламентын засаглал ч байлаа гэсэн хэзээд алдагддаггүй үеийн үед явж ирсэн монгол төрийн бодлого гэдэг юм байдаг байх гэж би боддог. Энэ монгол төрийн бодлогын үндсэн хэдэн зүйл бол байх ёстой. Өөрөөр хэлбэл Монгол улс, монгол үндэстэн, монголын ард түмэн оршиж байх ийм төрийн бодлого энд аль хэр туссан бол доо гэж бодогдож байна. Энэ бол миний бодоход тусгаар тогтнолоос ч дээгүүр тавьж үзэх зүйл болов уу гэж боддог. Төрийн тусгаар тогтнолоос. Энэнийг одоо оруулах тухай, энэнийг ганцхан үзүүлэлт дээр ярьж гэж бодож байна. Энэ дээр хэдэн гол гол асууцлууд байх ёстой, монгол төрийн бодлогод байх ёстой болов уу гэж боддог. Юуний түрүүнд бол хүн бүхэн ойлгож байгаа байх. Энэ бол, энэ монгол төрийн бодлого явж ирэхдээ бол ил, далд хэлбэрээр явагддаг байх гэж би боддог. Энэ бол газар нутгийн тухай асуудал байх ёстой, хил хязгаарын тухай асуудал байх ёстой, хэлний тухай асуудал байх ёстой. Энд бол гадаадын иргэд монгол оронд олноор оршин суух тухай асуудал байх ёстой. Ийм үндсэн тулгуур асууцлууд бол энэ Үндсэн хуулийн бодлогын нэг гол шугам болж явах ёстой гэж боддог.

Хоёрдугаар асуудал бол энэ дээр бид бол Төв Азийн нүүдэлчний соёл иргэншилтэй, ертөнцөд ер нь бараг ховорхон тохиолдсон ийм ард түмэн. Энэ бол ертөнцийн бусад ард түмнээс ихээхэн онцлог, нүүдэлчний соёл иргэншлийн энэ онцлогийг бас зарим талаар харгалзаж үзээгүй юм шиг ингэж санагдаж байгаа.

Гуравдугаарт бол эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, монголын ард түмний сэтгэлгээний өнөөгийн онцлогийг бас одоо төдийлэн <sup>сайн</sup> харгалзаж үзээгүй юм уу даа гэж ингэж бодож байна. Манай Үндсэн хуулийн ерөнхий төслийг аваад үзэхэд бол урагшаагаа хол харжээ. Энэ бол үнэхээр сайн зүйл. Хэрвээ энэ маань ямар нэгэн программ, ямар нэгэн бодлого байсан бол энэн шиг сайн юм бол байхгүй, хууль бол баталсан өдрөөсөө эхлээд хэрэгждэг учраас хэтэрхий урагшаагаа харчих юм бол ихээхэн түвэгтэй байдалд орно. Тийм учраас би энэ урагшаагаа харсан байдлыг харгалзаж

үзэх ёстой гэж ингэж бодож байна. Хууль бол, тэр тусмаа Үндсэн хууль. Үндсэн хууль бол бид тэнгэрийн дор, тэнгэрийн дор бол манай Үндсэн хууль байх ёстой. Хэн ч халдахгүй, хэрвээ баталчих юм бол. Тэрний дор төр маань оршиж байх ёстой. Тэрний дор ард түмэн маань байх ёстой. Хэрвээ бид баталсан өдрөөсөө эхлээд хүн шүүмжлээд, энээ тэрээ болоод, ингэчихэж байна, тэгж байна гээд амьдралтай тулгараад эхлэх юм бол энэ Үндсэн хуулийн маань, бидний нөгөө эрх зүйт төр байгуулах, хуулиа дээдэлнэ гэдэг юм маань түвэгтэй байдалд орчих юм биш байгаа цаа гэж ингэж бодож байгаа.

Энэ Монгол төрийн бодлоготой холбогдуулаад хэлэхэд нэг яригддаггүй, их ховор яригддаг, магадгүй энэ дээр ярих ёстой ийм сэдвийн тухай би ярьж хөндөө гэж бодож байна. Энэ төрийн амин холбооны тухай асуудал. Манай ард түмэн бол амин холбоог их чухалчилдаг байна. Ерөөсөө хаана ч бичихгүйгээр зөвхөн нэг үе нөгөө үедээ амаараа дамжуулдаг ийм юм бол манай төрийн бодлого дотор явж байх ёстой байх гэж би боддог, хуучин явж байсан байх гэж ингэж төсөөлдөг. Тэгэхлээр амин холбоог залгуулах асуудал бол магад ч үгүй манай төрийн ихээхэн холын, наад зах нь 18-20 жилийн дараагийн төрийн хэлбэр бол хаант засагтай байх юм биш байгаа гэсэн ийм юм бодогддог, энэ бол өнөөдөр хэрэгжихгүй, энэ бол Монгол улсаа гэж бид өнөөдөр нэрлэх гэж байгаатай адилхан энэ бол ирээдүйн зүйл гэж би боддог, хаант засагтай байхын тулд одооноос хаанаа бага наснаас нь ч байдаг юм уу, яадаг ч юм, тодруулаад, тэгээд 18, 19 нас хүрэхэд нь залах ийм юмыг бид өнөөдрөөс бодож байх ёстой, тэрнээс биш 18 жилийн дараа очоод гэнэтхэн нэг хаан гаргаж ирж тавих тухай асуудал бол энэ бүтэнгүй зүйл юм. Тийм учраас энэ юмыг бас бид өнөөдөр хөндөж ярих ёстой зүйл гэж ингэж боддог. Хаант засгийн давуу талыг би ярих шаардлагагүй гэж бодож байна. Энэ бол зүгээр ямар нэгэн дарангуйлагчийг хүсэн мөрөөдөж байгаа зүйл биш ээ. Энэ бол ямар нэгэн дарангуйлагчийг би хүсэн мөрөөдөж байгаа зүйл биш. Энэ бол алсын бодлоготой зүйл болгож явах ёстой. Яагаад тэр вэ гэвэл




өнөөдрийн уур амьсгалаар аваад үзсэн ч гэсэн би бол би, чи бол чи гэсэн ийм сэтгэлгээ өнөөдөр ноёрхож байна. Дараа нь бол төр, түмний холбооны тухай асуудал байна. Төр, түмний холбоон дээр бол хоёр зүйлийг бид нар анхаарах ёстой.

Нэгдүгээрт, энэ улсуудын ярьж байгаа парламент хоёр шаттай байна гэдэг дээр. Төрийн холбоог сайжруулах ёстой. Энэ дээр бол төр, түмний холбоо бол энэ дээр холдож байгаа. Хоёрдугаарт энэ сумын тухай асуудал байж болно. Зөвхөн зайн хугацаанаас нь аваад үзэхэд л малчин хүн бол ямар зайнд явж санал бодлоо төрдөө илэрхийлэх вэ гэдэг бол хол зай оршиж байгаа шүү дээ.

Гуравдугаарт, хамгийн сүүлд нэг зүйлийг хэлэхэд энэ тусгаар тогтнолын тухай асуудлуудыг энэ удаад ямар байдлаар энд хурц хөндөж тавих вэ гэдэг асуудал бидний анхаарлын төвд байх ёстой. Энд өнөөдөр бид яруу найрагч Дамбалбарын тухай ярьж байна. Энэ бол, хэргийн учир бол яруу найрагч Дамбалбартаа байгаа биш, хэргийн учир бол тусгаар тогтнолын холбогдолтой асуудлууд хөндөгдөж байгаа учраас энэ яригдаж байгаа зүйл гэж би ингэж ойлгож байгаа. Эндээс нь, бэлгэ дэмбэрэлээс нь авахуулаад олон зүйл дээр энэ дээр анхаарах ёстой гэж ингэж бодож байна. Тэгээд сэтгэлгийнхээ хөдөлгөөнийг барихгүй хамгийн сүүлийн зүйлийг хэлэхэд тусгай нэг зүйл, онцгой нэг зүйлийг хэлэхэд бол төрийн сүлдний төсөл бол сайхан төсөл юм шиг байна. Өнгөцхөн харахад. Хамгийн гол нь бол энд Алунгоо эхийн толгойн дээр эвэр хошуутай махчин шувуу суучихаад таван нумыг шулмын хумстай тийм гараар барьсан байгаа явдал бол үнэхээр энэ улсуудын сэтгэлд бол нийцэхгүй байх шиг байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо

141-р тойргийн депутат **Өлзийорших**: - Депутат нөхөд өө, би хөдөө нутгаас сонгогдсон депутат аа. Саяхан Говь-Алтай аймгийн Шарга суманд сонгуулийнхаа тойрогт очиж тэдэнтэй уулзаж төрийн бодлогын асуудал үндсэн хуулийнхаа төслийн талаар тодорхой ярилцаж, илэн далангүй санал бодлоо солилцсон. Ингээд тэд над энэ АИХ-ын 2 хуралдаан депутат та нөхдөд зарим зүйлийг үндсэн хуулийн төслийн талаар уламжилж өгөхийг даалгасан юм. Энэ бол бидний олонхи депутатуудын ярьж байгаа олонхи сонгогчдын саналыг илэрхийлж байгаа улсын нэрийн тухай асуудал байна. Үндсэн хуулийн нэрийн тухай асуудал байна. Хэвээр нь байлгах, сүлдэнд байгаа морийг шувуугаар солихгүй байх, өмчийг хувьд өмчлөхгүй байх, орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, ялангуяа сумыг хэвээр байлгах асуудал байгаа юм. Ингэхээр энэ бол I сум, аймгийн асуудал биш байна. Энэ бол манай орны хөдөлмөрчид ялангуяа хөдөө нутгийн хөдөлмөрчдийн олонхийн санал болох нь энэ хуралдаан дээр үг хэлсэн олон депутатуудын ярьсан зүйлээс тодорхой боллоо. Энээнээс бид ямар дүгнэлт хийх хэрэгтэй байна вэ гэхлээр ер нь энэ олонхийн саналыг бид хөдөлмөрчдөөс сонгогдсон депутат хүний хувьд тэдний захиа даалгаврыг биелүүлэх үүрэгтэйн хувьд зайлшгүй харж үзэх бодит зүйл боллоо гэж бодож байна. Энэ талаас нь аваад үзсэн ч гэсэн нөгөө талаар ер нь ингээд үндсэн хуулийнхаа төслийг зүйлчлэн хэлэлцээд ирэхлээр зэрэг зүйл бүр дээр улсын, нэр, төрийн нэрийг тогтсон байх явдал шаардана. Энэ учир байдлыг харгалзаж үзээд зарим нэг депутатуудын гаргасан саналыг харгалзаж үзээд бид одоо үндсэн хуулиа зүйлчлэн хэлэлцэхийн өмнө энэ улсын нэр, үндсэн хуулийнхаа нэрийг санал гаргаад санал хураагаад шийдчих нь зүйтэй байхаа гэж бодож байна. Энэтэй холбогдуулаад бага хурлын адрес хаяг дээр хөдөөгийн зарим малчин хөдөлмөрчин хүн бас шүүмжлэлтэй үг хэлэнийг уламжлах үүрэгтэй гэж бодож байна. Энэ нь юу вэ гэвэл ер нь бид одоо улсынхаа нэр, хуулийнхаа нэрийн талаар саналаа хэлээд байхад бага хурлын нөхдүүд яагаад авч үздэггүй, хуулиндаа тусгадаггүй анхныхаа оруулсан саналыг тулгаж мугуйдаж зүтгэж байдаг юм бэ хөдөөгийн хөдөлмөрчид бид чинь хуулийн нарийн асуудлыг мэдэхгүй байж болно. Гэхдээ ер нь

улсынхаа нэрийн талаар, хуулийнхаа нэрийн талаар бид чинь саналаа хэлэх эрхтэй, энэ хэлсэн саналаа бол хуульдаа оруулахыг шаардах эрхтэй бид гэж эмзэглэж ярьж байсныг хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Цаашид манай хуулийн төсөлд парламентын засаглал байх талаар заасан явдлыг хуульч хүний хувьд зүйтэй гэж үзэж байна. Энэ бол ардчиллыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх үүднээс үзсэн ч нэг хүний гарт хэтэрхий их эрх мэдэл төвлөрүүлэхгүй байхын үүднээс үзсэн ч ер нь төрийн удирдлага гүйцэтгэн захирах засаглалын асар их ажил, ачааллыг нэг хүн дээр овооруулахгүй байх үүднээс үзсэн ч хамгийн нийлэмжтэй зөв шийдэл байхаа гэж ингэж бодож байна. Гэхдээ манай улс бол японы эзэн хаан шиг, английн хатан хаан шиг тийм бэлгэдлийн ерөнхийлөгчтэй байхыг ард түмэн хүсэхгүй байна. Хүчтэй ерөнхийлөгчтэй байх нь зүйтэй гэж үзэж байна. Ер нь манай улсын түүхэн уламжлал, цаг үеийн байдал ч гэсэн энэ асуудлыг би шаардаж байна гэж үзэж байна. Энэ учраас ерөнхийлөгчийн эрхийг зохих хэмжээнд нь өргөтгөх нь зүйтэй. Өргөтгөж оруулах хэрэгтэй. Тухайлбал ерөнхийлөгчийн эрх үүргийг тодорхойлсон төслийн 33 дугаар зүйлд ерөнхийлөгчөөрийн эрх хэмжээний дотор засгийн газарт үүрэг чиглэл өгч байх, мөн ерөнхийлөгчийн зарлиг, шийдвэрийн биелэлтийг засгийн газар хангах үүрэгтэй байх талаар нэмэлт заалт оруулах нь зүйтэй гэж бодож байна. Цааш нь манай улсын парламент 2 танхимтай байх нь зүйтэй гэдэг санааг би дэмжиж байгаа юм, энэ талаар сонин хэвлэлд бичиж үндэслэлээ тодорхойлсон байгаа. Гэхдээ аль нэг гадаад орныг дагаж дууриах биш, өөрийн орны олон жил уламжилж ирсэн түүхэн онцлог, их, бага хурлын системд үндэслэн дээд, доод 2 танхимтай байх нь зүйтэй байх гэж бодож байна. Дээд танхим бол хуулийн биелэлтэд хяналт тавих, зохион байгуулах, төрийн бодлогыг олон түмэнд сурталчилах, төр, ард түмний холбоог хангах гэх мэтчилэнгийн олон үүрэгтэй байхаас гадна доод танхимаа байгуулдаг, илтгэл тайлангийн нь сонсдог, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгдөг байх нь зүйтэй байхаа. Хэрвээ ингэхгүй юм бол бид 53 хүнтэй улс төрийн товчоо бий боллоо гэж шүүмжилдэг байсан, 75 хүнтэй товчоо болоод, ерөөсөө дээрээ хяналт байхгүй ийм байдалд орох юм бол төвөгтэй байдалд орох байхаа. Бага хурал бол 30 орчим хүнтэй, жинхэнэ мэргэжлийн парламентаар бий болгоно. Хууль тогтоох гол ажилдаа хүчээ төвлөрүүлж ажиллана гэж ингэж бодож байна. Энэд бол хэд хэдэн сайн талууд бий. Энийг бол би тоочих шаардлагагүй гэж бодож байна. Нөгөө талаар шүүхийн зохион байгуулалтын асуудал

дээр шүүхийн бие даасан байдлыг хангаж, эрх үүргийг өргөжүүлэх талаар чухал заалт оржээ. Ер нь манай улсын шүүхийн үйл ажиллагаанд үндсэн реформ өөрчлөлт хийх шаардлага бол зүй ёсоор тавигдсаныг харгалзаж үзсэн гэж бодож байна. Гэхдээ шүүхийн эрх хэмжээнд зохих хэмжээний хязгаар хяналт байх нь зүйтэй байх аа. Шүүх алдах явдал байсан. Ер нь байдаг аа. Цаашдаа ч одоо алдахгүй байна гэсэн баталгаа байхгүй байгаа. Энэ учраас шүүхийн гаргаж байгаа алдааг засаж маш чухал хэрэгсэл болсон дээд шүүхийн хэдэн коллегууд байдаг, эрүү, иргэн, цэргийн, энэ бол маш чухал шат байгаа юм. Маш олон зуун хэргийг хянаж, учир зүйгийг нь олж байдаг юм. Гэтэл энэ коллегуудыг бол үгүй болгосон байна. Тэгээд энэ дээд шүүхийн хяналтын 2 шат байсан болбол I нь үгүй болж, ерөөсөө ганцхан шат үлдсэн байна. Нэг талдаа, нөгөө талдаа бол дээд шүүхийн энэ шүүхүүд бол асар их эрх үүрэг олгосон байхад анхан шатаар хэрэг шийдэх ийм эрх олгосон байна. Энийг харгалзаж үзмээр байна. Цааш нь хэлэхэд бол прокурорын байгууллагыг их сулруулжээ. 4 үндсэн хяналттай байсан бол 2 хяналттай болгочихсон байна. Тэгээд ер нь шүүх, прокурор 2 бие биенийхээ ажиллагаанд хяналт тавиад эцсийнхээ үгийг шүүх хэлдэг байсан болбол энэ систем алдагдсан байна. Энэ мэтийг цаашид харгалзаж үзэх нь зүйтэй байх гэж бодож байна. Тодорхой зүйлийг ярихад бас саналаа хэлнэ. Ингээд ганц, хоёр санал байна. Энэ эрх, үүргийн харьцаа хэтэрхий алдагдсан ийм тал байх шиг байна. Би энийг бол тоогоор механик харьцуулах гэж байгаа юм биш ээ. 19 эрх байна, иргэн хүнд, улсаас авах, нийгмээс авах, гэтэл өгөх юм нь, хийх юм нь, бүтээх юм нь 4-хөн байгаа юм. Энэ яг тоогоор харьцахгүй ч гэлээ гэсэн бас энэ дээр бодож үзмээр юм байна. Олонхи депутатуудын саналыг харгалзаж үзээд энэ нийгэмдээ хөдөлмөрлөх үүргийг л иргэн хүний үүрэг болгож оруулж өгөхгүй бол улс нийгэм чинь урагшаа явахгүй шүү. Энийг бодмоор байна. Нөгөө талаар улсын нийслэл Улаанбаатар хотыг бол үндсэн хуулийн төвшинд нэр заамаар байна. Цэцийн асуудал дээр өөр саналтай байна. Цэц бол шүүхийн системэнд багтах шүүхийн нэг хэсэг биш ээ. Энэ бол үндсэн хуулийн хяналтын үүрэг гүйцэтгэх байгууллага, энэ учраас тусад нь биеий нь даалгаж байлгах нь зүйтэй байхаа гэж ингэж бодож байна.

268-р тойргийн депутат Цэнджаргал: --Бид одоогийн хүрсэн түвшин ирээдүйн чиг хандлага түүнийг хэрэгжүүлэх шилжилтийн

үеийн үргэлжлэх хугацаанд явагдах явцад баримтлах бодлогыг нухацтай бодож, шийдэж байж, эцсийн шийдвэр гаргах ийм хариуцлагатай үүрэг хүлээж сууж байгаа хүмүүс гэж ингэж ойлгож байгаа. Хуулийг батлахад хуулиндаа өнгөрсөн үе, одоо үе, ирээдүйг ч сайн мэдэж үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай гэсэн ойлголттой байгаа. Улсын бага хурлаас оруулж байгаа төсөл урагшаагаа сайн харсан ийм төсөл болж байна гэж ингэж бодож байгаа. Иймээс ч шинэ үндсэн хуулийн төслийг олон арван жил үйлчлэх хууль байх шаардлагынх нь үүднээс авч үзвэл хуулинд оруулж байгаа, төсөлд оруулж байгаа гол гол асуудлууд, зарчмын гол гол асуудлуудыг зүйтэй гэж ингэж үзэж байна. Гэхдээ шилжилтийн үеийн хавсралт хуулийг зүйтэй гэж ингэж үзэж зөвшөөрч чадахгүй байгаа. Энийг тухайн үед нь хэлэлцэх үед саналаа хэлье. Энд зүгээр гол юмаа хэлвэл АИХ-аас бусад бүх засаглалын хэлбэрүүдийг их цааз батлагдсан өдрөөс эхлэн их цаазад бүрэн эрхий нь эдлүүлэхээр заасан эрх үүргий нь эдлүүлнэ гэж заасан байгаа. АИХ-д бол ерөөсөөн 25-ын 2 заалт, 69-р заалтын 2,3-хан заалтуудыг л одоо эдлүүлэхээр ингээд заагаад өгчихсөн ийм учир дутагдалтай юм байгаа. Ийм учраас энэ төслийг зүйтэй гэж үзэх үндэслэл алга гэж үзэж байна. Тодорхой гол асуудлуудаар саналаа хэлье, төрийн удирдлагын байнгын ажиллагаатай олон намын оролцоо бүхий парламентын хэлбэрийг гэхдээ дээд, доод танхимтайгаар байгуулах энэ үндэслэлийг дэмжиж байгаа, гэхдээ энэ олон намын хувьд олонхийн суудал авсан нам, засгийн газраа бүрдүүлдэг энэ зарчмыг тусгаж өгвөл болох юм болов уу гэсэн ийм бодолтой байгаа юм. 2-рт нь УИХ-ын гишүүдийн тоо цөөдөж байна гэсэн саналыг дэмжиж байгаа, гишүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байх, 3-рт нь бид өнөөдөр шилжилтийн үеийн эхэнд байж байгаа ийм улс орон, өөрийнхөө туршлагыг харгалзаж үзлээ ч гэсэн өндөр хөгжилтэй орнуудын хэмжээнд төрийнхөө удирдлага, түүний тогтолцоо хугацааны талаар тэр хэвээрэнгээр нь авч батлах асуудал арай учир дутагдалтай болов уу. Тийм учраас өнөөдрийнхөө төвшинд, өнөөдрийнхөө туршлага дээр тулгуурлаад, АИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаануудыг нэлээн богиносгох, бага хэмжээнд байх ийм үзэл бодол баримталж байна. Тухайлбал УИХ-ыг 4 жилийн хугацаатайгаар, Ерөнхийлөгчийг 4 жилийн хугацаатайгаар энийг тухайн үед нь саналаа тавъя. Зөвхөн бид шилжилийн эхэн үед

зогсож байгаа учраас өнөөдрийнхөө төлөв байдлыг тусгах нь зүйтэй болов уу гэсэн ийм бодол байгаа юм. Дараагийн нэг асуудал энд улсын нэр, томъёо байна, сүлдний хувьд энэ сүлд еөрчлөх нэг ийм туйлшрал гараад байгаа юм болов уу гэж бодож байгаа, миний хувьд, Улсын нэр томъёоны хувьд бол БНМАУ гэсэн энэ нэрийг хэвээр үлдээх ийм саналыг дэмжиж байгаа, сүлдний хувьд ч гэсэн одоогийн нэг дээдэлж хүндэлж байгаа энэ сүлдийг хэвээрэнгээр нь байлгах ийм саналтай байна. Тэгэхээр энд ард түмний ёс заншилыг бас харгалзан үзэх ийм шаардлагатай юм байгаа юм. Бид видеогоор ч сонслоо, үзлээ, тайлбар сонслоо, говийн ард түмний дунд нэг ийм ёс заншил явдаг юм. Чухам зүгээр тэр ёс заншил хэдий үеэс үргэлжилж гарсаныг би мэдэхгүй байна, говийн ард түмэн тооноор шувууны сүүдэр гэрт тусах, шувууны өд сөд гэрт орж ирэхэд муу ёрын юм болно гэж их цээрлэдэг, энэ чухам тэр цагаан шувууг зүүдэлж байх үед байсан ёс заншил юм уу үгүй юу, за лав сүүлийн 70 жилд энэ талаар үзэл суртлын юм явагдаагүй гэж бодож байна. Тэгэхээр энэ нэлээн дээр үеэс уламжлалтай ийм нэг хэсэг бүлэг ард түмний нутгийн заншил ийм юм байдаг юм байна. Энийг ч бас харгалзан үзэх нь зүйтэй байх аа. Ийм учраас энэ цагаан шувуутай с сүлдийг нэг их манай ард түмэн өнөөдрийнхөө түвшингээс ч гэсэн, урд өмнөх өнгөрсөн үеэ бодсон ч гэсэн хүлээж авч чадахгүй байх аа.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

-Хүний эрх, эрх чөлөөний талаар дэлхий нийтийн хүлээн зөвшөөрсөн түвшин, хэм хэмжээнд нэлээд ойртуулж баталгаажуулсан ийм асуудлыг анх удаагаа хуулийн төсөлд тусгаж байгаа гэдэг саналыг би бүрэн дэмжиж байгаа.Гэхдээ энэ дээр хүний эрх зөрчигдөж хэлмэгдэл давтагдахгүй байх онцгой нөхцөлийг анхаарч энэ хуулинд тодорхой механизм, зохион байгуулалтыг тусгаж өгөх нь зүйтэй байх гэж саналтай байгаа.

Эцэст нь горимын шинжтэй нэг санал байна.Төслийн талаар ерөнхий хэлэлцүүлэг явагдаж байна.Өнөөдөртөө энэ хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулах нь зарчмын ач холбогдолтой болов уу гэж миний хувьд бодож байгаа.Яагаад гэвэл төсөл нэгэнт баталсан эд биш учраас хуралдаанд оролцож байгаа эрхэм депутатуудын дийлэнх олонх нь ямар асуудал дээр санал нэгдэж байна гэдгийг депутатын хороо ч байдаг юмуу, ажлын хэсгүүд бүгд нэгтгээд I дэх өдөр боловсруулсан томъёолол дээр санал авахаар ийм хэмжээнд хүртэл нь хэлэлцүүлгийг явуулах нь зүйтэй болов уу гэсэн хувийн бодол байна.

428 дугаар тойргийн депутат Д. Ганболд -Би энэ ерөнхий санал шүүмжлэлээс нэрээ татаж байна.Горимын нэг санал хэльчихье.Түрүүн Очирхүү депутат санал гаргасан.Үдээс хойших хуралдаан эхлээд 15 цагаас ерөнхий санал шүүмжлэлийг зогсооё гэсэн ийм горимын санал дээр санал хурааж өгнө үү. Ийм санал тавьж байна.Ингээд яг дэс дараагаар бол одоо бол 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч уг хэлэх ёстой. Уг нь тийм л дэс дараатай байсан юмсан.

Х.Уртнасан: -дансэвэгийн дараа 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч байна.

328 дугаар тойргийн депутат Д. Дашзэвэг: -Тэгэхээр өнөөдөр бид Их Хурлаараа Их цаазын төслийн тухай асуудал хэлэлцэж байна. Энэ дээр би БНМАУ-ын нэр, сүлд, далбаа, Үндсэн хууль гэснийг бусад депутатын нэгэн адил дэмжиж байна.

Би энд Их цаазын төсөлд газрын талаар бол өөрийн гэсэн бодлыг, ойлгоц байна. Энд газрыг бол төрийн өмч байлгах нь зүйтэй. Гадаадын иргэд буюу хувьд өмчлөхийг зөвшөөрөхгүй байна. Энд эмзэглэж байгаа асуудал юу гэхээр өөрөөр хэлбэл, бид нар өнөөдөр хувьчилж явж байгаа, худалдаж байгаа зүйлүүд маань ихэнх нь хэний гарт очиж байна вэ гэдгийг бас бодолцох хэрэгтэй болжээ. Миний сонссоноор бол манай мөнгөний 20 хувь нь хятадын иргэдэд, 8 хувь нь японы иргэдийн гарт байна гэж байна. Энэ мэтчилэнгээр газраа энэ хэмжээгээр өмчилнө гэвэл хэдүйд энэ эх нутаг минь алга болох билээ гэж эмзэглэж байгаа учраас энэ хуулийн төсөлд "гадаадын иргэдэд түрээслэх" гэдгийг татгалзаж байна.

Төрийн байгууллын хувьд бид Ерөнхийлөгчийн засаглалтай, хоёр танхимтай байх нь зүйтэй гэж миний хувьд бодож байна. Хоёр танхимтай байхдаа депутатын тоо 150-200 байгаасай гэж бодож байна. Өнөөдөр бид Их Хурлын депутатуудыг эдийн засгийнх нь талаас манай Ерөнхийлөгч ойлголт өгсөн. Гэтэл жилдээ ганц болдог энэ чуулганд зарах зардлыг энэ диллэрээр тоглосон зардалтай холбож үзэж байгаа болов уу. Яахаараа энэ чуулганы асуудал депутатуудыг цөөнх байлгах гэж байгааг бид ойлгохгүй байна.

Эцэст нь энд улс төрийн бас нэг мафи үүсэх вий. Эндээс сэргийлж ер нь 150-200 депутатыг сонгож жилдээ нэг удаа ард түмнийхээ үгийг сонсож байх нь зүйтэй гэсэн учраас ойлгож байна. Ийм учраас Ерөнхийлөгчийн засаглалтай, парламентын хоёр танхимтай, 150-200 депутаттай байх санал байдаг юм.

Гуравдугаарт, орон нутгийн засаг захиргааны асуудал байна. Тэд сүүлийн 40 жилд энэ хөдөөгийн ард түмний нийгмийн



амьдралын асуудлыг шийдвэрлэх гэж энэ сум гэдэг юмыг байгуулсан. Гэтэл өнөөдөр бид энийгээ еөрчлөөд хороо, хошуу болгоод ингээд өргөтгөх байдал яригдаж байна. Энэ хөдөөгийн ард түмэнд үзүүлэх манай засаг, төрийн үйлчлэх асуудал бол үнэхээр холдож байна. Ийм учраас миний бодол бол аймаг, сум, баг гэдэг байдлаар байлгах хэрэгтэй. Баг гэдгийг одоогоор дээр үеийн багтай зүйрлэж үзэшгүй ээ. Хүн амдаа үйлчлэх хүрээгээр баг бол үнэхээр суманд байна уу гэхээс аймагт байх аргагүй болсон болов уу гэж миний хувьд бодогддог юм.

Тавдугаарт, хүний эрхийн асуудал үнэхээр энд түгээмэл зүй тогтлоороо оржээ. Гэхдээ энд хөдөлмөрлөх асуудлыг хуулиар баталгаажуулах хэрэгтэй. Хөдөөгийн нүүдэлчин, малчин ард түмний дунд чинь өнөөдөр мэргэжилтний хүрэлцээ үнэхээр хангалтгүй байна. Түрүүн ч аймгийн нөхдүүд ярьж байсан. Хөдөөд байгаа багш нар, эмч нар хөдөлмөрлөх эрхийн дагуу, хуулийн дагуу буцаж ирээд байна. Энд хэн очиж ажиллах юм бэ гэдэг санал тавьж байсан. Ийм учраас энд хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулах шаардлагатай гэж миний хувьд бодож байна. Нөгөө талаар энэ хуулинд эрх илүү ороод үүрэг дутуу орж байна. Ийм учраас үүргийн талаар нэлээн оруулж өгөх нь зүйтэй юмуу гэж бодогдсон.

Хохирогчийн бүрэн эрхийг хамгаалах талаар энэ хуулинд оруулах хэрэгтэй. Өнөөдөр орсонгүй гэж бодогдож байна. Ингээд энэ хуулийн зүйл анги яригдахаар зүйл ангиуд дээр бас ярина гэж бодож байна.

341 дүгээр тойргийн депутат П. Бямбажав: -Их цаазын төслийн талаар бид нэлээд ярилцаж байна. Бага Хурлын нөхдүүд, Үндсэн хуулийг боловсруулах комиссын нөхдийн хөдөлмөрийг бид зүй зохистой үнэлж байна. Гэхдээ анхаарч үзвэл зохих зарим асуудал байна гэж бодогдож байна. Бид ер нь тунхаглалын чанартай хуультай болчихгүй юмсан гэж надад бодогдож байна.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн, одоо, ирээдүйгээ ижил тэгшхэн харж боловсруулсан ийм хуультай болбол бидний

цаашдын ирээдүйд үр өгөөжтэй байх болов уу гэж бодогдож байна. Үүн дотор хамгийн гол зүйл бол үндэсний болоод эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг бид энэ хуулиндаа онцолж тусгаж нягтлан хэлэлцэж анхаарах ёстой болов уу гэж бодогдоно.

Бид чинь ер нь дэлхий нийтийн бусад улс үндэстнүүдтэй харьцуулаад үзэхэд ер нь үндэсний цөөнх шүү дээ, үндсэндээ, 2 сая гаруйхан хүнтэй ард түмэн байгаа. Тэгэхээр бид олон арван сая ам бүлтэй улс үндэстнүүдийн Үндсэн хуульд байдаг түгээмэл зүйлүүдийг энд авчирч тулгаад байвал бидний цөөнхийн эрх ашигт зарим талаар хэзгэй байдлаар нөлөөлөх болов уу гэж бодогдож байна. Энэ бол манай Үндсэн хуулийн гол нэг чиглэл байх ёстой гэж бодогдоно.

Нөгөө талаар Төв азийн эрс тэс уур амьсгалтай энэ нөхцөлд монгол орон нүүдлийн мал аж ахуй олон арван жил эрхэлж ирсэн энэ уламжлал маань манай Үндсэн хуулийн зарим зарим томъёолд их тодорхой тусгагдах ёстой гэж хувьд бодогдож байна. Өөрөөр хэлбэл, нүүдлийн мал аж ахуй эрхлэх нь энэ бүс нутгийн хүмүүсийн амьжиргаанд илүү ач холбогдолтой, өгөөжтэй учраас бид олон арван жил ийм хэв заншлыг эрхэлж ирсэн болов уу гэж бодогдоно. Тэгвэл нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг улс орнуудаас зах зээлийн эдийн засагт шилжихээр шулуудсан улс орон магадгүй манай улс байж магадгүй санагдана. Тийм учраас өөрийн гэсэн онцлог зүйлүүдийг энэ Их цаазын төсөлд бид онцгой байдлаар томъёолж тусгах нь зүйтэй санагдана.

Өөрөөр хэлбэл, нүүдэлчин уламжлал, малчин удмаа бид бодсон ч гэсэн энэ Үндсэн хуулийн онцлог энд тодорхой тусгагдах ёстой гэж бодогдож байна. Нөгөө талаар бид Үндсэн хууль батлагдахын урьд нэлээд хэдэн хуулиудтай болсон. Тэгвэл бид энэ Үндсэн хууль дээр гарч байгаа саналуудыг өмнө батлагдсан хуулийн заалтад уялдуулах биш ээ. Миний ойлголтоор бол Үндсэн хуулиа гол ноён нуруугаар нь батлаад батлагдсан хуулиудаа одоо батлах хуулиудаа Үндсэн хуульдаа зохицуулах ёстой болов уу гэж бодогдож байна.

Иргэний журамт үүрэгт нэмж оруулах зайлшгүй тусгавал зохих нэг санал байна. Өөрөөр хэлбэл, хэнийг ч гэсэн албадан хөдөлмөрлүүлэх ёсгүй гэсэн заалтыг эсрэг утгаар томъёолж зохих зүйл ангид тусгавал яасан юм бэ гэсэн санал байна.

Ер нь Монгол орныг, монгол хүнийг морьгүй төсөөлөх боломжгүй мэт надад бодогдож байна. Ийм учраас манай ард түмний дотор монгол морийг магтсан шүлэг, дуу, домог, үлгэр олон арав бий. Гэтэл цагаан шонхор шувууны талаар магтсан юм юу билээ гэхээр бас нэлээн ялгаатай бодогдож байна. Энэ талаар түрүүчийн уг хэлсэн депутатуудын саналтай би ижил саналтай байна.

Төрийн байгууламжийн хувьд миний ойлголтоор Ерөнхийлөгчийн засаглалтай, хоёр танхимтай парламенттай ийм улс байвал зүйтэй болов уу гэж бодогдож байна. Энэ нь юу гэвэл зах зээлд шилжиж байгаа, одоо цаг үеийн нөхцөл байдлаас ургаж гарч байна. Өнөөгийн нөхцөлд байгаа сахилга, дэг журам суларсан, эмх замбараагүй байдал нэлээн газар авч байгаа энэ нөхцөлд зайлшгүй Ерөнхийлөгчийн засаглал бидэнд шаардлагатай болов уу гэж бодож байна. Манай тойргийн сонгогчид ч гэсэн ийм санал бодолтой байгаа юм.

Газар өмчлөлийн асуудалд бид онцгой анхаарах ёстой. Нүүдлийн мал аж ахуй гэдэг чинь нэг үгээр хэлбэл манай эдийн засгийн үндэс, үндсийн үндэс байна. Энэ маань байгаль, цаг агаарын бэрхшээлээс зугатаж нүүж үйлдвэрлэлээ эрхэлдэг ийм онцлогтой байх юм. Энээс үндэслээд газар эзэмшлийн асуудал манай Үндсэн хуульд өөрийн гэсэн онцлогтой томъёологдох ёстой болов уу гэж бодогдоно.


Их Хурлын гишүүдийн тоог 76-гаар тогтоох санал орж байгаа. Миний ойлголтоор 150 орчим гишүүнтэй Их Хуралтай, түүний гуравны нэгээс дөрөвний нэгийн харьцаагаар байгуулагдсан Бага Хуралтай байх нь арай зохистой болов уу гэсэн ийм саналтай байна. Бусад саналуудаа тодорхой хэсгүүдийг ярилцахад хэлье.

347 дугаар тойргийн депутат Ч.Цунцаг: -Их цаазын төслийн талаар эрхэм депутатуудын саналтай миний санал олон талаараа нийлж байгаа.Түүнээс дотроос онцгой нийлж байгаа нэг санал бол манай Их цаазын төслийг хэлэлцэх явцдаа бусдын шахалт, ухуулганд орохгүйгээр өөрийн гэсэн оюун ухаанаараа Их цаазынхаа төслийг батлах гэсэн эрмэлзэл нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сонгогчид, хөдөлмөрчдийнхөө үндсэн эрх ашигт нийцсэн тийм Үндсэн хуулийг баталъя гэсэн саналтай миний санал нэг байна.Ингээд өөрөө бодож санаж байсан ганц, хоёр зүйлийг хэлье гэж бодож байна.

Депутатуудын ярьсан, дүгнэсэн, үзэж байгаагаар Их цаазын талаар гол үндсэн саналууд давхардаж байгаа учраас би энэ дээр олон давхардуулан хэлэхгүй гэж бодож байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Их цаазын төслийг хэлэлцэх явцад ажиглагдаж байгаа нэг зүйл бол манай бага хурлын боловсруулсан төсөл их хуралд оруулж байгаа энэ төсөл Их хурлын хооронд нилээн том зааг зөрөө байгаа нь ажиглагдаж байна. Энэ бол хэд хэдэн зүйл дээр депутатуудын хэлснээр ажиглагдаж байна. Энэ бол тодорхой байна. Энэ дээр хамгийн тодорхой асуудал юуг анхаарсангүй вэ гэвэл анхнаасаа авсан хөдөлмөрчдийн саналыг харгалзаж үзсэнгүй. Их цаазын төсөл бол зөвхөн Бага хурлын гишүүдийн санал, тэдний дүгнэлт, тэд нарын сэтгэл санаанд буусан хэмжээгээр боловсрогдож өнөөдөр Их хуралд орж ирж байгаа явдал бол хөдөлмөрчдийн саналыг тусгах талаар манай Үндсэн хуулийн төслийг боловсруулах комисс ч гэсэн Бага хурлын гишүүд ч гэсэн тодорхой анхаараагүй, өөрсдийн үзэл бодлын хэмжээнд хийсэн учраас ард түмний санаа сэтгэлтэй нийлэхгүй ийм зүйлүүд нилээд хэмжээгээр тусгагдсан явдал бол өнөөдөр Үндсэн хуулийн шинэ төслийн талаар тохиролцоонд хүрэхэд нилээн бэрхшээл учруулж байгаа болов уу гэж үзэж байна.

Хоёрдугаарт нь Үндсэн хуулийн төслийн талаар төрийн анхан шатны байгууллагуудын санал дүгнэлтийг ерөөсөө тусгасангүй гэж үзэж байна. 6 дугаар сард болсон депутатуудын бүсчилсэн зөвлөлгөөнөөр Их цаазын төсөлд тусгах асуудлын талаар төрийн захиргааны анхан шатны байгууллагуудын дарга нарын санал, Их хурлын депутатуудын саналыг бас авсан. Энэ дээр ер нь одоо яригдаад байгаа энэ зүйлүүдийг Их цаазад хэрхэн тусгах талаар нэгдмэл саналаа өгсөн. Энэ саналыг бас харгалзаж үзсэнгүй. Ийм учраас цаашид ер нь төсөл боловсруулах, хууль боловсруулах асуудалд ард түмний саналыг үнэхээр л авч байгаа юм бол тэр ард түмний уур амьсгалыг тусгах талын асуудлыг бодож тунгааж байвал яасан юм бэ гэсэн ийм санал надад байна.

Ер нь манай төрийн тогтолцооны талаар ч гэсэн аваад үзсэн ч бас бодууштай зүйл байна гэж бодож байна. Өнөөдөр ерөнхийлөгч, Их хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Дээд шүүх

гэх мэтийн /магээр/ төрийн тогтолцооны нүсэр их том апарат бий болж, доод анхан шатандаа ард түмэндээ жинхэнэ ойрдот ажилладаг сум татан буугдаж цаашдаа алга болох гэж тусгагдаж байгаа асуудал бол ер нь тэр бол ард түмнээсээ хөндийрч байна, төрийн маань толгой бол маш их том, их жижигхэн хөлтэй, нилээн ширүүхэн шуурганд толгойгоо даахгүй уначихаж магадгүй ийм том тогтолцоо тогтож байгаа юм биш биз дээ гэсэн иймэрхүү санал төрж байна аа. Ийм учраас төрийн анхан шатны байгууллагуудыг ард түмнээс холтгох гээд байгаагийн учир шалтгааныг үндсэндээ ойлгохгүй байна. Энэ талаар манай депутатууд маш их дэлгэрэнгүй, амьдралаас ургасан ийм санал дэвшүүлж байгаа учраас би энэ дээр олон зүйлийг нэмж ярих шаардлагагүй гэж үзэж байна. Сонгогчдынхоо санал хүсэлтийн дагуу сум татан буугдахыг би зөвшөөрөхгүй гэж үзэж байна. Ингээд бусад асуудлын талаар төрийн сүлд, туг, далбаа, улсын нэр, Үндсэн хуулийн нэрийн талаар бусад депутатуудтай санал нэгтэй байна.

Ж. Уртнасан -9-р микрофон Энхсайхан.-

45 дугаар тойргийн депутат Энхсайхан -Тэгэхлээр бид нар Үндсэн хуулийн асуудал ярьж байхад нэг том асуудлыг орхигдуулж ярьж байх шиг санагдаж байна. Тэр нь юу вэ гэвэл Монгол улс өмнө талдаа нэг том Хятад гүрэнтэй байгаа. Умард талдаа нэг Зөвлөлт гүрэн байгаа. Зөвлөлт одоо байхгүй л дээ. Их брос байгаа. Энэ хоёрыг байнга анхааралдаа авч асуудлыг шийдвэрлэхгүй бол болохгүй гэдгийг хэлмээр байна. Учир нь юу вэ гэвэл Үндсэн хууль дотор хамгийн их болгоомжтой хандах асуудал бол тусгаар тогтнолын асуудал. Тэгвэл бид нарын өнөөдрийг хүртэл явж ирсэн тусгаар тогтнолын асуудалд энэ хоёр гүрнээс маш их, энэ хоёр гүрний хүчний харьцаан дээр маш их юм явж байсан шүү гэдгийг бид анхааралдаа авахгүй бол болохгүй ээ. Тийм учраас бид нарын Үндсэн хуульд оруулах гээд байгаа төрийн тогтолцоо ч тэр, энэ бүх элдвийн шийдвэрлэх гээд байгаа асуудлууд, энэ хоёрын нөлөөнд автах уу, автахгүй юу гэдэг дээр бас анхаарч байхгүй бол болохгүй гэдгийг анхаарч ярилцмаар байна. Жишээлбэл, бид нар засаглалын асуудал ярьж байна. Ерөнхийлөгчийн засаглал гээд,

парламентын засаглал гээд ярьж байна. Гэтэл би энэ дотор энэ хоёр хүчин зүйлээ аваад үзэх юм бол ерөнхийлөгчийн засаглал байх нөхцөлд Умард болоод Өмнөд талаас нөлөөлөх нөлөөлөлд автах асуудал бол арай илүү байх болов уу гэж бодож байна. Парламентын засаглалд бол энэ хоёр нөлөөнд автах явдал арай бага байх болов уу гэсэн бодолтой байгаа юм. Сая асуудлуудыг ярьж байхад жишээлбэл Цагаачлалын хуулийг хэрэггүй гэж улсууд олон ярих юм. Би бол асуудлыг сайн ойлгож чадаагүйгээс энэ асуудал яригдаж байгаа болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл өнөөдөр бид Зөвлөлт орон ямар хүнд байдалд байгааг мэдэж байна. Дотроо иргэний дайн болох төлөвтэй ийм байдал ажиглагдаж байна. Улаан, цагаанаараа хөөцөлдөөд 21 он шиг ороод ирвэл бид яах вэ. Ямар хуулиар зохицуулах вэ, өнөөдөр Тувагаас, өнөөдөр Буриадаас, өнөөдөр юу ч болж мэднэ. Хүн ороод ирэхэд үүнийг ямар хуулиар зохицуулах вэ, энэ хууль бол Цагаачлалын хуулиар зохицуулахаас өөр аргагүй. Цагаачлалын хууль гэдэг бол гаднаас хүн урих гээд байгаа асуудал биш, гадагш нь хүн явуулах гээд байгаа асуудал биш. Цагаачлал гэдэг ойлголт бол гадны орж ирсэн хүнд өгөх статусын тухай асуудал яригдаж байгаа. Бид энэ асуудлыг юугаар зохицуулах вэ гэдэг асуудлыг тавимаар байгаа юм.

Өөр нэг асуудал бол хэн нэгэн улс, аль нэгэн одоо дэлхийн хэмжээнд ярих юм бол жишээлбэл Зөвлөлтийн хэмжээнд ярих юм бол олон улс бий болох ийм үзэгдэл явагдаж байна, задрал явагдаж байна. Энэ дотроос хэн нэг нь өөрийгөө Монгол улс гээд зарлавал яах вэ. Тэгвэл энэ Монгол улс гэдэг ойлголт БНМАУ гэдэг ойлголт хэн нь хэнийгээ багтаадаг ойлголт вэ гэдэг асуудал яригдах байх. Энэ талаасаа хандсан ч болох болов уу гэж бодож байна. Газрын асуудал дээр жишээлбэл гадаадынханд түрээслэхгүй гээд ярих юм. Би хэний төлөө ярьж байгааг үнэндээ ойлгохгүй байна. Яагаад манай Монгол улс гадаадад Элчин сайдын яамдаа нээхдээ газар худалдаж авдаг, яагаад гадаадын Элчин сайдын яамдууд манайд нээгдэхдээ газраа зүгээр авдаг юм бэ. Жишээлбэл бид Япон улсад олон тонноор нүүрс гаргая гэж бодъё. Тэр нүүрсийг чинь бид нар нэг хөлөг онгоцны хэвлийг ерөөсөө дүүргэж чадахгүй шүү дээ нэг удаагийн вагон явуулаад, дүүрэн состав вагон явуулаад. Тэрийг чинь дүүргэж өгөх тийм

юмыг чинь хүний нутаг дээр газар түрээслэх шаардлага гарна. Гэтэл яагаад бид нар хүний нутагт газар түрээслэхэд бид нарын эрх ашиг далайд гарах гарцтай болох тэр асуудал хэрэгтэй байхад яагаад бид еерсдийнхөө газрыг түрээслэхгүй гэж хэлчихээд хүний газрыг түрээслэнэ гэж **хэлж явах** вэ. Газрыг Монголын иргэдэд өмчлүүлэх асуудал дээр яг зүйл анги дээр нь тулахаар өшөө тодорхой ярилцаж болох болов уу гэж бодоод би зүгээр энэ асуудлыг яримгүй байна. Тийм учраас нэгэнт энэ энд ерөнхий шүүмжлэл явагдаж байгаа учраас би депутатуудад хандаж хэлэх юу байна вэ гэхлээр Үндсэн хуулийн асуудал болгон дээр шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэх болгон дээрээ урд талд маань ямар юм байна, хойд талд маань ямар юм байна, гадаад хүчин зүйлд бид олон удаа автаж байсан гэдгээ байнга бодож байх хэрэгтэй байна.

Өнөөдөр бид нарын дотор хардлага, сөрдлөгийн уур амьсгал хэнд үйлчлэх вэ гэдгээ бодмоор байна. Ийм уур амьсгал, ийм байдалд монголчууд явж байгаад эсвэл урагшаа холбирч унадаг, эсвэл хойшоо холбирч унадаг л байсан. Өнөөдөр бид Үндсэн хуулийн асуудлыг шийдвэрлэхэд ямар ч нам, ямар ч элдвийн асуудалд автахын хэрэг байхгүй. Бид еерсдийн толгойгоороо сайн бодож байгаад үндэсний эрх ашгийг дээр нь тавьж байгаад асуудалд хандая гэсэн ерөнхий асуудлыг ярья. Зүйл дээр нь очихоор ярилцъя гэж бодож байна.

Бямбаноров —Хурлын дарга аа. Гомдол байна. Төвийн хэсэг депутатаад өчигдрөөс хойш хүсэлт тавьж байж 9 дүгээр микрофон нээлгүүлсэн. Тэгээд бид нэрээ бичээд өгсөн. Бидний нэр байхгүй. Оронд нь Улсын бага хурлын гишүүд уг хэлчихээд байна.

Ж. Уртнасан —Уучлаарай. Бямбаноров даргаа. Таныг одоо наад микрофон дээр чинь байна. I-ээс эхлээд 5 дээр хүрэхэд та уг хэлнэ.

Бямбаноров —9 дүгээр микрофонд гэж зарласан шүү дээ.

Ж. Уртнасан —I дүгээр микрофон Гүлхүү.



Гүлхүү -За Бага хурлаас өргөн барьсан төслийг хэлэлцэж ерөнхий санал шүүмжлэл явж байна. Энд депутатууд олон чухал санал хэлж байна. Энэ дотор бас зөрөөтэй, авч хэлэлцэх ёстой олон янзын сайхан саналууд гарч байна. Энэ дотроос **онцгойлж** үзээд газрын тухай асуудлын хувьд нэг уг хэлье гэж бодож байгаа юм. Ер нь одоо газрыг өмчлүүлэх тухай асуудлыг эзэмшүүлнэ гэдэг энэ утгаар нь оруулбал зүйтэй болов уу гэж бодож байна. Өмчлүүлсний дараагаар ямар ч харьцаа, хэдийд ч, юунд ч хүргэж болзошгүй ийм байдалтай юм шиг байна. Газрыг түрээслүүлнэ гэдэг асуудлын хувьд байж болох асуудал байх. Гэхдээ тэр газрын хуулиар зохицуулагдах ёстой тэнд нарийн учир нь тодорч гарах байх аа.

Төрийн **тогтолцооны** хувьд би санал хийх шаардлагатай гэж үзэж байна. Сонгогчид маань ч үүнийг хэлж, даалгаж, зөвлөж байсан ийм учиртай. Тэгэхлээр манай эх орны хувьд бол парламентын засаглалтай байх нь зүйтэй юм болов уу. Тэгэхдээ хоёр танхимтай байх. Хоёр танхимын дээд танхим буюу Их хурал гэдэг нь 125-130 орчим гишүүнтэй, үүнээсээ Бага хурлаа байгуулах, Бага хурал буюу доод танхим нь 23-25 орчим гишүүнтэй, хороод ннэ дотроо ажиллахдаа заавал, ер нь Бага хурлын гишүүд буюу доод танхим бол заавал депутатууд юмуу Их хурлын гишүүн байх нь зохимжтой. Тэгээд хороодууд нь янз бүрийн мэргэжлийн эрдэмтэн, мэргэдээс оруулсан ийм байдлаар оруулбал зүйтэй болов уу гэсэн зүйлийг хэлмээр байна. Ер нь бол ийм хоёр танхимтай парламенттай байх явдал бол энэ манай Их хурлын II хуралдааны уур амьсгалаас зайлшгүй хэрэгтэй байна. Ер нь харилцан уялдаатай, ерөнхийлөгч ч гэлээ гэсэн, доод танхим нь ч гэлээ гэсэн дээд танхимдаа буюу Их хуралдаа тайлагнадаг, тэгэхдээ тайлан бол заавал одоогийнх шиг хугацаа заахгүйгээр хоёр жил хагасад ч юмуу, хоёр жилд ч юмуу, аль эсвэл шаардлагатай үед ч юмуу хуралдаг ийм байгаад Бага хурал маань хуулиа баталж байдаг, хэлэлцэж байдаг, ийм л байдлаар байвал зүйтэй юм болов уу гэж. Цаашилбал хөдөөгийн засаг захиргааны зохион байгуулалтын хувьд төсөлд зааж байгаа зүйлийг зүйтэй гэж үзэж байгаа юм. Тэгэхдээ хошуу гэдэг үгийн ард таслалын ард байдаг юмуу аль эсвэл

хаалтан дотор сум гэдэг үгийг тавьж өгөх нь зүйтэй байх аа. Сум үгүй болсны дараагаар өнөөдрийн батлах гэж байгаа хуулийн хэмжээгээр буюу аль эсвэл биднийг батлагдсаны дараагаар нөгөө хошуу гэдгийг чинь ойлгоод баахан сумдуудыг нэгтгэх гэсэн ийм бас л нэг захиргаадсан хэлбэр гараад ирж болох юм. Ер нь эх орныхоо байдлыг бодоод, үзээд байхад зарим нэг хангайн юмуу тухайлбал, Төв, Сэлэнгэ, Булган гэх мэтчилэнгийн аймгууд Дархан, Эрдэнэт хот юмуу Хөтөл гэх мэтчилэнгийн газрууд нь хошуу болоход баруун, зүүн юмуу говийн аймгууд тэр их нутагтай, цөөхөн хүн амтай ийм газар бол хошуу болгочихвол нөгөө сум маань баг болоод эцэстээ баахан эзгүй нутагтай, ер нь тэгээд хүмүүсүүд нь хошууныхаа нутгийг бараадсан, аль эсвэл аймгийнхаа төв рүү хошуурсан ийм байдлаар явагдаж мэдэх юмаа. Ер нь манай монгол эх орны нутаг хязгаар болгонд мал сүрэг нь багширч, малчны бор гэрийн тоононоос аргалын утаа боржилж байвал бид нутагтаа эзэн байж, ингэж ёстой Тиймгүй бол төвлөрөл рүү дамжиж, ард түмэн маань төвлөрсөөр ирсэн ийм байдалд сүүлийн хэдэн 30-аадхан жилд асар их хөдөлгөөн үүснэ шүү дээ. Үүнийг бид бодолцохгүйгээр болохгүй юмаа.

Цаашилбал баг гэдгийг ямархуу байлгах юм бэ. Баг гэдэг чинь ямар хэмжээ хязгаартай юм гэдэг өнөөдөр тодроогүй байна. Ийм нөхцөлд бол сум гэдэг үгийг шууд хошуу болгоод баталчих ийм бололцоогүй гэж үзэж байна. Цааш нь энэ Үндсэн хуулийн Их цаазын төсөлд орж байгаагаар Шүүхийн засаглал буюу хуулийн байгууллагуудын тухай асуудал бол хэтэрхий олон болсон, тэгээд эрх мэдэл эзэлсэн иймэрхүү байдалтай байна. Тийм учраас үүнийг анхаарч үзэж депутатуудын хэлж байгаа саналыг манай байгуулагдсан хороо юмуу ажиллаж үзвэл зүйтэй болов уу. Энэ асуудлын талаар, бусад асуудлуудын талаар тухай тухайн үеийнх нь асуудлын үед саналаа хэлбэ гэж бодож байна. Ингээд энэ ерөнхий шүүмжлэлээс тодорхой руугаа орж зүйл анги руугаа, хэлэлцэх асуудлаар санал хураалгах асуудлыг хийж өгвөл зүйтэй болов уу гэж санал тавих гэж байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

*Д. Баяндүүрэн*

/Д. БАЯНДҮҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

96 дугаар тойргийн депутат Н.Сэндэнжав: Их цаазын төслийг боловсруулах талаар Улсын Бага Хурал, түүний комисс, гишүүдээс гаргасан хүчин чармайлтыг зохих ёсоор үнэлж байна. Ингээд Их цаазын төсөл, баримт бичгийн талаар өөрийнхөө үзэл бодлыг гурван асуудлаар тодорхойлж хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт Их цаазын утга агуулга, чиглэмжийг авч үзэх юм бол Их цаазад манай орны нийгэм эдийн засгийн хөгжил, улс төрийн байдал, окуны соёлын хөгжлийн өнөөгийн түвшинг бүх талаар нь шинжлэн дүгнэж, Монгол орон ямар замаар замнах, улс орноо ард түмэн хөглөх гол гол асуудлуудыг тусгасан улс төрийн баримт бичиг байх ёстой гэж үзэж байгаа. Энэ утгаар нь авч үзэх юм бол Их цааз маань хууль эрхийн чиглэмж давуутай ийм баримт бичиг болсон байна. Ийм учраас Их цаазын бүлэг, зүйл тус бүрийг авч хэлэлцэхдээ хууль эрхийн процедурын чиглэлтэй асуудлыг хасаж Их цаазыг цомхон баримт бичиг болгох талаас нь анхаарч үзүүштэй зүйл гэж үзэж байна.

Хоёрдугаарт Их цаазын хамт Монгол орны нийгмийг хөгжүүлэх Концепци, улс орныг хямралаас гаргах Үндсэн чиглэл, бусад онц арга хэмжээнүүд боловсрогдох учиртай. Эдгээр баримт бичигнүүд Их цаазын төсөлтэй хамт боловсрогдоогүй учраас Их цааз нүцгэрч хэрэгжих баталгаа бага байгаа бололтой харгдаж байна.

Гуравдугаарт Их цаазыг бид манай орны хөгжлийн энэ шилжилтийн үед үйлчлэх үндсэн баримт бичиг гэж ойлгож байгаа. Үүнийг тайлбарлах шаардлагагүй байх гэж бодож байна. Ингээд Их цаазын төсөлд тусгагдсан асуудлуудтай холбогдуулаад Их цаазын төсөлд нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байгаа хоёр асуудлаар өөрийнхөө бодлыг хэлье гэж бодож байна. Нэгдүгээрт Их цаазын маань гол ноён нуруу, амин сүнс бол Монголын хоёр сая хүн, манай орны нийт хөдөлмөрчид байх ёстой. Ард түмнээ дээдлэх, ард түмэн төр засгаа байгуулж дэмжих, хариуцлага хүлээлгэн огцруулах ийм эрхтэй байх ёстой. Их цааз бол төрийн байгууллагуудыг ард түмний дээгүүр гар-

гахаас болгоомжилж хаасан ийм чиглэл энд зарчим тусгалаа олох ёстой. Чухамхүү ингэж байж л өөрчлөлт шинэчлэлтийн учир утга ойлгогдоно байх гэж би бодож байгаа. Үүнтэй холбогдуулаад Их цаазын төслийн нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлд Засгийн бүх эрх бид ард түмэн мэднэ гэж. Иймэрхүү маягийн заалт бидний өөрчлөх гээд байгаа энэ хуучин үндсэн хуульд бий. Энэ заалт маань хэрхэн яаж биелж ирсэн бэ гэдгийг өнөөдөр бид мэдэж байгаа. Энэ утга агуулга цаашдаа хэвээрээ үлдэж байна. Өөрөөр хэлбэл төр, төрийн байгууллага гэдэг маань ард түмний дээгүүр тавигдсан хэвээрээ үлдэхнээ. Ард түмэн маань төр, засгаа байгуулж, дэмжиж, хариуцлага хүлээлгэн олцуулах хариуцлагын тал нь Их цаазын төсөлд алга болжээ. Энийг хэд хэдэн депутат нөгөө талаас тайлбарлаж ярьж байсныг дэмжиж байна.

Хоёрдугаарт Их цаазад улс төрийн сөрөг хүчийг зөвшөөрсөн заалт нэмж оруулах шаардлагатай гэж үзэж байгаа юм. Сөрөг хүч бол нийгмийн хөгжлийн бодлогыг зөв чиглэлээр, олон түмний санаанд нийцэхүйцээр боловсруулж, хэрэгжүүлэх том сургууль бөгөөд гадны даралт шахалт, түрэмгийллээс улс орноо сэрэмжлэх соргог хүч гэж үзэх ёстой. Чухамхүү ингэснээрээ манай нийгэмд олон ургальч үзлийг төлөвшүүлэх, ардчиллыг хөгжүүлэх, тогтоох бас нэг тодорхой баталгаа гэж үзэж байна. Эцэст нь Их цаазын төсөлд зохих тусгалаа олсон газар эзэмших хэтийн тухай засаг захиргааны зохион байгуулалтын бүтэц, удирдлагын тухай асуудлаар улсын нэр, үндсэн хуулийн нэр, улс орны бэлэг тэмдэг, туг далбаа, улсын Их Хурал, Парламентын засаглалтай холбогдсон, улс төрийн тогтолцоотой холбогдсон асуудлаар уг хэлсэн депутатуудын нэлээд хэсэгтэй санал нийлж байгаа тэд нарын үндэслэлийг дэмжиж байгаа учраас өөрийн тодорхой саналыг Их цаазын төслийн бүлэг, зүйл бүр дээр ярилцах үед тодорхой хэлбэ гэж бодож байгаа.

За баярлалаа.

Харжаубай:

За тэгэхээр хүндэт депутатуудаа би та бүхэнд нэг зүйлийг танин мэдэхүйн талаас тайлбарлаж ярьж өгөх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Яагаад ингэж байна гэвэл. Та нар намайг мэдэхгүй байж болно. Би бол Монголын эртний түүхийг судалдаг эртний түүхч хүний хувьд нэг зүйлийг ойлгуулъя гэж бодож байна. Гэхдээ би санал бодлоо та бүхэнд тулгахгүй. Гэхдээ морио авахуу, шувуугаа авах уу, энэ <sup>Та</sup> бүхний сонголтын асуудал байгаа юм.

Ерөөсөө энэ нүүдэлчид, тэр дотроо энэ монголчууд маань хүнээ ясан төрөл, цусан төрөл гэж хоёр хувааж байгаа юм. Энийг та бүхэн сайн мэднэ. Ясан төрөл гэдэг маань эцгийн тал, цусан төрөл гэдэг маань эхийн тал байгаа юм. За ясан төрлийн дээд тэнгэрээс их тэнгэр, тэнгэр, дэд тэнгэр маань байна. Энэ билэгдэл нь нар. За цусан төрлийн билэгдэл нь газар, тэрний билэгдэл нь нэг талаас сар. Нар, сар гэсэн хос хос үйлдэлтэй байгаа юм л даа. Тэгэхээр жинхэнэ тэр сүлдэр, уг нь сүлдэр гэж хэлдэг юм шүү энийг бол. Би сүүлийн үед энийг сүлд гэж ингэж хэлдэг боллоо. 17 дугаар зуунаас хойш сүлд гэж хэлдэг болсон. Сүлдэр нь жинхэнэ тэр Хяд аймгийнх, Нян Дарлигийн угсааны Хяд аймгийн сүлдэр нь бол цагаан шонхор шувуу байдаг юм. Энэ ямар ухаантай юм бэ гэвэл тэр их тэнгэрийн элч гэсэн уг. Энэ бол маш их нууц байдаг байсан. Дээр үед өөрөөр хэлбэл Чингис хаан хүртэл мянган жил хүртэл мянган жилийн дотор тэр монголчууд амьдарч байсан юм бол бол тэр Хяд аймгийн улсууд тэр сүлдрээ бас нууж далд байлгадаг байсан юм. Өөрөөр хэлбэл нөгөө манжлага байна шүү дээ манжлагны дотор тугийн голд ороож нууц байдалд байлгадаг байсан юм байгаа юм. Энэ маань Чингисийн үед ил гарч ирсэн, ил гаргасан байгаа юм. Тэгэхээр Чингисийн үе маань ямар юм бэ гэвэл, энэ маань бөөгийн шүтлэгийн үе шүү дээ. Дараа нь бид шарын шашин авсан, бурханы шашин бас байгаа. Тэгээд шарын шашин авлаа. Дараа нь бидэнд тодорхой энэ марксизм, ленинизм гээд явчихаж байна шүү дээ. Тэхээр асуудал ийм байна. Сая энд би хэлж байна шүү дээ. Цусан төрөл, ясан төрөл гээд. Цусан төрөл, ясан төрөл гэдгийг бол нэлээд настай улсууд, бараг энд байгаа улсууд бол мэдэж байгаа л даа. Сайн мэддэг. Тэгэхээр энэ дотор бол ус юуг газраар төлөөлж ярихад бол уул маань нөгөө эцгийн талын бөлөг тэмдэг, ус маань эхийн талын бөлөг тэмдэг. Өөрөөр хэлбэл энд бол сая хэллээ шүү дээ. Хатан туул, хан богд гэж. Энэ мэтчилэнгээр хувааж ярьдаг. Энийг бол энэ талаас нэг ойлгочихвол. Тэгээд бас түүхийн

нэг тодорхой баримт байдаг юм. Энэ Чанхын сүм гэж байсан. Архангай аймгийн Хархорины тэнд. Эндээс бол 1924 онд нэг туг авчирсан байгаа юм. Жамьян гуай. Тэгээд тэр тугийн манжлаган дотор Сүлдэр байсан. Тэр сүлд маань ямар сүлд байсан бэ гэхээр хар эрээн барс байсан. Хар эрээн барс. За энэ хар эрээн барс яагаад гарч ирсэн бэ гэвэл нөгөө эхийн талын, газрын төлөөлөл эхийн талын билэгдлийг төлөөлөл маань нэг талаар барс, тэгээд могой, луу гэх мэт ингээд явдаг юм. Тэгээд энэ дайны хар туг учраас тэр талыг нь нэг авсан юм бололтой байгаа юм л даа. Гэтэл энэ Луу гүний сүм гэж байсан. Та бүхэн сайн мэднэ. Одоо Увс аймгийн нутаг. Энд энэ эрдэмтэд сонин мэдээ олсон байгаа юм л даа. Энд бол ингэж гарч байгаа. Хөгшчүүд нь ярьж байгаа юм л даа. Тэгээд тэр туг нь бол, сүлд нь бол алга болсон. Тэгээд хаана байгаа нь тодорхойгүй, хөгшчүүд ярихдаа ингэж ярьж байгаа. Чингисийн сүлдэр байсан гэж байгаа юм. Тэр туган дотор. Энэ бол Чингисийн жинхэнэ цагаан туг. Тэрний сүлдэр нь юу байсан бэ гэвэл морь байсан гэж ярьдаг. Морь. Энийг тэр настай улсууд бол 1924, 1925 оны үед бол манай тэр үеийн том том эрдэмтэд, тэр Дэндэв гуай, Жамьян гуай эд нарт тэмдэглүүлж хэлсэн байна л даа. Тэгэхээр би юугаа авах вэ гэдгийг өнөөгийн нөхцөлд, ялангуяа одоо бидэнд буддын шашин бол голлож байна шүү дээ. Шашны хувьд бол. За үзэл суртлын хувьд бол чөлөөтэй ингээд болчихлоо. Тэгэхээр энийг бол ард түмэн маань өөрөө сонгож, ялангуяа депутат бол нэг тийшээгээ туйлшралгүйгээр ер нь бодож болгоож байж авбал яасан юм бэ. Тэгэхээр энэ талаар ганц санал дэвшүүлэх гэсэн юм.

Энэ удаад энэ сүлдээ бид түр гэдэг тодорхойлолтоор баталчихаж болох юм. Тэгэхээр энэ нөгөө сүлдээ, жинхэнэ сүлд, сүлдрээ бид бол юугаа яаж авах асуудлыг бол ер нь тусгайд нь авч үзвэл яасан юм бэ. Бас одоо сая авъяаслаг, Авъяас гэдэг хамтлаг, пүүс маань нэг уралдаан зарласан байна шүү дээ. Тэр уралдааныг зарим нэг материал нь энд байж байна. Тэр нэг хоёр тийшээ гарсан морь, хууртай энэ улсуудтай, тэр зураачтай, Эрдэнэтөгтох гэсэн байхаа, тэр зураачтай бид бас ярьж уулзаж, тайлбарлуулж болох байх гэж бодож байна. Энэ сүлд гэдэг маань, улсын сүлд маань орчин үед улсын сүлд гэдэг маань мон-

голчууд бид бие биенийгээ мэднэ. Энэ бол ойлгомжтой. Бидэнд энэ ямар нэг тэмдэг, юугүйгээр бид ойлгоно. Тэгэхээр сүлд гэдэг маань гадаад ертөнц рүү хардаг юм шүү дээ. Монгол гэхэд бол ерөөсөө бүх хүний нүдний өмнө бол давхиж байгаа морьтой хүн л харагдана л даа. Тэгэхдээ Монгол гэдгээ төлөөлдөг нэг зүйл бол далбаан дотор төлөөлдөг юм бол сүлд нь байдаг юм. Тэгэхээр энүүгээр танигдах ёстой. Нөгөө талаар бидний өмсөж байгаа баг гэсэн үг. Хуучин социализмын үед бид ямар багтай байсан билээ. Энэ багаа өөрчлөхгүй бол гадаад ертөнцөд биднийг хүлээж авахгүй.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч

ЭНХТУЯА

В. ОЖУН

Б.Энхтүяа /388 дугаар тойргийн депутат/ -Тут, сүлд, төрийн дуулал энэ бүгдийг өөрчлөх ноцтой шалтгаан байхгүй учраас хэвээр нь үлдээе гэсэн саналтай байна. Манай сүлдэнд хятадын луу байхгүй, хойно байгаа улсын маань 16 сүлдтэй адилхан гэж үзэж байгаа юм. Гэхдээ миний бодлоор бол тэд удахгүй тэр 16-гаа өөрчлөх байх гэж бодож байна. Сталины хэлсэн үгийг нэгэн үг бурхныхаа сургаалаас илүү зөв гэж дагаж байсан, өнөөдөр Сталин л хэлсэн бол ямар ч юм байсан буруу гэж туйлширч болохгүй байх.

Үнэн үгийг дайсан ч хэлсэн байсан авах хэрэгтэй, үндсгүй худлаа үгийг нөхөр нь ч хэлсэн байсан орших хэрэгтэй. Морь, шувуу хоёрын аль нь илүүг маргаад яахав. Шувуу дагаж ниссэндээ ертөнцийн талыг эзлээгүй байх, монгол морьны гайхамшигт шандсаар эзэлсэн юм болов уу гэж бодож байна. Морио алсан, галт тэргэнд ачиж явуулсан, ертөнцийн нарыг коммунизмынх болгосон бидний л буруугийнх.

Төрийн сүлд бидэнд хийсэн нүгэл байхгүй. Бид төрийн сүлднийхээ өмнө буруутай гэж бодож байна. Хамгийн ноцтой, бидний авах гэж байгаа шувуу гэдэг маань 1200 оны үеийн сүлд болох нь байна. 1200 он гэдэг маань нэгдсэн монгол улс байгуулагдаагүй байсан тийм үе. Тэр үед төв азийн элгэн дээгүүр маш олон өөр шашин шүтлэг, зан заншилтай, ямар улс болохоо мэдээгүй байсан олон овог аймгууд нүүдэллэн, хэрэн хэсэн олзлон булаалдаж байсан юм. Тэр үеийн тэр он тооллын сүлдийг сэргээнэ гэдэг бол галаар наадаж байгаатай адилхан аюултай хэрэг юм.

Биднийг шувуутай сүлдээ авлаа гэнгүүт уламжлалаа сэргээж байгаа юмдаа гэж бодоод хөрш орнууд маань уламжлалт газар нутгийг маань буцааж өгөхгүй. Харин ч нэгдсэн монгол улс байгуулахаас өмнөх үеийн түүхийн улбаанаасаа өөр улс орон, улс үндэстэн энэ сүлд чинь биднийх, бид нутгаа авъя гэхийг байг гэх



газаргүй.

Ер нь монгол мориныхоо нуруунаас буух нэг нь бууж л байг, монгол улс : мориныхоо нуруунаас бууж болохгүй. Морьтой монгол хүн сүлднээсээ бууж болохгүй гэж бодож байна. Энд ямар ч оюуны хоосрол байхгүй. Хэн нь хоосроод байгааг цаг хугацаа шалтана. Манай сүлдэнд байгаа таван хошуу бол оросын юм биш байх гэж бодож байна. Энэ бол олон улс үндэстний далбаан дээр байдаг, нар сар хоёр дээр маань од нэмэгдлээ гэж үзэхэд харшлах шалтгаан байхгүй.

БНМАУ гэдэг нэрийг алдах юм бол БНМАУ-аа алдах нөхцөлийг бүрдүүлчихэж магадгүй юм. Ард гэдэг үгийг би ангийн ялгаа гэж бодохгүй, ард түмэн гэж бодож ирсэн. Миний үеийнхэн ч гэсэн мөн адилхан, миний үр хүүхэд ч гэсэн тэгж бодох байх гэж бодож байна.

Монгол улс гэдэг нэрийн дор ямар нэгэн улс орныг байгуулчихыг байг гэх газаргүй гэдэг ийм сэрэмж төрдөг юм. Нармай монгол улсыг байгуулах, эх газартаа эргэж гарна гэсэн наран улсын бодлого хэвээрээ байгаа. 1945 онд бууны сум, сэлэмний ирэнд бууж өгөөгүй монголчууд өнөөдөр доллар, иенд бууж өгч олзлогдож байгаа. Япончууд сүүлийн үед эх газартаа ирлээ, хөх толботой хүүхэд төрдөг гэх мэтээр их ярьж байгаа.

Соёмбоны тухай дээр бол хүн төрөлхтөний оюуны өв юмаа. Энийг бид өөрсдийн уламжлалт нар, сар, гал гурваараа монголчлоод өөрийн болгочихсон байгаа. Энэтхэг гаралтай гэж ганц нэг хүн хэлж байгаад сэтгэл эмзэглэж байна. Энэтхэг гаралтай гэж бид бурхнаа, гүнгэрваанаас нь гаргаад шилбүүр барьсан морьтой хүнийг оруулаагүй л байгаа шүү дээ.

БНМАУ-ын төрийн дууллын үгийг өөрчлөх ноцтой шаардлага байхгүй болов уу гэж бодож байна. Цаг үеийн шахалтаар орсон нэр устай нэг бадаг нь тэр цагаа өнгөрмөгц хасагдчихсан. Одоо үлдэх ёстой бадаг нь дуулагдаж байгаа гэж санаж байна.

## 3.

"Ардын эрх" сонинд гарсан төрийн дууллын үгийг ажиглахад хуучин дууллын ядмаг хуулбар болсон гэдгийг яруу найрагчийн хувьд хэлмээр байна.

"Дархан манай хувьсгалт улс" гэдэг үгнээс эмзэглэх хэрэггүй юм. Энэ хувьсгал бол октябрийн хувьсгал ганцаараа байгаа юм биш ээ. Хувьсгал одоо ч үргэлжилж байна. Ер нь бид цаг ямагт л хувьсгал хийж байгаа шүү дээ. Даяар монголын ариун голомт дайсны хөлд хэзээ ч орохгүй гэдэг энэ гайхамшигтай мөр, даяар монгол гэдэг үгэнд манай бүх иргэд, ард түмэн багтдаг бол ариун голомт гэдэг үгэнд манай түүх багтдаг юмаа.

Монгол улс тэлж ч байсан, хумигдаж ч байсан. Энэ бидний байгаа газар бол монголын ариун голомт юм гэсэн үг. Цаашдаа бас тэлж ч болно, хумигдаж ч болно. Гал голомтондоо дайсны хөлийг гишгүүлэхгүй гэсэн санаа байгаа.

Зоригт монголын золтой ардууд зовлонг **тонилгож** жаргалыг эдлэв гэдэг мөрөнд ертөнцийн амьдралын мөн чанарыг шингээсэн мөнхийн утга байгаа гэж үзэж байна. Зовлонг **тонилгож** дуусдаггүй, жаргалыг ч эдэлж дуусдаггүй. Энийг манай өнөөдрийн өөрчлөн байгуулалт харуулж байна. Энэ дууны үгний утга тэгэхээр хуучрахгүй. Үг болгоныг задалж та бүгдийг чилээгээд яахав. Ер нь эд нарыг өөрчилнө гэдэг бол эдийн засгийн бүрэлгэн сүйтгэх улс төрийн бодлогын алсын хараагүй, үзэл суртлын туйлшрал болж байна уу гэж бодож байна.

Тут, сүлд өөрчлөх, нутаг дэвсгэрээ дахин дахин хуваарилж, хүн амаа хооронд нь дайсангуулах ийм ажил бол бидний гол ажил бишээ гэж бодож байна.

Түүхийг сөхөх юм бол бид нар өөр юм сөхөх хэрэгтэй. Газраа түрээслээд тэр чигээр нь алдчихсан манай түүхийн гашуун сургамжийг эргэж саная. Хэдэн зуухан жилийн өмнө байгаа. Газар маань улсынх байг. Улсын газарт тарьсан ногоо хувийнх байг гэж

бодож байна.

Гадаадын иргэд үйлдвэр, пүүсээ байгуулаг яахав явахдаа алт мөнгөө аваад явна биз, бид нутагтаа үлдье гэж бодож байна.

Улсынхаа нийслэлийг Улаанбаатар гэж оруулах саналтай байна. Энэнээс гадна Ерөнхийлөгчийн засаглалтай улс байх нь дээр болов уу гэж бодож байна. Ерөнхийлөгч маань эрхтэй, үүрэгтэй, энэ бүхэн нь, би яагаад ингэж хэлж байгаа юм бэ гэвэл, мянган толгойтой нэг сүүлтэй могой мянган толгой нь хоорондоо хэрэлдэж байгаад тэргэнд дайрагдсан, нэг толгойтой мянган сүүтэй могой мянган сүүлээ чирээд аваад гарчихсан гэдэг үлгэр байдаг. Тэгэхээр тэрнийг бас энэн дээр нэг бодвол яасан юм бэ?

Харин Ерөнхийлөгч маань Засгийн газартай орооцолдохгүй байх нь дээр байх. Бүх цэргийн жанжин болох нь төрийн эргэлт гарахгүй байхын баталгаа болж магадгүй юмаа гэж бодож байна.

Ж. Уртнасан -Нэг минут үлдэж байна.

Б. Энхтуяа -Дахин давтан үг хэлэх ёстой таван минут, гурван минутыг маань нэмж өгнө үү. Би нэг шинэ санал оруулах гэсэн юмаа.

Миний хуулинд оруулах саналыг би дэмжинэ гэдэгт депутатуудад итгэж байна. Энэ маань юу вэ гэхээр Цагаачлалын хуулинаас монголчууд бүгдээрээ айж байгаа. Хоёрхон сая хүнтэй юм чинь айхгүй яахав. Гадаад улс манайд сая сая доллар өгч байна. Сая сая шуудай гурил ч өгч байна. Нэг ширхэг ч гэсэн монгол хүнийг өгөхгүй байгаа. Жирийн нэгэн эмэгтэй ямар ч баян гүрний өгч чадахгүй байгаа монгол хүнийг төрүүлж өгч байгаа. Сая долларынхаа араас эзэн нь ирэхийг байг гэх аргагүй. Эх хүн бол үр хүүхдээ үлдээгээд явдаг жамтай.

Тэгэхээр монгол улсын тусгаар тогтнолын баталгаа болсон монгол улсын үйлдвэрлэх хүчний хүчин болсон энэ даяар монголын

үр садын тухай асуудал бол монголд төрийн бодлогыг хүлээж энэ асуудал ихээхэн хохирч байна гэж ингэж үзэж байна. Энэ төрийн бодлогыг Үндсэн хуулиараа баталгаажуулж өгмөөр байна.

Илүү хүн төрмөгц хүнс, хоолыг нь хасдаг хятадын төрийн бодлогоос манай төрийн бодлого өөр байх ёстой гэж бодож байна. Өнөөдөр төрж байгаа монгол иргэд чинь өлгийгүй байна шүү дээ, хамгийн наад зах нь. Өнөөдөр хамгийн олон хүүхэдтэй эмэгтэйчүүд 34-44 насандаа тэтгэвэрт хөөгдөн гарч, хүүхдүүд нь өлсөж, өмсөж зүүхээр гачигдаж, хүүхэд төрүүлэх сонирхол эрс багасаж байгаа.

Төр иргэнээ тэжээх цаг болжээ гэж хэлмээр байна. 17 нас хүртэл нь иргэнээ тэжээг. Төр иргэн улс төрдөө насан туршдаа зүтгэг. Олон хүүхэд төрүүлсний хүүхдийн тэтгэврийн мөнгийг аваад 10 хүүхэд төрүүлсэн байлаа ч гэсэн ажил хийхгүй байж болох бололцоог төрийн алсын хараагаар тавьж өгнө үү. Энэ бол эмэгтэйчүүдийг ажил хийлгэхгүй, гэрт нь хүүхэд гаргана гэсэн үг биш. Үр хүүхдээ тэжээх эцэг, эхийн ачааллыг төр, засгаас хөнгөлж үзнэ үү гэсэн үг юм. Миний хэлэх үг одоо дуусах нь ээ.

Энийг Үндсэн хуулиар баталгаажуулахгүй бол зах зээлийн үеийн Засгийн газар ажил ч өгөхгүй, хоол ч өгөхгүй байж байгааг бид нар харж байна шүү дээ. Тэгэхээр энэ тэтгэмжийг саятан, хувийн өмчтөн гарч ирж байгаа нөхцөлд албан татварын хуулиар зохицуулж болно гэж бодож байна. Энэ ариун үйлсэд хөрөнгө хандивлах эх оронч монгол хүн ч олон байгаа гэдэгт итгэж байна.

Ж.Бямбаноров /305 дугаар тойргийн депутат/ -Ард нийтээр хэлэлцүүлж, Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьсан Их цааз буюу Үндсэн хуулийн шинэ төсөл нь улс төрийн тогтолцооны хувьд парламентат ёс, эдийн засгийн харилцааны хувьд зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед нийгмийн амьдралын гол гол асуудлуудыг тэр дотроо Үндсэн хуулиар шийдвэрлэж болох

## 6.

бүх асуудлыг олон улсын хууль зүйн түвшинд хүргэж шийдэх гэснээрээ энэ бол эрмэлзэл сайтай, санаачилгатай ийм хууль болсон байна гэж үзэх үндэс байна. Гэвч хөдөө орон нутаг, ард түмэн, орон нутгийн Ардын Хурал, захиргааны саналыг тун бага тусгасанд харамсалтай байна гэж үзэж байна.

Бид ардчилал, өөрчлөлт, шинэчлэлтээс ухрахгүй. Ухраа ч үгүй. Тэгэхдээ юуг өөрчлөх, юуг уламжилж авч үлдэх, өөрчилбөл хэдийд яаж өөрчлөх вэ гэдгийг сайтар тунгааж, олон түмнийхээ санал бодлыг харгалзах нь юу юунаас чухал гэж үзэж байна. Ингээд Их цаазыг Үндсэн хууль гэж нэрлэх саналтай байна. Хаанаас нь ч үзэж харсан энэ Үндсэн хууль юм. Улсын нэрийн хувьд БНМАУ байх, сая хүн ярилаа, олонхи нь ийм саналтай байна. БНМАУ гэдэг нэрээр бид НҮБ-д элссэн. Энэний цаана эдийн засгийн асуудал ч, олон улсын харилцааны асуудал ч нэр өөрчлөхөд гарч ирэхгүй гэх үндэстгүй, энийг бид сайтар ойлгох хэрэгтэй гэж үзэж байна.

Сүлдний хувьд морь унасан монгол хүн сүлдэндээ үлдэх байх. Ер нь монголын төрийг тогтоход морь заавал оролцоод байгаа юм. Чингис хаан ч морьтойгоо явж, тулгар төрөө байгуулсан. Манжийн дарлалаас бид морьтойгоо явж ялалт байгуулж, улс төрөө автономит монгол улсыг тогтоосон. 1921 оны ардын хувьсгал жанжин маань морьтойгоо явж үүнийг хийсэн.

1990 оны ардчилсан тогтолцоо, улс төрийн шинэ тогтолцоог цагаан морин жилдээ хийсэн. Ийм учраас монгол хүн морио бэлгэдэх нь зүй ёсны хэрэг гэж үзэж байна. Коммунизмын тэр улаан нар гээд байгаа тийм нар байхгүй. Ертенц ганцхан нартай. Тэр нараар нь тодорхойлчихвол болох байх.

Далбааны хувьд алтан соёмбот энэ далбаандаа ард түмэн дуртай байгаа гэдгийг хэлбэ.

Газрын асуудал их анхаарал хандуулж байна. Газар бүх нийтийн мэдэлд, тэр тусмаа төрийнхөө өмчинд байх нь зүйтэй. Өөрийнхөө иргэдэд газрыг эзэмшүүлэх хэлбэрээр өмчлүүлж болох

юм. Энэ эзэмшүүлэх хэлбэрээр өмчлүүлэх асуудлыг юу гэж хэлж байна вэ гэвэл үр удам нь өвлөн эзэмших эрхтэйгээр газрыг эзэмшүүлж болох юм. Харин гадаадынханд бол түрээсээр эзэмшүүлж байх нь зүйтэй байх. Энэ цаанаа бас нээлттэй эдийн засгийн бодлого, орчин үеийн эдийн засгийн зах зээлийн асуудалтай холбоотой байгаа учраас энийг тэр хуульд туссанаар нь тэгж заах нь зүйтэй гэж үзэж байна.

Парламентын бүгд найрамдах улсыг зөвшөөрч байна. Тэгэхдээ танхим хоёр танхимтай байх зайлшгүй шаардлагатай байна. Дээд доод танхимтай. Өөрөөр хэлбэл одоогийн улс төрийн энэ тогтолцоог боломжийн тогтолцоо гэж үзэж байгаа. 1990 онд тогтоосон энэ тогтолцоог бид санамсаргүй тогтоогоогүй. Энэ нэг жил гаруй ажиллалаа. Бас чиг зохих шийдвэр, гарах ёстой хуулиудаа гаргаж, ард түмнийхээ өмнө хийх ёстой юмаа хийж байна. Гэвч олон алдаа бий. Үүнийг шүүмжилж болно.

Тэгэхээр харин төлөөллийн чанарыг нь дээшлүүлж, одоогийн Их цаазын төсөлд зааснаар биш Улсын Их Хурлыг 150 орчим гишүүнтэйгээр, Улсын Бага Хурлыг доод танхимыг харин тоогий нь цөөлж 30 орчим юм уу, тэр хэмжээний гишүүдтэйгээр дээд доод хоёр танхимтай байхгүй бол болохгүй юм шиг санагдаж байгаа. Сонгогчид олон түмэн ч ийм саналтай байгаа.

Улсын Их Хурал жилд нэг удаа хуралдаж, Улсынхаа Бага Хурал буюу доод танхимынхаа тайланг сонсдог, Засгийн газрынхаа тайланг сонсдог байх нь зүйтэй.

Үндсэн хуулийн цэцийн хувьд энэ бол шинэ зүйл, энэ зүйтэй юм. Тэгэхдээ гишүүдийн тоо нь хэт олон байна. 9 гэдэг бол олон байна. Тоогий нь цөөлж, тав болгох нь зүйтэй. Хугацааг ч гэсэн Их Хурлынхаа хугацаагаар сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

Ерөнхийлөгчийн хувьд хоёр шаттай сонгууль явах нь зөв байх. Улсын Их Хурлын хугацаагаар сонгогдож байвал зохимжтой

8.

байх. Тэгэхгүй бол байж байгаад нэг сонгууль явуулдаг ийм сонгуулийн орон болж болзошгүй нь ээ.

Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын хувьд аймаг, сум, баг гэж байх нь зүйтэй байх. Багийг шинээр гаргаж ирж байгааг дэмжиж байна. Энэ ард түмэндээ засаг төр ойртоход хэрэгтэй юм. Гэвч хошууд байгуулаад сумдыг нэгтгэж эхэлбэл эдийн засгийн бухимдал дээр орон нутгийн бухимдал нэмэгдэж дээр нь үндэстэн, ястны маргаан ч гарахгүй гэх баталгаа байхгүй. Энэ талаас нь бид хандах ёстой.

Засаг даргыг Засгийн газрын Ерөнхий сайд нэг томилох, дороос ард иргэд буюу хөдөлмөрчдийн хурал нэг сонгох энэ хоёрын зааг дээр байгаа хүн гэдэг бол ямар баталгаатай юу байх нь тодорхой бус байна. Ер нь аймаг, сумдын Хурлын байгууллага ямар эрх хэмжээтэй байх нь тодорхой бус байна. Ингэхээр өөрөө удирдах ёсны тухай хууль гарвал энэ тодорхой болох байх. Энэ хуулийг яаралтай боловсруулж гаргах нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа юм. За ийм зүйлийг хэлье. Баярлалаа.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*Д. Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.16  
Кассет № Ш.-10  
12.51-13.00

Ж.Уртнасан: За баярлалаа.Эрхэм депутатууд аа, одоогийн байдлаар бидэнд хурлын удирдлагад 59 депутат бичгээр саналаа ирүүлээ.54 хүн үг хэллээ.Нэр бүхий 16 тойргийн депутат санал ирүүлж байна.Төрбиш, Гурбазар, Банзрагч, Буянмөнх,

Хүүхэнбаатар, Лханаасүрэн, Буяндэлгэр, Пүрэвжав, Цэрэнхүү, Шагдар, Цогт-Очир, Ван Бямба гээд... энэ 16 депутатын санал энэ ерөнхий саналыг тасалъя.Явгаад вэ гэхээр санал давхардаж байна, цаг бага, үнэ нь өндөр, тодорхой шийдэлгүй явж байна.Тохиролцоонд хүрэхгүй байна.Үлдсэн хэсэг нь бичгээр саналаа өгье.Танхимын уур амьсгал тодорхой хэдхэн зүйл дээр эргэлдэж байна гэсэн ийм үндэслэлтэйгээр ийм томъёоллыг ирүүлж байна.Санал хураалгаж өгөөч ээ, ерөнхий санал солилцох асуудлыг зогсоож, үдээс хойш бүлэг зүйл тус бүрээр хэлэлцэх асуудлаа хэлэлцэж эхэлье гэсэн ийм санал хураалт явуулж өгөөч гэж хүсч байна.

Танхимаас

Энэ олон түмэн сонгогчиддоо төлөөлж ирсэн улсууд энэ дотор байж байна.Ганц хүн боловч энэ танхимд хэлэхийг хүсч байна.Түүнээс санал таслахгүй шүү.

297 дугаар тойргийн депутат Тангад:Энэ болохгүй байхаа. Ер нь ижил санал бол их олон гарлаа.Өөр санал гаргаж хүн яагаад ярьж болдоггүй юм бэ? Би бол ярина, өөр юм ярина.

Танхимаас

Санал таслахгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.Ер нь нэг депутатын хөлс мөнгө, нөгөөхийгөө төлөөлнө гэж ямар нэгэн хуульд байхгүй байгааг анхаарна уу? Их Хурлын дарга.

Ж.Уртнасан:Баярлалаа, уур амьсгалыг мэдэрлээ.  
Одоо ...



Танхимаас:

Зарим нь их сонин байна.Өөрөө үгээ хэлчихээд, болихдоо одоо таслах нь зүйтэй байна, энэ ямар муухай, монголын ард түмнээсээ ичихээ байчихсан ийм юм ярьж байхаас болимоор юмаа. Бид нар өөр өөрийн гэсэн нааштай саналууд байх ёстой шүү дээ.Тэгтэл нөгөө талаас сая яруу найрагч Энхтуяа яриа биз дээ.Ямархуу утга учиртай, яаж хандаж ярьжбайнаа? жишээ нь. Тэгэхээр олон түмэн бас ярина шүү дээ.Хэсэг, 50-иадхан хүн ярьчихаад, бид нар дэгээ 2 өдөр хагас ярьсан юм чинь энэ Үндсэн хуулийнхаа өргөн санал шүүмжлэлийг яагаад нэг өдөр хагастай ярьж болдоггүй юм бэ? дор хаяад.Хэрэв маргааш бүтэн сайн өдөр, хэрэв болдоггүй бол маргааш бүтэн сайн өдөр үргэлжлүүлээд ярьсан ч болно шүү дээ, бүр хэдүүлээ хатуурья гэвэл.

Танхимаас:

Энэ хүмүүс үг хэлчихээд тасаллаа гээд байх юм.Би жишээ нь үг хэлээгүй байгаа.Тэгэхдээ цөмөөрөө ярья гэвэл 430 депутатаа цөмийг нь яриулъя.Хэрвээ яг тэгж асуудал тавибал. Бүр тэгж ярьж байгаад, дараа нь, мэдээж хүн болгон юм хэлье л гэж бодож байгаа.Тийм учраас нэгэнт олонхийн санал гарчихсан, давтагдаж байгаа ийм нөхцөлд хий дэмий цаг үрж, би л депутат, би л хэлэх ёстой гээд ингэж давтаж байх хэрэг байна уу?

Тийм учраас санал хураалтаараа энэ асуудлыг тасалмаар байна.Хэрвээ ярина гэвэл 427 депутат 427-уулаа үгээ хэлье тэгээд дараагийн асуудалд орьё.

Ярих нь зүйтэй байнаа.Заавал ижил санал гаргаж байх ~~балбаггүй~~ шүү дээ.Бусдыгаа сонсох хэрэгтэй шүү дээ.

427 дугаар тойргийн депутат Н.Элбэгдорж:

Хүндэт депутатууд минээ нэг зүйл дээр анхаараач ээ. Та бид бүгдээрээ тодорхой тодорхой хүмүүс сонгогчдыг төлөөлсөн.Та бидний дотор бие биенээ төлөөлөх эрх хэнд ч байхгүй.

Лав л намайг ямар нэгэн депутат төлөөлөхгүй гэж би бодож байна. Тэгээд энд нэг удаа цуглаж байгаагийнхаа хувьд та бүхний дунд энэ бүрэлдэхүүн дотор үгээ хэлэх ийм бодолтой байна. Үүнийг минь битгий хааж боогооч ээ. Ийм бодолтой депутатууд байгаа байхаа гэж бодож байна.

Танхимаас:

Асуудал маш их давтагдаж байна. Хурлын даргын зүгээс тэр асуудал давтагдаж байгаа энэ үед бол энэ асуудал чинь түрүүн хүн ингээд ярьчихсан, одоо та ижил юм ярьж байнаа, өөр юмаа ярихгүй гэж хэлж болох юу? нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид яах вэ үгээ хэлнэ. Хэлж болж байна.

Зарим нь бол бичгээр өгч байгаа. Үүнийг чинь бүгдийг нь телевизээр харуулдгийг нь харуулаад, хэвлэл дээр энэ хэлсэн үгнүүдийг нь чинь бүгдийг нь хүн бүр дээр биччихэж болохгүй юу? Ийм л сонирхол хүн бүрт байх шиг байна.

167 дугаар тойргийн депутат Ш. Гүрбазар: Эрхэм депутатууд аа, би нэг юмыг бодсоноо л хэлж байгаа юм. Хэрэв улсуудыг үг хэлүүлэх, хэлүүлэхгүйдээ цаг хэмнэх гэдэгтээ ч биш юм. Миний хувьд нэг эмзэглэж байгаа юм байна. Би тэр парламентын танхимд хууль ёс боловсруулж үзсэн биш. Надад бодоход, ер нь бид энэ хэлэлцүүлгээсээ болоод ямар нэгэн ёс горимын эсрэг юм хийгдэж байгаа юм биш байгаа. Болчихож байгаа юм биш байгаа. Яагаад гээч? Ерөнхий хэлэлцүүлэг ярьж байхад, ерөнхий хэлэлцүүлгээр юу ярих ёстой вэ гэдгээ тохироогүй ярьснаас болоод, зүйл рүү ярилаа. Зүйл рүү орноо гэдэг чинь, дараа хэлэлцэх ёстой юманд ямар нэгэн хэмжээгээр олонхийн саналд ухуулга шиг тийм нөлөө орж буруу болж байгаа юм биш байгаа. Жишээ нь бид өөрсдийгөө соёлтой байхыг хүссэн мөртөө бид асар бүдүүлэг юм өчигдрөөс хойш хийж байна шүү дээ.

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар гаргасан төрийн бэлгэ тэмдгийн комисс 6 сар ажлаа хийгээд, нэг хэсэг хүмүүж уран бүтээлээр мэрийж хийгээд, зүтгээд Их Хурлынхаа депутатуудад

үзүүлж байгаа юмыг чимээгүйхэн амаа хамхиж байгаад, зүйл дээрээ ярихын оронд тэр хүмүүсийн буруу юм шиг дайрч даншлаад загнаад байх хэрэггүй шүү дээ. Жишээ нь энэ чинь цаад хэлэлцэх Үндсэн хуулиндаа эвгүйгээр нөлөөлөх вий гэдэг талаас нь би эмзэглэж байгаа юм. Зарим зүйлийг чинь бид нар сүүлд нь ярих ёстой. Жишээ нь 4 хүнийг Их Хурлын депутатаар өрсөлдөж байхад нь бид сайхан сонсчихоод, нууцаар саналаа өгдөг болохоос, чамайг сонсохгүй, чамайг сонсохгүй гэж загнадаггүй биз дээ. Түүнтэй адилхан шүү дээ. Хуулиа л бодож байгаа юм.

61 дүгээр тойргийн депутат Д. Дамбийжанцан: Энэ үг хэлж байгаа улсуудыг эрхийг нь хязгаарлаж болохгүй. Юу вэ гэхээр энэ чинь манай монголын бүх хөдөлмөрчдийн санаа сэтгэлийг хэлэх гэж байгаа шүү, энэ улсууд. Тийм учраас бид нар асуудалд нэлээн ул суурьтай, нийт хөдөлмөрчдийгөө төлөөлсөн улсуудын үгийг сонсох хэрэгтэй. Үгүй дээ гэхдээ 427 депутатынхаа 50 хувийг ч гэсэн үг хэлүүлж байж асуудлаа шийдэхгүй бол хэдхэн хүн үг хэлүүлчихээд ингэдэг чинь юу болж байна вэ? Ялангуяа одоо халуун чулуу долоож, халуун цэг дээр байгаа хөдөөгийн хөдөлмөрчдийн санал сэтгэлийг аж ахуй, сумын дарга нар, нэгдлийн дарга нар, малчид, энэ хүмүүсүүдийн үгийг тэсч ядаж хүлээж аваач гэж бодож байна.

Дэгээ хэлэлцэхдээ хоёр гурван өдөр зарсан юм. Энэ үндсэн хэлэлцүүлэг дээр яагаад хоёр өдөр зарж болдоггүй юм бэ? Тийм учраас миний санал өнөөдөр бүтэн үндсэн асуудлаа хэлэлцүүлээсэй гэж бодож байна.

Танхиаас:

Үг хэлсэн хүмүүс, бидний тойргийн даалгавар, сэтгэл санаа боллоо гээд хажуугаас санал оруулж, үг хэлэх ёстой юмыг татгалзаж байна. Энэ буруу. Бид ард түмнээ төлөөлөөд энд сууж байгаагийн хувьд үгээ хэлэх эрхтэй.

Энэ байдлаар Элбэгдоржийн хэлж байгаа үгийг дэмжиж байна. Ерөөсөө хурлын нэг байдаг еөрснөө л болчихвол тэгээд л боллоо гэсэн сэтгэлээр хандаж болохгүй. Цаанаас ард түмний өгсөн... гүүрэг даалгаврыг хурал дээрл хэлэхгүй юм бол бид энд ирсний хэрэггүй шүү дээ.


Ж.Уртнасан: Манай дэгийн дагуу завсарлах цаг болж байна. Зарлалын чанартай 3 зүйл байна. Депутатууд анхаарна уу?

Депутатуудын хорооны гишүүд 13 цагт энэ танхимдаа зөвлөлдөнө үү гэсэн зарлал байна.

Манай улсын Их цаазын төслийг ард түмнээр хэлэлцүүлсэн дунг цахим тоолуураар нэгтгэсэн энэ завсарлагаанаар 2 дугаар давхрын танхимд депутатууд сонирхож болно. Манай аппаратын ажилтнууд уг дунгийн талаар та бүхэнд тодорхой тайлбар өгнө гэж байна. Их Хурлын депутатууд, нэгдлийн холбооны зөвлөл, нэгдлийн ерөнхий хорооны дарга нар 14.15 минутад Их Хурлын танхимд цугларна уу гэсэн 315 дугаар тойргийн депутат Бат-Эрдэнийн зарлал байна.

За баярлалаа, үдийн завсарлага.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн



Д.ЧУЛУУНШЭЦЭГ

Ж.Уртнасан:—Эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанаа үргэлжлүүлье.Одоо та бид уг хэлэх ажлаа ер нь танхимын мэдрэмж уг хэлэх ажлаа үргэлжлүүлье гэсэн депутатуудын санал олонхи нь байгаа юм.Уг хэлэх ажиллагааг үргэлжлүүлье.Төгөхдээ эрхэм депутатуудад манай зарим депутатын ирүүлсэн саналыг давхар харгалзаж үзнэ биз ээ.Саналууд их давхардаж байна.Товчхон хэлмээр байна.Тодорхой шийдэлд хүрэхгүй байна.Уур амьсгал тодорхой хэдэн зүйл дээр эргэлцэж байна гэдгийг эрхбиш анхаарах биз ээ.Одоо депутат Тогооч.

Ардын Их Хурлын 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч: —

танхимаас:

—Уртнасан дарга аа сая тавдугаар микрофон алгасчихлаа шүү дээ.Сая Энхтуна дөрөв дээр хэлсэн шүү дээ.

Ж.Уртнасан:—Тав дээр хэлсэн хэлсэн.Сая Депутат Бямбаноров хэлсэн шүү дээ.

Ардын Их Хурлын 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч:

—Зарим депутатуудын сэтгэлийн хөөрлөөр уг хэлэх эрхээ хасуулах шахаж харамсаж суулаа.Угээ хэлье, сонгогчдынхоо бодлыг илэрхийлье гэсэн депутатуудын тэмцлээр уг хэлж баярлаж байна.Энэ бол зөвхөн минийх биш, энд байгаа олон арван депутатуудын зовлон жаргал байх аа гэж бодож байна.

Хэлэлцэж байгаа асуудлын хувьд яривал зарчмын асуудлын хувьд бид нар нэг зүйл байна.Үндсэн хуулийн төсөлд Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна гэж заасан мөртлөө төрийн эрх барих байгууллагаа төв,орон нутаг гэж хоёр хуваадаг нь юу юм бэ? Би үүнийг хэлэхдээ төрийн байгууламж гэдэг гуравдугаар бүлэг дээр орон нутгийн төрийн эрх барих болон төрийн захиргааны байгууллагуудыг оруулахгүйгээр тусад нь

Ж.Уртнасан:—Эрхэм депутатуудын өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанаа үргэлжлүүлье. Одоо та бид үг хэлэх ажлаа ер нь танхимын мэдрэмж үг хэлэх ажлаа үргэлжлүүлье гэсэн депутатуудын санал олонхи нь байгаа юм. Үг хэлэх ажиллагааг үргэлжлүүлье. Тэгэхдээ эрхэм депутатуудад манай зарим депутатын ирүүлсэн саналыг давхар харгалзаж үзнэ биз ээ. Саналууд их давхарлаж байна. Товчхон хэлмээр байна. Тодорхой шийдэлд хүрэхгүй байна. Уур амьсгал тодорхой хэдэн зүйл дээр эргэлдэж байна гэдгийг эрхбич анхаарах биз ээ. Одоо депутат Тогооч.

Ардын Их Хурлын 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч: —

танхимаас:

—Уртнасан дарга аа сая тавдугаар микрофон алгасчихлаа шүү дээ. Сая Энхтуяа дөрөв дээр хэлсэн шүү дээ.

Ж.Уртнасан:—Тав дээр хэлсэн хэлсэн. Сая Депутат Бямбаноров хэлсэн шүү дээ.

Ардын Их Хурлын 430 дугаар тойргийн депутат Д.Тогооч:

—Зарим депутатуудын сэтгэлийн хөөрлөөр үг хэлэх эрхээ хасуулах шахаж харамсаж суулаа. Үгээ хэлье, сонгогчдынхоо бодлыг илэрхийлье гэсэн депутатуудын тэмцлээр үг хэлж баярлаж байна. Энэ бол зөвхөн минийх биш, энд байгаа олон арван депутатуудын зовлон жаргал байх аа гэж бодож байна.

Хэлэлцэж байгаа асуудлын хувьд яривал зарчмын асуудлын хувьд бид нар нэг зүйл байна. Үндсэн хуулийн төсөлд Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна гэж заасан мөртлөө төрийн эрх барих байгууллагаа төв, орон нутаг гэж хоёр хуваадаг нь юу юм бэ? Би үүнийг хэлэхдээ төрийн байгууламж гэдэг гуравдугаар бүлэг дээр орон нутгийн төрийн эрх барих болон төрийн захиргааны байгууллагуудыг оруулахгүйгээр тусад нь

## 2.

хийсэн асуудал ямар учиртай юм бэ гэдгийг асуух хэрэгтэй байна. Үгүй дээ төрийн байгууламж гэдэг энэ бүлэгтээ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гэдэг юм уу, манай улсын төрийн байгууламж нь төрийн эрхийг барих төв, орон нутгийн төрийн эрх барих болон захиргааны байгууллагаас бүрдэнэ гэдэг занц өгүүлбэр ч болсон хийж өгөхгүй юм уу гэсэн ийм бодол байна. Үндсэн хуулийн төсөл сайн боловсруулсан гэдэг дүгнэлттэй би санал нэг байна. Гэвч зарим үе дээр энэ хууль маань бусад бүх хуулийн үндэс болох үндсэн үүргээсээ өмнө тэдгээр хуулиудын юу бич гэдгийг зааж өгсөн, зааварласан, зарим нэгэн зүйлийг жижигрүүлж хэлж өгсөн, зүйлчилсэн ийм хууль болж уу гэдгийг хэлэх хэрэгтэй байна.

Тухайлж яривал орон нутгийн хурал тэргүүлэгчтэй байх, тэр нь орлогчтой, нарийн бичигтэй байх асуудлыг өнөөдөр Үндсэн хуульд үгчлэн заамааргүй байна. Энэ бол өнөөдрийг хүртэл мөрдөж байгаа орон нутгийн Ардын депутатын хурлын хуулиар зохицуулагдаж байгаа, зохицуулагдаж болох зүйл гэж ингэж үзэж байна. Гэтэл энэ хуулин дээр заримдаа сум, хороо, хорин гэж зааж өгсөн байна. Би энэнтэй санал нийлмээргүй байна. Өнөөдрийн засаг захиргааны хуваарийг өөрчлөх шаардлага байна уу гэвэл байна. Гагцхүү энэнийг бид нар ард түмэнтэйгээ хэлэлцэж байж тэдний санал, онол хүсэлтийн дагуу шийдвэрлэж болмоор санагдаж байна. Энэ дээр та биднийг депутатуудыг ардыг төлөөлж, энэ засаг захиргааны нэгжийн талаар бичсэн хуулийг батал гэвэл бид нар баталмааргүй байна. Энэнийг миний бодлоор бол ард түмэнтэйгээ ярилцаад, хуулиа гаргаад ингээд тусад нь хийж болох ёстой байх аа гэж бодож байна. Би энэнийг орон нутгийн засаг захиргааны хуваарийн хууль ч гэдэг юм уу, өөрөө удирдах ёсны хууль ч гэдэг юм уу, ийм тусад нь хууль гаргах байх гэж ингэж бодож байна. Энэ хуулиар нэлээд зүйлийг зохицуулж болмоор байна. Энэ хууль өөрийн ач холбогдлоороо Үндсэн хуулиас илүүгүй юм аа гэхэд дутуугүй ийм хууль байж болно байх аа гэж үзэж байна.

Ийм учраас Үндсэн хуулийн энэ хэсэг дээр орсон янз бүрийн дэгэлсэн, заасан, зааварласан тэр хүчин зүйлүүдийг бид нар

авч хаямаар байна. Ингэхгүй бол явж явж Үндсэн хуулийнхаа нэрийг олохгүй, сүүлд нь явж явж Дэгийн хууль ч гэж нэрлэх юм уу ийм байдалд хүрч магадгүй байна.

Хоёрдугаарт, төрийн тогтолцооны хувьд парламентын бүгд найрамдах улс байна гэдгийг зөвшөөрч байна. Энэ дээр ард түмнийхээ төлөөлөлтийн түвшинг ч харсан гэсэн төрийн эрх барих хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааг харсан ч гэсэн хоёр танхимтай байх, төлөөлөгчдийн байгууллага 150-200 орчим төлөөлөгчтэй, тэндээсээ бүрдсэн хууль тогтоох, төрийн эрх барих байнгын байгууллагатай, ийм танхимтай байвал яасан юм бэ гэсэн ийм санал байна. Гагцхүү хоёр танхим маань чухам зэрэгцээ орших уу, бие биендээ хяналт тавих уу гэдэг асуудал бол та бидний харин нухацтай ярих ёстой ийм зарчмын асуудал байна гэж ингэж үзэж байна.

Өнөөдөр бид нар өнөөдрийн шинэ тогтолцооны дагуу бүрэлдсэн төрийн эрх барих байгууллага Засгийн газрын үйл ажиллагааг зөвхөн энэ тогтолцооны зохион байгуулалтын бүтцийн буруу мэтээр авч үзвэл бид нар арай өрөөсгөл дүгнэлт болох болов уу гэсэн ийм бодолтой байна. Ийм учраас энэ дээр бид нар нэлээн нухацтай ярья гэж ингэж бодож байна.

Нэр томъёо, сүлд, бэлгэцлийн хувьд бид нар энц дахин дахин яримааргүй байна. Та бидэнд өөрийн гэсэн бодол байна. Сонгогчдын хүлээлгэсэн итгэл найдвар байна. Ганцхан энэ дээр үндэслэл байвал үндэслэлээ хэлье гэсэн ийм бодолтой байна.

Ардын Их Хурлын 374 дүгээр тойргийн депутат Т.Санжаа: —Бага Хурал, комиссоос Их Хуралд оруулж байгаа Үндсэн хуулийн төслийг ихээхэн хөдөлмөр зарцуулж хийсэн гэдгийг зүй ёсоор ойлгож байна. Гэвч энэ Үндсэн хуулийн төслийг хийхэд үндсэн хоёр алдаа байна гэсэн ийм бодлыг хэлье гэж бодож байна. Үүнд, нэгдүгээрт нь хуулийн төслийг хийхдээ нийт ард түмнээс авсан, нийт ард түмнээр хэлэлцүүлсэн санал, дунг бага тусгасан байна. Хоёрдугаарт



нь Бага Хурлын эрхэм гишүүд хуулийн төслийг боловсруулсан комиссууд бол Монгол орны улс төр, нийгэм, эдийн засагт өөрчлөлт гарлаа. Ийм учраас энэний баталгаа болгож улсын нэр, хуулийн нэр, улсын сүлд, далбааг өөрчлөх хэрэгтэй гэсэн туйлшруулсан бодлогыг баримталсан юм уу даа гэсэн ийм бодол байна. Ингэж болохгүйгээр санагдаж байна. Нийт ард түмнийхээ бодол, саналыг ихээхэн тусгаж хийвэл бидний баталж гаргах хууль маань амьдралд нийцэж, ард түмэнд зайлшгүй хэрэгжих тавилантай урт удаан настай хууль болох нь тодорхой юм аа. Ингээд би өөрийн сонгогчид, хөдөлмөрчдийн бодол хүсэлт болон, өөрийнхөө бодлоос хуулийн төсөлтэй холбогдуулж хэцэн зүйлийг хэлэхийг хүсч байна.

Юуны урьд засаглалын хувьд бол Ерөнхийлөгчтэй, парламентын засаглалтай байх нь зүйтэй гэсэн ийм санал байна. Энэ дээр парламентын дээд, доод танхимтай хоёр хуралтай байвал яасан юм бэ. Их Хурал нь 200-гаад депутаттай, Бага Хурал бол 20-21 гишүүнтэй байвал зүйтэй юм. Энэнийг тооцож үзэхэд хуулийн төсөлд орсон 76 гишүүнтэй нэг Их Хуралтай байх энэ төслөөс улс төр, засаглалын хувьд ч төр, зардал төсөв, орон тооны хувьд ч төр өр нь хялбар нийцэж байгаа юм гэсэн ийм бодол байна.

Хоёрдугаарт нь засаг захиргааны нэгж, түүний зохион байгуулалтын хувьд бол одоогийн байгаа бүтцийг давын өмнө тав арван жилдээ баривал зүйтэй юм. Энэ дээр аймаг, сум, баг гэж байх нь илүү зохимжтой санагдаж байна. Ингээгүйгээс хошуу болгож, сумуудыг нэгтгэж ийм асуудлыг хийгдсэнээс болж сумын төв балгас болох, хамгийн гол нь ард түмэн, төр хоёрын хоорондын холбоо улам холдох юм биш үү гэсэн ийм бодол байна.

Гуравдугаарт нь газрыг хуульд тусгахдаа газрыг бол ард түмний баялаг өмч, төрийн өмч гэж байхаар тусгаж, газрыг өмчлөх буку гадаадын харьяалалтай хүмүүст, харьяалалгүй хүмүүст түрээсэлж өгөх асуудлыг одоо хугацаа болоогүй ийм асуудал юм, өөр нь манай монгол орон газар, мал хоёртойгоо зөв харьцах асуудал бол ойрын хэцэн жилүүдийн онцгой чухал асуудал юм гэсэн ийм бодол байна. Цааш нь хуулийн нэр Үндсэн хууль гэж нэрлэх, улсын нэрийг Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэж нэр-

лэх, сүлдийг морь байгаагаар дүрсэлж хийх нь зүйтэй юм гэсэн сонгогчдынхоо саналыг бас уламжилъя гэж ингэж бодож байна. Ингээд нийт депутатуудаас ер нь бид бол батлан гаргах гэж байгаа хууль маань аль хэр хүчин чадалтай, урт удаан настай байх вэ гэдэг бол гагцхүү хуулийн чанарт орших юм. Ийм учраас бид ихээхэн чанартай ард түмний сэтгэл санаа, эрх ашигт нийцсэн ийм хууль гаргахад зүтгэл чармайлт гаргах нь зүйтэй юм гэсэн ийм бодол байна. Ингээд зүйл бүлгүүдэд саналаа нэг бүрчлэн дараа нь ярья.

Ардын Их Хурлын 346 дугаар тойргийн депутат Ч. Дэмбэрэлням :  
 -Их цаазыг боловсруулсан дунгийн талаар тавьсан илтгэлтэй холбогдуулж өөрийн саналыг хэлье гэж бодож байна. Тэгэхээр энэ боловсруулж Ардын Их Хуралд өргөн барьж байгаа Их цаазын төслийг бүхэлд нь дэмжиж байна. Энэ талаар шүүмжлэлтэй хандах ганц хоёр зүйл байна. Энэнийг хэлье гэж бодож байна. Тэгэхээр Их цаазыг боловсруулж илтгэл тавихдаа, ер нь илтгэлтэй холбогдуулж депутатуудад бас дүгнэлт, хавсралт илтгэл оруулах ёстой байсан болвч уу гэж миний хувьд бодогдож байгаа. Тухайлбал энд Ардын Их Хурлын байнгын комиссууд, Шинжлэх ухааны академийн төр эрхийн хүрээлэн, их сургуулийн мэргэжлийн тэнхимүүд мэт ийм газруудын хавсралт илтгэлийг оруулж депутатууд <sup>ад</sup> нэгдсэн ойлголт өгөх ийм дүгнэлттэй илтгэл оруулах нь зүйтэй байсан байх гэж ингэж бодож байгаа.

Энэ Их цаазтай холбогдуулж хэлэхэд ер нь манайд энэ хууль боловсруулах, хууль бүтээх энэ үйл ажиллагаа бол амьдралаас жаахан хөндий явагдаад байгаа ийм тал байна уу даа гэж ингэж бодогдож байна. Тэгэхээр хуулийг бол зөвхөн онол, гадаадын туршлага дээр тулгуурлаж боловсруулчихаад маргааш нь эргээд амьдрал дээр гарч байгаа нийгмийн харилцааг зохицуулахад хүрэхлээрээ энэ хоёрын хооронд зөрчил гарч байгаа. Ийм учраас амьдралтай бас нэлээн ойртуулах шаардлага гарцаагүй байгаа боловч уу гэж ингэж бодогдож байна. Ингээд энэ хуулийн төсөлтэй холбоотой хоёр санал байна.

Парламентын бүтцийн хувьд депутатуудын гаргасан саналтай

## 6.

үндсэндээ санал нэг байна. Энэ дээр нэмж хэлэхэд засаглалын хувьд манайд хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал гэсэн гурван засаглал байна гэж байгаа. Ерөнхийлөгч бол энэ гурван засаглалын чухам алинд нь хамаарах вэ гэдэг асуудлыг бас авч үзмээр санагдаж байна. Үндсэн хуулийн төсөлд Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл гэснээс үзэхэд хууль тогтоох засаглалаа хамаарагдах болов уу гэж ингэж бодогдож байгаа. Тэгэхээр Ерөнхийлөгчийн эрх хэмжээний тухайд хуулинд зааснаар Улсын Их Хурлын эрх хэмжээтэйгээ бас нэлээн давхцсан зүйлүүд байгаа. Тухайлбал Ерөнхийлөгчийн төрийн эрхийн асуудалд гурав дөрвөн асуудлыг Улсын Их Хурлын даргатай зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэж байхаар заасан ийм байдлууд бий. Тэгээд энэнээс ургуулж бодоод нэг асуудлыг депутатуудын анхааралд хандуулъя гэж ингэж бодож байна. Ер нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга бол Ерөнхийлөгч байх, Улсын Бага Хурлын дарга Дэд Ерөнхийлөгч байх ийм хувилбараар авч үзвэл яасан юм бэ гэсэн ийм нэг саналыг оруулъя гэж бодож байна. Энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд бол энэ асуудлын талаар олон депутат ярилаа. Тэгэхээр миний хувийн дүгнэлт бол.../бичлэг хийгдээ гүй/

...одоо манайд авч үзэх ёстой асуудал мөн үү гэвэл мөн байх ёстой. Манайд одоо аж ахуйн нэгж бүрийг <sup>ТУШИГЛҮҮЛЭЭД</sup> засаг захиргааны олон нэгжийг байгуулснаар сумдын тоо хэтэрхий олширч сүүлийн үед сумын дотор олон жижиг сум давхар байгуулагдаж ирсэн ийм юм бий. Тэгэхдээ энэнийг бол энэ хуулийн төсөлд оруулахдаа ямар ч бэлтгэлгүйгээр, урьдчилсан санал дүгнэлтгүйгээр, тухайн бүс нутгийн онцлог, байгаль, цаг агаарын онцлог, ард түмний санал хүсэлтийг судлахгүйгээр ингэж оруулсан явдал шаардлаганд нийцэхгүй байна гэж би хувьдаа ингэж бодож байна. Энд өнөөдөр хөндөгдөж яригдахгүй байгаа нэг асуудал бол орон нутагт төрийн байгууллага байхгүй юм шиг ийм байцлаар энэ хуулийн төсөлд тусгагдаж орсон байна. Тухайлбал аймгийн хурал, сумын хурал байхгүй болох нь ээ. Төр бол зөвхөн цээрээ одоо төрийн удирдлагатай, орон нутагт бол төрийн удирдлага байхгүй, орон нутгийн өөрөө удирдах ёс байгаад, гүйцэтгэх

засаглалыг төлөөлсөн засаг дарга нэг тамгын газрын аппаратын цөөхөн хүнтэй ажиллах ийм байдлаар тусгагдсан байна. Тэгэхээр энэ бол манай орны нөхцөлд одоохондоо хэрэгжүүлж болох асуудал мөн юм уу, биш юм уу энэ талаар бас депутатууд санал онолоо бэлтгэж ярих нь зүйтэй болов уу гэж бодож байна. Миний хувьд бодож үзэхэд энэ асуудал одоохондоо хараахан бас болохгүй болов уу ялангуяа аймгийн хувьд гарцаагүй хуралтай байх нь зүйтэй байх. Сумын хувьд харин төлөөлөгчдийн хурлын хэмжээнд асуудлаа шийдээд явдаг байж болох юм. Тэгэхээр энэ асуудлын хувьд би энэ орон нутгийн засаг захиргааны тухай хууль, газрын тухай хуулийг Улсын Бага Хурлаар нэг удаа анхны хэлэлцүүлэг хийгээд хойшлуулсан энэ хоёр хуулийг энэ Их цаазын төслийг хэлэлцэхээс өмнө хэвлэлд нийтэлж нийт ард түмнээр хэлэлцүүлж, санал дүгнэлтийг авсан болбол өнөөдөр депутатууд бас нэгдсэн ойлголттой ирж, энэ дээр асуудлаа ярихад бололцоотой байх байсан болов уу гэж ингэж бодож байна.

Ийм учраас одоогийн Их цаазад орон нутгийн засаг захиргааны хуваарийг одоогийн бүтцээр байлгах саналыг дэмжиж байна. Энэнийг депутатууд бид ч тэр, Улсын Бага Хурлын гишүүд ч тэр шийдчих асуудал биш, энэнийг хэрэв өөрчлөхдөө хүрэх юм бол Монголын ард түмэн өөрсдөө мэдэж шийдэх ёстой ийм асуудал. Ийм учраас нийт ард түмэнд одоо энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хуулийн төслийг нийт ард түмнээр хэлэлцүүлсний дараа авч үзэх асуудал байх аа гэж ингэж бодож байна. Ийм учраас Их цаазын энэнийг хуучнаар нь байлгах саналтай байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙДСЭН ✓ *Мөнх* П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

33-р тойргийн депутат Мөнхөө: -Их цаазын төслийг их хөдөлмөрийн үр дүн гэж депутат хүний хувьд хүндэтгэж байна. Энд олон улсын туршлагыг ихээхэн харгалзаж үндсэн хуулийг боловсруулж хэрэгжүүлдэг тэр төвшинд ойртуулахыг эрмэлзэсэн маш их тийм сайн тал байгаа гэж бодож байгаа. Эх оронд болж байгаа амьдралын бүх хүрээнд явагдаж байгаа энэ өөрчлөлтийг хууль зүйн баталгаатай болгох энэ чухал үүрэг хүлээж байгаадаа сэтгэл ханамжтай байгаа юм. Гэхдээ одоо хэрэгжүүлж байгаа болон цаашид хэрэгжих арга хэмжээний нэлээд асуудлыг энэ хуулинд туссан хэлбэрээр нь бид урт удаан настай хууль батлах гэж байна гээд баталчихвал өнөөгийн амьдралд зөрчилдөж болох болов уу гэдгээс их сэтгэл зовж байгаа юм. Энд юу байна вэ гэхлээр жишээлбэл эмнэлгийн тусламжийн тухай асуудал байгаа юм. Хуулинд төлбөргүй эмнэлгийн тусламжийг хуулийн дагуу үзүүлнэ гээд байгаа. Тэгэхлээр хууль батлагдсаны маргаашаас эхлээд эмнэлгийн бүх тусламж төлбөртэй болох нь ээ гэж ингэж ойлгогдож байгаа. Өнөөдрийн амьдрал ард түмэн бүх эмнэлгийн тусламжийг төлбөртэй болгочихвол хүлээж авах чадвартай байгаа эсэх нь хэнд ч ойлгомжтой. Мөн боловсролын асуудал байгаа, ерөнхий боловсролыг зөвхөн улсаас үнэ төлбөргүй олгоно гэсэн байгаа, бүх шатны бүх боловсролыг төлбөртэй болгох нь ээ хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлээд, ингээд бодохоор миний өнөөдрийн батлах гэж байгаа сайхан хариуцлага маань бас өнөөдрийн амьдралд яаж очиж буух бол, энэ шилжилтийн үеийн асуудал юм уу, энэ дээр бас зориуд анхаарал тавьж, зохих хэмжээгээр хандах ёстой юм биш байгаа гэсэн үнэхээр сэтгэл зовоосон зүйл бодогдож байгааг зориуд аудторид санал хуваалцаж хэлбэ гэж бодож байгаа. Өөр нэг юм бол манай хууль монгол хууль байх ёстой. Нуудэлчин яахав хүүхэд залуучууд голлосон хүн амын бүтэц, нийгмийн зохих хүрсэн төвшинг аль болохоор бууруулахгүй байхын төлөө тэмцэл энэ бүхэн энэ хуулинд тусгалаа олох ёстой гэсэн ийм зүйл өөрийн эрхгүй сэтгэл зовоож байна. Хувьд өмч шилжүүлэх гэдгээр бүх зүйлийг улсын нуруунаас авчихаж болох мэт бодлого хувийн өмчтэй болсноор бүхнийг шийдчих мэтээр үзэх энэ туйлшралыг ч гэсэн бид энэ шилжилтийн үед хэрхэн даван туулах вэ, өнөөгийн ард түмний амьдралд тулгараад

байгаа энэ зүйлд бидний баталсан хууль хэрхэн дундуур нь одоо гарч явж чадах вэ гэдэгт эрх биш ухаанаа зарах ёстой болов уу гэсэн нэг ийм юмыг би санал хуваалцаж хэлбэ гэж бодсон юм. Өөр нэг сэтгэл зовоож байгаа юм бол үнэхээр миний эцэг эх төрж өсөөд өөд болсон, би өөрөө төрж өсөөд өнөөдөр ажиллаж байгаа, миний үр хүүхэд өнөөдөр амьдарч байгаа, энэ бүхэл бүтэн үеийн зурвасыг түүхэн зурвас үе гэдгээр огт үл тоож энэ хуулийг баталж болмооргүй ийм юм санаа зовоож байгаа. Үнэхээр ард түмний санал ийм байна гэж олон хүний амнаас гараад байгаа ч гэсэн энэ түүхэн цаг үеийн дотор өсөж бойжсон энэ хүмүүсийн сэтгэл зүйг ямар нэгэн хэмжээгээр энэ хуулийг хүлээж авах, хэрэгжүүлэхэд шууд холбоотой гэдгийг эрх биш харгалзах ёстой болов уу. Энэ дээр олон юм цааш нь хэлэхгүй, жишээ нь би шонхорыг хүлээж авмааргүй байна. Сүлдийг ухаандаа элементээр батлах ийм саналтай хүний нэг ээ. Өөр нэгэн зүйл бол бид хэтэрхий урагшаа харж тийм түүх, ийм түүх бичигдсэн гэж ярих юм, зүгээр миний мэдэх монголын цэцтэй бичигдээд дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн ямар түүх байдгийг өнөөдөр мэдэхгүй, ямар ч байсан манай түүхийг бид бүх нийтээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дэлхий нийтэд ч гэсэн зохих хэмжээгээр хүлээж авсан ийм л баримтан дээр тулж ярих байх. Бид ч зарим зүйлийг туйлшран ярьж байгаа гэдгээ өнөөдөр бас зарим ухаантай хүмүүс ухаарч байгаа байх гэж би энд хэлэхийг хүсч байна. Ийм учраас хууль боловсруулсан хуулин дээр ажилласан хуулийн төслийг эцсийн вариант болгон оруулж байгаа хэсэг, энэ хуулийг батлах гэж байгаа хэсэг, аль аль нь еер өөрийнхөө үндэслэлийг маш их нухацтай ухаантай, хүлээцтэй бүрэн хэмжээгээр сонсох, их цаг зарах нь бол зохих хэмжээний цагаа зарцуулж тэвчээртэй хандах нь хуулийг ард түмэн болон цаашдаа хэрэгжих баталгаа сайтай ийм хууль батлах энэ хариуцлагаа ухаарах нь л хэрэгтэй болов уу гэсэн. Ийм юм байна. Парламентын засаглалтай бүгд найрамдах улс байхыг би хувьдаа дэмждэг. Энэ бол энэ ээдрээтэй үед чадварлаг бөгөөд цаашдаа сайн амьдрах чадвартай парламент бий болгох нь өнөөгийн үеийнхний түүхэн хариуцлага байхаа гэж ингэж бодож байна. Газар өмчлүүлэх асуудлын хувьд азнаж шийдэх ёстой асуудал болов уу, энийг заавал өнөөдөр шийдэхгүй байснаас болоод ёстой харин юу хохирчих гээд байгаа юм бол. Би үнэндээ мэдэхгүй байгаа. Яагаад

гэхээр бид газрын үнэ цэнийг зөвхөн малаараа дамжуулж мэдэрч ирсэн болохоос яг чухам газрыг өөрийн мэдэрсэн ийм уламжлал энэ туршлага бидэнд хомс байгааг эрх биш харгалзаж үзэх болов уу. Харин түрээслэх тухай асуудлын тухай асуудлын тухай ярьж болох юм болов уу гэсэн ийм юм бодогдож байна. Нөгөө талаас шилжилтийн үе , энэ үе ямар хэмжээгээр үргэлжлэхийг өнөөдөр хэн ч хэлж чадахгүй байгаа ийм үед Америк шиг 200 жилийн настай хууль батална гэж бас хэт улайран зүтгэх явдал ч гэсэн бидний хуулийн цаашдын хэрэгжилт, бидний явуулж байгаа өөрчлөн байгуулалтанд хор хохирол учруулж магадгүй юмаа гэдгийг бид тал талдаа бодох ёстой юм болов уу, урд нь жишээлбэл шашны гэхэд бид ганцхан талаас нь авч үзээд бүгдийг нь үгүйсгэчихсэнээ өнөөдөр ярьж байгаа энэ түүхэн сургамжаас ч гэсэн эргэн санах нь зүйтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байна.

44\_р тойргийн депутат Ш.Сүрэнжав:- Нэг зүйлийг эхэнд нь хэлье. Ер нь одоо лам хүн чойгоо биенээсээ салгалгүй авч явдаг гэдэг шиг энэ ард түмний сэтгэлийн мэдрэмж ямагт бидэнтэй хамт байх ёстой болов уу гэж бодож байна. Тэгэхлээр энэ ард түмнээр яагаад хэлэлцүүлсэн юм бэ гэхлээр энэ ард түмний санаа бодлыг тусгана гэдэг бодлын үүднээс л хэлцүүлсэн болов уу гэж ингэж бодож байх юм. Тэгэхээр ард түмний одоо ер нь тэгээд ард түмний санаа бодлыг харгалзахгүйгээр ч юм уу ямар нэгэн хөт-<sup>юманд</sup>лөгдөөд хийчих юм бол энийг чинь ард түмэн сайн хүлээж авахгүй бол нөгөө дургүй ламанд дарж байж сахил хүртээнэ гэдэг шиг болоод явчихвал дургүйд хүчгүй байдаг аа. Тэгэхлээр энэний үүднээс л энэ улсууд яриад байгаа байх. Тэгэхээр давхардана гэж бодолгүйгээр ч гэсэн зарим зүйлийг хэлэхээс аргагүй болж байна. Одоо бид өнөөдөр үндэсний сэргэн мандалт гэж ярьж байгаа. Тэгвэл сэргэн мандалт гэдэг чинь юугаараа ярих юм бэ гэдэг чинь хүн ахтай, дээд захтай гэдэг юм. Тэгэхээр чинь ах захаа мартаад ёс заншлаа өнөөдөр бол гишгэчихээд галуур залуучууд хурган маягийн залуучууд дураараа дургиж байна шүү дээ. Энэний чинь л одоо хумьж авах төртэй ёстой байгаа юм шиг, төрийн сүлдээ гэж дээдэлж байдаг энэ ард түмний чинь сэргэлийг тусгасан үндсэн хууль баталж гаргахдаа байгаа байх гэж бодлын үүднээс ингэж хэлж байгаа юм. Тэгээд зарим зүйл дээр томъёолоод

хэлбэл энэ Ерөнхийлөгч нь харьцангуй их эрх мэдэл бүхий парламентын засаглал манай өнөөдрийн нөхцөлд өнөөгийн нөхцөлд зохимжтой гэж ийм зүйл оруулахыг хүсч байна. Ерөнхийлөгчийг яагаад яриад байгаа юм гэдэг чинь бас энэ ард түмний санаа сэтгэл өнөөгийн байдалтай холбоотой. Түрүүн Энхтуяа нэлээн цэцэн томьёолж хэллээ. 1000 суултэй, I толгойтой могой гэж, тэгэхээр энэ чинь Чингис хаанаа ч бодоод үзье, Богд хаант монгол улсаа ч бодъё. Улс эзэнтэй, толгойтой байх ёстой. Тэгэхээр Адъяасхрэн бол Ерөнхийлөгчгүй байя гэж хэлсэнтэй эрс зөрж байгаагийн учир энд юм. Тэгээд засаглалын хомсдол гэж ярьж байгаа нь ч энэнтэй холбоотой. Тийм учраас Засгийн газарт оролцох Ерөнхийлөгчийн эрх мэдэл бол нэлээн их байхгүй бол болохгүй гэж санаж байна. За үндсэн хуулийн тухайд бол их Монгол гэж хэлэх дээр зэрэг их гэдэг тэр монгол хүнээ их монгол Шаравжамц гэхээр тэр үгэнд чинь багтаад хэлчихэж байна шүү дээ. Тэрэн шиг их засаг юм уу, Үндсэн хууль 2-ын нэгээр байя гэдэг ийм санал оруулж байна. Тэгээд нэг жижиг гэхгүй жижгээс том юм бүрэлддэг үг, үгнээс бол одоо мянган утга цацардаг гэж ярьдаг шүү дээ, Жишээ нь цээрлэнэ гэдэг үг энд 2 газар орж байна. I нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авахаар завдахыг цээрлэнэ гэж байна, нөгөө нь II-ийн I-д бол хүний амь насыг зоргоор бусниулахыг цээрлэнэ гэжээ, хатуу цээрлэнэ гэж, энэ цээрлэнэ гэдэг чинь энд их тусгүй оновчгүй хэлэгдэж байна. Цээрлэнэ гэдэг чинь юмнаас цээрлээд хамар амаа таглах төдий салхины дээгүүр өнгөрөх төдий юмыг энэ хүний амь бусниулахыг цээрлэнэ гэж ингэж хэлээд явчихдаг чинь бол энэ хуулинд ер тэрнийг юман чинээ бодохгүй байгаа юм шиг ёстой үхсэний хохь, амьдын зол гэж байгаа юм шиг сонсогдож мэдрэгдэж байна. Жигшинэ ч юм уу, хориглоно ч юмуу тэгэхээр, үг гэдэг бол энд их учир утгатай байхын үүднээс энийг ярьж байгаа юм. Давхардахгүйгээр хүн хүн өөрийнхөө юмыг илэрхийлэх, өөрийн аргатай байдаг, тэр морины тухайд бол ямар ч байсан л хэлье морь соёмбо 2-оо орхих юм бол миний бодоход монголын заяа орхино байх шүү. Морь, морийг Сталин тэр морь бай гэж өөрснийхөө хүслийн үүднээс тийм домог зохиочихоод, тэр домгоо тулгаад байна шүү дээ. Хэн хажууд нь байж байгаад хэзээ сонсоод ямар юман дээр бичсэн юм. Тэгэхээр морийг яривал морь ч эртний, яагаад гэвэл Чингисийн үед цутгасан алтан зоосон дээр, мөн Өгөөдэй хааны нас барахад цутгасан алтан



зоосон дээр морь дүрсэлсэн байгаа нь өнөөдөр Британы музейд хадгалагдаж байна гэдгийг эрдэмтэн мэргэд хэлээд, яриад байна шүү дээ. Тэгэхээр энэ үүднээс ч гэсэн ерөөсөө тэгээд яахав морь хэлснээрээ хоцрогдсонд тооцогддог юм бол тооцогдохоос, ноён гэлээ гээд жинс ургахгүй, нохой гэлээ гээд сүүл ургахгүй гэж ингэж бодож байна. Өөр нэг зүйл бол, бас нэгэнтээ удиртгалд нэг ийм юм нэмнээр байна. 2 зүйлийг онцолж яриад байна шүү дээ. 1 нь тусгаар тогтнол байна, 2 дахь нь нүүдлийн өвөрмөц байдал байна шүү дээ. Тэгэхээр жишээлэх юм бол удиртгал юугаар ч сольггүй үнэт зүйл болсон тусгаар тогтнолоо бататган бэхжүүлж, түүх ёс төр, нүүдлийн өвөрмөц соёлынхоо уламжлалыг эрхэмлэн өвлөж гэж найруулсан ийм зүйлийг ч одоо цохож зааж оруулах нь ихээхэн учир холбогдолтой болно гэж ингэж бодож байна. За бас энд нэг зүйл байгаа. Энэ Ерөнхийлөгчийн насан дээр ч юм уу, улсын их хурлын гишүүний насны зүйл энд дурдагдаж байгаа. Тэгэхээр энэ чинь ард түмэн еерөө бас их мэргэн цэцэн юм хэлсэн байдаг аа, 40 хүрсэн эр, 4-өө дарсан ат гэж хэлдгийг дэмий нэг хэлээгүй, бүх юмг эрийн цээнд хүрсний хэмжүүр болгож хэлж байгааг энд бас насны тухай юман дээр бодолцох биз ээ гэж ингэж бодож байна. За мөн өөр нэг зүйл бол хариуцлагын асуудал байгаа юм. Ер нь сонгуульд ялсан нам нь л Засгийн газраа байгуулдаг байх, тийм л журмыг энд оруулж хийх нь зүйтэй байх. Энэ чинь буцаад буух эзэнтэй байх ёстой байх, үүнээс ургуулаад нэг зүйлийг хэлэхэд өнөөдөр банк Улсын бага хурлын мэдэлд байдаг нь ямар учиртай юм бэ? Энэ чинь зүйрлэхэд Засгийн газар зарцуулах эрх нь байдаг, гэтэл мөнгө нь байдаггүй чинь өөр нь хоосон хүнээс ямар ялгаатай юм бэ. Ийм зөрчилтэй юмнууд байгаа юм биш үү. Энийгээ засаглалынхаа юмнуудад бодож тал талаас нь бодож, оруулах бизээ гэж. Үүний нэг нь өөр нэг зүйл түрүү бас зарим хүмүүсийн ярианд тус цухас дурдагдлаа. Бурханы, шажныг төрийн мэдэлд байх, бурхны шажныг тэгэхээр энэ чинь уламжлалаа ярина гэж зарим хүмүүс их ярьж байгаа. Уламжлалаар ярьж гэвэл Хувилай хааны үед чинь төрийн шажин болгоод тэгээд Пагвай ламыг энэ төрийн шажны тэргүүнд тавьж байсан гэдгийг бас бодолцож болох л байх. Монгол бичгийн тухайд бол энэ бол бидний ардчиллын цаг үед дэвшүүлж гаргаж ирснийг оновчтой юмны чинь нэг энэ биш үү. Тэгэхээр ямар нэгэн

6.

бэрхшээлийг яриад байвал бүтэхгүй юмыг олон хэлж болно. Монгол бичгийг төрийн бичиг болгох гэсэн энэ санаагаа орхихгүй юман дээрээ хуульчилж одоо гаргаж ирэх нь бол хамгийн чухал зөв байхаа гэж ингэж бодож байна. За ингээд олон зүйлийг сүлдний тухайд бол сая санаагаа хэлсэн, оруулах зүйлүүдийг хэлтээ. Тэгээд цаг их одоо олон юм давхардуулах хэцүү байх, зүйлчилж ярих юман дээр хэлэх, санах зүйл нэлээн байна. Ингээд бас нөхдийнхөө цагийг бодолцье. Ер нь бас олон хүн энд саналаа хэлэх гэж сонгогчидоо төлөөлж ирсэн, тэгээд зарим нь түрүүлж хэлчихвэл, өөрийнхөө ажлыг боллоо, бүтлээ, гэж бодчихоод одоо энэнээс хойшхийг нь болиё гэж хэлдэг бол өнөө Францын I4-р Людовик надаас хойш галав юүлсэн ч ямай гэж хэлж байсантай дүйж магадгүй юм.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

*Ш. Бурмаа*

Ш. БУРМАА

1997. XI. 16:

Кассет № III 13

15.31-15.46.

156 дугаар тойргийн депутат Ж.Гантөмөр:

-Их цаазын төсөл бол 2000 оныхоо түүхийг эргэж харж, 2000 оны ирээдүйгээ харж боловсруулсан, нэлээн хүний хөдөлмөр шингэсэн түүхэн баримт бичиг болсон байна гэж үзэж байна. 7, 8 нэр томъёоны зүйлээс бусад үндсэн агуулгатай нь миний хувьд бол санал нэг байна. Хэл найруулгын хувьд бас жаахан хармаар хармаар юмнууд байх юм гэж бодож байна. Тухайлбал, 17-гийн нэгд "амьд явах эрхтэй" гэж бичсэн байгаа юм. Энэ бол барууны орнуудын Үндсэн хуулиас болхидуухан орчуулсан орчуулгын хэлбэр гэж би бодож байна. Амьгүй явах эрх, үхэж явах эрх гэж монгол дээр буухгүй юм шиг санагдаад байгаа юм.

Хуулийг хүн зохиож болдоггүй, хууль бол амьдралын бодит тусгал байх ёстой. Гагцхүү амьдралыг хэр зэрэг танин мэдэж цаасан дээр хэр зэрэг томъёолон буулгаснаас хуулийн амьдрах чадвар нэлээд шалтгаална гэж бодож байна. Манай хууль бол ирээдүйгээ нэлээн харсан байна. Энэ бол зөв. Гэхдээ миний бодлоор бол ирээдүйгээсээ одоодоо ойр байх нь зүйтэй. Ингэж бодож байна. Ингэхгүй бол буухгүй. Тухайлбал, улсын нийслэлийг "Улаанбаатар" гэж хэлэхээс цээрлэсэн байна. Тэгсэн хэрнээ 1997 онд байгуулагдах, жинхэнэ ёсоороо байгуулагдах хошууг энд тодорхойлсон байх юм.

Ер нь ямар ч байсан, уржигдар байна уу, дэд ерөнхийлөгч хэлэх шиг болсон. 2020 хүртэл бараг л өөрчлөхгүй байх гэж. Манай эх орны эдийн засгийн потенциалгаас үзэхэд 2020 он гэхэд улсынхаа нийслэлийг Улаанбаатараас өөр газар шилжүүлэн суулгах бололцоо ерөөсөө байхгүй. Энэ бол өнөөдөр ч харагдаж байгаа эд шүү.

"Хошууг" 5-6 жилийн өмнөөс урьдчилан томъёолох нь одоо өмч хувьчлалын хуулийг урьдчилж гаргаснаас улсын өмч үрэгдэж байгаатай нэгэн адилаар энэ бүтээн байгуулсан их хөрөнгө маань

үрэгдэх үүд хаалгыг нээж байгаа юм биш үү. Энийгээ ерөөсөө одоо сум хэвээр нь байлгаж байгаад яг тэр үедээ Үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулаад хошуу гэдгээр нь зохион байгуулах ёстой байвал болохгүй юмуу гэсэн ийм нэг бодол байгаа юм.

Манай Үндсэн хууль боловсруулах комисс, Бага Хурлын эрхэм гишүүд бол хуулийг урт настай болгохын тулд засвар хийлгэхгүй гэсэн ийм л чигийг барьсан юмуу даа.

Багийн хувьд бол 1930, 1940-өөд оны багийг хэлээд байна уу, шинэ маягийн баг зохион байгуулах гээд байна уу гэдэг нь одоогоор ойлгомжгүй байна. Одоо зарим сумдад байгуулагдсан баг бол 40, 50-иад оны баг байгаа. Энэ бол цаашаа явахгүй. Энийг өөр маягаар, хэрвээ баг байна гэх юм бол шинэчилсэн маягаар зохион байгуулах хэрэгтэй. Тухайлбал, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйнууд өнөөгийн зохион байгуулагдсан багаар бол хэд хэдэн багийн нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэлээ явуулж байгаа. Төв нь оршиж байгаа багийн даргадаа захирагдах уу, үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл мал сүрэг адгуулан бэлчээрлэж байгаа хөдөө хээр байгаа бригадын захирагч, Засаг дарга нарт захирагдах уу? Бид энийг нэлээн бодмоор юм шиг байна шүү.

Хоёр танхимтай парламент гэдгийг бол би зөвшөөрч байна. Ерөнхийлөгч бол нэлээн хүчтэй байх хэрэгтэй гэж бодож байна. Ер нь бид бэлгэдлийн юмыг сүрхий, хоёр ч сүрхий бэлгэдэл байна. Монгол улсын тусгаар тогтнолын бэлгэдэл бол энэ шувуу ч юмуу, морьтой хун ч юмуу, ямар ч байсан ийм зураг байх нь. Тэрнээс гадна ард түмний эв нэгдлийн бэлгэдэл бол Ерөнхийлөгч байх нээ. Ийм олон эв нэгдлийн бэлгэдэл байх юмуу. Ер нь Ерөнхийлөгчийг жаахан ажлын хун байлгамаар надад бодогдоод байдаг юм.

Бага Хурлын гишүүний насны хувьд ярилаа. Энэ 25 гэдэг бол хэтэрхий залуу байна. 40 хүрч байж сая амьдралын ухаан сууна. Дан онол бодоод дан шинэлэг сэтгэлгээгээр бодож болохгүй ээ. Гадаад орнуудын парламентын гишүүдийн туршлагыг үзсэн ч гэсэн ер нь 60, 70 настай хун голцуу байдаг бололтой юм

билээ. Тэгэхэд 40 бол залуудах нас биш, 25 нас бол өдөр тутам алдаж, онож болох тогтворгүй, улс төрийн хувьд ч гэсэн тогтворгүй нас болов уу гэж би хувьдаа боддог юм.

Манай Үндсэн хуулийн төсөлд 76 гишүүн гээд байгаа. 76 гишүүнийг сонгоход их бэрхшээл гарна шүү. Хүнээ танихгүй. Гадаад орнуудад бол хэн энэ депутатаар, Сенатын гишүүнээр сонгогдож байна вэ гэвэл хөрөнгөтэй зорьтой улсууд сонгуулийн өмнөх компанийг өрнүүлж асар их хэмжээний мөнгө зөрж байж өөрийгөө сурталчилж, олон түмэнд итгүүлж байж ингэж болдог түүхтэй. Хэрвээ ингэж бид чадахгүй юм бол төрийн жолоо атгалцаж чадахгүй, хэн нэг хүнийг нүдээ аньж байгаад сонгосонтой адил болох вий гэдэгт сэтгэл эмзэглэж явдаг юм.

Монгол улсын нэрийг "монгол" гэж нэрлэхэд татгалзаад байх юм алга гэж бодож байна. Учир нь яагаад вэ гэхээр Үндсэн хууль эхлээд "бүгд найрамдах улс мөн" гэж тунхагласан байгаа учраас би энд санал нэгдэж болох юм гэж бодож байна.

Газрыг ч гэсэн мөн гадаадынханд түрээсээр эзэмшүүлж болно. Өнөөдөр Сингапийг Хятад улс Англи улсад эзэмшүүлээд 1997 он хүртэл энд шинжлэх ухаан техник, шинэ технологи нэвтрүүлэх, улс орны үйлдвэрлэх хүчний хөгжлийг хурдасгахад чухал нөлөө үзүүлж байгааг бид нүдээрээ биш ч гэсэн сонин хэвлэлээс үзэж харж байна. Тэгэхээр энийг бол бололцоотой юм гэж бодож байна.

Сүлдний хувьд бол сүлдийг өөрчлөх нь зүйтэй. Энэ бол үнэхээр монгол хүн мандаж байгаа нарыг билэгшээдэг болохоос биш шингэж байгаа нарыг билэгшээдэггүй. Энэ бол баруун тийшээ жаахан засах юм бол баруун хойшоо жинхэнэ коммунизмын улаан нар мандсан Петербургийн зүг давхиж байгаа юм шиг байна, үнэндээ. Энийг жаахан зүүн тийш нь харуулаад ертөнцийн улаан нар луу харуулаад тайлбарыг коммунизмын биш ертөнцийн гэвэл маргаашцаа итгэсэн бэлгэдэл болж болно гэж бодож байгаа юм.

Ир нь хүн өөрийнхөө үзэл бодол, итгэл үнэмшилд үнэнч байх ёстой. Би Бадраа гуайн хувьд хэлэх гэж байна. Бадраа гуай уламжлалдаа, Бадарч зохиолч уламжлалаа хүсдэг, хүндэтгэдэг юм байна. Үнэхээр уламжлалаа хүндэтгэдэг бол Бадраа, Бадарч гэх мэтийн улсуудыг ойрын хэдэн хоногт партай байшингаасаа гарч монгол гэрт орж гэнэ гэдгийг бид сонсох байх гэж бодож байна. Хэрвээ ингэхгүй юм бол энэ итгэл үнэмшил биш ээ. Уламжлал ч биш.

Энэ шувуутай сүлдийг хийхдээ Нууц товчооны нэг зүүдийг яасан байна. Энд ч би буруу санаагүй бол Өөлүн эх нэг шөнө унтаж байтал нэгэн сайхан эр үүр шөнийн заагаар ирж хэвлий дээр нь гурван удаа илээд нэгэн сайхан хүү төрөв гэсэн ийм байх шиг байдаг. Бас дээд тэнгэрээс заяатай Бөртө чоно бол монголын ард түмний, монгол түмний эх үүсвэр гэсэн ийм утгатай байдаг шиг санаж байна. Ингээд үзэх юм бол монгол орны сүлдийг тэнгэрээс бууж байгаа эмэгтэй хүн юмуу, зүүрмэг-лэнхэн унтаж байгаа эмэгтэй хүнээр дүрсэлж тавьсан ч болох юм шиг надад ингэж санагддаг юм.

Сүсэг бишрэлтэй хүн бол өөрт нь гүндэг барьсан малын махыг зооглохдоо нүглээ наманчилж маани уншдаг юм шиг байгаа юм. Тэгэхээр манай зохиолчид, Бадарч бол манай хөдөө нутгийн хөдөлмөрчдийн хайр хүндэтгэлийг хүлээсэн нэртэй зохиолччоо. Адуу, тэмээг маань их магтдаг. Би энэ хүнийг монголын ард түмний хийморь сүлдийг нуруундаа авч яваа сүргийн манлай адуун сүргийг магтдаг хүн гэж ойлгодог байсан. Өнөөдөр идэж уудаг, адсага хөмийг нь хөл дороо дэвсдэг, үүнийгээ наманчилж адуугаа дурсаж шүлэг бичдэг хүн байжээ гэж ингэж бодож байна.

Ингээд Их цаазын бусад төслүүдийн талаар саналаа сүүлд бүлэг бүлэг дээр нь хэлье гэж бодож байна.

Ж. Уртнасан: -Уучлаарай, эрхэм депутатууд аа, нэг яаралтай, шуурхай мэдээлэл хийе, зарлалын чанартай юм гарлаа. Тэгэхээр та бүхний сонорт сонстоё. Хариуцсан байгуул-

лагын маань ажилчны гэр 6 хуухэд үүр хавиар шатжээ.Энэ эцэг, эхэд нь тусламж үзүүлэх талаар намайг дуудаж байна.Үг хэлэх дараалал дөхөж байгаа боловч арай болоогүй байна.Надад одоо үг хэлэх боломж олгож, оройн хуралдаанаас 3 цагийн чөлөө олгоно уу.Их Хурлаас эмгэнэл илэрхийлэх боломж байна уу. 3 дугаар тойргийн депутат, Шинжлэх ухааны академийн геологийн хүрээлэнгийн захирал Р.Барсболд гэсэн байна.Ийм учраас энэ онцгой байдлыг харж үзээд депутат Р.Барсболдод 3 дугаар микрофон дээр үг хэлэх зөвшөөрөл олгоё.Энэ хуралдаанд оролцож байгаа Ардын Их Хурлын депутатуудын нэрийн өмнөөс, хуралдаанд оролцогчдын нэрийн өмнөөс энэ эмгэнэлтэй үйл явдалд эмгэнэл илэрхийлэх нь зүйтэй гэж бодож байна.

3 дугаар тойргийн депутат Р.Барсболд: -Миний үг хэлэх дараалал хэдий ойртож байсан боловч хараахан болоогүй байлаа. Ингээд энэ эмгэнэлт явдлаас болж эрхэм депутатууд намайг өмнөө оруулсанд талархаж байна.Юм хэлэхэд хэцүү болчихлоо, гэсэн ч зөвхөн өөр хоорондоо уялдаатай энэ зэрэг асуудлыг аваад товчхон ярья гэж бодох юм.

Монгол улс бол парламентын бүгд найрамдах улс.Энэ бол зүйтэй гэж үзэж байх юм.Улсын Их Хурал бол манай парламент болох юм байна.76 гишүүнтэй 6 жил сонгогдоно, 3 жилээр сэлбэгдэнэ.Ардын Их Хурлын даргатай, дарга нь Ерөнхийлөгчийн түр эзгүйд бүрэн эрхийг эдэлнэ гэсэн ийм хэсэг уялдаа холбоотой асуудал дээр товчхон яриад үзье гэж бодсон юм.

Манай Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага гэж төсөлд заасан байгаа.Энэ бол зүйтэй юм.Гэхдээ Улсын Их Хурлын нэг танхимтай, тэнд ажиллах 76 гишүүн гэвэл миний бодоход арай цөөдөж байна уу даа.Нэгэнт төрийн эрх барих юм байна, нөгөө талаас Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч гэж бичсэн байгаа.Иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж ажиллан манай ард түмний ашиг сонирхлыг илэрхийлнэ гэсэн иймэрхүү хундтэй үүрэг гүйцэтгэх, ингээд ирэхээр зөвхөн 76-хан хун ард түмнийхээ ашиг сонирхлыг, нийт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх гэсэн ийм хундтэй үүрэг биелүүлэх элч болоход арай цөөдөж байна уу гэсэн иймэрхүү санаа байх юм.

Нөгөө талаас манай Парламент ажиллах болоход 76 харилцан цөөхөн тооны гишүүн бол өөртөө их тийм хэмжээний эрх мэдэл хуримтлуулсан болох юмаа даа. Ер нь Парламент маань төрийн эрх мэдлийн хувьд их л хүчтэй байгууллага болох юм байна. Ингээд цөөхөн гишүүнд хуваагдах тэр эрх нь бол мөн бас их байх юмаа. Энэ талаасаа үзсэн ч гэсэн ер нь Парламентын гишүүдийн хуримтлуулсан эрх мэдэл их болох тусам ардчилал энэ нь аль хэр сайн нөлөөлөх вэ гэсэн иймэрхүү ойлголт байх юм. Миний бодоход гишүүн тус бүрийн эрх нь ихсэх тусам ардчиллын түвшин ер нь жаахан доошоо буух талтай болов уу гэж бодож байна.

Нөгөө талаас Парламентад манай улсын Их Хурлын үйл ажиллагаанд бол намуудын ажил, намуудын нөлөө их болох юм байна. Ингээд ирэхээр ардчилал бага зэргээр аажмаар хорогдоход хүрэх юм бол гишүүн тус бүрийн тэр хуримтлуулсан багагүй хэмжээний эрх мэдэл, намуудын нөлөө ингэж нийлээд хэсэг бүлгийнхний нөлөө Парламент дотор хэтэрхий их болох юм биш биз гэсэн иймэрхүү ойлголт байх юм. Ингэхээр гишүүдийн тоог арай нэмэгдүүлэх нь зүйтэй болов уу гэж бодож байгаа юм. Нг тэр байна гэж хэлэхэд хэцүү юм. 100-гаас дээш байвал зүгээр юмуу даа, 120, 130 гэж зарим депутатууд ярьж байх шиг байна лээ.

Нэг танхимтай ч байж болмоор юм. Гэхдээ 6 жил гэдэг нь их юм. Дөрвөн жил гэсэн ийм санаа явж байдаг, ер нь зүгээр юм биш үү.


Ардын Их Хурлын даргын талаар цөөхөн хэдэн үг хэлэхийг хүсч байна. Уг нь парламентын сонгодог хэлбэрт хурлыг зохион байгуулдаг, удирдан явуулдаг тийм нэг өвөрмөц тушаал байдаг гэдгийг нөхөд мэднэ. Одоо чухам яаж орчуулдаг юм бүү мэд. Спикер гээд нэг юм тааралдаж байдаг юм байна. Энэ бол тийм өвөрмөц үйл ажиллагаа шаардсан, авьяас чадвар ч гэж хэлж болох юм байна. Гэхдээ даргын тал нь их зонхилсон биш, жинхэнэ зохицуулагчийн тал нь их чухал гэсэн иймэрхүү тий тушаал байдаг юм байна, нэлээн улс оронд бол. Манайд бол



"дарга" гэж байна. Дарга ч байж болох юм байна. Гэхдээ нэг тийм харгалзах зүйл байгаа юм биш үү гэж би хэлмээр байх юм. Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн түр эзгүйд эрхийг бүрэн эдэлнэ гэсэн байгаа юм байна, түр хугацаагаар ч гэсэн. Ингэхээр бас л тийм их хэмжээний эрх мэдлийг төвлөрүүлэх бололцоотой ийм тушаал үүсгэж байгаа юм биш биз ээ.

Түрүүн хэлж байсан, намууд их нөлөөтэй болно. Ингээд бодоход Улсын Их Хурлын ийнхүү чухал тушаалыг эдлэх улс төрийн үнэхээр эрх мэдлийг төвлөрүүлсэн тушаалын төлөө тэмцэлд нэлээн ширүүн болж мэдэх юмаа даа. Энэ зуны 8 дугаар сарын 20-дын үеийн үйл явдлыг та бид нар бүгдээрээ сайн мэднэ. Үүнээс энэ эргэлт болохоос өмнө нь ч гэсэн сонин хэвлэлд өөрийнхөө, манайхны Улсын Их Хурлын даргын зиндаанд очих хүний талаар бол Зөвлөлтөд их шүүмжилж байсан шүү дээ. Ухаандаа, ардчиллыг хумих талаар ихээхэн ажилласан байж байна. Зөвхөн өөрийн талынхыг товойлгохоор тэдний чиг шугамыг баримтлахаар их ажиллаж байсан. Ингэж ярьж байлаа. Өөрийнхөө, парламентын ардчиллын үед ч гэсэн түүнийг жаахан хумих боломж олддог юм ...

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

тийм боломжийг илэрхий тавиад өгчихөж байгаа юм биш биз гэсэн ийм санаа төрж байх юмаа. Улсын Их Хурал уг нь их л чухал үүрэг гүйцэтгэх том дээд зиндааны түвшингийн байгууллага болж байгаа шүү дээ. Ингээд ирэхлээр тал бүрээс нь шүүж ямар болох гэдэг дээр нь их сайн бодож хэлмээр юм. Хууль хэдий сайн байсан ч гэсэн амьдралтай тулгарахдаа л учир байдал нь шалгагддаг шүү дээ. Одоо харахад дэвшигдсэн төслийн хувьд бол төрийн байгуулал гэдэг тал дээр сонирхолтой сайхан юм олон л байх шиг байх юм. Гэхдээ манай нөхцөлд, манай өвөрмөц нөхцөлд энэ шилжилтийн гэдэг их үргэлжилж байгаа энэ нөхцөлд бол юмыг нь сайн бодож боловсруулахгүй бол хэцүү тал гарч ирж магадгүй юм. Энэ ерөнхий хэлэлцүүлгийн үеэр олон зүйлийг дурдасхийж товчхон дурдах төдий өнгөрөхөд харамсалтай байна. Ухаандаа тэр санааг дэмжинэ, тэрнийг дэмжихгүй байна, бэлэгдэл нэрний талаар бас хэлэх юм байна, гэхдээ боломж цаашид олох байх. Тодорхой зүйл бүрээр нь ярихад санаагаа дэвшүүлэхийн бодож байна. Тэгэхдээ юу ч болсон миний бодоход **депутатууд** ярьж байна лээ. Уламжлал, шинэ үеийн өөрчлөлт энэ хоёрын дунд л зөвөөр хосолж байж л учир байдлыг олох нь зүйтэй байх л даа. Алтан соёмбо ямар ч байсан үлдэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Уламжлалын талаас, нөгөө талаас авч үзэх юм бол монгол улс гэдэг нэрийг зарим депутатууд хүлээж авмааргүй бодож байх юм.

-Бид Монголын, монгол орон маань, монгол улс үндэс маань урт удаан түүхтэй, баялаг сайхан соёл иргэншилтэй гэж ярьдаг. Соёл иргэншил бүрэлдэн тогтсон гол үндэс суурь нь хүчтэй төртэй байсны л учир шалтгаан шүү дээ. Олон хүн тухайн үедээ уулзаж ярьж байхад иймэрхүү юмыг сануулдаг байсан юм. Гадаад орны нилээн том эрдэмтэн цахим тооцоолуурын төвийн дарга ингэж ярьж байсан юм гэнэ лээ. Үүнийг хэвлэсэн байсан нилээн олон сонин, сэтгүүлд. Монголчуудын, дээр үеийн монголчуудын тэр цэрэг удирдах арга барилыг тайлж учрыг олохын тулд нилээн сүрхий хөтөлбөр зохиож компьютерийн аргаар л учрыг олохоос өөр боломжгүй юм даа тэр үед бол. Өөрөөр хэлбэл манай төрийн

зохион байгуулалт, бүтэц, удирдлага тэр үедээ нилээн сүрхий, уг нь ч их сүрхий байжээ. Зөвхөн энэ ийм төр байснаас л соёл иргэншил бий болсон байна шүү дээ. Төргүй соёл иргэншил гэж байдаггүй биз дээ. Иргэншил гэдэг уг чинь юу гэж байгаа юм бэ, хангах утгаараа. Ингээд ирэхлээр монгол улс гэсэн ер нь ч дэлхийд аль хэдийнэ биднийг монгол улс гэж нэрлэж байдаг байх. Тэгэхэд үүнээс бол янз бүрээр бодоод наана цаана бодож байх нь юу л бол доо гэж бодох юмаа. Миний бодоход харин монголчууд Монгол улс гэсэн нэрийгээ ч сэргээгээд нилээн бахархаж авч явж болмоор юм шиг бодогдох юм.

Ж. Уртнасан - За 3 дугаар микрофон, депутат Сарай. 4 дээр Цэрэндорж бэлтгэж байгаарай.

Сарай - Бид ингэж шуугиж, ярьж, асуудал тавьж байгаа явдал маань аргагүй. Манай орон цоо шинэ нийгэмд шилжиж, энэ гурван жилийн дараа, таван жилийн дараа манай улс ямар дүр төрхтэй болох юм бэ гэдгийг их муу төсөөлж байгаа учраас бид өнөөдөр Үндсэн хуулийн нилээд заалт зүйлүүд дээр ингэж маргаж, удаан ярилцаж байгаа нь зүй ёсны юм болов уу гэж бодож байна.

Өнөөдөр өмчийн харилцааны хувьд хувийн өмч нийгэмд шилжиж байна. Анги гэж баячууд, ядуучуудтай болох нь шиг байна. Саятангууд засгийг удирдах нь шиг байна. Ийм зүйлийг бодолцож үзэхэд гурван жилийн дараа Үндсэн хуулийг ийм маягаар боловсруулахад ойлгогдох юм болов уу гэж бодогдож байна. Үндсэн хуулийн талаар депутатууд олон санал хэлж байна. Миний бодоход зарим зүйл дээр ерөнхий хэлэхэд Засгийн газрын эрхийг нилээн хязгаарласан иймэрхүү чигтэй юмуу гэж бодох юм. Энэ ч болж байна уу үгүй юу. Банкнийг хүртэл Бага хурал Засгийн газарт захируулахгүй гэж үзсэн энэ ер нь ямар ч дэлхий, ямар ч практик байгааг мэдэхгүй. Засгийн газар эдийн засгийг командалж зогсч байж л энэ засаг төр болно шүү дээ. Шүүх гэдгийг хэмжээгүй эрх эдлүүлж байх шиг байх юм. Үндсэн хуулийн цэц гэдэг ч хяналтын хороо. Ер нь 9 жил хэмжээгүй хэдэн хүнтэй болж байгаа нь хаашаа юм бэ гэсэн ойлгогдохгүй юм байх юм.

Үндэстний цөөнхийн хувьд заалт их бага байна. Ховдын зөвлөлгөөн дээр ч бид хэлсэн. Олон зүйл байна. Би тэрийг юу гэхэв. Манай депутатууд мэргэн ухаандаа бодож, тухайн үед бүлэг бүлгээр ярих үед ярилцана биз гэж бодож байна. Би энэ Үндсэн хуулийн дотроос хошуу, сум гэдгийг сугалж хэдэн үг хэлье.

-Би намын анхны байгууллагын дарга өнөөдөр ганцхан хүн энэ дотор байгаа болов уу гэж бодох юм. Их хурлын бүрэлдэхүүнд, 30 жилийн өмнө манай нэгдлийн "Алтай" хөгжил гэж байгуулагдаад татан буугдаад, Ойгор сум гэж байсан, татан буугдаад, энэ оны 4 дүгээр сарын 15-наас эхлээд эргээд тэр нэгдлийг байгуулж, Ойгор сумын буурин дээр балгасан дээр очоод байж байгаа нэгдлийн дарга хүн юмаа. Тэгэхээр үүнтэй уялдуулж хоёр зүйлийг тодруулмаар байна. 30 жилийн өмнө Ойгор сумыг татан буулгаж Улаанхус сумтай нийлүүлжээ. Энэ жил нэгдэл нь салж хуучин Ойгор сумын балгас дээр очсон, одоо 80 мянган малтай, 4 мянган хүнтэй 750 өрхтэй, 8 жилийн дунд сургуультай, хүн эмнэлэгтэй, тооцооны касс, банк, ахуйн үйлчилгээ холбоо зэрэг салбаруудтай, би одоо юунд зовж байна, юу болж байна вэ гэхлээр энэ суманд аймгаас нэгдлийн төвд шуудан очиж байна, энэ сумын гурван хэсэг 400 орчим өрх байна. Сумын төвөөс 120-150, 180 км алслагдсан, шуудан байхгүй. Одоо энэ бригадын хөдөлмөрчдөөс ер нь сум, аймагт ирэхээсээ Улаанбаатарт ирэх нь амархан байна. Бүр жаахан хэтрүүлсхийгээд хэлэхэд. Шуудан байхгүй сумаасаа явж байгаа. Энэ нэгдлийн хүрээнд 800 илүү тэтгэвэртэн байна. Одоо оны эхнээс аваад нэг ч тэтгэвэр аваагүй хүн олон байна, хүн үнэмших үү үгүй юу. Лантав гуай эртээд Ховдын зөвлөлгөөн дээр 3 сарын тэтгэвэр аваагүй гэж байсан. Өнөөдөр 10 сарын тэтгэвэр аваагүй сууж байна шүү дээ. Тэгэхээр ард түмэн юу болж байна гэж бодож байна.

Иргэдийн бүртгэл гэж 100-150 км газарт нэг хүүхдээ бүртгүүлэхийн тулд <sup>хүн</sup> ирж байна. Тэр хүүхдийг бүртгүүлээд өлгий сүүний хэдэн мөнгө авах нь замын зардлаасаа хэтрэх юмуу, давах юм уу ямар байгаа юм бэ тодорхой байна. Ингээд иргэдийн бүртгэл, тэтгэвэр тэтгэмж, шатахуун гэж том юм гарчихсан. Одоо

мотоцикль ихтэй. Дандаа сумын төвөөс очоод 20 литр бензин авч байна. Би депутатуудад хэлсэн. Одоо ерөөсөө шатахууны асуудал хүнд боллоо. Энэ дээр клуб, сургууль, эмнэлэг байна. Ер нь сургууль, эмнэлэг цаашдаа тарчихгүй л юм болбол сургууль, эмнэлэг ард түмэнд ойр байх нь онцгой ач холбогдолтой байна аа. Ингээд хөдөлмөрчид 750 өрхийн 10 мянга гаруй хүн сумын захиргаа байгуулах асуудлыг Их хуралд тавьж, 12 дугаар сарын 30-ны өдөр гэхэд л нөхөр Сарай чи энэ сумыг байгуулж өг надад гэсэн шаардлагыг тавьж байгаа юм шүү дээ. Харин тийм учраас байдлыг харахад надад бол ийм нэгж хэрэгтэй байна. Ний нуугүй хэлэхэд. Сумын дарга, орлогч, буюу нарийн бичгийн дарга, нийгэм хангамжийн нэг зааварлагч, санхүүгийн байцаагч хэрэгтэй байна. Гарцаагүй ийм 4 хүн байна. Тэгэхээр засаг захиргааны нэгж өнөөдөр шаардагдаж байна. Хөдөлмөрчид үүнийг хүсч байна. Тэгэхлээр хошуу гэдгийн цаана ер нь Үндсэн хуульд хошуу, сум, баг гэж оруулбал ямар байдаг юм бол доо. Гэхдээ сая депутатууд зөвхөн ярьж байна даа. Баг гэдэг чинь өнөөдөр ямар багийг төсөөлж байгаа юм бэ. Хуучны адил төсөөлж байгаа юмуу, ер нь ямар маягийн аппараттай байх юм бэ сайн мэдэхгүй байна.

Манай нутагт бол багийн дарга гэдэг бол хөрөнгө чинээтэй, олон түмэнд нэр хүндтэй, жаахан настай, өөрөө морь унаатай, ер нь багийн дарга хэлэхэд эргэн тойрны омог отгийнхон хөдөлдөггүй ийм хүмүүс багийн дарга байсан. Энэ багийн даргад тухайн үед захиргаадах үе ч байсан, захирагдаж байсан. Одоо нэг дунд мэргэжлийн зоотехникч юмуу малын бага эмч багийн дарга хийх юм бол бараг үгий нь сонсдог хүн олдох юм болов уу гэж. Одоо сумын даргын, сумын захиргааны үгийг сонсохгүй байна шүү дээ. Ийм нөхцөлд би бол ер нь хуучин байдлаараа сэтгэл баг байгуулах юм бол ямар ч үр дүн өгөхгүй болов уу гэж би ийм тооцоотой хүн байгаа юм. Тийм учраас энэ байдлыг эрхбиш бодолцож өнөөдөр ард түмэн сумын захиргаанд хүрч чадахгүй ингэж бухимдаж, засаг төрдөө хандаж асуулт тавьж байхад одоо хошуу байгуулах юм бол хошуу гэдэг нь юу болох юм байгаа юм бэ миний бодоход. Хэрвээ засаг захиргааны энэ байдлыг өөрчилж хошуу болгоно гэх юм бол орон нутагт нь нилээн эмх замбараагүй

мал аж ахуй, газар тариалан маань нилтээн унасан, ер нь энэ 3 жил болшгүй. 1990 оноос тун шуугиантай юм хөдөө гарах юм шүү. Энэ бол гарцаагүй гэж бодож байна. Тийм учраас сум гэдгийг Гончигдорж дарга өчигдөр дурсаатах нь лээ. Ер нь сум гэдгийг зохих цэг дээр нь байгуулж, хошуу гэдгийг байгуулбал ямар байдаг юм бол доо. Хошуу байгуулахад бас давуу тал бий. Жишээлбэл Манай Сагсай, Цэнгэл, Улаанхус гурвыг үзэхэд Цэнгэл сум нь модтой, модыг нь авна, Сагсай, Улаанхус нь хадлантай, хадлангийг нь авна, отрын нутагт явна. Боломжтой тал бий нь бий. Төрийг бас үгүйсгэж болохгүй юм. Гэтэл цаг хугацааны хувьд нэг арай ард түмэн хүлээж авмааргүй ийм нэг жаахан түрүүлсэн гэх юмуу, ийм цаг үед хошууны тухай яриад байгаа юм **болов уу даа**, үгүй бол сумын жижигхэн нэгжийг байгуулж өгч хөдөлмөрчдийг тайвшруулах тал нь юу байдаг юм бол доо. Үүнийг бодож үзвэл ямар байгаа юм бол доо. Багийн бол хөдөлмөрчдийн дунд миний ярьж байдаг энэ <sup>/сонсогдоогүй/</sup> хүртэл хийдэг захиргааны тодорхой нэгж болгохгүй болбол морьтой ганцхан хүн энэ багийн даргын үүргийг гүйцэтгэхгүй байх шүү. Бусад юмыг бүлэг дээр нь ярьж. Ялангуяа манай сонгогчдын бас нэг зүйлийг <sup>захисан</sup> Засгийн газрын тайлан дээр ярьж гэж бодож байна.

Ж. Уртнасан - 4-р микрофон дээр Цэрэндорж, 5-р микрофон дээр Алгаа бэлтгэж байгаарай.

232 дугаар тойргийн депутат Цэрэндорж - БНМАУ-ын Үндсэн хуулийн нэрийг өөрчлөхгүйгээр Үндсэн хууль гэдэг нэрээр нь нэрлэе гэсэн саналтай байна. I дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд Монгол улсад засгийн бүх эрхийг ард түмэн мэднэ гэснийг яаж хэрэгжүүлэх юм бол гэсэн баталгаа зайлшгүй тодотгох шаардлагатай байна гэж үзэж байна. Төрийн эрх мэдлийг давамгайлүүлж, ард түмний эрхийг хязгаарлаж байгаа юм шиг санагдаж байгаа юм. Үүнийг би баталгаа болгож хэлэхэд монгол улсад газар, түүний хэвлий ой ус болон байгалийн бусад баялаг ард түмний мэдэл, төрийн хяналтанд байна гэсэн боловч ус ой, амьтан, байгалийн бусад баялаг бол төрийн өмч гэснээр ард түмний эрхийг хязгаарлаж байна гэж үзэж байна. Амьдралд болж байгаа

нэг жишээ дурдъя гэж бодож байна. Одоо байгалийн баялгийг төрийн өмчид өгснөөр сумын захиргаа өөрийнхөө орлого, төсвийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглаж байна. Ер нь ойгоос мод бэлтгэхэд захиргаанд зохих хэмжээний орлого ордог, газрын хэвлийд байгаа баялгийг захиргаа мэдэж өгөх, тэрнээс орлого олох энэ талаасаа голлож эрх мэдлээ хэтрүүлэх хандлага гарч магадгүй байна. Ийм учраас үүнийг бүх ард түмний мэдэлд төрийн хяналтанд байна гэсэн утгаар байвал зүйтэй байх болов уу гэж үзэж байна.

Нөгөө талаар тэр гадаадын иргэдэд газрыг түрээсээр өгөх юмуу тусгай болзлоор өгнө гэдэг энэ заалтыг хасах нь зүйтэй байх. Хэрвээ түрээсээр өгөх юм бол тодорхой хугацаагаар тодорхой заах, 5-аас илүү жилээр гэдэг юмуу. Ер нь 20, 30 жилээр эзэмшүүлчих юм бол газрынхаа, хөрснийхөө үржил шимийг дууссаны дараа бид хамжуултай хөрс эргүүлж авах байдаг юмуу энэ утгагүй асуудал шиг байна.

Төрийн сүлд, тугийг хуучнаар нь хэвээр үлдээх саналтай байна. Түрүүн уг хэлсэн хүмүүс тайлбарыг нь хэлсэн учраас дахин тайлбарлах шаардлагагүй байх аа гэж үзэж байна. Ер нь сүлдэн дундаас малаа гаргаж шувуу оруулна гэдгийг малчид маань зөвшөөрөхгүй байгаа шүү. Мөн улсын нийслэлийг Улаанбаатар хот гэдгээр нь зааж өгөх хэрэгтэй байна. Ер нь эрт орой хэзээ нэгэн цагт энэ нийслэлийн маань нүүдэл хийж магадгүй юм шиг хөдөлмөрчдийн дунд тийм ойлгоц байна аа.

2 дугаар бүлэгт 16 дугаар зүйл дээр Монгол улс гадаадын иргэний эрх үүргийг тодорхойлохдоо цаад улсын иргэдийн эрх үүрэгтэй адилхан хоёр талаасаа хэлцэл хийж байгаад эрх олгохоор юм шиг байх юм. Гэтэл манайхны эдийн засгийн хүчин чадал, бололцоо нь даах юм болов уу, ер нь одоо саятангууд орж ирээд энд амьдрах тийм хэмжээгээр цөөнх нь гадаадад очоод монголынхоо хөрөнгийг үрээд байх юм биш үү гэсэн тийм бодлого төрж байх юм. Мөн гадаадад хавчигдаж, мөрдөгдсөн иргэдийг монголд байлгах эрхийг баталгаажуулж өгөхөөр заасан байна. Үүнийг бас түдгэлзвэл яасан юм бэ гэсэн саналтай байна.

3 дугаар бүлэг дээр улс төрийн байгуулал гэдэг хэсэг дээр хэдхэн санал хэлмээр байна. Ер нь одоо улс төрийн байгуулал бол хүн ам нь төвлөрөн суурьшсан гадаадын хөгжилтэй орнуудын тэр аргаар хийгдэж байгаа юм биш биз. Ер нь тархай бутархай аж ахуйтай, одоо ч ардын аж ахуйтан голлож байгаа үед өшөө ч бас тархай болох ийм нөхцөлд бид өвөрмөц зохион байгуулалттай ажиллах нь зүйтэй байх гэж бодогдож байна.

Ардын Их Хурлыг Улсын их хурал болгож байгаа нь ард түмнээс засгийн эрхийг барьж байсан хуучин эрх хэмжээг нь боогдуулж байна уу гэсэн бодлого төрж байна. Үүнийг жишээгээр ярих юм бол өнөөдөр бид нь засаг захиргааны нэгж бүрээсээ депутатаар сонгогдож, төлөөлөгч нь энд сууж байхад энэ шинэ төсөлд 76 хүн гэсэн байна. Тэгэхлээр энэ бол 28-30 мянган хүн буюу 14 мянга нь сонгогчид гэх юм бол энэ дээрээс ард түмний жинхэнэ төлөөлөгч байнгын санаа зоригийг нь илэрхийлж байх тийм бололцоо олдохгүй болох нээ. Үүнийг үндэслээд Ардын Их Хурлыг хоёр танхимтай байлгах. Дээд танхимыг нь бол ер нь засаг захиргааны нэгжийг зохион байгуулагдах тэр асуудалтай холбож засаг захиргааны нэгж бүрээс нэг хүн байх буюу 200-гаас дээш хүн байх нь зүйтэй юм. Доод танхим нь харин 30-аас илүүгүй байлгавал яасан юм бэ гэсэн санал байна. Тэр ерөнхийлөгчийн талаар бас нэг санал хэлмээр байна. Ер нь парламентын нам <sup>уул</sup> Дотроос эрх барих нам нь ерөнхийлөгчөө, ерөнхий сайдаа нэр дэвшүүлж гаргаж байвал яасан юм бэ, тэгэхдээ ерөнхийлөгч, ерөнхий сайд нь ажил хавсарч байх юмуу, эсвэл тэр нь болдоггүй юм бол ерөнхийлөгч нь ерөнхий сайдаа, Засгийн газартаа ажлын чиглэл өгч байдаг, Засгийн газар нь түүнийг биелүүлж байдаг ийм хэлбэрээр зохион байгуулбал яасан юм бэ гэсэн санал байна. Тэр хошууны талаар бол бас дэмжиж байгаа хүний нэг. Ер нь одоогийн байдлаар сум байлаа ч гэсэн нилээн хэдэн сумдыг нэгтгэх зайлшгүй шаардлага байна. Энд бол сумын төвийг хаягдаад балгас болчихно гэж итгэхгүй байна. Ер нь нэгэнт сургалтын, эмнэлгийн үйлчилгээ төлбөртэй болох юм бол сумын төв дээр аж ахуйн байгууллагууд нь голлож



суурьшаад ерөөсөө ч анхнаасаа аж ахуйн байгууллага нь барьж байгуулж бий болгосон юм, тэр хаягдахгүй байх. Тэнд нь харин эмнэлэг, сургууль, ясли, цэцэрлэг, үйлчилгээний газруудыг хэвээр ажиллуулж, засаг төрийн байгууллагаа хошуундаа шилжүүлж, тэр зохих хэмжээний зардлыг төвлөрүүлэн зохицуулбал ихээхэн хэмнэлт гарах болов уу гэсэн бодлого байна. Нөгөө талаар бол олон юм бий. Түүнийг зүйл анги дээр нь ярьж.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН

*Баян*

/Д. БАЯНДҮҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

151 дүгээр тойргийн депутат Б.Алгаа: Манай сонгогчид ийм дүгнэлт хийж байгаа.Шинэ Үндсэн хуулийг боловсруулахад комисс Бага Хуралд нэлээд ажил хийсэн нь тодорхой байна.Гэвч хөдөөгийн хөдөлмөрчдийн саналыг тусгасангүй, ард түмний амьдралаас тасархай байна, ард түмний сүсэглэн хүндэлж биширч явдаг зүйлийг үгүйсгэсэн байна гэж.Энэ байдлаас харахад Үндсэн хууль сүлд, дуулалаа өөрчилж байгаа асуудал хүнд байна.Яагаад гэвэл бидний амьдрал хүнд байхад ихээхэн хэмжээний зардал гарах энэ бидний шүтдэг зүйлийг өөрчилсөн их зардлаа одоо картныхаа барааг олж авч чадахгүй байгаа хөдөлмөрчид олон байна, ядарсан улс олон байна.Энэ олон сая төгрөгөө их хурлаас шийдэж бидний амьдралд туслах мөнгө болгож өгөхийг хүсэмжилсэн.Нэгдүгээрт.

Хоёрдугаарт Үндсэн хуулийн зорилт иргэний ардчилсан нийгэм гэсэн зорилт байгаа.Ер нь зорилтыг хүнлэг энэрэнгүй энэ иргэний ардчилсан нийгэм болгож өгөөчээ.Ардчиллын нэрээр ардчилал хийх нь зөв, эхэлж байгаа нь сайхан талтай юмнууд бий, гэвч танхайрах, дэггүйрхэх, панз наймаа хийх ийм байдал, дэггүй, сахилгагүй хэлбэр ихэссэн.Иймд хүнлэг, энэрэнгүй гэдэг үгийг заавал оруулж өгөөч гэдэг асуудлыг хөндөж тавьж байгаа.Энэ ч зөв юм шиг санагдаж байгаа.Харин улсын нэр дээр Бүгд Найрамдах Монгол Ардчилсан Улс гэж нэрлэмээр байна.Яагаад гэвэл Үндсэн хуулийн букуу нийгмийнхээ зорилтонд ардчилсан нийгэм гэж орж байгаа учраас энэ үгийг А-гий нь А-гаар солихдоо биш, ард гэдгийг ардчилаар солих нь зөв юм гэсэн санал өгч байгаа.

Энэ Үндсэн хуулийн иргэний эрхэнд өндөр настны эрх ашгийг хамгаална гэж үг ороогүй.Энэ юу гэсэн үг вэ гэвэл хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаална гэсэн болохоос биш өндөр настанаа орхижээ.Бидний одоо үе чинь ээж, аав далан жилийн алган дээрээ сургасан улсууд ээж, ааваа, өндөр настангуудаа мартчихаж болдог юм болов уу.Энийг бодож эднийхээ талаар, өндөр настангуудынхаа талаар, аав, ээжийнхээ талаар санаж сэтгэж оруулаасай.Тэтгэвэр, тэтгэмж гэж ч үг байхгүй.Эдийн тусламж үзүүлнэ гэсэн үг орсон байгаа.Бид ч хаачих юм болж байна аа.Сарай дарга сая энэний түрүүнд 10 сар тэтгэмж аваагүй байна гэж дурдсан.Энэ байдлыг бо-

дохгүй бол болохгүй юм шиг санагдаж байгаа. Энэ дээр дүгнэлт хийж дээдэх нь суудлаа олохгүй болбол доодох нь гүйдлээ олохгүй гэж хөгшид, өвгөдөө үзэж харах, бодож сэтгэх талаар манай дээрээс явуулж байгаа бодлого арай далан жил бидний аав, ээж, днийхээ алган дээр өсөж бойжчихоод эднийгээ үгүйсгээд байгаа энэ байдалдаа дүгнэлт хийгээсэй гэж хүсэмжилж байсан.

Хүний иргэний үүрэгт хүн хүнээ хүндлэхийг дээдлэх үүрэгтэй гэдгийг заавал оруулах шаардлагатай. Одооны сахилгагүй, дэггүй, цанз наймаа хийх энэ байдал нэлээн газар авсан учраас хүн хүнээ хүндлэхгүйгээр ардчилсан нийгмийн тухай бодоход нэлээд бэрхшээлтэй гэсэн.

Дараа нь Үндсэн хуулийн цэц хуучин Улс төрийн Товчоо гараад ирлээ. Ийм учраас Дээд шүүх, дээд шүүхийн зөвлөл, Их Хурал, Бага Хурал байж байхад энийг хэрэггүй гэж үзэж байгаа.

Өөрийн орны өвөрмөц онцлогийг харгалзан хэвшмэл эдийн засагтай байна гэж заасан. Хэвшмэл эдийн засаг гэдэг чинь одооны энэ ядуурал, үгүйрлийн хямралын эдийн засгийг хэвшмэл эдийн засаг гэж нэрлэж байгаа юмуу, ер нь хэвшмэл эдийн засаг гэдэг нэр томъёо буруу байна гэдгийг зүй ёсоор шүүмжилж байгаа. Ерөнхийлөгчийн хүндэтгэлийг хуулинд зааж өгөх ёстой юм. Энэ байхгүй. Яагаад гэвэл гурван жил, дөрвөн жил ч байдаг юмуу, болсны дараа хүндэтгэлийн зарчимд заагаагүй, Үндсэн хуулинд эроогүй бол бас дураараа загнасан гэдэг үг гарч ирнэ. Хэн байх нь хамаагүй Ерөнхийлөгч бол хүндэтгэлийн ямар нэгэн Үндсэн хуулиар олгосон эрхтэй байх ёстой гэдгийг бодох хэрэгтэй юм.

Ерөнхийлөгч хүнийг зургаан жилээр, дөрвөн жилээр байлгана гэдэг буруу байна, зургаан жилээс доошгүй байх шаардлагатай. Яагаад гэвэл нэг үйлдвэрийг дарга хийх ч юмуу, нэг аж ахуйн дарга хийхэд нэг жил хүнтэйгээ ажлаа мэдэх гэж будилдаг шүү дээ. Нэг улсын ерөнхийлөгч хийнэ гэдэг чинь дөрөвхөн жилд юу бүтээж, юу зохион байгуулж, ард түмэндээ яаж өгөөжтэй ажиллаж чадах юм бэ. Ийм учраас эхний жил нь зургаан жилээс доошгүй, хоёрдахь жил нь дөрвөн жилээр байх нь зүйтэй гэж үзэж байна.

367 дугаар тойргийн депутат Ү.Цэдэнбал: Үндсэн хуулийн төсөл боловсруулах комисс Бага Хурлын нөхдөөс боловсруулсан хуулийн төсөл ихээхэн хүч хөдөлмөр гаргаж ард түмнээр хэлэлцүүлэхэд өргөн олны санал, итгэлийг хүлээлгэсэн нэлээд томоохон арга хэмжээ болж өнгөрсөн юм. Тэгэхдээ Үндсэн хуулинд ард түмнээс гаргасан санал хүсэлт бага туссан тул манай хөдөөгийн хөдөлмөрчид, ер нь нийт ард түмэн бол энэ үндсэн хуулийг хэрэгжүүлэх, цааш нь хүлээж авахдаа нэлээд сэтгэл дундуурхан байгааг сонгогчдын байдлыг танилцуулахыг хүсч байгаа юм. Ингээд Үндсэн хуулинд Их цаазанд гарч байгаа энэ хууль, улсын нэр, хуулийн нэр, улсын билэгдлийн тухай асуудал дээр өөрчлөхгүй байгаа талаар өгч байгаа депутатуудын саналтай санал нэг байна. Яагаад вэ гэвэл энд бол үндэслэлийн хоёр зүйл байгаа юм. Одоо бидний цаана сонгогдсон хөдөлмөрчид бол сардаа хоёроос гурван кг гурилын картын нормтой, 2-3 кг будааны нормтой байж байгаа тэр нөхцөлд манай улсын нэг мөнгөн сангийн нэг 80 гаруй сая долларыг нэг хэсэг нь тогложихож, бид нар 20 гаруй хоног хуралдаж 3 саяыг нь идлээ, цаана нь нэрийг чинь өөрчлөөд 12 саяыг нь зарлаа гээд орхивол сонгогчид бид нарыг тийм ч их баяртай, ард түмэнд, бид нарт юм бүтээж ирлээ гэж хүлээж авахад хэцүүхэн байгаа байхаа.

Ийм учраас улсынхаа сан хөмрөг, эдийн засгийн бодлогод тулгуурлаж, бас зарим өөрчлөх асуудлаа хугацааг бодож асуудал тулгавал яасан юм бэ гэсэн ийм асуудал байгаа юм.

Хоёрдугаарт хүний эрхийн асуудал дээр нэг санал байна. Хүний эрхийн асуудалд Ерөнхий боловсролын сургуулийг үнэ төлбөргүй эзэмшүүлнэ, эмчлэхэд эмнэлэг үйлчилгээгээр хангуулахад үнэ төлбөргүй гэсний гадна, энэ асуудал дээр мэргэжил эзэмших асуудал яах юм бэ. Цаашдаа хүний амь насыг даатгалд оруулах талаар хүний асуудал дээр анхаарч үзмээр байгаа юм. Өнөөдрийн байдлаар эмчилгээ үнэ төлбөргүй хийгдэж байлаа ч гэсэн энэ материалыг ард түмэн өөрөө хөөцөлдөж, энэ хэмжээнд хүндэрвэл хөдөлмөрдийн аж байдал хүндрэх юм гэсэн ийм зүйлүүд байгаа юм.

Төрийн зохицуулалт дээр 2 танхимтай, Ерөнхийлөгчийн Засгийн газартай улс орон байхад зохих талаар гаргаж байгаа

саналыг дэмжиж байна. Ингэхдээ Ерөнхийлөгчөөс Засгийн газарт үзүүлэх энд энэ харьцах харьцааны талаар, өөр эрхийг нь нэмэгдүүлэх талаар хуулинд тусгаж өгвөл яасан юм бэ, анхаарч үзэх нь зүйтэй юмаа гэж.

Орон нутгийн засаг, захиргааны тал дээр хоёр зүйлийг тодотгож хэлэхийг хүсч байна. Сумын орон нутгийг аймаг, хушуу, багаар зохион байгуулагдахаар илтгэл, хурал, тогтоолын бунд орсон. Гэхдээ багийг өчигдөр дэд ерөнхийлөгч тодорхойлохдоо сумаас арай бага, сумын тэнцүү гэсэн хоёр тэнцлэлийг хэлсэн. Тэгэхээр миний ойлгож байгаагаар газар, нутаг, малаар сумаас арай бага байх юм байна. Ажиллаж байгаа орон тооны хувьд сумтай тэнцүү байх юм гэж ойлгож хүлээж авлаа. Энэний талаар суманд одоогийн ажиллаж байгаа засаг захиргааны нэгжийг багруу шилжүүлвэл тэр хэмжээний орон тоо нэмэгдэж ажилладаг юм бол гэдэг бас нэгэн эргэлзэх бодлого төрж байгаа юмаа. Гэхдээ хушуу, сумыг хушуу болгоно гэж Үндсэн хуулийн төсөл, Их цаазын төсөлд хавсралт хуулинд орсон энэ хугацааг болбол би ер хүлээж авч, зөвшөөрөхгүй байгаа юм. Яагаад вэ гэвэл одоогийн сумын гүйцэтгэх захиргаа бол орон нутагт гол ажил түшиж байгаа байгууллага бол сумын гүйцэтгэх захиргаа, тэрний дарга дээр бид нар бүх ажлыг явуулж байна. Гэтэл одоо хушуу болгон ч мөдхөн зохион байгуулагдана баг чинь 1992 оноос эхлэнэ гэвэл одоогийн явуулж байгаа бүх арга хэмжээ, орон нутгийн засаг захиргааны арга хэмжээ зогсоход хүрнэ. Энэ цаашдаа ч бас хүндрэлд оруулна.

Ийм учраас энэ хушуу зохион байгуулах асуудлыг байдаг юм бол ер нь хуулинд, хавсралт хуулинд заасан хугацаануудыг бүгдийг орхиж, дараа нь төр, засгийн бодлогоор энийгээ шийдвэрлэвэл яасан юм бэ гэсэн ийм зүйлүүдийг санал болгож хэлэх байна. Ингээд үндсэн бүлэг бүр дээр өөрийнхөө санаж бодож байгаа бусад зүйлүүдийг нэмэрлээдхийг хүсэж байна.

370 дугаар тойргийн депутат В.Цамба: Их цаазтай ерөнхийлэлтийн байдлыг бол зөвшөөрч байна. Их цааз бол оюун ухаан дайчилж, үнэхээр зохих ёсоор зохион байгуулагджээ гэж үзэж байна. Ганц нэг зүйл дээр санал өгөх саналтай байна.

Нэгдүгээрт газар өмчлөх эрхтэй иргэд байх ёстой. Хоёрдугаарт ерөөс төрийн өмчийн газрыг бол цаашид бусдыг эдлүүлэхдээ ганцхүү төлбөртэйгээр эзэмшүүлэх ёстой гэдэг саналтай байдаг. Энэ талаар цаг гарвал дараа нь ярина.

Хоёрдугаарт нь бол үндэсний аюулгүй байдлын дотор үндэсний эдийн засгийн аюулгүй байдал бол чухлаар тавигдах ёстой. Манай орон шиг эдийн засгийн хувьд ядуу, хөгжлөөр буурай орны хувьд ийм байгаа, зайлшгүй чухлаар тавигдах ёстой. Ийм ч учраас Их цаазад үндэсний эдийн засгийн бие даасан аюулгүй байдлыг хуулиар бататгана гэсэн заалтыг бол зайлшгүй оруулж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

Гуравдугаарт манай ард түмний төрийн хамгаалалтанд газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, тэрнээс гадна манай агаар мандал бол зайлшгүй тодотгож орсон байх шаардлагатай. Бид бол ерөнхийдөө агаарын хилийг зөрчлөө гэж яригдаад байдаг. Дайн байлдаан болох дээр ч гэсэн эжлээд агаараар дайраад дараа нь газраар явдаг юм байна. Ийм учраас агаар мандал бол ард түмний адил төрийн хамгаалалтад байна гэдэг асуудал нэр зааж орох шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Ардын Их Хурал бол төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага байх ёстой. Түүнээс зүгээр дээд байгууллага гэж орхисон байна. Ардын Их Хурлын, тэгэхдээ нэг мандат бүхий сонгуулийн төчнөөн тойргоос бүрдэнэ гэдгийг оруулж өгөх хэрэгтэй. Ингээд түрүүчийн тайлбар ярианаас сонсоод байхад магадгүй олон мандаттай, магадгүй 76 хүний нэр жагсаагаад ч юмуу, ингээд сонгууль нутаг дэвсгэрийн хэмжээний явагдах юм шиг байна. Тэгэх юм бол бид хүнээ судалж танихгүй Бага Хурлынхаа гишүүдийг сонгосон шүү. Бөөнөөр нь Ийм учраас нэг сонгуулийн тойрогт нэг мандаттай байна гэдгийг онцолж тусгах шаардлагатай гэж бодож байна.

Засаг захиргааны нэгжийг хушуу ч гэж нэрлэнэ үү, сум ч гэж нэрлэнэ үү, ер нь цаашдаа хөгжлийн хувьд өөрчлөгдөх тийм хандлага бол байх байх. Нийлэх, салах тийм юм байх байх. Урьдах энэ сургамжаас үзэхэд ингэж сум орныг нэгтгэхэд нэгдүгээрт төв, суурин

бол эзгүүддэг, хоёрдугаарт хөдөөгийн хөдөлмөрчдийн, түүний дотор нүүдлийн малчдыг удирдлага, ахуй үйлчилгээ, сургууль, соёл үйлчилгээ, мал эмнэлгийн үйлчилгээ бол хөндийрдөг, урьд нь засаг захиргааны нэгжийн хэмжээгээр зохион байгуулагдсан аж ахуйн нэгж бол үндсэндээ задардаг, дөрөвдүгээрт хамгийн гол үндэсний цөөнхийн эрх ашиг бол цөөнх үндэстэн, ястны эрх ашгаар хохирдог ийм сургамж байдаг. Энэ бүхнийг бодолцон үзэж хэрвээ хушуу, сум, засаг, захиргааны нэгжийн зохион байгуулалтыг өөрчлөхөд чухам юуг гол нь анхаарч, хөндөхгүй байх юм гэдэг заалтыг л тэрэнд оруулж өгөх хэрэгтэй байна. Адгийн наад зах нь бол 61 дүгээр зүйл дээр засаг захиргааны нэгжийг шинээр болон өөрчлөн зохион байгуулахад цөөнх үндэстэн ястны хүсэл сонирхол, эрх ашгийг хөндөхгүй байхаар хийнэ гэсэн маягийн ч юм байдаг юмуу, энэ заалтыг оруулж өгч тэдний эрх ашгийг хамгаалахгүй бол энэ дээрээс болж маргаан бол байнга гарч байдаг юм.

Дараа нь хувийн өмчийг бол хууль ёсоор хураахыг хориглосон заалт оржээ. Энэ нь нөгөө талдаа нийтийн өмчийг хураана гэхтэй адилхан юм. Энэ талаар асуултаар асуусан. Тэгсэн нь ерөөсөө нийтийн өмч гэдэг уг ганцхан төрийн өмчийг хэлж байна гэж тайлбар авлаа. Би бол төрийн өмчид бол нам, олон нийтийн байгууллага, сүм хийдийн өмчийг бүгдээрээ багтаж байгаа юм гэж ойлгосон. Энүүгээр бол Засгийн газар тогтоол гаргаад намын хөрөнгийг ч өөрчлөн дайчлах, олон нийтийн байгууллагын хөрөнгийг ч өөр тийш нь дайчлах ийм боломжтой болсон юм шиг байна. Энэ заалтыг хасъя. Дээр 4 дүгээр зүйлд заасан байгаа. Ер нь өмчлөгчийн эрхийг ганц хуульд зааснаар хязгаарлаж болно гэж заасан байгаа. Ингэхээр энэ заалтыг бусдыг үгүйсгэх маягаар ингэж оруулах шаардлагагүй байна гэж бодож байна. Цаашилбал Үндсэн хуульд нэмж өөрчлөлт оруулахдаа ард нийтийн санал явуулгыг явуулсны үндсэн дээр эхлэн шийдэж байна гэж оруулах нь зүйтэй юм гэж үзэж байна. Түүнээс биш одоо ахиад дараачийн байг гэхэд нойтон жил ч бол Үндсэн хуулиа өөрчлөө гэдэг асуудлыг яригдахааргүй ингэж оруулья гэж бодож байна. За ингээд хугацааны хувьд газрыг яагаад төлбөртэй өмчлөхийг дэмжээд байгаа юм бэ гэдгийг ярих хэрэгтэй байна. Нэгдүгээрт бид газрыг үнэхээр эзэн нь юм бол, нийтээрээ эзэн нь юм бол аль тодорхой

хэсгүүдийг хамт олон өмчлөхдөө үүнийг төлбөртэйгээр өмчлөх ёстой. Хоёрдугаарт манай хөдөө аж ахуйд байгаль, цаг агаарын янз бүрийн нөхцөл байна. Нэг хэсэг нь нэг хониндоо 5 га нутагт бэлчээж байхад, нөгөө хэсэг нь 1,5 га-д бэлчээж байх жишээтэй. Нэг хэсэг нь малаа 3 мянган метр өндөрт төллүүлж байхад нөгөө хэсэг нь 1000 метр өндөрт үнэндээ зун болсон байхад мал төллөж байх жишээтэй. Чухамхүү ийм бол эрс зөрүүтэй байдал бий. Энийг одоо гагцхүү газар нь төлбөрөөр зохицуулна. Хуучин бид үүнийг хөдөө аж ахуйд ийм зохицуулахдаа говийн бүсийн нэмэгдэл гэж 10-25 хувийн юмаар зохицуулж байсан. Одоо энэ бол байхгүй болно. Мэдээж бид нар чөлөөт үнэд шилжсэн байхад ялгаварт үнэ гэж юу гэж байх вэ. Хэрвээ яг одоонийхоор байхад хөдөө аж ахуйд ажиллаж байгаа малчид, хөдөлмөрчид бүгдээрээ хохирно. Ийм учраас төлбөр бол зайлшгүй байх хэрэгтэй. Энийг бол олонхийн юмуу цөөнхийн саналаар шийдвэрлэх биш, мэргэжлийн байгууллага дүгнэлтээ гаргаж оруулах ёстой юм. Үнэхээр ийм ялгавартай газар байна уу, энийг тогтоох шаардлагатай юмуу гэдгийг эрдэм шинжилгээний байгууллагууд тогтоогоод эднүүсийг нь харин хурал дээр комисс гаргаж тогтоогоод ингээд бид дунг танилцуулж ингэсний үндсэн дээр шийдэх ёстой юм. Үнэхээрийн санал хурааж шийдэх юм бол магадгүй бүгдээрээ төлбөргүй байж гэдэг дээр гар өргөж тэр олонхи болж баталж өгнө.

Энэ асуудлыг шийдэхдээ гагцхүү цөөнхийн эрх ашгийг хүндэтгэж тэр бол жинхэнэ дүгнэлтийг харгалзаж шийдэх, бодит байдлыг харгалзаж энэ асуудлыг оруулах шаардлагатай гэж үзэж байна.

107 дугаар тойргийн депутат Л.Баяндалай:

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Бичээч



ЭНХТҮЯА

В.ОЖУН



1991-ХI-16  
Кассет III-16  
16.21-16.37

Д. Баяндалай/ 375-р тойргийн депутат/ /-Улсын

Бага Хурлаас бидэнд өргөн мэдүүлж байгаа Их цаазын төслийг бүхэлд нь нааштай үзэж байна. Иймээс энэ хуулийн төслийг Их Хуралдаа оруулан хэлэлцүүлж, нэг бүрчлэн хэлэлцэх ийм саналтай байна. Энэ дашрамд өөрийн зарим бодлыг хэлье.

Өнөөдөр эх орон маань өөрчлөлт шинэчлэлтийн энэ давалгаан дунд явж байна. Бүх л юмыг өөрчлөх, хуучин байсан бүгдийг л өөрчлөх гэсэн ийм эрмэлзэл, ийм хүсэл, ийм үйл ажиллагаа газар сайгүй өрнөж байгаа үед энэ Их цаазын төсөл гарч ирсэн, энэ дунд боловсрогдож гарч ирсэн. Өөрчлөхөөрөө энэ зарим нь зах зээл рүү өөрчилнө, зарим нь хуучин байдлаараа өөрчилнө, хуучин нь хэт эртний хуучин байдлаар, жинхэнэ монгол ёсоороо гэхээр бүр урагшаа яваад алга болоод өгнө, бүр ухраад Чингис, цаашаа хүннү сүннү юу гэдэг юм. Тэгээд яваад өгдөг.

Эсвэл зах зээлд орно, гадны парламент дуурайна гэхээрээ зэрэг л бүр цаашаа америк, япон гээд яваад өгнө. Дунд нь өөрийнхөө, одоо байгаа монгол дээр ерөөсөө тогтож чадахгүй. Ийм байдалтайгаар, энэ байдал маань энэ хуулинд зүй ёсоор тусаж байна. Үндэснийхээ юмыг оруулж байгаа нь энэ гээд хэдэн нэр оруулсан. Хошуу, Их цааз, засаг дарга гэсэн энэ нэрнүүд нь одоо жинхэнэ монгол юм, монгол хууль болж байгаагийнхаа хувьд энэ нэрнүүдтэй болохоор монгол хууль болчихоод байгаа юм уу хаашаа юм. Дэлхийн парламентын ёсонд нийлүүлнэ гээд авахаараа нөгөө монгол нь биш болоод явчих жишээтэй. Яг өнөөдөр монгол улсын маань нутаг дэвсгэрийн байдал, эдийн засгийн байдал, хүн ардад одоогийн тогтсон ёс заншил, мэдрэмж, мэдлэг, боловсролын түвшин энэ бүх байдлаа харгалзаж үзэх хэрэгтэй.

Мөнхийн хууль бий болгох мөрөөдөл бол сайхан. Бид үүний төлөө зорих ёстой. Гэхдээ мөнхийн хуульнаас наана бидэнд завсрын хууль хэрэгтэй юм шиг байна. Өнөөдөр бид завсрын үе шатанд амьдарч байна. Бүх юмыг өөрчилнө гээд байна, өөрчлөөд юундаа хүрэхийг мэдэхгүй тэр цаг үе дээрээ явж байна шүү дээ. Хэн ч

өнөөдөр хэлж чадахааргүй байна. Өнөөдөр хэн ч итгэж, хэдэн жилийн дотор монгол улсыг ийм болгочихно гэж итгэлтэй хэлэх тийм хоншоортой аавын хүү бол даанч байхгүй байгаа, тийм бололцоо ч алга. Иймээс өнөөдрийнхөө цаг үеийг мэдэрч, энэ өөрчлөгдөж байгаа цаг үедээ зохицсон, завсрындуу шинжтэй хууль гаргавал бидэнд арай илүү нийцэх болов уу.

Улс төр маань, эдийн засаг маань тогтворжоод ирсэн үед, хүн ард маань парламентат ёсоо ойлгодог, урьд өнгөрсөн түүхээ мэддэг энэ цаг үед нь өөрчлөх юмаа өөрчилье. Тийм энэ өөрчлөлт шинэчлэлт маань одоо тэгэхээр нэг нэрээр хөөцөлдөх шинж рүүгээ ороод ирлээ л дээ. Энэ өөрчлөлт шинэчлэлт, ардчилал маань саатаж, доголдож эхэлж байгаагаа харуулж байна. Ноднин ганцхан бужигнуулаад л өөрчлөөд хаячихсан. Өнөөдөр нөгөө томоохон дорвитой юм яриад байсан хүчнүүд маань алга болчихсон. Ихэвчлэн одоо нэр төр, нэр өөрчлөх тухай асуудал руу орж эхэлж байна шүү дээ. Энэ чинь саатаж эхэлж байгаагаа харуулж байна. Тодорхой онолын том концепцгүй, чиглэлгүй, мэдлэггүй явсныг харуулж байна шүү дээ. Ийм үед бид чинь одоо байгаа амьдрал дээрээ жаахан тогтож харж тэгж өөрчлөх.

Өөрчлөх шаардлага байж болно. Тухайлбал улсын нэр, сүлд юу байдаг юм, өөрчлөх шаардлага байж болно. Гэхдээ өөрчлөх бүр хэрэгтэй ч байж магадгүй. Гэхдээ түүнийг цаг үеийг нь олох хэрэгтэй байна. Аливаа цаг үеийг нь олоогүй өөрчлөлт, ялангуяа хомроглон хүчээр захиргаадах маягаар өөрчилсөн өөрчлөлт болгон гамшиг тарьдгийг олон жилийн турш бид өнгөрсөн хоёр жилийн дотор ч гэсэн ечнөөн төчнөөнөөр нь үзлээ шүү дээ. Бид иймээсээ сургаж авах цаг болжээ.

Тусгаар тогтнолын тухай бид үнэхээр санаа зовохгүй бол болохгүй байж болохгүй асуудал. Энэ Үндсэн хууль дээр бид тусгаар тогтнолын асуудлыг үнэхээр ухаалгаар авч хоцрохгүй бол бидний тухай тусгаар тогтнолоо хамгаалах гол арга маань ухаан. Бидэнд өөр юм байхгүй. Бидэнд эдийн засаг, техникийн тийм том боломж байхгүй. Тэр тусмаа НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн хоёр

том орны дунд бусад орноос тасархай ийм байдалтай байж байна. Бидэнд тусгаар тогтнолын баталгаа хэзээ ч алдагдаж мэдэхээр энэ нөхцөлд бид оршиж байгаа юм. Хэдийгээр дэлхийд олон улсын тэр соёл иргэншил дээшилж, бие биэндээ халдан түрэмгийлэх явдал багасаж байгаа ч гэсэн арилаагүй байна. Бид энд яаж авч хоцрох ёстой вэ? Улсын нэрнээсээ, сүлд тэмдэгнээсээ, тэгээд газрын тухай асуудал дээр, энэ бүгдийг ухаалаг бодох ёстой. Өө гаргахгүй байх ёстой. Бусад түрэмгийлэх өө гаргахгүй байх ёстой.

Тэр газар түрээслэх тухай асуудал зайлшгүй байх ёстой асуудал. Энэ нь нэг талаар бидэнд нэг цагт, бидний тусгаар тогтнолоо, бид айж байна, тусгаар тогтнолоо алдчих вий дээ гэж айж байна. Нэг тал дээр очсон чинь бид нарын тусгаар тогтнолын зохих ёсны нэг талын баталгаа ч болж мэднэ шүү дээ. Олон улсын эрх ашгийн манай улстай холбогдоод ирвэл бидэнд олон улсын өмгөөлөлд орох бололцоотой болно шүү.

Тэгээд энэн дотор ажиглагдаж байгаа муухай уур амьсгал, ерөөсөө манай орон даяар явж байгаа. Хардлага сөрдлэгийн уур амьсгал байх юмаа. Энэ Үндсэн хуулийн төслийг боловсруулахад ч тэр хардлага сөрдлэгийн юмнууд давамгайлж, бие биеэ нэг юм оруулах гэхээр нь чи тэгэх гэж л тийм юмаа оруулж байгаа, чи хуучинсаг үзэлтэй учраас тэрнийгээ хамгаалах гэж ингэж байгаа гэж одоо нэг ийм байдлаар хардаж, өнөөдөр ч ярихаараа тэр, Улсын Бага Хурал өөрийгөө авч хоцрох гэж л ийм төсөл оруулж ирж, тэгээд л хамгаалж байгаа ч гэдэг юм уу, хөдөөнөөс ирсэнээр бодоход сумын дарга сумынхаа дарга хэвээр хоцрох гэж тэр хошууг эсэргүүцээд байгаа ч гэдэг юм уу, нэг иймэрхүү хардлага сөрдлэгийн уур амьсгалыг бид больж, жинхэнэ улс төр, эдийн засаг, тусгаар тогтнолоо бодож, ингэж ямаар байна.

Тусгаар тогтнолын асуудал бид нарын дотор эвдрэлцлээс болж алдаж байсан түүх олон бий гэдгийг санацгаахсан.

Ц.Элбэгдорж /427 дугаар тойргийн депутат/ -Миний хувьд

ерөнхий санал шүүмжлэл гэдэг бол Их цаазын тодорхой үг, өгүүл-  
бэрийн тухай асуудал бус, харин би энэ Их цааз бичгийг юу  
гэж ойлгож байгаагаа, та бидэнд ямар хэмжээний үүрэг ноогд-  
лоо гэж бодож байгаагаа, Их цаазыг батлахад юуг анхаарах ёс-  
той гэж үзэж байгаагаа хэлэх явдал гэж ойлгосон юм. Ингээд  
би өнгөрөгч өдөр ерөнхий санал шүүмжлэлийн үеэр хэлье гэж  
бодож бичсэн зүйлээ уншъя. Би хэлэх үгээ нэмэгдэл минутаасаа  
хоёр минутыг нэмж, энэ их гүн хүндэтгэлтэй чуулганд есөн ца-  
гааны бэлгэдлийг бодож есөн минутад багтааж хэлье.  
Хүндэт депутатууд та бүхэн хүлээж авна уу.

Энэ чуулганд оролцож буй депутатууд л Их цаазыг батална.  
Тиймээс бид еер хоорондоо ерөнхий ойлголцолд хүрч, төрийн хү-  
ний уужуу ухаанаар Их Хуулиа бүтээх цаг болжээ. Их цаазыг хэ-  
лэлцэж батлахдаа депутат бүр хэд хэдэн зүйлийг анхаармаар са-  
нагдана. Энэ чуулганаас баталж гаргах Их хуульд монгол улсын  
хойшдын бүх хууль нийцсэн байх ёстой. Хэрэв бид өнөөдрөөс цааш-  
хийг харж чадахгүй, загварчлалаас гарч, асуудалд алсын хараа-  
тай хандахгүй бол монголын сэргэн мандлын эх суурийг бат  
нягт хуульчлах бус харин улс орныхоо хөгжил цэцэглэлтийг чө-  
дөрлөхөд хүрнэ.

Мөн хуульд цаг зуурын шинжтэй, аливаа үзэл номлолыг  
дагасан зүйлийг тусгамааргүй байна. Хэрэв ийм асуудал руу их  
хэлбийвээс бидний бүтээсэн их хууль хүнээр хэлбэл хүүхэд нас-  
наасаа гарч чадалгүй, цагийн эргэлтийн аяг дагаж цөөхөн жил  
амьдарсан хуулиудын нэрийг нэгээр нэмэх төдийгөөр нас нь гүй-  
цэх болно.

Монгол улсын их хуулийн нас эцсийн эцэст өнөөдрийн тө-  
рийн эрх барих дээд байгууллагын яс чанарын илэрхийлэл, та  
бидний чадамжийн хэмжүүр болно.

Монгол улсын их хууль нь монголчуудын уламжлал их өвөг  
дээдсийн маань хүн төрөлхтөний соёл иргэншилд оруулсан хувь

## 5.

нэмэр лугаа утга төгөлдөр, урт удаан наслах учиртай гэж бодогдох юм. Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьж буй Их цаазын төсөл ямар ч тохиолдолд их хууль болж наад зах нь нэг шат дээших ёстойгоос бус, хуулийн төслөөс төслийн төсөл болж улам муудах учиргүй гэж бодогдож байна.

Монгол улсад ардын засаг гэж яригдсан 70 жилд өнөөдрийн та бидний хэлэлцэж буй Их цааз шиг өргөн хэлэлцүүлэгт өртсөн монгол түмний оюун ухааны уламжлалын дээдсийг аль болох шингээхийг эрмэлзсэн хууль цааз байгаагүй гэж хэлэхэд хилсдэхгүй биз ээ. Иймээс ч Их цаазыг хэлэлцэхэд тун няхуур, алсын хараатай хандахгүй бол ярьж ярьж хурал өндөрлөх үед Улсын Бага Хурлаас өргөн барьж буй Их цаазын төсөлд туссан зүйлүүд дээр л эргээд буух вий дээ.

бид

Ингэхгүйн тулд биесээ тун тэвчээртэй сонсож, Их цаазыг хэлэлцэх явцад багагүй суралцах хэрэгтэй болж байна. Суралцах гэдгээс үүдээд нэгэн зүйлд их санаа зовинож буйгаа нуух юун. Юун гэвэл депутатууд маань битгий ятгаад бай, би ухуулгад орчих гээд байна, ийм яриа сонсмооргүй байна гэж их ярих юм. Энэ нь битгий надад юм ойлгуулах гээд бай, би юм мэдчих гээд байна, би бүх асуудлыг урьдчилаад шийдчихсэн, миний шийд наддаа л зөв гэсэнтэй дагаар нэг юм даа.

МИНЬ

Ухааны баян дээдийн баян гэж монгол түмэн! ярьдагсан. Ер нь аль ч оронд хууль тогтоох төрийн дээд байгууллага нь тухайн ард түмний гэгээ гэрэл нь оюун ухааны олонлог нь байдаг. Монгол улс ч энэ зүй тогтлоос гажих ёсгүй гэж би ойлгох юм. Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хүч тэнхээ, дур зоргоороо авирлах явдлыг бус оюун ухааныг шүтдэг учир парламентын тогтолцооны татах хүч нь өдгөө улам нэмэгдэж байна.

Парламентат ёсны эрүүл уур амьсгал монголд ч алаг цоог нэвтэрсээр байгаа нь энэ удаагийн Ардын Их Хурлын чуулганаас ажиглагдаж байна. Хамгийн том даргын үгийг бус, том нэртэй урт

илтгэлийг бус, мэргэн гэгдэх нэгэн хүний сургаалийг бус, харин оюун ухаанаа уралдуулж, амьдралын эгэл үнэнийг дээдэлж, бодол саналаа чөлөөтэй илэрхийлж, аливаа асуудлын учир зүйг олж байж шийдвэрлэх гэж депутатууд мэрийж байгаа нь дээрхийн нотолгоо болох биз ээ. Гэхдээ ихэнх депутатууд маань ард түмэн, сонгогчид гэсэн гүн хүндэтгэлтэй энэ хоёр үгийг гар дамжсан бор төгрөг мэт үг, өгүүлбэр бүрийнхээ хооронд жийрэгэвчлэх юм. Ард түмэн маань олон янзын санаа бодолтой, олон янзын хүнээс бүрэлддэг.

Сонгогчдын дунд ч таны төлөө санал өгөөгүйгээрээ таныг сонгосон, танаас өөр үзэл бодолтой сонгогч олон бийг та бид мартаж яахан болох билээ. Ер нь их эрх мэдэлтэй байна гэдэг бол юу санаанд орсноо ярина, дураараа шийдвэр гаргана, санаснаараа зүтгэнэ гэсэн үг биш байхаа.

Их цаазын үндсэн үзэл санааг дэмжиж байгаадаа депутат та бүхэнд Их цаазыг дүн нуруутай, та бидэнд Их цаазыг дүн нуруутай батална гэж итгэсэндээ олон хүн улс төр, олон нийтийн олон байгууллага зөвхөн ерөөлийн үг хэлж, энэ их чуулганд та биднийг үдэн мордуулаад анхааралтай харж суугааг мартаж боломгүй.

Та биднийг монголчууд төдийгүй, ардчилал, шударга ёсыг шүтэгч дэлхийн олон улс гүрэн, түм түмэн хүн харж байгаа. Дэлхийг хардаг монголын нүднээс монголыг хардаг дэлхийн нүд хавьгүй том нь эргэлзээгүй.

Төрийн тэргүүн хэн байна гэдгээс нь биш, төрийн дээд эрх барих хууль тогтоох байгууллага нь хэр бодитой, жам ёстой уялдсан зөв шийдвэр гаргаж чадаж байна гэдгээр нь дэлхийн улс түмэн итгэх итгэлийнхээ хэм хэмжээг тодорхойлдог. Учир нь аливаа парламентыг төлөөлөх шийдвэр гаргах чанараар нь тухайн ард түмэн бүхлээрээ байна гэж ойлгодог. Иймээс та бид дэлхийн улс түмний итгэлийн өргөдөл дээр ард түмнээ төлөөлж тамга дарах гэж байна.

Их цаазад зөвхөн сүүлийн хоёр жилийн ардчилал, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн монголчуудын тэмцлийг бататгаж буй бус манжийн эрхшээлд орсноос хойшхи бүхэл бүтэн гурван зууны турш алд биеэ алдруулан байж монголыг өдий зэрэгтэй авч ирсэн үе үеийн монголчуудын төрт ёс, эрх чөлөөний тэмцлийн үр дүнг хуульчлан тунхаглах гэж байна.

Их цаазад орж байгаа үг, өгүүлбэр бүхэн тодорхой утга агуулж, нийгмийн бүхэл бүтэн харилцааг хуульчлан зохицуулахад зориулагдаж байгаа. Иймээс хийж чаддаг байснаа чадахгүй болж, уламжлал заншлаа огоорч, монголоо мартаж, тэжээвэр хүмүүсийн олонлог болж, хүний эрхшээлд орсон эмгэнэлт хувь тавилангаасаа салах гэвэл салсан шиг л салах хэрэгтэй.

Аливаа улс орныг эрхшээлдээ оруулахын тулд заавал зэвсэгт түрэмгийлэл шаардлагагүй байдаг шилдэг туршилтын үр дүнг монголчууд амсахаараа нэг болж байна. Бидэнд нэрнээс өөр юм үлдээгүй, боолын боол монгол хэрэгтэй юу? Бидэнд уламжлалт түүхээрээ, төрт ёсоороо гайхуулсан монголын монгол хэрэгтэй юу? Энэ асуултад хариулах түүхэн үүрэг зөвхөн та бидэнд ноогджээ. Та бидний шийдвэрээс монголчууд төдийгүй, дэлхий нийт монголчууд чинь хувь заяагаа өөрсдөө шийдэж чаддаг болжээ, өөрийн толгойтой болжээ гэдгийг ойлгох, олж харах ёстой. Та бидэнтэй ах дүүс байсан, та бидэнтэй адил туршилтад өртсөн улс гүрнүүд ч эмгэнэлт хувь тавилангаасаа тууштай салж байна.

Ер нь гол дээгүүр харайж байгаа хүн дунд нь гишгэдэггүй шүү дээ. Харайсан л бол цаад эрэгт нь буух ёстой. Хэрэв зориг алдаж дунд нь гишгэвэл усанд унана. Гэхдээ та бидний унах усыг ус гэж хэн ч хэлээгүй. Магадгүй хүн төрөлхтний хараалыг идсэн зуунгаас зуунг их намаг байж болохыг яаж мэдэх вэ?

Депутатууд бид хөрс нь бүрэлдээгүй байхад ямар ч шимтэй үр соёолдоггүй, зүй тогтол, цагийн эргэлт юуг ч өөрчилж чаддагийг аль аль талдаа хүлээн зөвшөөрөх, харгалзаж

үзэхээс өөр аргагүй болжээ. Зүйрлүүлж хэлбэл халгай ургадаг хөрсөнд, вансэмбэрүү ургахгүй, хонин жил хичнээн өнтэй байлаа ч хойтон дахиж давтагдахгүйтэй адил юм. Энэ удаад бид загварчлалаас гарч хариас тулгасан хүний шүтээний оронд монгол ухаанаараа, монгол шүтээнээ Их цааз бичгээ бүтээж чадахгүй бол түүхийн давтамж дахиж ингэж нүүрээ нааш харуулах болов уу?

Та бидний хэлэлцэх гэж буй Их цаазын төсөлд нухацтай ярмаар, монголынхоо ирээдүйг, маргаашийд дэнслэн дэнслэн бодмоор бас ч өөрчилмөөр, улам сайжруулмаар! Үг, өгүүлбэр олон бий. Харин шил хүзүүнд нь шивсэн хачиг хувалзыг нь устгах гэж байгаа нь энэ гэж хонинд хүчээр дуст идүүлж болохгүй шүү дээ. Энэ үг зөвхөн Их цаазын төсөлд хамаарах бус, дэлхийн нийтийн өмнө нүүрээ тахалдаг дөнгөж бүрэлдэж буй ардчилал, төрийн ардчилсан тортолцоо, түүний цаана монгол түмний хувь заяа бий шүү.

Та бидний үүрсэн ачаа дэндүү хүнд бололтой. Харин та бид бүгдээрээ сонгогчиддоо, ард түмэндээ энэ ачааг даана гэж амлаж, тэдний итгэлийг хүлээж Ардын Их Хурлын депутат болж, нэгэнт Их чуулгандаа цугласнаас хойш ачаа хичнээн хүнд байсан ч мөр мөрөө түшиж үүрч гарахаас өөр аргагүй. Харин бидэнд өөрсдийнхөө бүрэн эрх, онц эрхийн тухай тухтайхан ярилцах боломж хэзээ ч гарна. Одоо зав алга. Үндсэн ажлаа сайн хийцгээе.

Соронзон хальстай тулгаж  
нийлсэн

*Д. Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг



287 дугаар тойргийн депутат Ч.Хурц: Манай Улсын Бага хурал Үндсэн хуулийг шинэчлэн боловсруулах комисс, манай эрдэмтэн мэргэд, өөрсдийнхөө оюун санаа, сэтгэлийг шамдан ажиллаж, та бидэнд БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг Монголын Их цааз нэртэйгээр оруулж хэлэлцүүлж байна.

Энэ хуулийн төслийг боловсруулахад их хүч чармайлт гаргаж, бид бүхэнд үнэхээр сэтгэл санааг тал талаас нь дайчлах тийм бодит бололцоотой санаа гаргах боломжийг гаргаж өгсөн энэ нөхөлдөө юуны урьд баяр талархлаа илэрхийлье гэж бодож байна.

Шинэ үндсэн хуулийг боловсруулахад зарцуулсан энэ хөдөлмөр, энэ оюун санааны бүтээлийг ч бид, Их Хурлын депутатууд та бид нар үнэлж үзээд, энэ чуулганыхаа хэлэлцэх гол асуудал болгож ярилцаж байгаа маань нэн таалалтай байна.

Бидний депутатууд Монгол орон ардчилсан, зах зээлийн харилцаанд шилжсэн, олон намын тогтолцоо бүхий засаглалтай орон болсон шүү гэдгийг дэлхийн буюу гадаадын хүмүүсүүдэд гайхуулах гэж энэ Үндсэн хуулийг бүтээж байгаа юм бишээ.

Гагцхүү монголын ард түмэн, иргэн бүр дагаж мөрдөх, дээдлэх боломжтой тийм үндсэн хуулийг ард түмэндээ зориулж бүтээхэд та бидний зорилго оршиж байгаа юм.

Тиймээс энэ хууль бол бидний боловсруулаад батлах хууль маань зөвхөн монголын ард иргэдийн хууль, монголын засаглалын хуульгэдгийг бид хатуу ойлгож, ер нь энэ хуулиа Их цааз биш Монголын Их засаг хэмээх хууль гэж нэрлэвэл зүйтэй болов уу гэсэн саналтай явж байна. Энэ хуулийн төслийг боловсруулахдаа манай хуулийн комисс, бусад нөхдүүд хэд хэдэн үндсэн зарчим баримталжээ.

Бид ч гэсэн энэ зарчмыг хатуу сайн баримтлах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Энэ нь нэгдүгээрт манай оронд ялсан сүүлийн үед бий болсон манай залуучууд, эх орончдын сэтгэл зүрхээрээ тэмцэж өгсөн ардчиллаас бид ухрахгүй. Түүнийг хөгжүүлэн шударга, үнэн, ариун үйлсийг эрхэмлэхэд бид гол зарчмыг, энэ хуулийг боловсруулах зарчим болгох нь зүйтэй байхаа гэж бодож байна.

Хоёрдугаарт, зах зээлийн харилцаанд шилжиж байгаа улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлийг тууштай мөрдөж, нэгэнт эхэлсэн зүйлээ эцэст нь хүргэхийн тулд чармайх энэ зарчим бидний энэ Үндсэн хуульд бүрэн тусах болов уу гэж ингэж бодож байна.

Гуравдугаарт, монголын ард түмэн, иргэдийн олон ургальч үзэл бодлыг бүрэн тусгасан, маргаашдаа итгэх итгэлийг нь төрүүлсэн, тийм л хууль байх зарчим байх болов уу гэж бодож байна.

Дээрх зарчимд тулгуурласан үндсэн хуулийн агуулга бол бүхэлдээ зах зээлийн харилцаанд шилжиж байгаа, засаг төр, ард түмний хоорондын уялдаа холбоог ардчиллын өргөн утгаар тогтооход оршиж байна.

Үүнийг нэг талаас нь хэлбэл, ард түмний ашиг сонирхлыг хамгаалсан төрийн засаглал тогтоох явдал мөн гэж үзэж болно.

Нөгөө талаас нь авч үзвэл улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалж, ардчилсан шударга ёс, ард иргэдийн тэгш эрх, эрх чөлөөг хангасан засаглалыг бүрдүүлж чадсанаараа хуулиа дээдлэх зарчимд ард түмэн шилжих механизмыг бий болгоно гэсэн үг.

Ингэхээр энэ бол ард түмэн, төр засаглал хоёрын хоорондын холбоо уялдааг хуульчлан тогтооно гэж байгаадаа гол нь байгаа юм.

3.

Ийм учраас зөвхөн энэ бол улс нийгмийн дээд талын хэсэг биш, зөвхөн ард түмэндээ зориулсан зүйл биш. Тийм учраас аль аль талыг нь хангасан тийм л хуулийг бид боловсруулах явдал чухал байгаа.

Өөрөөр хэлбэл өнөөдрийн энэ хуулийг ингээд манай Их цаазын төслийг уншихад зөвхөн дээд тал Парламент хэсэг, засгийн засаглалын талаа бодоод, ард түмэндээ яаж хүрч байгаа юм бэ гэдэг тал дээрээ туйлын дутуу байна. Өөрөөр хэлбэл энэ хуулийн I, II бүлэг үнэн хэрэг дээрээ муу боловсрогджээ. Ард түмэн тал чинь муу боловсрогджээ гэж ойлгож байгаа. Зөвхөн төр засаглалын хуваарь болоод сүүлд очихоор зэрэг III бүлгийн сүүлчээс эхлээд энэ доод засаг, сум, орон нутгийн зохион байгуулалтад дөхөөд очихоор нэлээд хэмжээгээр амьдралд ойртох нь байтугай холдмоор шинжтэй болж байна.

Бид энэ Үндсэн хуулиа ярихын тулд юуны урьд Засгийн газар, Бага Хурлынхаа тайланг сонсчихоод ярьсан бол их сайн байсан юм. Яагаад вэ гэхээр зэрэг энэ Засгийн газар, Ерөнхийлөгч, Бага Хурал маань нэг жил гаруй хугацаанд яг энэ Үндсэн хуулийнхаа үзэл бодлоор ажилласан юм шүү. Тэгээд энэ үзэл бодол маань ямар үр дүнд хүргэж байна вэ гэдгийг бид эргээд хараад энэ дээрээсээ дүгнэлт хийх бололцоо байсан юмаа. Түүнээс өөр бид засаг, бага хурлаа шүүмжилж, халах, огцруулах, энэ тухай асуудлыг бид ярих гээгүй юмаа. Хамгийн гол нь шинэ боловсруулах үндсэн хуулиа ямар хэмжээнд боловсруулах вэ гэдгээ хэлэх үндэслэлээ боловсруулж авахад энэ чухал байна. Гэвч энэ маань бидэнд бүтсэнгүй. Олонхи депутатууд үүнийг маань дэмжээгүй учраас бид одоо сүүл талаас нь юм уу, дүгнэлтгүйгээр энэ зүйл рүүгээ ороход хүрч байна.

Энэ Засгийн газар, парламентын ажилласан хугацаанд хуримтлуулсан туршлага ололт дамжилт, алдаа дутагдал, аль аль нь бий. Гэхдээ бид энэ хурлын ажиллагааны явцад олсон ололтыг нь дөвийлгөж магтаад байх нэг хэсэг байхад нөгөө хэсэг алдаа

дутагдлыг нь дуудан хэлж, муучлах явдал хэрэггүй байхаа гэж бодож байна.

Туйлшрал бол бидний ажулаа. Бүх хүч, бүх хүн бүр хүч оруулж хэлбэл энэ туйлшрал бидний сүйрэл болно. Тэгэхээр миний хэлэх гэсэн зүйл бол ер нь одоо энэ ямар засаглал тогтоох вэгэдэг дээр бид гол анхаарлаа төвлөрүүлэх ёстой. Одоогийн өнөөдрийн боловсруулаад байгаа бол энэ хууль чинь Францын засаглалын хэсэг, Франц-Америкийн хуулийг холиод хийчихсэн бантан болчихжээ. Тийм учраас энэ бантан чинь хоорондоо зохицолдохгүй байна. Яагаад зохицолдохгүй байна вэ гэдэг нь 20 дугаар тогтоол, диллерийн хэргээс тодорхой харагдаж байна.

20 дугаар тогтоол бол улсын мөнгөн санхүүгийн асуудал төгрөгний ханшны тухай асуудлыг ярьж байхад, Улсын Бага Хурлын шийдэх ёстой асуудал байсан. Энэ тухай Бага Хурлын гишүүн Жанцангийн сонин дээр гарсан статьяа тодорхой зааж өгсөн. Гэтэл энэ хурлыг Засгийн газар авч шийдээд, бүр болохгүй алдагдалд ороод хүмүүсүүдийн бухимдал төрөөд ирэхээр Ерөнхийлөгч дундаас нь зарлиг гаргачихаж байна. Ингэж засаглалыг хувааж болохгүй.

Диллерийн тухай асуудлыг бид ярьж байна. Өнөөдөр манай Бага Хурал банкаа жинхэнэ хууль ёсоор удирдаад явсан бол, банкны асуудал байх байсан. Энэ Бага Хурлын асуудал байх байсан. Гэтэл өнөөдөр бид энэ диллерийн асуудлыг Засгийн газартай холбож байна.

Магадгүй Ерөнхийлөгч үүнийг мэдэж байсан байж магадгүй. Ийм учраас бид засаглалыг буруу хуваахын учир үүнд байна. Одоо өнөөдрийн бидний уншиж байгаа энэ Их цаазын төсөл бол засаглалыг 5 группт хуваачихаад байна. Ийм 5 группт хуваасан засаглал бол олигтой засаг явахгүй. Италийн засаглал, Японы засаглал өнөөдөр, парламентын засаглал маш хэврэг засгийн газартай байж байнаа гэдгийг харуулаад байна.

Ийм учраас Монголын Засгийн газар ч гэсэн энэ асуудлыг, энэ засаглалыг хуваахад бодох нь зүйтэй гэж бодож байна. Би энэ зүйлийг хэлмээр байна. Бусдыг нь суулд ярья.

98 дугаар тойргийн депутат Л.Марав:

Энэ Бага Хурлаас оруулсан Үндсэн хуулийн төсөл бол 6 дугаар сарын зөвлөлгөөний үед бидэнд хэлэлцүүлж байсан төслөөс боловсронгуй, тэнд депутат бидний ярьсан зарим зүйлүүд тусгагдсанаараа арай давуу талтай байна гэж үзэж байна.

Гэхдээ миний хувьд энд хоёр зүйл дээр бас сануулж хэлэхэд илүүдэхгүй болов уу гэж бодож байна.

Нэгдүгээрт; өнгөрсөн үеийн түүхэн ололтоосоо зарим зүйлийг хэтэрхий үгүйсгэсэн ийм хандлага энэ хуулинд заагдсан.

Хоёрдугаарт, гадаадын хуулиудаас, тухайлбал Үндсэн хуулиудыг тухайлбал олон орны үндсэн хууль судлаад өөрсдөө ч гэсэн туршлага судалж Бага Хурлын гишүүд явж байхдаа олж ирсэн санал хүсэлтээ зарим талаар тулгаж, орчуулгын чанартайгаар оруулсан ийм зүйлүүд харагдаад байгаа юм. Энэтгэл дээр бид анхаарлаа төвлөрүүлэх ёстой байх гэж бодож байна. Тухайлбал хүн бүр эрх зүйн субъект байх ёстой гээд оруулчихаж байгаа юм. Субъект гэдгийг 80 настай хөгшин уншаад ойлгох уу? 8 настай хүүхэд үүнийг орчуулахгүйгээр тархиндаа шингээх үү гэвэл энэ бас л нэлээн зайтай зүйл л дээ.

Тийм учраас би Бага Хурлын даргаас энэ асуусныг асуугаад, хариугий нь авахад бас л онцын зүйл хэлэвгүй.

Эрх, үүрэг гэсэн зүйлүүд бол тэнцвэртэй байх ёстой л гэж бодож байна. Хэтэрхий их эрх эдлээд, үүргээ бага биелүүлэх үү? үүргээ сайн биелүүлж байж, эрхээ эдлэх үү? гэвэл энд бас уялдаатай байх зүйл байх. Гэтэл эрхэн дээр нь олон зүйл оруулж өгөөд хүний эрх, эрх чөлөө гэдэг нэрийн дор, үүргэн дээр нь

болохоор амьд явахын эх үүсвэр болсон хөдөлмөрлөх үүргийг хүртэл оруулахгүй ийм тал байгаа юм. Энэ бол хөдөлмөр хийх эрх тэр тухайн хүний ухамсарт үйл ажиллагаатай холбоотой гэж үзэж байгаа юм байлгүй.

Ийм байдлаар ингэж хандаад байвал үүргээ биелүүлж, эх орныхоо өмнө хөдөлмөрлөж, улс эх орныхоо эдийн засгийг өөд нь татах тийм сэтгэхүйтэй хүн ховордоно шүү. Дан дамын наймаагаар амьдраад нэг их тийм хөдөлмөр хийхгүйгээр улс эх орон маань урагшлахгүй байх л гэж би бодож байна.

Миний хувьд хуулинд заадан эрх мэдэл бүхий ерөнхийлөгчтэй, парламентын засаглалтай байхыг л дэмждэг. Газар түүний баялгийг улсын онцгой өмч байлгаж байгаад, тэр засгаасаа хатуухан хяналт тавихгүй бол ардчиллаар далимдуулж улс эх орныхоо хөрсийг ухаж, төнхөж гадагш нь гаргасаар байгаа ийм хүмүүсүүдтэй хийх тэмцэл маань өнгөрсөн нэг жилийн хугацаанд үнэхээр ажиглагдсан шүү дээ.

Байгалийн баялгаа бид гадагш нь хяналтгүйгээр гаргаж хулгай маягаар ингэсээр байтал улс эхорондоо гадаадаас бас хүн оруулж ирж түрээсээр өгөөд байвал дараагийн үед маань хэр зэргийн баялагтай газар уламжлагдах болоо гэдгээс ч гэсэн бодох юм байгаа юм.

Үндсэн хууль, БНМАУ гэсэн нэр томъёо, туг далбаа, төрийн дууллыг хэвээр нь байлгах шаардлагатай байхаа гэж үзэж байна.


Харин сүлдний хувьд бол хэлбэрийг нь өөрчилж болно, агуулгыг бол өөрчилмөөргүй санагддаг. Энд агуулгын хувьд өргөн хүрээтэй зүйлүүд орсон. Манай байгаль дэлхийн эрдэнэт зүйлүүд энд байгаа, уламжлагдаж ирсэн бүх зүйлүүдийг харуулсан зүйлүүд бий. Тэр коммунизмын улаан наран өөд морьтой хүн давхиж байна гэж байна.

Зарим нь нар жаргах зүг л гэх юм. Хүн хүн өөр өөрийнхөөрөө ойлгодог байхаа. Ямар ч байсан шувууг зөвшөөрөхгүй л гэж үзэж байна. Шувуу бол үнэхээр шувуу цагаан хоолтой шувуу, махан хоолтой шувуу, өлсгөлөн явдаг шувуу гэж ангилагддаггүй нь мэдээж.

Манай ард түмэн махчин шувуу гэдэг үнэлгээ л өгсөн бол түүнийг сэтгэхүйгээс нь гаргаж хаятал тодорхой хугацаа шаардагдах байхаа.

Эцэст нь хэлэхэд бид энэ чуулган дээрээ бодуштай юм байна уу? Эв эеэ олж нэлээн ухаалаг, цагаа хэмнэсэн байдалтай бид ингэж баймаар байна. Ингээд өглөөний хуралдаан эхлэнгүүт л шинэ сэдэв гаргаж ирээд л шөнө бодож байгаад ирдэг юм уу? Үймүүлээд хаячихдаг ийм хүмүүсүүдтэйгээ жаахан тооцоо хийж, эргэж харж баймаар юм шиг санагдаж байна.

Соронзон хальстай тулгаж  
Нийлсэн



Д.ЧУЛУУНШЭЦЭГ

Ардын Их Хурлын 6I дүгээр тойргийн депутат Д. Дамбийжанцан:  
 -Тэгэхээр Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байгаа энэ үед уг хэлэх болсондоо баяртай байна. Юүний өмнө хэд хэдэн саналыг хэлж хүргэх нь зөв гэж бодож байгаа. Санаа давхардана. Тэгэхдээ үгээ хэлнэ. Юу вэ гэхлээр зэрэг БНМАУ-ын нэр, Үндсэн хуулийн нэр, энэ нэрийн тухай асуудлыг бол хүн болгон ярьж байгаа, хуучнаар нь байлгана гэж. Энэнийг бол хуучнаар нь байлгахгүй бол ерөөсөө болохгүй байгаа. Хамгийн их бухимдал төрүүлж байгаа асуудал, энэ нэрийг солих гээд байгаа асуудал их бухимдал төрүүлж байгаа. Яагаад ингээд одоо манай сонгогчид юу ярьж байгаа вэ гэхлээр Монголын ард түмнийхээ ихэнхийн саналыг яагаад саналынхаа ихэнхийн шийдвэрээр яагаад төсөл боловсруулж яваад байгаа юм бэ? Цаашдаа хөдөлмөрчдөөс ингээд санал авна гэх юм бол бид л саналаа өгөхгүй дээ гэж ингэж хэлж байгаа. Тийм л итгэл найдваргүй болоод байна шүү дээ.

Төрийн сүлдийн хувьд бол хуучин загварыг жижгээр өөрчлөх хэрэгтэй. Депутатуудтай санал нэг байна. Тэгэхдээ манай сонгогчид ярьж байгаа. Манайхан ч гэлээ гэсэн төрийн минь сүлд минь аварч өршөө гэж ингэж биширч шүтэж явдаг, гэтэл одоо өлий сахиж байгаа сар шиг шувуунд энэ сайхан залбиралт үгээ хэлэх болов уу цаа яах бол гэж ингэж ярьж байгаа. Тийм учраас сүлдийн хувьд депутатуудтай санал нэг байна. Өшөө юу байна гэхлээр зэрэг хүний эрхийг баталгаажуулах талаар нэлээн бодлогтой юм хийх хэрэгтэй байна. Тэр шүүхийн тухай депутатууд ярилаа. Шүүхийг их эрх мэдэлтэй, баралгаатай ажлыг нь өгөөд, цалингий нь хүртэл баталгаажуулаад, бууруулахгүй гээд ингээд баталгаатай юм өгөөд байдаг, гэтэл наад амьд явах эрхтэй, эмнэлгийн тусламж авах эрхтэй, энэнийг тэр шүүхийг тэгж баталгаажуулсан шигээ яагаад баталгаатай хэлж болдоггүй юм бэ. Энэн дээр бас нэлээн бодох хэрэгтэй болов уу гэдэг ийм санал байна. Дараа нь юу байна гэхлээр энэ Их Хурлын 76 гишүүний тоог нэмэх хэрэгтэй. Гурван жил болоод сэлбэх тухай асуудлыг ерөөсөө ойлгохгүй байна. Ер нь эцсийн эцэст



2.

гурван жил болоод сэлбэх сонгууль бол ер нь бүтэн жилжингээ ч сонгууль явуулаад барахгүй байх шүү. Сая бид нарыг л Их Хурлын депутатаар сонгоход мөн ч олон дахин сонгууль явсан. Тийм учраас энэнийг нэлээн сайн тодотгож энэ оньсогоо сайн тайлбарлаж өгөхгүй бол ойлгохгүй байна.

Өөр юу вэ гэхлээр энэ засаг захиргааны нэгжийн хувьд нэлээн ярилаа. Энэн дээр үнэхээр манай сонгогчид, ер нь хөдөлмөрчид их бухимдаж байгаа. За энэ юу вэ гэхлээр зэрэг үзэл бодол янз янз болсон. Одоо жалга цовны үзэл арилаагүй, улам ихдэж байгаа, тэгэх нь битгий хэл, жалга цовоороо ч гэлээ гэсэн, сум хоорондоо ч гэлээ гэсэн нударган зоцоон хийж байгаа шүү дээ. Энэ нуух юм байхгүй. Радиогоор яригдсан. Тийм учраас юу вэ гэхлээр зэрэг хошууны хэлбэрт орох юм бол ер нь байршил өшөө одоо ингээд өөрчлөгдөнө. Ер нь ингээд хошууны засаглалаар ингээд шийдчих юм бол одоо ингээд нэг тэнгэр дулаарч хавар болоод ирэхлээр зэрэг их нууж гарна. За ер нь гарцаагүй хошууны системд орох нь. Тийм учраас би хуучин дээр үеийнхээ хошуу нутаг уруу явъя цаа гэсэн бодолтой хүмүүсүүд их байгаа. Тийм учраас энэ хүмүүсүүдийн бодлыг нэлээн хүндэтгэн үзэж, энэ засаглалын асуудлыг нэлээн нухацтай ярьж шийдэхгүй бол болохгүй байх гэж ингэж бодож байна.

Ингээд Үндсэн хуулийн төслийг хэлэлцэхэд бүлэг, зүйл дээрээ микрофон олдвол саналаа хэлнэ. Товчхон ийм зүйл хэлье.

Ардын Их Хурлын 354 дүгээр тойргийн депутат Х.Баянмөнх:  
-За тэгээд нэг хүсэлт байна. Би тамирчин хүн учраас ер нь энэ суух их бэрх байна. Надад энэ суух дасгал бага байдаг юм байна. Тэгээд энэ санал хураахаас бусад цагуудад энэ дотуур бичиг зөөх барих тийм ажил байвал надад оноож өгнө үү. Санал хураах болохлоор кнопон дээр саналаа бичүүлнэ. Тэгэхээр би ингэж ойлгож байна. Түрүүн уг хэлсэн депутатуудын нэгэн адил энэ Үндсэн хууль-Их цаазын төслийг боловсруулахад оруулсан энэ их хөдөлмөр зүтгэл, сэтгэл санаа, боловсрол, энэ

3.

их үнэ цэнэтэй зүйл гэдгийг би депутатуудынхаа нэгэн ажил хүлээн зөвшөөрч, хүндэтгэж байна. Тийм учраас их идэвхтэй хариуцлагатай оролцохыг хүсч байна. Би бодож байна. Энэ Их Хуралд оруулж ирж байгаа Их цаазын төсөл Их Хурлаас бусад бүх шатанд эцсийн хувилбараар хэлэлцэж, шийдэгдсэн ийм төсөл байх. Өөрөөр хэлбэл Их Хурал санал нэгтэй баталчих юм бол ердөө ямар ч засвар хийхгүйгээр гар өргөөд баталчихвал манай улсын Үндсэн хууль байж болох юм гэсэн ийм хэмжээнд боловсрогдсон ийм төсөл байх ёстой гэж үзэж байна. Тиймийн нь хувьд яривал энд хэлэх зүйл нэлээн байна. Би энэ Бага Хурал, Их цаазыг боловсруулах комисс, бусад шатны комиссууд, ард түмний санал хүсэлтийг тусгах комисс гарсан, энэ бүх үйл ажиллагааны бэрхшээлийг одоо л ойлгож байна. Яагаад гэвэл Их Хурлын депутатууд бид бол энэ зовлонг биеэр эдлэх нь ээ.

Яагаад гэвэл энэ Үндсэн хуулийг ард түмэн бол жинхэнэ бидний оюун санаанд, сэтгэл санаанд шингэсэн хууль гаргаж өгөөчээ гэж хүсээд байна. Ирүүлээд байна. Тэгэхлээр зэрэг ойрын тав юм уу, арван жилийн юмыг оруулмаар байна. Ер нь одоо шилжилтийн үеийн тийм нэг программ, тиймэрхүү юм оруулах хэрэгтэй болдог. Ард түмнийхээ өнөөгийн хэрэгцээг хангая гэвэл. Үндсэн хуулийнхаа урт удаан насыг бодож олон жилийн ирээдүйтэй жаахан холыг харж хийе гэвэл өнөөдөр ард түмний эрх ашигтай харшилдсан ийм хоёр зүйл дээр үнэхээр зовдог юм байна. Бид ч өнөөдөр энэ амьдралыг үзлээ. Энэнийг шийдэх тийм хариуцлагатай үе бол бидэнд тулгарч байна. Нөгөө талаар энэ Их цаазын төслийг боловсруулахад би энэ эдийн засгийн талаас нь хэр зэрэг тооцоо хийсэн бол. Өөрөөр хэлбэл бидний төрийн тогтолцооны одоо энэ аппаратын зардал энэ үнэ маань хагас миллиард гаруй гэж ингэж дуулсан. Болвол зөв байх. Гэтэл шинэ Их цаазын төсөлд оруулж байгаа төрийн тогтолцооны аппаратын зардал ер нь ингээд хараад үзэхэд тэрнээсээ илүү гарсан байх гэсэн ийм хандлага байна. Ийм учраас энэ шилжилтийн үед, ойрын 5-7 жилийн дотор бол энэ зардлыг манай ард түмэн нуруундаа үүрэх нь мэдээж. Ингэхлээр энэ тал дээр энэ их өөрчлөлт, сүлд

## 4.

өөрчлөнгүүт л улсын хилээр байгаа бүх шонгийн наана цаана байгаа юмыг өөрчлөх болно. Ингээд ирэхэд эдийн засгийн ямар тооцоотой байгаа бол гэсэн ийм юм бодогдож байна. Энэ талаас нь харж үзээ юу үгүй юу? Нөгөө талаар бол тэр 76 гишүүнтэй Их Хурлын талаар бол яг миний сэтгэл санаанд юм буухгүй байна. Яах вэ сонгоод авсан хойноо ажиллаж болох юм биз. Сонгож авах нь бэрх байна. Энэнийг бараг чадахгүй байх. Одоо бид сум болгоноос нэг хүн сонгож авахад жил гаруй, өнөөдрийг хүртэл чадахгүй байгаа юм чинь хэдэн сумыг нийлүүлж хошуу болгож байгаад долоо, найман сумыг, тэгээд тэрэн дотроос нэг хүн гаргаж авъя гэвэл бид бараг тэр Их Хурлыг сонгуулийн хугацаанд явах байх. Тэгээд энэ чинь бидэнд бол нэг хүн сонгогдохгүй бол 4 хүн нэг хувь эзэлж байгаа юм чинь, 76 хүн чинь I аравны хэдэн хувь эзлэх нь, тэгвэл бас одоо санал хураалтанд нөлөөлж эхлэх болно. Бид бол яах вэ олны олон цэн, дөрвөн хүн, нэг хоёр хүн алга байхад бидэнд нэг их нөлөөлөхгүй юм байна.

Ингэхлээр зэрэг тэр 76 хүнийг гаргаж авах гэдэг их захгүй ихээхэн сонгууль, олон шатны эргэсэн, буцсан, шалгасан иймэрхүү юм болох байх. Тэгж байж арай гэж байж сонгож авсан 76 хүн бол Их Хурлын гишүүн байх үүргээ хангасан 76 хүн гарч ирэх үү үгүй юу. Жишээлбэл ийм л бэрхшээлтэй юм харагдаж байна л даа. Нөгөө талаар тэр хошууны асуудал бас санаанд буухгүй байна. Манай сонгогчид хэлж байсан нацад. Манай Хяргас сум бол Цагаанхайрхан сумтай нэг нийлээд дахиж байгуулагдаад нэг төвөөсөө, "Дэжээлин" хийдийн төвөөс нүүгээд одоо өнөөдөр нэг газарт шинэ байгуулсан сум байгаа. Тэгээд манай сумын сонгогчид үнэхээрийн энэ сум нүүж суух, зөөх, салах, маргалдах ийм зовлонг биеэрээ амссан хүмүүс. Энд их бэрхшээл бий. Энэ болбол манай уудам эх орон харилцаа холбоо, зам муутай, тархай бутархай мал аж ахуй эрхэлдэг ийм хүмүүсүүдийн амьдралын энэ нөхцөлийг бодож хараагүй, жаахан арай эртэдсэн ийм төсөл болов уу гэж бодож байна. Энэ бол аяндаа хөгжлийнхөө зүй тогтцоор хот, суурингаа байгуулаад тодорхой хэдэн жилийн дараа өөрөө энэ амьдрал, энэ

5.

зохион байгуулалт уруу ороод ирэх байх. Тийм учраас энэнийг бол их яарсны хэрэггүй юм болов уу гэсэн ийм санаа байна. Эцэст нь хэлэхэд энд харцах сэрцэх тухай, ер нь бие биендээ ярьж байна л цаа бид нар. Депутатууц чөлөөтэй ярилгүй яах вэ. Гэхдээ бол улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийнхөө хамгийн хариуцлагатай энэ үйл явдал дээр улс төрийн сэрэмжтэй байхыг хэн ч сануулж, хязгаарлаж болохгүй байх аа гэж бодож байна.

За баярлалаа. Дэгийн цагуу завсарлага 20 минут.

СОРОНЗОН ХАЛЪСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



П. ТӨМӨРБААТАР

Бичээч Л. Хорлоо

266-р тойргийн депутат Ц.Цэвэгдорж: - Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажилд энэ комисс, бага хурал ихээхэн анхаарал тавьж, хүч хөдөлмөр зарцуулж, энэ үндсэн хуулийнхаа ноён нурууг босгосон гэж ингэж үнэлж байна. Гэвч одоо үндсэн хуулийн комисс бага хурлын хувьд бас анхаарууштай хоёр зүйл байсныг би тэмдэглэж хэлбэ гэж бодож байна. 1-рт энэ ард түмний саналыг авчихаад энэ ард түмний санал биш ээ гэж ингэж үндсэн хуульд ард түмний саналыг тусгаагүй явдал нэн хангалтгүй юм шиг санагдаж байна. 2-рт, энэ бага хурал ер нь комиссын гишүүдийн хувьд ч гэсэн зарим нэг зүйл дээр туйлшрах хандлага ихээхэн гаргасан юм болов уу гэж ингэж бодож байна. Тухайлбал одоо уг хэлж байгаа хүмүүсийн үгнээс үзэхэд ер нь л одоо өөрчлөх ёстой, бүх юмыг өөрчлөх ёстой гэсэн ийм туйлшрал ер нь улаан өнгө бол коммунизмын өнгө, ер нь монголын бүх юм одоо зөвлөлтийг дуурайсан, гэх мэтийн одоо ийм туйлшралд орж, зарим нэг юман дээр хангалтгүй хандсан байна гэж ингэж дүгнэж байна. За энэ үндсэн хуулийн төсөлд бол одоо хэдэн санал байна. Үндсэн хуульд зарим нэг ерөнхий заалт байна. Тухайлбал өчигдөр Бага хурлын дарга Гончигдорж гуай тайлбарлаж байсан. Энэ дээр бол би ганцхан жишээ л хэлбэ л дээ. Парламентын гишүүдийн, улсын их хурлын гишүүдийн гуравны хоёрыг 3 жилд солино. Энийг одоо сонгуулийн хуулиар зохицуулна, тодотгож өгнө гэж , ингэж бол үндсэн хуульд бусад хуулиудаар зохицуулна гэж ингэж ерөнхий ер нь үндсэн хуульдаа заалт оруулж боломгүй байна. Гол гол юмнуудаа ер нь үндсэн хуульдаа тодорхой хиймээр байна. Бидний туршлага бий. Хууль, гаргаж байгаа хуульд зарим нэг талаараа юм нь ихээхэн зөрчилддөг ёстой , ийм юм гараад байдаг. Энүүнийгээ их анхаармаар байна гэж ингэж бодож байна. За үндсэн хуулийн төсөлд бас зарим нэг заалтууд хоорондоо бие биэндээ харшилдсан заалтууд орсон юм шиг санагдлаа. Тухайлбал хүний эрхийг хамгаалах талаар нэлээн олон заалт гаргачихаад, хойно нь хүний эрхийн гол асуудал болсон зарим нэг асуудал бас тухайлбал намын гишүүн байж болохгүй ч гэх юм уу, ингээд эрхий нь үгүйсгэсэн юмнууд бас байж байх шиг. Мөн хавсралт хуулин дээр засаг захиргааны нэгжийг 1995 оноос мөрдөнө гэж ингэж хийчихээд мөн 1992 оноос хошуу болгоно гээд оруулчихсан

ийм юмнууд ихээхэн байх шиг байна. Энэ заалтууд дээрээ бид ихээхэн анхааралгүй нь болохгүй нь ээ. Төрийн байгууллагын хувьд парламентын бүгд найрамдах улс байх нь зүйтэй, 2 танхимтай байх нь зүйтэй болов уу. Энэ 2 танхимтай байхдаа тэр улсын их хурал нь 100 гишүүнтэй, УБХ-ы нь 50 гишүүнтэй, ингэж байгуулвал зүгээр зүйтэй байхаа гэж ингэж бодож байна. За энэ нь цаанаа бол ер нь улс орныхоо нутаг дэвсгэр, засаг захиргааны зохион байгуулалт хүн амын тархай бутархай байдлыг харгалзам энэ тоо энэ парламентынхаа танхимыг ч гэсэн одоо ингэж зохион байгуулах нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байна. Би үүн дээр нэг санал хэлэхэд одоо ер нь хүмүүсийн санал бараг гарчих шиг боллоо. Ер нь ихэнх нь гарч байна. Тэгэхээр одоо ер нь ихэнх хүмүүс зарим хүмүүс болбол парламентаг 2 танхимтай байлгана гэж байна, үндсэн хуульд нэг танхимтайгаар төсөл явагдаж байгаа, ийм учраас зарим нэг юман дээр хувилбараа боловсруулж байвал юутай вэ гэж ингэж бодож байна. 2 танхимтайгаар боловсруулах ийм хувилбар ч гарч магадгүй болж байх шиг байх юмаа. Энэ улсын нэр, хуулийн нэр, сүлд далбаагаа өөрчилөмгүй санал байна. Өчигдөр бидэнд үзүүлсэн киноноос /касетагд бичлэг тасарсан/

ихээхэн цээрлэдэг юм байгаа юм. Нөгөө талаар ер нь монгол хүн шувууны дүрстэй тийм дээл өмсөөд явдаггүй. Ийм цээрлэдэг юмнууд их байдаг юм шүү. Энийг бас нэг анхаармаар байна гэж ингэж бодогдож байна.

Эцэст нь хэлэхэд энэ Улаанбаатар хотын депутатуудад нэг анхааруулах зүйл байна. Энэ хөдөөнийхөө депутатуудад үг хэлэх эрхий нь өгөхгүй, ер нь аашилж загнах, энэ явдал ер нь нэлээн их байх шиг байх юм. Энүүнд би их гайхаж байна. Ер нь суулт ч байсан загнаж байдаг, цуглаан ч байсан загнаж байдаг, хурал ч байсан загнаж байдаг ийм нэг чиглэл рүү хандчих вий энэ Улаанбаатарын депутатууд ингэж бас нэг хэлмээр байна.

334-р тойргийн депутат Батсүх: -Үндсэн хуулийн төслийг боловсруулах талаар төсөл боловсруулах комисс, улсын бага хурал ихээхэн ажил хийсэн гэдгийг бид гарцаагүй одоо талархах ёстой. Гэхдээ санал зөрүү зарим

асуудлын талаар хэд хэдэн асуудал дэвшүүлбэ гэж бодсон юм. Ялангуяа их цаазын үндсэн хууль гэж нэрлэх, монгол улсын төрийн сүлд, туг, тамга, тэмдэг мөн хуучнаар байлгах бусад хүмүүсийн адил нэгэн саналтай байгаа юм. Дараа нь газрын тухай асуудлын талаар санал байгаа юм. Монгол улсын иргэд газар өмчлүүлэх тухай асуудлыг үндсэндээ зөвшөөрдөг. Ер нь одоо зах зээлийн нөхцөлд , зах зээлд орж байгаа энэ нөхцөлд бид газар-гүйгээр зах зээлд орно гэж зүүдлэхийн аргагүй гэж бодогддог. Газартай байж байж л зах зээл явуулна. Зах зээл явуулах үндсний үндэс бол газар мөн, гэж ингэж ойлгодог. Энэ талаар олон тайлбар яривал нэлээн юм ярьж болох байна. Гэхдээ газар дээр төрийн өмчийн газрыг гадаадын иргэн харьяалалгүй хүнд түрээсээр мөн түүнчлэн хуульд заасан бусад болзол хэлбэрээр эзэмшүүлнэ гэдгийг <sup>ОГТХОН Ч</sup> зөвшөөрөхгүй байгаа юм. Үүний талаар бол ихээхэн эргэлзэл төрж байгаа юм. Энэний цаана бол нэг утга яваад байгаа юм гэдэг бодлого явагдаад байх шиг санагдаад байгаа юм. Чухамхүү газрыг хэнд, хэзээ, ямар улсад, ямар гадаадын хүнд өмчлүүлэх гээд байгаа юм гэдгийг бид нарт бас нэг юм мэдрэгдээд байх шиг санагдаад байгаа юм. Ийм учраас энийг хэзээ ч зөвшөөрч болмооргүй нэг юм бол энэ байгаа юм. Дараа нь нэг санал хэлэхэд зарим одоо энэ үндсэн хуулийн утга агуулга, уг үсэг дээр хуулийн хүн биш учраас ойлгохгүй байна, амьд явах эрхтэй гэж нэг юм заагаад байгаа юм. Аливаа юмс үзэгдэл хоорондоо эерэг букуу сөрөг талтай байдаг. Үүний сөрөг тал нь юу гэж ойлгомоор юм бэ дээ. Хүн амьд явах эрхтэй байдаг юм бол санаатай букуу санамсаргүйгээр хүн үхэх үүрэгтэй гэж ч бодмоор юм шиг. Дараа нь төрийн байгууллагын хувьд бол парламентын бүгд найрамдах улс байх нь зөв гэж боддог. Гэхдээ одоогийн хэлбэрээр АИХ-тай байж хүн нь 120 орчим үүнээс багагүй гишүүдтэй, үүнээс гадна 30 юм уу түүнээс цөөн тооны улсын бага хуралтай баймаар гишүүдтэй, УБХ-тай баймаар юм шиг санагдаад байгаа юм. Энэ нь хөдөөгийн 15 мянган хүн тутмаас 1 депутат, хотын 30 мянган хүн тутмаас 1 депутат сонгогдвол нэг ийм 120-иодхон хүнтэй байж болмоор . Гэхдээ Улсын бага хурал их хуралдаа тайлагнадаг энэ хязгаарлагдмал эрхтэй байх нь зүйтэй гэж ойлгодог. Үүний сацуугаар 29-р зүйлийн I-рт Улсын их хурлын гишүүн нь улсын төсвөөс цалин хангалт авна гэдэг ийм нэг заалт ороод байгаа юм. Энэ бол ерөөсөөн ойлгогдохгүй

байгаа юм. Энэ цалин хангамж, улсын их хурлын гишүүний цалин хангамжийг үндсэн хуулиар баталгаажуулаад байгаа асуудлыг би ерөөсөө ойлгогдохгүй байгаа юм. Хэдэн хүний цалин хангамж 2-ыг заавал үндсэн хуулиар баталгаажуулах ямар асуудал байна вэ. Энэ бол улс төрийн товчооны хэлмэгдүүлээд байгаа хэсэг улстай холбоотой ухагдахуун гарч ирээд байгаа юм шиг бодогдоод байгаа юм. Дараа нь ер нь манай засаглалын хэлбэр одоохон үедээ парламентын ч юм шиг, ерөнхийлөгчийн ч юм шиг нэг л хачин саармаг хэлбэртэй харагдаад байгаа юм. Түрүүчийн Хурц депутатын саналтай тун ойролцоо бодогдоод байх юм. Хуулийн төсөлд ч нэг иймэрхүү хэлбэр харагдаад байдаг юм. Ер нь Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг ажиглаад байхад улсын бага хурал, Засгийн газрын үйл ажиллагаанд ихээхэн нөлөө бүхий байх шиг харагдаад байгаа юм. Манайхан бол эрх багатай, зөвхөн тун эрх хэмжээ багатай гэж ойлгоод байгаа юм. Маш хүчтэй нөлөөтэй байх шиг байгаа юм. Ер нь улс төр, эдийн засаг, оюун санааны хүчтэй хямралд ороод байгаа өнөө үед бид УБХ-ын тухай асуудлыг авч ярилцана гэж байна, засгийн газрын тухай асуудлыг авч ярилцана гэж ярьж байна, ер нь энэ дээр ерөнхийлөгчийн тухай тайланг авч хэлэлцэхэд болохгүй юм гэж байх ч үгүй юм шиг бодогдоод байгаа юм. Энийг депутатууд анхааралдаа авууштай юм шиг бодогддог. Мөн үндсэн хуулийн төсөлд монгол улсын ерөнхийлөгчийг сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, монголын 3 үеийн уугуул иргэнийг сонгох нь зүйтэй гэсэн ийм санаа орж байгаа юм. Энэ бас нэг юм анхны төслийн хэмжээнд тэгж авсан, сүүлдээ өөрчлөгдсөн, ийм учиртай ийм санал ордог. Дараа нь монгол улсын засаг захиргааны нэгжийн тухай хувьд бол үндсэндээ зөвшөөрч болохгүй байна. Энийг үндсэн хууль дээр заавал одоогийн энэ үндсэн хууль дээр баталгаажуулж заах заавал албагүй, энэ дээр хавсралт хууль үндсэн хууль 2-ын энэ бүлгийн бүтнээр нь өөрчлөх шаардлага гарч ирэх байх. Ийм саналтай байгаа. Ямар ч болов энэ хуулинд оруулахгүй байгаад, хэзээ улс төр, эдийн засгийн нөхцөл бүрдсэн нөхцөлд энэ хуулийн төслийн 88 дугаар зүйлийн 2-т заасны дагуу нэмэлт өөрчлөлт дараа нь оруулж болно гэсэн санал байна. Эцэст нь хэлэхэд манай сонгогчид надад 2 зүйл даалгаж явуулсан, ийм юм дамжуулъя. 1-рт үндсэн хуулийг заавал баталж ирээрэй, 2-рт Засгийн газрын 268-р тог-



5.

тоолыг заавал хүчингүй болгож ир. Хэрвээ энэ хоёрыг гүйцэтгэж  
ирэхгүй бол битгий ирээрэй, гэсэн даалгавар өгсөн.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

1991.XI.16.

Кассет № Ш.20

17.37-17.50.

315 дугаар тойргийн депутат Ч.Бат-Эрдэнэ: -Улсын Бага

Хурлаас Их Хуралд оруулж байгаа Их цаазыг дэвшүүлсэн концепцийнх нь түвшинд авч үзэх юм бол их зүйл хийгдсэнийг үгүйсгэхгүй байна. Гэхдээ энэ хуулийг цаг хугацаа, орон зайных нь хувьд авч өөрийн дүгнэлтийг хийхэд дараах дүгнэлтэд зайлшгүй хүргэж байгаа юм шиг ойлгогдож байна. Нэгдүгээрт, уул хуулийг боловсруулахдаа өнгөрсөн цагаа үнэлэхдээ хэт таамгаар авсан, одоо цаг дээрх бүх зүйлээ хэт үгүйсгэсэн, устгахыг чиглэсэн, ирээдүй цагаа бол үндэслэл тооцоо муутайгаар зохиомлоор бий болгох гэсэн ийм ойлгоц төрөөд байна. Орон зайных нь хувьд авч үзэх юм бол гадаадын хүч хөрөнгө, гадаад хөрөнгө оруулалтыг өөрийнхөө эдийн засагт чөлөөтэй оруулах, өөрийнхөө орны газрыг түрээслэх, хүн хүнээ чөлөөтэй цагаачлуулах, чөлөөтэй гаргах, гуравдугаарт, өөрийнхөө улс орны хүн ардын эрхийг хэт хуульчлан тунхаглаж, үүргийг нэлээн багасгасан ийм чиглэлүүд хуулийг уншиж судалж байх явцад харагдаж байна.

Ингээд бодоод үзэхэд энэ хуулийг баталлаа гэж бодоход Монгол орны хөгжил, хөгжих хугацаа, хөгжлийн түвшин нь бол мэдэгдэм өөрчлөлт орох нь гарцаагүй юм. Гэхдээ харин Монгол нь монголоороо үлдэж чадах болов уу даа, үгүй болов уу гэдэг дээр нэлээн сэтгэл эмзэглэж байна.

Төрийн тогтолцооны хувьд бол тэр 75 гишүүнтэй нэг танхимтай хурлыг гишүүдээ <sup>яаж</sup> бүрдүүлэх, бүрдсэн гишүүдээсээ тодорхой хэсгийг яаж шинэчилж байх механизмаа өнөөдөр олоогүй, ямар нэг аргаар бүрдүүлнэ гэсэн таамаглалын төдий ийм байдал харагдаж байна. Ихэнх улсуудын хэлж байгаа зүйлсээс санаа авахад ямар ч байсан Их Хурлаа бүрдүүлсэн, Их Хурлаасаа хоёр танхимаа байгуулсан энэ туршлага дээрээ үндэслэсэн энэ хэлбэрээ сонгож авах нь илүү зохимжтой байна гэдэг дээр санал нэг байна.

Ерөнхийлөгчийн хувьд бол Ерөнхийлөгчөөс Засгийн газарт нөлөөлөх асуудлыг хэт багасгасан, Ерөнхийлөгчөө хэт бэлгэ тэмд-

2.

гийн шинж чанартай болгосон ийм байдал аяндаа харагдаж байна. Засаг захиргааны зохион байгуулалтын хувьд практик амьдрал дээр ухаандаа одоогийн нэг нэгдэл хоёр салж жижгэрч байгаа үндэслэлийг тухайн газар нь очоод үзэхэд ерөөсөө төр, засгийгаа өгүүлсэн, нэгдлээ хоёр салгах юм бол сум маань хоёр салаад бид нар төр маань хуваагдаж ирэх байх гэсэн ийм хандлага давамгайлж байгаа. Гэтэл өнөөдрийн энэ хуульд дэвшүүлж байгаа санаа бол харин ард түмнээсээ төр, засаглалаа холдуулах чиглэлээ баримталсан юм биш байгаа гэсэн ийм бодол байна.

Нөгөө талаар нэг эмзэглэж байгаа зүйл бол бид нар хүрсэн түвшингээсээ ухралт хиймээргүй байна. Бид нар социализмын замаар гэж 70 жил хөгжихдөө буруу ч байлаа, зөв ч байлаа хүн ардынхаа нийгмийн талаар хүрсэн түвшингөөс ухралт хиймээргүй л бодож байна. Тухайлбал, шинэчилж батлах гэж байгаа Үндсэн хуульд хүн сурах, эмчлүүлэх эрхээр л хангагдаж байгаа болохоос биш одоогийнхоо хүрсэн түвшинг хэт үгүйсгэж ухралт хийж хуульчлах гэж байгаа юм болов уу даа гэсэн ийм эмзэглэл төрж байна.

Төрийн сүлд, бэлгэ тэмдгийн хувьд бол манай сонгогчдын санал бол нийт гаргаж байгаа хүмүүсийн саналтай ойролцоо байгаа юм. Гэхдээ депутатын хувьд бол бид Үндсэн хууль батлахдаа тодорхой сэтгэл зүйн бэлтгэлтэй, бас иргэний зоригтой хандах шаардлагатай гэж бодож байгаа.

Эцэст нь горимын шинж чанартай нэг санал хэлэхэд, бичгээр олон хүн санал өгсөн тухай хурлын дарга танилцуулсан. Мөн олон хүн уг хэлж байна. Гэхдээ би ерөнхийн хэлэлцүүлгийг таслах санал гаргахгүйгээр ерөнхийгөөсөө тодорхой руу шат шатаар орж бас олон хүний санал дотроос тодорхой хэсгийг нь ажлын хэсэг, манай депутатын хороо боловсруулалт хийж тодорхой томъёолол гаргаж ирж бас ерөнхийгөөс тодорхой руу шилжих ийм шатлалын асуудал руу анхаарах нь зүйтэй байна гэж бодож байна.

317 дугаар тойргийн депутат Д.Мандах: -Оршилгүйгээр шууд саналаа хэлээд явъя.Хамгийн нэгдүгээр асуудал бол ерөнхий санал шүүмжлэл дээр нэгэнтээ өөр, Улсын Бага Хурлаас оруулж ирж байгаагаас өөр бэлэн төсөлтэй хүн байсан бол тэрийгээ ярих ёстой байсан байх.Ингээд санал шүүмжлэлээс карахад тийм юм байхгүй юм шиг байна.Тийм учраас бид нар одоо итгэж сонгосон энэ улсуудынхаа оруулж ирсэн төсөл дээр яриад батлахаас өөр замгүй болж байна гэдэг нь ойлгогдож байна.Тэгээд ч одоо өөр төсөл дээр яриад цоо шинэ зарчмын юм гаргаж ирэх хугацаа бол байхгүй байна.Тийм учраас энэ төсөл дээр би ярьж гэж бодож байна.

Ерөнхий зүйл дээр Үндсэн хууль ямар байх ёстой, зарчмын хувьд.Энийг батлахад юу анхаарах тухай бол депутатууд нэлээн зүйл ярилаа.Энэ дээр би нэмээд зарим нь давхцаж магадгүй, дөрвөн зүйлийг ярих гэсэн юм.

Хамгийн нэгдүгээр асуудал бол их олон депутат ярьсан. Яг өнөөдрийнхөө бодит байдалд нийцүүлж гэж.Тэгээд олон түмний саналыг авсан мөртлөө тусгаагүй тухай ярьсан.Миний хувийн бодлоор бол энэ асуудал нэлээн харьцангуй.Өөрөөр хэлбэл, бид нар өнөөдөр ердийн ухамсрын түвшинд тохируулж энэ Үндсэн хуулийг хийх үү, эсвэл ердийн ухамсрынхаа түвшинг урагш нь чангаасан, алсаа харсан хууль хийх үү гэдэг дээр би нэлээн алсаа харсан хуулиа хийх нь зүйтэй болов уу гэдэг үүднээс олон түмний саналыг шууд тусгана гэдэг бол харьцангуй гэж хэлэх гэж байгаа юм.Энийг бид нар нэгдүгээрт, анхаарах ёстой байх.

Хоёрдугаар асуудал бол бас нэг зарчмын зүйл юу байна вэ гэхээр өнгөрсөн хоёр жилийн хугацаанд гэж хэлдэг юмуу даа энэ хугацаанд монгол оронд болж өнгөрсөн энэ бүх өөрчлөлтүүдийг бид нар үнэхээр зарчмын өөрчлөлтүүд гэж үзэж байгаа юм бол энэ үүднээсээ Үндсэн хуульд хандаж ихэнх гол юмаа өөрчлөх ёстой.Нэлээн улсууд ярьж байна.Ерөөсөө юмыг заавал өөрчлөхийн тулд өөрчилж байгаа юм гэж.Миний бодлоор бол тийм биш.Үнэхээр манай монгол оронд болж өнгөрсөн энэ юмнууд

чинь зарчмын өөрчлөлтүүд байсан юм бол тэр мөн чанар нь хэлбэрээрээ заавал илэрхийлэх ёстой гэдэг үүднээс нэлээд гол зүйлүүдийг өөрчлөх ёстой байх гэдэг энэ зарчмыг би баримталья гэж бодож байна.

Туравдугаар асуудал бол нэлээн олон депутатууд энэ хуулийг шилжилтийн хууль байх талаас нь бас үндэслэж ярьж байх шиг байна. Миний бодлоор бол 200 жилийнх нь хаашаа юм, ямар ч гэсэн шилжилтийн үеэ ч гэсэн багтаачихдаг, нэлээн алсыг харсан байх <sup>ёстой</sup> гэж бодож байна. Ийм учраас энэ хуульд бол жижиг сажиг зүйл юмуу, эсвэл заавал нэрлэж заасан зүйл юмуу, тэр үүднээс нь оруулах асуудлыг багасгаж гэсэн зүйл байгаа.

дөрөвдүгээрт, ерөнхий зарчмын зүйл бол бид нар уламжлалаа сэргээсэн асуудлыг бол үнэхээр анхаарч байгаа. Энэ дээр зарим нэг гадаадын нэр томъёо гэж тооцох юм бол үнэхээр Бага Хурлын гишүүд маань уламжлалаа сэргээх гэсэн монгол хэллэг энэ юмаа ашиглах гэсэн энэ хандлага хүчтэй байгаа гэдгийг бид нар зүй ёсоор хүлээн зөвшөөрөх ёстой байх аа. Энийг ч гэсэн бодож бид нар ямар ч гэсэн монгол дүр төрхтэй хууль гаргах ёстой байх аа гэсэн ийм дөрвөн зүйлийг хэлэх гэсэн юм.

Энэ дээр хэлсэн үндэслэлүүдээс холбогдуулаад цааш нь зарим санал хэлье гэж бодож байна. Энэ дээр хамгийн нэгдүгээр зарчмын асуудал бол засаглалын тухай асуудал байгаа. Энийг их олон хүн ярьсан. Миний хувийн бодлоор бол бид нар ерөнхий хэлэлцүүлгээ дуусаад зүйл бүрээр хэлэлцэж эхлэхээсээ өмнө засаглалын ямар хэлбэртэй байх вэ гэдгийг санал хураалтаар тогтох ёстой байх аа. Түгэхгүй шууд Бага Хурлаас оруулж ирсэн төсөл дээрээ зүйл бүрээр яриад явах юм бол өөр засаглалын хэлбэртэй байж гэсэн депутатын саналыг хэрэгжүүлэх тийм хугацаа юмуу, бололцоогүй болно. Тийм учраас засаглалынхаа хэлбэрийн асуудал дээр энэ тэргүүнд нэр, сүлднээсээ өмнө саналаа авчихаад энэнийхээ дагуу тэр хэлбэрийн бүлэг зүйл байх, тэр хугацааг бэлтгэх ийм цаг авах ёстой байх аа гэж бодож байна.

5.

Үүнтэй холбогдоод засаглалын хувьд, депутатын хувьд энэ дээр Парламентын засаглалыг сонгож авч байгаа. Энэ дээр би хэд хэдэн үндэслэлээ хэлье гэж бодож байна.

Хамгийн нэгдүгээрт, ердийн ухамсрын түвшинд энэ үндэслэлээ хэлэхэд ямар ч байсан дурын тохиолдолд монгол оронд алдаж онохгүй нь тулд олон хүн бодож шийдвэр гаргасан нь нэг хүн бодсоноос хамаагүй дээр ээ, хамгийн наад зах нь.


Хоёрдугаарт, бид нарын хуучин явж ирсэн энэ тоталитар систем буюу нэг хүний захиран тушаах тэр юм ахиад үүсэх нийгэм, эдийн засгийн үндэс бол бүрэн устаагүй байгаа. Энийг бид нар харгалзан үзэж парламентын засаглалыг нэг хэсэгтээ байлгах ёстой болов уу гэж бодож байна.

Дараагийн нэг асуудал бол хүмүүсүүд нэлээн шүүмжилж байгаа. Парламентын засаг бол хэмжээгүй эрхтэй байна гэж. Тэгэхээр миний ойлгож байгаагаар бол энэ парламентын хэмжээгүй эрхийг бол гурав, дөрвөн хүчин зүйлээр багасгаж болно гэж бодож байна. Хамгийн нэгдүгээрт бол, сонгогчид Парламентынхаа гишүүдийг татан буулгах асуудлыг хүчтэй ярих ёстой байх, хоёрдугаарт, намууд хүчтэй болох юм бол оппозиц намын чиглэлээр шүүмжлээд энэ парламентын эрхийг хязгаарлах асуудал байх болов уу. Эцэст нь Ерөнхийлөгч бол энэ парламентынхаа шийдвэрт хориг тавьдаг тэр системийг бид нар хэвээр нь хадгалах ёстой байх аа. Үүнтэй холбогдуулж Ерөнхийлөгчийн хувьд нэг ганцхан өгүүлбэр эцэст нь хэлэхэд Ерөнхийлөгчийг нийт ард түмнээр сонгоод гэхдээ нэгэнтээ парламентын засаглал байгаа учраас огцруулах эрхийг парламентдаа өгөх тийм чиглэлээр байх ёстой болов уу гэж бодож байна.

Өөр нэг юм хэлэхэд энэ дээр "хошуу"-ны тухай асуудлыг манай ихэнх депутатууд маш бага ойлголттой байгаа. Энийг олон депутатууд хүсэлт тавьсан, ямар үндэслэл байгаа юм бэ гэдгийг тайлбарлаж өгөөч ээ гэж. Миний хувьд ч гэсэн энэ талаар бол бодсон нийгэм, эдийн засгийн үндэслэл байгаа юм бол тэрийгээ даруйхан энэ зүйл бүлгээр хэлэлцэж эхлэхээс өмнө депутатуудад танилцуулах нь зүйтэй гэж

Их Хурлын удирдлагад хандаж хэлмээр байна. Ер нь бол зарчмын хувьд бол яваандаа бид нар эдийн засгийн хөгжлийг дагасан, өөрөөр хэлбэл, олон сумууд нийлээд өөрөө өөрийгөө хангаж чадах тийм байдалтай нийгэм, эдийн засгийн цогцолборыг дагасан засаг захиргааны нэгжтэй болох байх аа. Энэ үүднээсээ би хошууны зохион байгуулалтыг дэмжиж байгаа юм. Их баярлалаа.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.Оюунчимэг

Ж.Уртнасан -9 дүгээр микрофон.

35 дугаар тойргийн депутат Бямбаа -Их цааз нэртэй шинэ Үндсэн хуулийн төсөлд саналаа хэлсэн ард олны санаа бодлыг ямар нэг хэмжээгээр тусгасан Үндсэн хууль боловсруулах комисс, бага хурлын оюуны хөдөлмөрийг үр дүн гэж зүй ёсоор хүндэтгэн үзэж байна.Өөртэйгээ уулзаж,захиа даалгавраа өгсөн цөөн сонгогчидтой захиа,өөрийнхөө санал бодолтой нэгтгэн хэдэн саналыг нуршсан тайлбаргүйгээр хэлэхийг хүсч байна.Нэгдүгээрт, Үндсэн хуульд улсын нэрийг хэвээр **үлдээх** саналыг дэмжиж байна.Монгол хүнд,би мал аж ахуйн мэргэжилтний хувьд бол сүлд нь яаж өөрчлөгдөхийг мэдэхгүй байна,ямар ч байсан монгол хүн мориноос салж болохгүй ээ.Тэрнээс илүү бэлэгдэл хүндэтгэл байхгүй гэж бодож байна.Эрлийз ухаантай их мэргэдийн сургаалаар морио шүтээнээсээ салгаж болохгүй гэдгийг өөрийн хувьд бат зогсоно гэж бодож байна.

Хоёрдугаарт эх орны газар шороо бол ард түмний өмч өө. Үүнийг хэн хүн хувьдаа өмчлөөд,эзэмшээд байж болохгүй ээ. Үүнийг тодорхой эзэмшүүлэх хэрэгтэй.Хувийн өмч болгож болохгүй гэж бодож байна.Газар бол эд хөрөнгө,мөнгө бишээ.Гадаадын иргэдэд өгөхдөө ч гэсэн тусгай хуулиар зохицуулж өгч түрээслүүлэхгүй бол газраар дамжиж бүх юм улс орны тусгаар тогтнолд ч аюул учирна гэж олон хүн болгоомжилж байгаа бол зүйн хэрэг гэж бодож байна.

Засаглалын хувьд бол парламентын засаглалтай БНМАУ байх нь зүйтэй гэсэн саналтай байна.Парламентын харин хоёр танхимтай.Их хурал нь барагцаалбал 100-120 гишүүнтэй,Бага хурал нь 30-40 гишүүнтэй байх нь илүү зохимжтой гэж үзэж байна.Ерөнхийлөгчид бол эрх олгох хэрэгтэй.Өнөөдрийн ерөнхийлөгч шиг хэлсэн уг нь хэрэгждэггүй,хийсэн нь мэдэгддэггүй ийм ерөнхийлөгч бол хэцүү л байх шиг байна ард түмний амьдралд.Тийм учраас хуулиар энэ ерөнхийлөгчийг хариуцлага хүлээдэг,юм хийдэг,



хийсэн нь ард түмэндээ мэдэгддэг тийм юмыг хуулиар л оруулж өгмөөр санагдах юм. Даанч сэтгэлийн хомсдолтой мал аж ахуйн хүн болохоор ухаан санаа минь хүрэхгүй байна. Төрөөс эдийн засгийн тусламж авах хэрэгтэй гэсэн заалт оржээ. Үнэхээр эрхүүд олон байгаа боловч гол ард түмний хүсэн мэдэж байгаа тэтгэвэр тэтгэмж баталгаатай байх уу, үгүй юу гэдэг бол тодорхойгүй байна. Ийм учраас үүнийг тодруулж оруулах нь зүйтэй гэсэн санал байна.

5 дугаар зүйлд иргэний үүрэг дээр нэг зүйлийг хэмж хэлье гэж бодсон юм. Иргэн бүр улсынхаа нэр төрийг бодох цаг болжээ. Өнөөдөр Монгол улсын нэрийг боддог хүн гадаадад бас байдаг л байх, цөөрч байх шиг байна. Хоёрдугаарт эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө өөрийн биеийн болон оюуны хөдөлмөрийг зориулах үүрэгтэй гэж оруулмаар байна. Ер нь авах эрхтэй юм бол улс орноо хөгжүүлэхэд өөрийнхөө чадах юмаар хувь нэмрээ оруулах ёстой гэж үзэж байна. Сумыг нэгтгэн цөөлж, хасах асуудлыг санаагаар хийж болохгүй ээ. Тухайн аймаг сум өөрснөө зохицоод нэгдэж нийлэх юмыг хуулиар хориглож болохгүй. Энэнийг сум орныг удирдаж байсныг хувьд өөрийнхөө төрсөн сумыг ч устахыг үзсэн, хоёр гурван сум нийлээд ямар зөрчилтэй байдгийг ч харсан. Энэ бол хүчээр хийж болох ажил бишээ.

Эцэст нь хэлэхэд Үндсэн хуульд төрөөс ямар шашныг төрийн албан ёсны шашин болгож оруулах вэ гэдгийг заагаагүй байна. Бүсийн зөвлөлгөөн дээр олон хүн энэ талаар сэтгэл түгшээсэн саналууд хэлж байсан. Монгол оронд олон төрлийн шашин нэвтэрч байна аа гэнэ. Хоёрдугаарт, ямар хүн шашны номыг сурталчилж чадах вэ гэдгийг баталгаатай болгох. Өнөөдөр эргэцүүлсэн, дээлийнхээ энгэрийг сольсон болгон бол би шашин мэддэг гэж ард түмний /сонсогдоогүй/ нийгмийн тустай хөдөлмөрөөс хөндийрч, хэцүү байдалд ард түмнийг мөлжих **хөлдөр лүү** орж байгааг үгүйсгэхгүй гэж бодож байна. Тийм учраас ямар шашныг төрийн шашин гэж үзэх юм бэ. Үүнийг хуульд тодруулж өгөх ёстой гэсэн санал байна.

Ж. Уртнасан -I-р микрофон Ялалт байгаа шүү. Дараа нь Цэвээндорж байна. 2-р микрофон дээр Бат-Эрдэнэ бэлтгэж байгаарай.

Ялалт –Эрхэм нөхөд депутатууд аа.Ерөнхий хэлэлцээрт дараахь хэдэн саналыг шууд оруулья гэж бодож байна.Өнөөдөр хэлэлцүүлэхээр оруулж ирсэн энэ Үндсэн хууль Их цааз нэртэйгээр оруулж ирж байгаа Үндсэн хууль бол нэг талаас 700 жилийн өмнөх монгол улсын түүхэн уламжлалыг ямар нэгэн хэмжээгээр сэргээхийг оролдсон.Нөгөө талаас өндөр хөгжилтэй Англи,Франц, Америк улсуудын Үндсэн хуулиудын хувилбар мэт санал сэтгэгдэл төрүүлж байна.Энэ нь өнөөгийн хөгжлийн ямар ч бай түвшинд байгаа монгол улсын маань,монгол түмний маань жинхэнэ бодит байдлаас хол байна шүү гэдгийг хэлэх гэсэн юмаа.За хэт урагшаа үсрэх,хэт хойшоо ухрах нь аль аль нь үнэхээр аюултай.Энэ үүднээс цагаан шувуутай сүлд тэмдгийг хүлээн авах,бэлтгэл сэтгэл зүй,эдийн засаг,бүх талын бэлтгэл бол хангагдаагүй гэж үзэж байна.Ганцхан жишээ хэлэхэд бид нар чинь дөнгөж өчигдөр Чингис хааныхаа нэрийг хэлж чаддаг зориг зүрхтэй болж байгаа биш үү. Иймээс магадгүй 10 жилийн дараа Азийн нэгэн бар болчихсон үед,10 жилийн дараа ч юмуу,хэдэн жилийн дараа ч юм бэ Азийн нэгэн бар болчихсон үед сүлд,тэмдгийг түүхэн байдлаар нь сэргээх ийм эдийн засгийн,улс төрийн боломж илэрч магадгүй ээ. Өнөөдөр үнэндээ гэхэд **хөгшчүүлийнхээ** тэтгэврийг ч өгч чадахгүй ийм хүнд байдалтай байна шүү дээ.

Их цааз биш Их засаг хууль гэж нэрлэх саналтай.Үндсэн хууль,Их цаазын төслийг бүхэлд нь авч уншиж үзэхэд дэндүү нуршуу,дахин дахин тодорхойлолтуудыг хэд хэдэн газар давтсан, хэл зүйн боловсруулалтын шаардлагатай байна гэж үзэж байна. Хэрвээ хүн программист компьютерийн тусламжтайгаар энэ төслийг дахин чандлан боловсруулах гэдэг утгаар нь үнэхээр боловсруулж шигшиж үзэх юм бол 30–40 хувь багасах боломжтой гэж үзэж байна.

Газар бол ямар ч байсан хувийн өмч байх ёстой.Өнөөдөр нэг газар хашаа бариад байшин шовойлгоод авдаг,маргааш нь бульдозероор түрүүлж байдаг ийм оготноос дор ямар ч эрхгүй ийм **иргэн** байх ёсгүй ээ.Мөн Үндсэн хуульд бол иргэнээ хамгаалах зүйл тусгах хэрэгтэй байна.Иргэнээ хамгаалах гэдгийг юу гэж

үзэж байна вэ гэхлээр зэрэг бусад оронд бол иргэнийг үнэхээр тэр улсын иргэн, бусад гадаадын хүмүүсээс хямд төсөр үнээр идэж уух хамгийн ойр зуурын хэрэгцээтэй юмаа авч байдаг, гадаадын хүмүүст бол тэр нь дэлгүүрт байдаг үнээрээ зарагдаж байдаг ийм учиртай байх юмаа. Мөн газрыг заавал түрээслэх хэрэгтэй гадаадын хүмүүст бол. Үүнээс айх явдалгүй. Ганцхан жишээ хэлэхэд Токио хотод байдаг Монголын элчин сайд бол газрыг худалдаад авчихсан, дээр нь байшин барьчихсан, 20 хэдэн жилийн өмнө авсан. Өнөөдөр тэр нь хэдэн зуун сая долларын үнэтэй болчихсон байгаа шүү дээ. Ийм учраас бид нар мөн тийм түвшинд авааниж газрыг түрээсэлж өгч байх хэрэгтэй юмаа. За баярлалаа.

Уртнасан-За. Бат-Эрдэнэ. - Бат-Эрдэнэ алга байна.

2 дугаар микрофон Гомбо. Гомбо бичгээр өрсөн болж байна уу. Тэгвэл 2 дугаар микрофон Жагварал.

Жагварал - Их цаазын төслийг боловсруулахад маш их хүч чармайлт дайчилж гаргасан Очирбат даргатай комисс Улсын бага хурлын эрхэм гишүүдэд юуны өмнө талархал илэрхийлэхийг хүсч байна аа.

Их цаазын төслийн хувьд бол онол, арга зүйн маш их өндөр түвшинд боловсруулагдсан ийм төсөл дээр ажиллаж байна. Нөгөө талаар өнөөгийн амьдралаас нилээд ирээдүй рүү орсон, өөрөөр хэлбэл ухамсрын хувьд биднээс <sup>нилээд</sup> түрүүлсэн ийм төсөл байх шиг санагдаж байгаа юм. Бид чинь өнөөдрийнхөө юман дээр юмыг ургуулж бодоод, энэ хоёрын хооронд жаахан зөрчил гарч байх шиг санагдаж байна. Нөгөө талаар төрт ёсны дотоодын уламжлалыг бас багахан харсан болов уу. Ер нь гадаадын сонгодог хэлбэр, арга маягны хэлбэр ихтэй учраас ерөнхийдөө ойлгомж муутай, монгол ухаан нилээд үгүйлэгдсэн, улс орны амьдралыг өнөөдрөөс эхэлж зохицуулах талаасаа шинжлэх ухааны төсөөллийн тал нь нилээд давуутай болсон. Ийм л төсөл байна уу гэж бодож байгаа юм. Энд харин бахархах тал нь бол гадаад талаасаа хэнээс ч айх юм байхгүй ардчилсан шинж чанартай, одоо бид ингээд дотооддоо зохицуулж чадвал сайн хууль болох үндэс нь бүрдээд байх шиг байгаа юм.

Тэгэхдээ нэг үлгэрийн юм байдаг. Арслан бол их хүчирхэг амьтан байдаг учраас гадаад талаас нь хэн ч дайраад, яаж ч чаддаггүй, гагцхүү дотоод талаас нь өөрөөс нь өт гарч унагадаг гэсэн ийм ёс байдаг. Тийм учраас энэ дотоод асуудлыг анхаарахгүй байж өөрөөсөө байж болохгүй болов уу гэж бодож байна аа. Нөгөө талаар Их цаазыг боловсруулах хугацаа бол дэндүү бачимдаж уу гэж бодож байгаа юм. АНУ хамгийн сайн үндсэн хуультай юм гэнэ лээ. 20 жил боловсруулсан гэж дуулсан. Тэгэхээр өнөөдөр сүлд, тэмдэг юмнууд нь нилээн наашлаад <sup>ойртоод</sup> ороод ирсэн юм шиг байгаа юм. Энэ боловсруулах хугацаагийн нь бид бодоогүй юм шиг байгаа юм. Ардын хувьсгал ялаад 3 жил гаруй хугацаанд бэлтгээд 24 онд анхдугаар хуулиа баталсан бол бид ардчилсан сонгууль хийгээд жилийн дараа энэ шинэ үндсэн хуулийг батлах гэж байгаа юм. Хэдийгээр бид шинэчлэлтийн үеийн улс төрийн шинэ тогтолцоог бүрдүүлсэн ч гэсэн шинэ Их цаазад түүнийгээ огтхон ч тоогоогүй, түүнээс бүр цоо шинэ одоо төрөөгүй байгаа төрийн тогтолцооны хуулийг боловсруулсан байгаа юм. Нэгэнт амьдрал дээр байхгүй учраас тэрхүү төр, түүний Их цаазын талаар би болон манай сонгогчид нь ойлгох нь тун муу байгаа юм. Ингэхлээр эрхэм депутат Гүрбазарын хэлснээр хүн мэдэхгүй юмныхаа дайсан нь болдог л юм бол би тийм юм болох вий дээ гэж үнэхээр болгоомжилж байгаагаа нуух юун билээ.

Ингээд бид нар өнөөдөр хуулиа өөрчлөх гэж байгаа болохоос биш монголоо алдах гэж байгаа хэрэг биш гэдэгт найдаж байгаа юм. Ингэхлээр төрт ёсныхоо уламжлалаас ганц хоёр зүйлийг ч болсон авмаар байгаа юм. Үүний тоонд энэ БНМАУ-ын нэр, Үндсэн хуулийн нэр, сүлд, бэлэгдлийн зүйлүүд зохих ёсоор орох болов уу гэж найдаж байгаа юм. Ингээд орчиход гадаад талын баталгаа нэгэнтээ бүрдсэн учраас зоригтой ч хэлж, зоригтой ч хамгаалж болмоор санагдаж байгаа юм. Бид ер нь монголчууд монголоороо үлдмээр байна. Хуучин болгоныг халах гэдэг хууч өвчнөөс салмаар байна. Эд юмсыг эвдэхэд амар хялбар байдаг боловч эвлүүлж бүтээхэд хэцүү байдаг билээ. Үүнээс хэцүү юм бол хүний оюун санааны өмч баялаг руу дур мэдэн дайрч доромжилж яасан ч болохгүй. Энэ дээр их бодмоор байгаа юм. Чингис хаан

эзэлсэн орныхоо ард түмнийхээ шашин шүтлэгийг маш ихэд хүндэтгэдэг байсан, түүний уужим саруул ухаантайн шинж удамшиж бидэнд үлдэх үлгэр жишээ бизээ гэж бодож байна.

Монголчууд бурхнаасаа салангуут төрийнхөө сүлдийг түшиж авсан нь үнэн юмаа. Түмэн олны минь амь амьдрал даатгаастай байгаа ийм сүлд ээ. Зөвхөн энэ танхимд хэлэхэд л манай алдарт хоёр Мөнх хүртэл харийн орны дэвжээн дээр ялчихаад хоёр хөлдөөрээ тэнцэж ядан явж байхдаа ээжтэйгээ адилхан алтан соёмбоор далласан туг руугаа хараад хүчээ авч байсан нь худлаа гэхгүй байх аа гэж бодож байна. Өдрийн од шиг ганц сансрын нисэгч минь эх орон дээгүүрээ явахад ээж аавтай нь цуг алтан соёмбот тут нь даллаж байсныг бодоход энэнд үнэхээр хайр нь шингэсэн ийм юм байгаа юм. Өнөөдөр үүнийгээ солино гэхэд эд нөхөд ч гэсэн нэгийг бодож суугаа байх аа гэж бодож байна. Ийм учраас төрийн минь сүлд рүү хамаагүй дайрвал амиа хорлоно гэж 10 хүн мэдэгдсэн явдал ч бидэнд бас нэгийг бодогдуулж байгаа юм.


Их цаазын төсөлд Монгол улсад Засгийн бүх эрхийг ард түмэн мэднэ гэж заасан байна. Үнэхээр түүний баталгаа энэ сүлдэнд байж байгаа нь харагдаж байгаа юм. Ингэхлээр зэрэг ардаа хүндэлсэн төрийн минь сүлд бат оршихын үндэс энэ болох болов уу гэж бодож байна. Сүлдэндээ мөнхөрсөн ард түмэн минь төрийнхөө хуулийг дээдлэн сахихын тулд төрийн минь өлмий бат оршиж, мэлмий тунгалаг байхын өлзий хутаг орших болов уу гэж бодож байна. Нөгөө талаар бодож санамаар зүйл байна аа. Бид төрийн шинэ тогтолцоог буун дуугүйгээр сольж чадсан явдал бол үнэхээр монголчуудын бахархал мөн. Хүн төрөлхтөн хувьсгалын зуун болсон 20 дугаар зуунаас ардчиллын зуун болох 21 дүгээр зуунд шилжихдээ төрт ёсоо зэр зэвсгийн хүчээр биш тайван замаар Үндсэн хуулийн аргаар шинэчлэх эрин үеийг нээхэд монголчууд өөрийн хувь нэмрээ оруулсан буянтай үйлс бүтээсэн гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ ялалтыг гай дагаж явдгийг мартаж боломгүй байна. Үүнийг бидний өнгөрүүлсэн буурал түүх бэлхнээ сануулж байна. Хаан ширээ булаацалдах, хэргэм зэрэгт тэмүүлэх зэрэг муу зуршил уламжлуулж ирсэн бөгөөд өнөө үед

бүр ч гаарч болзошгүй байгааг эрхэм депутатууд бид анхаарах ёстой. Амархан сайн байна уу гэж мэндэлдэг манай монгол ёсонд амгалан тайван байх шиг сайхан юм байхгүй билээ. Гэтэл улс төрийн тогтвортой байдлыг дээдлэн эрхэмлэхийн оронд бараг жил болгон сонгууль явуулах замаар байр суурь булаацалдах санаархал газар авч байна уу гэж бодогдож байдаг юм.

Энэ нь ард түмнээ хүндэтгэх утгаар биш ард түмний нэр барьж, **тэднээр** даажигнаж байгаа хэрэг гэж үзвэл зохистой мэт санагдана. Ардын хувьсгалын 70 жилийн доторх алдаа гажуудлыг ч өнөөдөр шинэ маягаар давтагдаж **болзошгүй байна**. Жишээ нь феодалын хөрөнгийг хураагаад оронд нь хамтрал коммун байгуулах явцад монголын үндэсний баялаг мал сүрэг хичнээн үрэгдэж сүйтсэнийг мэдэх хүн өнөөдөр ч бидний дунд байж байна. Үүний яг сөрөг хувилбар өнөөдөр гарч ирж төр нэгдлийн хөрөнгийг тарааж байгаа нь түмэн олонд тус болохоосоо түрүүлж түрийвчинд орох нь их байгааг бид харсаар байна. Тэгэхдээ түүхэндээ 25 сая хүрч нэг баярлуулсан хэдэн мал минь түүхэндээ 20 сая хүрэхгүй болж түгшүүр зарлах вий дээ гэж эмзэглэж байна. Сүм хийдийг тарааж нурааж, суурин дээр нь сумын төв, сургууль, байгуулж байсан цаг саяхан. Тэгвэл өнөөдөр тэр бүхэн зад үсрэх, зарлан дуудахаа авчихаад байж байна аа. Ардын сургуулиас ламын сургуульд шууд шилжиж байна. Сургууль завсардсан хүүхдийн тоо, суралцаж байгаа хүүхдийн тоо хоёр ойртож байна. Сүм хийдүүдийг сэргээж, сумын төвүүдийг чөлөөлөх баримжаа гарч ирж байна. Дайны хажуугаар дажин, хувьсгалчдын хажуугаар хонзогногчид гарч ирж хувьсгалт цэргийн хурдан бууны аманд гар хоосон шалдан лам нарыг золиосолж байсан үеийг хэн ч мартаагүй, юу ч мартаагүй. Тэгвэл өнөөдөр ардчиллын нэр барьсан анархистууд босч ирж, сум хөдөөг ялгалгүй эзлэн түрэмгийлж эхэллээ. Дамчдын тоо хачиг хувалз шиг олнороход ядуучууд доод жингийн төлөг борлон шиг ширвэгдэж байна. Хөдөөгийнхөн углах гутал, мөрөнд өмсөх хувцас, чанах цай, татах тамхиар тасарч эхэллээ. Хот газар хоосон хонох явдал жирийн үзэгдэл болж хулгай дээрэм ширүүслээ.

Ийм эгзэгтэй үед Их цааз гэгч хууль гаргах гэж байгаа-  
даа олон талаас нь сайн бодож, тунгаах хэрэгтэй байна. Ард  
түмэнд ардчилал хэрэгтэй. Гэхдээ ардчиллыг идэж болдоггүй,  
ардчиллыг өмсөж болдоггүй нь амьдрал дээр нотлогдож байна.  
Бүрэн эрхтэй БНМАУ-ын шинж чанарыг хадгалсан бүх талаараа  
монгол хууль гаргацгаая.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



/Д.БАЯНДУҮРЭН/

Бичээч Д. Энэбиш

60 дугаар тойргийн депутат Ё. Давааням: Их цаазын төслийг хамтын оюун бүтээл гэдгийг зүй ёсоор үнэлж байна. Гэхдээ энд нийт ард түмнээр хэлэлцүүлээд авсан саналыг бүрэн тусгаагүй байгаа учраас шүүмжлэлтэй ярих хэдэн зүйлүүд байна. Алс хэтийгээ бодож нэлээн холыг бодсоноос болоод энэ хууль маань бол бас Монгол газар нутаг дээрээ хэрэгжих, одоогийн байдлаар бол хэрэгжих үндэс муутай ийм монголчлогдсон, эрлийздүү ийм хууль болох нь гэж айж байна. Их цаазын төсөлд ард гэдэг үгнээс нэлээд тойрч цэрэвсэн ийм байдал ажиглагдаж байна. Энэ бол бас өрнөдийн орнуудыг дуурайж байгаа нэг гашуун манайхны дуурайж явж байгаад алдаж байсан ийм гашуун сургамжийг давтахвийдээ гэж бодож байна.

Төрийн сүлдэнд мөн мажчин шувууг залж Сталины даалгавраар залагдсан гэж ярьж байгаа морьтой малчин ардаа огцруулах гэж байгаа нь бас хөдөөгийн хөдөлмөрчдийн сэтгэл санааг эмзэглүүлж байна. За өөрийнхөө шүлэг найргийн онгон шүтээн болгон хөлөг ажнайгаа магтан дуулж байсан найрагч Бадарч гуай яагаад онгод нь төөрч шувууруу орчихсон юм болоо. Энэ талаар бид бас харамсаж байна. Миний хувьд харамсаж байна.

Зах зээл өндөр хөгжсөн орнуудад иргэд нь хөдөлмөрийг амьдралын!<sup>эн</sup>тэргүүний хуульчлаагүй үүрэг болгосныг дуурайж иргэдээ хөдөлмөрлөх үүргээс чөлөөлж болохгүй байхаа. Хэрвээ бид хөдөлмөрлөх үүргийг нь чөлөөлөх юм бол хар захын дамчдыг олшруулахыг хуулиар баталгаажуулж байгаа хэрэг гэж үзэх үндэстэй юм гэж бодож байна. Манай залуучуудын нэг хэсэг нь өнөөдөр хөлс гарган хөдөлмөрлөхөөсөө айж, амар хялбар аргаар амьдрахыг хүсдэг болсон нь нууц бишээ. Эдийн засгийн хямралаас гарч зах зээл хөгжсөн орон болоход хүн бүр хөдөлмөрлөж, ард түмэн эх орондоо тус дэм болох ёстой. Ийм учраас хөдөлмөрлөх үүргийг хуулинд оруулах ийм саналтай байна. Бас эдийн засгийн биеэ даасан бүс нутгийг хөгжүүлэх хэтийн зорилго чиглэлдээ хэт хөтлөгдөж хэд хэдэн сумыг нэгтгэж хушуу болгохоор ингэж төсөлд оруулсан нь ард түмний бухимдлыг хөдөлгөсөн ийм үймээн болгоход хүрсэн байна. Манай түүхэнд сүм хийдээс авахуулаад сум, бригадыг олон удаа нурааж нүүлгэж



балгас болгож байсан ийм гашуун эмгэнэлт сургамж бий. Үүнийгээ бид мартаж өсгүй юм. Тэгэхээр одоо сумдыг нэгтгэвэл ард түмэн төрөөсөө улам алслагдана. Сумын төвүүд балгас болохгүй гэсэн ийм баталгаа бол байхгүй юм. Одоогийн хөл нүцгэн, явган сумын захиргаа ажил үйлдвэрлэлдээ хүрэхгүй байгаа. Гэтэл пуус, хоршооллын нэртэй дамчид олддоггүй бензин, олддоггүй машиныг хөлөглөж малчдыг мөлжин хөлжиж байна. Сумгүй нөхцөлд ганц багийн дарга ойд төөрсөн өнчин янзага шиг болох вийдээ гэж бодох юмаа.

Ийм учраас 21 дүгээр зууныг эхэлтэл сумтайгаа байя гэсэн хөдөлмөрчдийнхөө саналыг дамжуулж байна. Мөн төсөлд шүүх засаглалын дийлдэшгүй хүчийг ч гэсэн бид эргэж хармаар шаардлагатай байна. Улсын Их Хурлын гишүүдийн тоог 200 болгож, ерөнхийлөгчтэй, парламентын хоёр танхимтай засаглал тогтоох ийм саналыг тавьж байна.

354 дүгээр тойргийн депутат Ш.Бороодой: Бидний хэлэлцэж байгаа Үндсэн хуультай холбогдуулж хоёр, гурван санал хэлье гэж бодож байна. Үндсэн хуулийн удиртгал хэсэгт Үндсэн хуулийг Их цааз гэж нэрлэнэ гэж ингэж томъёолжээ. Түрүүн бид нар асуусан асуултаас үзэхэд Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Чимид гуай ингэж хариулж байсан. Үндсэн хуулиндаа бид нар тусгай Их цааз гэж нэр өгч байгаа юмаа гэж. Тэгвэл хууль гэдэг үг маань цааз гэдэг үгээр солигджээ гэдэг ойлголтонд хүрч байна. Нэгэнт хууль гэдэг үг цааз гэдэг үгээр солигдчихоогүй болохоор бусад хуулийг юу гэж нэрлэх юм бэ. Бага цааз гэх үү, аль эсвэл хөдөлмөрийн цааз гэх үү, тэтгэмжийн цааз гэх үү, тэтгэврийн цааз гэхүү гэх мэтчилэнгээр цаашлаад энэ зохицолдохгүй байна гэж ингэж бодож байна.

Ийм учраас Үндсэн хууль гэдэг нэрийг хэвээр нь байлгах саналтай байна. Түүнээс гадна Үндсэн хуулийн бүр I дүгээр бүлэгт бол БНМАУ гэдэг нэрийг Монгол улс гэж нэрлэхээр томъёолсон байна. Энийг дээд депутатуудын нэгэн адилаар би БНМАУ гэсэн нэрийг хэвээр үлдээх ийм саналтай байна. Яагаад гэвэл хэлэгдээгүй ганцхан зүйл хэлэхэд бид БН гэдэг үгнээс цэрвэх шаардлага-

байхгүй. Энэнээс цээрлэх шаардлага байхгүй. Бид олон үндэстэн ястны ийм улсаа. Мөн түүнээс гадна дэлхийн олон орны ард түмэнтэй эв санааны нэгдэлтэй, найрамдалтай байх ёстой ийм улсаа. Ингэж бодож байна.

Ард гэдэг үгнээс цэрвээд ер нь байх шаардлага байхгүй гэж ингэж үзэж байна. Тухайлбал БНМАУ-ын Засгийн эрхийг Засгийн эрх ард түмний мэдэлд байна гэж гуравдугаар зүйлийн I-д ингэж заажээ. Тэгэхлээр ард түмний гарт нэгдэл байх юм чинь ард гэдэг үгнээс цэрвэхгүй бид нар ингэж зөвшөөрөөд Засгийн эрх ард түмний гарт байна гэдгийг хүлээн зөвшөөрч байна шүү дээ. Ийм учраас ард гэдэг үгнээс цэрвэх шаардлага байхгүй гэж ингэж бодож байна.

Дараа нь БНМАУ-ын газар нутаг монголын ард түмний мэдэлд байх ёстой. Тэд өмчлөх ёстой, бид бол газраа гадаадын иргэдэд түрээслүүлнэ гэдэг нэрээр худалдах юм бол Монгол улс яваандаа газар нутаггүй ч болж мэднэ, байгалийн баялаггүй ч болж мэднэ. Өөрөөр хэлбэл бидний хойч үе, үр хүүхдэдээ залгамжлуулах юмгүй болж байж мэдэх юм байна шүү гэдгийг анхаармаар байна. Хэзээ нэгэн цагт бид нар газар нутгаа гадаадын иргэдэд худалдсан гэдэг гажуудал гаргаж гэмт хэрэгтэн болж мэдэхээр байна гэж ингэж бодож байна. Мөн төрийн сүлдийг хуучин хэвээр нь байлгах ийм саналтай байна. Яагаад гэвэл сүлдэндээ махчин шувуу оруулчихаад, үндсэн хуулиа их цааз гэж ингээд нэрлэчихвэл холбоо махчин шувуугаар цаазлуулах шиг холбоо ийм шүүх гарч байж мэднэ шүү гэдэг ийм ойлголт төрөөд байх юмаа гэж ингэж бодож байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын эдийн засгийн үндэс болсон мал аж ахуй, бид нарын амьдралыг хангагч таван хушуу малаа бид нар шүтэхгүй, манай оронд байдаггүй, 1200-гаад онц одоо нэг цэцэн хүний зүүдэлсэн зүүдийг шүтэх нь ямар хаашаа ухаантай байна гэж ингэж бодож байна. Ийм билэгдэлгүй юм байж болохгүй гэж бодож байна. Түүнээс гадна тэр таван сумны тухайд бол Бодончоор гэдэг хүний хатанд 5 хөвүүндээ таван мод өгсөн тухай юм Нууц товчоон дээр бий. Гэтэл одоо 5 сум болгосон байна. Таван сумыг билэгдлийн зүйл гэж би үзэхгүй байна. Дээр үед Цэрэг техник зэвсэг дайны янз бүрийн техник зэвсэг хөгжөөгүй байхад одоо харваагаар байлдаж байсан. Энийг бид нар үзэж хардаг

байсан. Би энийг өөрөөр хэлбэл байлдааны зэвсэг гэж хэлэхэд бүрэн боломжтой гэж үзэж байна.

За бид нар дараа нь Монгол улсын төрийн байгуулалтанд онцгой анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Яагаад гэвэл улс маань нэг үгээр хэлэхэд Ардын Их Хуралгүй болж байна. Мөн Засгийн эрхийг ард түмэн мэднэ гэдэг агуулга ч алдагдаж байна гэж үзэж гэж байна. Мөн түүгээр барахгүй аймаг маань Ардын Хуралгүй болж байна, сум маань Ардын Хурлын гүйцэтгэх захиргаагүй болж байна гэдэг ийм ойлголт төрж байна. Энэ шинэ хуулийн төсөлд улсын их хурлын гишүүд гэж ингэж томъёолж, энд цалин хангамж, онцгой эрхийн тухай ингэж заагдсан. Энэ заалт болбол захиргаадалтын үеийн Улс төрийн Товчооны долоон хүний байдлыг санагдуулж байна. Түүний оронд өөрчлөлт шинэчлэлтийн үеийн Улс төрийн Товчооны 76 гишүүн бий болжээ гэдэг ойлголтыг төрүүлмээр байна. Нэг. Ард түмэн нь ийм мэдлийн тухай болбол энэ дээр үнэхээр харамсмаар юм байна. Төрийн эрх мэдэл ард түмний гарт байна гэсэн боловч ард түмэн мэдэж байгаа юм байхгүй байна. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын 76 гишүүнийг дээрээс намуудын гаргаж өгсөн нэрсийн дагуу энийг сонгоно гэдэг саналаа хураалгаад тэгээд гүйцээ. Ингээд ард түмний мэдэл өөрөөр хэлбэл төгсөж байна гэсэн ийм агуулга ойлгогдож байна. Ийм учраас ард түмэн нь төрийнхөө мэдлийг мэддэг, эрхийг нь мэддэг, хянадаг, шалгадаг, хариу тайлагнадаг ийм харилцан уялдаатай байх ийм зохион байгуулалтыг зохицуулж өгмөөр байна гэж ингэж бодож байна.

Үүнээс гадна нэг санал байна. Парламентын дээд, доод гэсэн 2 танхимтай байх нь зүйтэй юм гэж үзэж байна. Одоо Улсын Бага Хурал одоогийн зохион байгуулалтыг зөв зохион байгуулалт гэж ингэж үзэж байна. Улсын Бага Хурлыг 20-25 хүнтэй, Ардын Их Хурлыг 200 хүнтэй байгуулах нь зүйтэй гэж бодож байна. Ингээд товчлоод нэг зүйл хэлэхгүй бол болохгүй нээ. Сумуудыг нэгтгэх тухай асуудал байна. Энэ сумуудыг нэгтгэх нь ард түмнээс төр тусгаарлагдаж байна гэж ингэж үзэж байна. Яагаад вэ гэвэл хушуу болж сумыг томруулж, хушуу болж сумуудыг багасгах нээ. Нэрдэх гэнэ. Тэгэхээр одоогийн байгаа сум дээр захиргаа ажиллахгүй болох нээ. Захиргаа ажиллахгүй болохоор тэнд байгаа албан газрууд ажиллахгүй болно.

5.

Тэгвэл аажимдаа өөрийнхөө автоматаар банкны салбар буух нь, холбооны салбар буух нь, тэр одоо ясли, цэцэрлэг буух нь, ингээд бүх албан газрууд автоматаар татан буугдах нээ. Тэгвэл одоо суманд 7 хоногт I удаа ирдэг хэвлэл хушуу байгуулахад I4 хоногт I удаа ирэх болж таарч байна. Ийм байдлаар удирдлага ч байхгүй, зохион байгуулалт ч байхгүй төрөөс салангид болох нээгэж ингэж ойлгогдож байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн



ЭНХТҮЯА

Бичээч

В.ОКУН

Ч.Намсрай / 183-р тойргийн депутат/ -Их цаа-  
зын төслийг боловсруулахаар томилогдсон комисс бүтэн нэг жил  
ажиллаад Улсын Бага Хурал хоёр удаагийн хуралдаанаар хорь  
шахам хоног хуралдаж боловсруулсан төслийг бид өнөөдөр хэлэл-  
цэж байна.

Төсөл үр дүнтэй болсон эсэх нь энэ хурлаас батлагдаж га-  
рах асуудлаар хэмжигдэх байх гэж бодож байна. Комисс, Улсын  
Бага Хурлын гишүүд маань хэрэв энэ төсөл Улсын Их Хурлаас  
батлагдаад гарчихвал бид ард түмэнтэйгээ хамт байгаа юм бай-  
на гэж ойлгох болов уу? Хэрэв ихээхэн засвартай батлагдвал  
ард түмэнгүй болчихжээ гэж ойлгох байх, ингэж дүгнэлт өгвөл  
сайнсан гэж ингэж бодож байна.

Ингээд би олон зүйл ярилгүй ганцхан зүйл дээр хэдэн  
зүйл ярья гэж бодож байна.

Үндсэн хуулийн өнөөдрийн энэ зарчмын асуудал, гол санаа  
бол улс үндэстний аюулгүй байдлыг баталгаатай болгох, хүний эрх  
эрх чөлөөг баталгаатай болгох энэ хоёр гол үндсэн зүйл дээр  
төвлөрөх байсан болов уу гэж бодож байна. Энэ үндэстэйгээ хол-  
богдуулаад энэ хуулийн 3 дугаар зүйлийн хоёрдугаар заалт дээр  
төвлөрч хэдэн санаа хэлэх гэсэн юм.

Энэ заалтан дээр, хоёрдугаар заалтан дээр төрийн эрх  
мэдлийг хууль бусаар авах, авахыг завдахыг хориглоно гэсэн  
ийм заалт бий. Өнгөрсөн түүхээс аваад үзвэл төрийн эрхийг ма-  
найд ойрын жилүүдэд ер нь гадны хөндлөнгийн хүч булаагаад  
авчихаж байсан нь юу юм бол? Ний нуугүй хэлэхэд төрийн эр-  
хэнд хууль ёсоор гарсан тэр хүч төрийнхөө үйл хэргийг хуу-  
лийг хууль бусаар хэрэгжүүлж байсан түүхийг бид мэднэ.

1932 онд буруу санаагүй бол, Чойбалсан Ерөнхий сайд болж,  
1958 онд Цэдэнбал Ерөнхий сайд болоод хууль ёсоор засгийн эр-

хийг явуулахдаа бүгд хууль бус ажиллагаа хэрэгжүүлсэн. Гэтэл энэ заалтад өнөөдөр засгийн эрхийг, хуулийг хууль ёсоор хэрэгжүүлэхийг хориглоно гэсэн энэ заалт байхгүй байгаатай холбогдуулж би хэдэн санаа хэлэх гэж байгаа юм. Энэ бол улс үндэстний тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой энэ асуудал гэж би ингэж ойлгож байна.

Өөрөөр хэлбэл энэ хуулинд засгийн эрхэнд байгаа хүчнүүдээс энэ хуулийг хуулийн дагуу хэрэгжүүлэх механизм баталгаа бол хуулинд байхгүй байна гэж би ингэж дүгнэх гэж байна. Энэ асуудал дээрээс үндэслээд би ганцхан санаа хэлэхэд парламент ганц эрхтэй, ганц хэмжээ хязгааргүй 76 хүнтэй парламент чинь нэг хүнтэй ч бай, 76 хүнтэй ч бай, төрийн эрх, хуулиа буруу хэрэгжүүлнэ гэх баталгаа хаана байгаа юм бэ гэж ингэж нэг санаа хэлмээр байна.

Хоёрдугаарт улс, үндэсний аюулгүй байдалтай холбогдсон газрын асуудлыг хэлэх гэж байна. Газрыг хувьд өмчлүүлэх нь, гадаадын хүнд түрээсээр өгөх нь өө. Би хилчин хүн, эх орны хилийг 30 жил манасан, ширхэг чулууны төлөө би тэрэн дээр зогссон. Гэтэл газраа түрээсээр өгчихөөд, бид эх орныхоо хамгаалж байсан, өөрийнхөө цэнхэр нуурыг, Тоо вангийн үхрийн ширээр авсан дархан уулыг түрээсээр өгөөд гадна нь сууж байгаад

манай нутгийг захаас нь сэмлээд өгвөл яах юм бэ? Ингэж нэг бодсон уу? Энэ гадны хүн чинь гадаадаас орж ирээд, эх орны газрыг түрээсээр авахдаа дандаа төвлөн сууж байгаад авах биш байх. Зэвсэг бариад эх орны хилийг алхахаасаа, хүрээ бариад эх орны хилийг алхвал бид зүгээр суух юм уу гэж ингэж асуухаас өөргүй ийм байдал харагдаж байна.

Дараагийн нэг асуудал дээр бид юу ярих гэж байна вэ гэхээр бид өнгөрсөн буруу юмыг өөрийгөө тэтгэж чадах эдийн засаггүй, бусдын хараат байсан гэж ингэж улиглаж байгаа, зэмлэж байгаа, харуусаж байгаа. Өнөөдөр энэ асуудлаасаа гарах арга зам юу байна вэ гэхээр олон хэвшилт эдийн засагтай, өмчийн бүх

3.

хэлбэрийг тэгш хөгжүүлнэ гэж ярьж байна.Энэ нь зөв.

Зах зээлийн эдийнзасаг, дэлхийн түгээмэл хандлагад шилжих асуудал манай хөгжлийн цаашдын зөв гэдгийг би ойлгож байна. Гэхдээ газрыг гадаадын хөрөнгөтнүүдэд өмчлүүлээд, гадаадын хүмүүс их мөнгөтэй орж ирээд, өнөөдөр монгол улсын ихэнх баялаг, эдийн засгийн гол өндөрлөгүүдийг эзлээд авбал, ахиад чонын амнаас гараад барын аманд орлоо гэгчээр ахиад бусдын хараат болчих тийм эдийн засагтай болчих юм биш биз ээ.Энийгээ бас энэ Үндсэн хуулинд харж үзэхгүй бол бид ирээдүйд ийм замыг тавьж өгчихөөд энэн дээр гарын үсэг зурчихаад, хойч үе маань хорь гучин жилийн дараа, тавь жаран жилийн дараа, зуун жилийн дараа бас харуусаад зогсож байх, тийм болчихно гэхэд үгүйсгэх газар байхгүй шүү гэдгийг хэлэх гэж байна.

Дараагийн нэг асуудал засаглал хуваах асуудал байгаа юм. Засаглалын асуудлыг мөн л энэнтэй холбож яримаар санагдаж байна.Засаглалын асуудлаар Улсын Их Хурал, Их цаазын цэц, Улсын дээд шүүх, түүгээр ч барахгүй парламентын гишүүд Дээд шүүхийн гишүүд, цэцийн гишүүд гэсэн хэмжээ хязгааргүй эрхтэй, хэн ч халддаггүй, өнгөрсөн хугацаанд байсан тэр дархан эрхтэй, дархан бүсүүд бий болох нь ээ.Тэгэхээр энэ асуудлыг чинь бас нэг харж үзвэл яасан юм бэ гэж ингэж хэлмээр байна.

Хоёрдугаарт нь хүний эрхийг холбоод би ганц санал хэлье. Цаг бага учраас би энийг товчлохгүй бол болохгүй байна.Хүний эрхийн асуудал дээр 18 эрхтэй, 4 үүрэгтэй ингэж Их цаазын төсөлд орж иржээ.Гэтэл өнөөдөр бид нар юу ярьж байна вэ? Гэмт хэрэг есөж байна, хүн хүнээ алж байна.Монгол хүн хүнээ алдчихлаа гэж ярьж байна.Гэтэл монголоо монгол болгож хүмүүжүүлэх асуудал чинь хүний үүргээс яагаад чөлөөлөгдчихөөд байгаа юм бэ? Эцэг эх нь үр хүүхдээ, үр удмаа,залуу үеэ хүмүүжүүлж, ирээдүй хойчоо авч явах тийм залуу үеийг хүмүүжүүлэх асуудал чинь эх орны ирээдүйтэй, эх орны аюулгүй байдалтай, эх орны тусгаар тогтнолын холбоотой юм биш үү? Энэ үүргийг эргээд яагаад харж болсонгүй вэ гэж, энэ асуудал дээр би тогтож .

хэлмээр санагдаж байгаа юм.

Хамгийн сүүлд нь хэлэхэд хил хэн ч халдашгүй дархан гэж энэн дээр сайхан томъёолсон, би энэн дээр ажиллаж байгаагийн хувьд үнэхээр баярламаар ийм томъёо байгаа юм. Гэтэл энийг эргээд харахаар зөрчилтэй хэдэн санаа, өөрөөр хэлбэл хилийг хуулиар бататгана гэнэ. Хуулиар бататгана гэсэн цаасан дээр бичсэн хуулиар хийсвэр сэтгэлээр бататгаж болно л доо. Гагцхүү улсын хилийг өнөөдөр, торгон хилийг сэмлэхгүй байлгаж байдаг, хилийн ширхэг чулууг хөдөлгөхгүй байлгаж байх тэр үүргийг хэн биелүүлэх вэ гэдэг асуудлыг энэ хуулинд бас харж үзэх хэрэгтэй юм биш үү?

Энийг өнөөдөр үнэлэхгүй явсаар байгаад өнөөдөр эх орон газар нутгаасаа алдчихсан тухай ярьж байгаа. Энэ хуулийн энэ заалтан дотор дахиад юу байна вэ гэхээр улсын хилд хэн ч халдашгүй дархан гэж хэлчихээд улсын хилийг гадаадын цэргийг хууль гаргаж байгаад нэвтрүүлж болно гэж хэлж байна. Тэгэхээр энэ зөрчилтэй санаа чинь өөрөөр хэлбэл, улсын хил халдашгүй дархан юм бол улсын хилээр гадаадын цэрэг хэнбугай ч орж ирэхгүй байх, тийм асуудал биш үү гэж би ингэж хэлмээр байна. Энэ бүхнийг санаж үзвэл яасан юм бэ гэж бодож байна. За баярдлаа.

Д.Шагдар /398 дугаар тойргийн депутат/ –Шинэ Үндсэн хуулийн төсөлд хөдөөнөөс ирсэн депутатын хувьд хэлэх хэдэн үг байна.

БНМАУ гэсэн нэрийн хувьд өөрчлөхгүй гэсэн ийм санал байна. Энэний учир нь гэвэл манай БНМАУ-ын хил хязгаар нэр өөрчилснөөс болж гадна байж байгаа улсууд одоогийн байж байгаа БНМАУ-тай хил хязгаарын талаар гэрээ хийсэн, монгол улстай хийгээгүй гэх баталгаа алга байна. Ийм учраас БНМАУ-ын нэрийг хэвээр үлдээх ийм саналтай байна.

Хоёрдугаарт нь засаг захиргааны хувьд ихэнх депутатын саналуудтай нэг байна. Одоогийн байж байгаа засаг захиргааны



зохион байгуулалтыг өөрчлөх зайлшгүй эдийнзасгийн, улс төрийн ийм шаардлага байхгүй гэж ингэж үзэж байна. Ийм учраас энийг одоогийн байгаа засаг захиргааг хэвээр нь байлгах саналтай байна.

Бусад төрийн сүлд, далбааны хувьд бол зарим депутатууд тайлбар хийсэн. Энд зардлын тухай тайлбар хийсэн. Энэ зардал бол хийсвэр, бага хэмжээний зардал гэж ойлгогдохоор ярьсан. Бидний бодож байгаагаар зөвхөн нэг хоршооллын тамга, тэмдэг хийлгэхэд 2-3 мянган төгрөг гарч байгаа. Манай улсын хэмжээн дээр гарах энэ төрийн сүлд, далбаа, соёмботой холбоотой ийм зардлууд миллиардаар яригдах байх гэж бодож байна.

Төрийн тогтолцооны хувьд парламентын засаглалтай ийм төрийн зохицуулалттай байх ийм саналыг дэмжиж байна. Ингээд бусад саналууд давхардаж байгаа учраас дараа тодорхой зүйл дээр санал хэлэхийг хүсч байна.

Ө.Ганхуяг /336 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр депутатууд бид бол энэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэхэд зөвхөн өөрсдийн санаа бодлыг биш сонгогчдынхоо санаа бодлыг илэрхийлж байгаа учраас энд бол аль болохоор олон хүний үгийг сонсож, олон хүний бодлыг төвлөрүүлэх үндсэн дээр зөв шийдэл гаргах явдал бол бидний чухал үүрэг гэж бодож байна. Ингээд хэдэн санал хэлье.

Нэгдүгээрт нь, ер нь одоо бид өргөн хэлэлцүүлэг явуулж байна, энэний дараагаар бид тодорхой зүйл бүлэг дээр хэлэлцүүлгийг явуулна. Ингэж явуулахад бид юуны өмнө улсын нэр, хуулийн нэрийг тогтох шаардлагатай юм шиг санагдаж байна. Тийм учраас энэнтэй холбогдуулаад нэг зүйлийг хэлэхэд ер нь аливаа улс орны нэр, нэрэн дотор тухайн улсын улс төр, нийгмийн байгуулалт, шинж чанар агуулагддаг ийм учиртай. Тийм учраас улсын нэрийг тогтооход миний хувьд бол одоогийн санал юу вэ гэхээр БНМАУ гэсэн энэ нэрийг хэвээр байлгах шаардлага-

тай байна. Яагаад вэ гэхээр энэ бол нэгдүгээрт манай улсыг бүгд найрамдах улс гэдгийг гадна талаасаа нэрнээсээ томъёолон харуулж байна.

Хоёрдугаарт, төрийн эрх бол ард түмний мэдэлд байдаг гэдэг энэ санааг агуулж байгаа юм. Заавал монгол улс гэж нэрлэхээд хуулиа уншиж судалж, хуудсыг нь эргүүлж харж байж бүгд найрамдах улс гэдгийг харалгүйгээр, шууд нэрнээс нь улсыг гадаад, дотоодод танигдуулдаг байх явдал бол чухал байна гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, хуулийн нэрийн хувьд миний хувьд Үндсэн хууль ч гэж нэрлэмээргүй байна. Их цааз ч гэж нэрлэмээргүй байна. Ер нь бид түүхэн уламжлалаа сэргээж байгаа энэ нөхцөлд бол бусад оронд давтагдашгүй тийм өөрийн уламжлалт нэрийг сонгож хэрэглэвэл зүгээр болов уу гэж бодож байна. Тийм учраас одоогоос 785 жилийн өмнө буюу, 1206 онд Чингисийн Их засаг гэдэг ийм нэртэй хууль гарч байсан байна. Тийм учраас хуулиа Их засаг гэж нэрлэвэл ямар вэ гэсэн ийм бодолтой байна.

Төрийн тогтолцооны хувьд бол одоогийн систем дээр аваад үзэхэд ер нь Улсын Их Хурал гэж дангаараа орсон байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал, Бага Хурал гэсэн ийм хоёр шаттай байх ийм саналтай байна. Улсын Бага Хурал гэдэг бол одоогийн энэ системийг хадгална, Улсын Их Хурлын хувьд бол миний хувьд энэ депутатуудын саналаас арай өөр санал хэлмээр байна. Депутатууд маань Их Хурлыг байгуулахдаа бол одоогийн бидний адил депутатуудыг цөөн тоогоор, 150-200 депутат сонгоод, 5-6 жилийн хугацаагаар үүрэг гүйцэтгүүлээд ингээд Их Хурлыг бүрэлдүүлэх санал тавьж байна.

Миний хувьд бол ер нь депутат гэдэг энэ нэр томъёог цааш нь хэрэглэмээргүй байна. Ер нь Улсын Их Хурлын төлөөлөгчдийг сонгож байх хэрэгтэй. Тухайн Хурал бүрийн төлөөлөгчдийг ард түмнээс сонгох үндсэн дээр хуралдаан, хуралдаанд төлөөлөгчдийг оролцуулж, ингэснээрээ нэг хүн 4-5 жил сонгуулийн

үүрэг гүйцэтгээд байхгүй, ард түмэн, ажилчин, малчин ээлжлэн сонгогдон оролцох энэ явдал бол өшөө ардчиллыг хөгжүүлэх ийм өргөн бололцоотой гэж үзэж байна. Манайд ч урьд өмнө нь ийм уламжлалаар Их Хурлын гишүүдээ сонгож хуралдаж байсан түүхтэй учраас ийм саналыг хэлмээр байна.

Төрийн тогтолцооны хувьд парламентын бүгд найрамдах улс байх нь зүйтэй гэж бодож байна. Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгох саналтай байна. Энэ төсөлд хоёрдмол утгаар байгаа. Эхний шатанд бүх ард түмнээс, хоёрдугаар шатанд төлөөлөгчдөөс, өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас сонгоно гэж. Тийм учраас хоёрдугаар шатанд ч гэсэн ард түмнээс сонгох хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ бол иргэний ардчилал биш, улс төрийн ардчилал болж, энэ сонгуульд аль олонхийн суудал авсан нам бол өөрийнхөө хүнийг шууд Ерөнхийлөгчөөр сонгоход хүргэх талтай.

Тиймд хоёрдугаар шатанд бүх ард түмнээс шууд сонгоход чирэгдэлтэй гэж үзвэл аймаг, хот тус бүр тодорхой тооны хүмүүсээс бүрдсэн тойргийг байгуулж, түүнээс шалгарч үлдсэн хоёр хүний саналыг хурааж, олонхийн саналыг авсан хүнийг Ерөнхийлөгчөөр сонгуулах ийм саналтай байна.

Засгийн газрын хувьд гэх юм бол Засгийн газрыг сонгуульд олонхийн суудал авсан нам дангаараа байгуулах нь зүйтэй гэж бодож байна. Ерөнхий сайдыг Улсын Их Хурлаас томилох, харин Ерөнхий сайд бол Засгийн газраа өөрөө дангаараа бүрдүүлэх хэрэгтэй. Одоо энд бол Улсын Их Хурлаас Засгийн газрыг бүрдүүлэхээр заасан байна. Энийг өөрчилж ер нь Ерөнхий сайд хэнтэй ажиллах вэ гэдгээ өөрөө сонгож аваад ингээд энэ үндсэн дээр ажиллаж чадвал цаашдаа үйл ажиллагаагаа явуулж бүрэн эрхээ дуусгах, ажиллаж чадахгүй бол хамтаараа огцорч байхад ч гомдолгүй юм.

Тийм учраас Засгийн газрыг Ерөнхий сайдын эрхийг өргөтгөж дангаар нь бүрдүүлэх тийм эрх хэмжээг олгох хэрэгтэй гэж би бодож байна.

Эцэст нь хэлэхэд энэ сонгуульт хугацаа харилцан адилгүй янз бүр байна. Ерөнхийлөгч 4 жил, Улсын Их Хурал 6 жил, Ерөнхий сайд 6 жил гэх мэтээр ийм олон хугацааг тогтоосон байна. Миний саналаар бол шинэ төрийн тогтолцоог нэгэн ижил хугацаанд бүрдүүлж, нэгэн ижил хугацаанд өөрчлөн зохион байгуулж сонгож байх нь зүйтэй гэж бодож байна. Тийм учраас ер нь сонгуульт хугацааг бүх шатанд бүх сонгуульт хугацаануудыг ижил 4 жилээр сонгуулийг явуулж байх ийм саналтай байна.

Соронзон хальстай тулгаж

НИЙЛСЭН

*Д. Алтанцэцэг*

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.16

Кассет № III-24

18.32-18.50

Депутат /нэр тойргоо хэлээгүй/

Ерөнхий хэлэлцүүлгийн үед нэг санал оруулъя гэсэн бодсон юм. Энэ нь 1206 онд их монголын тулгар төрийн сүлд болгож өргөмжилсөн 9 алд цагаан тугийг монголын шүтээн болгож Их цазад оруулах ийм саналтай байгаа юм.

Үүний учрыг өгүүлэхийн бол өнөөдөр энд зарим нөхдүүд, окуны хоосролтой гэж ярилаа гэдгээс ихээхэн эмээглэж байна. Энэ бол үнэн. Би окуны хоосролд орсон тэр олон олон монгол залуучуудын нэг нь би өөрөө. Юунд хоосров оо? Бид нар өнөөдөр түүхээ мэдэхгүй байна. Шар туужид эхэнд нь гардаг хүн есөн үеэ мэдэхгүй бол ойд төөрсөн сармагчин адил гэж хэлснийг мэддэг байсан бол бид тэр түүхийг мэддэг явсан бол өнөөдөр овгоо ч мэдэхгүй шахуу тарчилж явах уу? Үгүй байхаа. Энэ чинь бас л нэг окуны хоосрол. Тэгвэл бид нар мэдэж байгаа байх. Зөвлөлтөд, гадаадад суралцаж байсан окутнууд, Зөвлөлтийн 16 дахь республик нь танайх, сүлдээ хар гэхэд хэлэх үггүй нүүр нь улайгаад сууж байсан окутнууд энд ч олон байгаа байх.

Ерөөсөө окуны хоосролд бид олон олон үеийн турш нэрвэгдсэн шүү дээ. Тэгээд өнөөдөр бид окуны хоосролд ороогүй гэж ярьчихаад энгийн нэг механик хэрэглээгээр яриад байж болохгүй байх. Тэгвэл өнөөдөр манай залуучууд чинь итгэл, бишрэлтэй байж, шүтээнтэй байж энэ улс орондоо нэлээд юм бүтээх ёстой байх. Гэтэл одоо залуучуудыг харахад хэн бүгд мэдэж байгаа шүү дээ. Ямар ч хэрэг хийг, хулгай хийх, хүн алахаас буцахгүй. Тэдэнд чинь өнөөдөр хүндлэх, бишрэх юм алга. Мэдэх сайн түүх алга, ийм байхад тэд чинь юу ч хийхээс буцахгүй байна. Энэ дээр нь эдийн засгийн хямрал нэрвээд ирэхээр зэрэг юугаа ч худалдахад бэлэн болчихоод байна шүү дээ.

Ийм тохиолдолд бид яагаад окуны хоосролгүй гэж яриад байна вэ?

## 2.

Үүнийг мэдүүлэхийн тулд бид нар өнөөдөржинхэнэ шүтэх бишрэх, сүлдлэх дээдлэх юмыг нь хэлж өгөх ёстой байх. Тэгэхдээ би үүнийг шүтэж биширнэ гэснээрээ аливаа нэг сургаалийг аливаанэг намыг, аль нэг шашныг шүтэхийг хүсээгүй.

Гагцхүү өвөг дээдсээ шүтэхийг хүсч байгаа юм. Энд Хамаг Монголын түүхийг нуусан цагаас эхлээд л бид нар нэлээн хоосролд орсон байгаа. Тэр байтугай, хөх судрыг хэрвээ бидний өнөөдрийн тэр буруутгаад байгаа Ю.Цэдэнбал уншсан байсан бол улс төрийн мандан буурах цаг нь зусар залхай сайд, янаг дотно хатан эрх барилцаад ирэхэд улс гүрэн самуурах буку гэж хэлснийг мэдэж байсан бол бид нар ийм эмгэнэлтэй юманд орохгүй байсан шүү дээ.

Энэ бүхнийгээ мартчихаад эргээд урьдны түүх гэж их олон жилээр урагшаа явж байна, та нар, зүтгэж байна. Өнөөдрийн юм хэрэгтэй гэж ярьж байгаа маань нэг л авцалдахгүй байна. Яах вэ энэ дээр, одоогийн нөхцөлд хийморийн цэнхэр тэнгэрт, цахилан гялалзах шонхор цагаан сүлд минь гэж бидний сүсэглэх гэж хүссэн олон залуучуудын хүсэл энэ удаад бас л тэр хувь заяа нь дутах юм шиг байна.

Тэгэхдээ энэ дээр нэг юманд эмзэглэхэд би ч бүр дүүрч, бидний үр хүүхэд, хойч үеийнхээ өмнө удмынхаа өмнө сэтгэлдээ тарчилж, шаналж л нүд анихгүй байгаасай гэж бодож байна.

Тийм учраас бид нар өнөөдөр сүлд, ялангуяа үүнийг эрхэмлэж дээдэлдэг юмаа, нэр усаа нэлээн алстайхан бодож байж, хойшдынхоо залуучуудыг, үр хүүхдээ хүмүүжүүлэх үү гэдгийг нэлээн анхаарч өгөөч ээ гэж хүсч байна.

304 дүгээр тойргийн депутат Намсрайжав:

Үндсэн хуулийн төсөл боловсруулсан комисс, Улсын Бага Хурлын үйл ажиллагааг бид өндөр үнэлж байна.

Их Хурлын 304 дүгээр тойргийн сонгогчдоос Үндсэн хуулийн төслийн талаар тодорхой 12 зүйлийг нийт сонгогчдын 77 хувиар санал авахад санал тус бүр дээр тодорхой зүйл тус бүр дээр 75-85 хувийн саналыг зөвшөөрч байсан юм.

Тэгээд би саналаа хэлбэ гэж бодож байна. Нэгдүгээрт нь, төрийнсүлд, соёмбо, зарим нэрүүд монголын ард түмэнд гай тариагүй, үүнийг өөрчлөхгүй байхад монголд бүх юм сайн сайхан болчихгүй ээ, тийм учраас АНУ-д үндсэн хууль сайн боловсруулаад 200 гаруй жил мөрдөж байгаа гэсэн. Манай ард түмний бэлгэдэж ирсэн, дээдэлж ирсэн энэ сүлд наад зах нь одоо 100 жил болог гэж би бэлгэдэж байна.

Нөгөө талаар энэ төрийн энэ тамганы бариулыг мөн шонхор шувуутай байна гэж Үндсэн хуульд заасан байгаа. Үүнийг би зөвшөөрөхгүй байна. Мөн Чингисийн тугны хэлбэртэй байвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Сумыг нийлүүлж, хошуу болговол их хэмжээний хөрөнгө үрэгдэж, замбараагүй байдал одоо бий болгохгүй гэх баталгаа байхгүй ээ. Би ганцхан жишээг хэлэхэд миний ажиллаж байгаа Хушаат сум 1950-иад онд татан буугдаад, 1987 онд дахин байгуулагдсан. Сум татан буугдахад юу үлдсэн бэ гэхээр одоо өнөөдөр Хушаат суманд Хушаатын нэг ч иргэн байхгүй. Хушаат сумын бүх хөдөлмөрчид Улаанбаатар, Дархан, Сүхбаатарт шилжсэн байгаа.

Хоёрдугаарт, Хушаат сумын суурин дээр барилга байшин нэг ч байхгүй, эзэнгүй бэлчээр, эзэнгүй өвөлжөө үлдсэн байгаа.

Туравдугаарт, ер нь тэнд амьдарч байсан настай хөгшин хүмүүсүүд бас уугуул нутгаа бодож санаж, сэтгэлийн дарамтанд ордог юм шиг байгаа юм. Өнгөрсөн зун манай аймгийн 60 жилийн ой болоход энэ Улаанбаатар хотод байгаа уугуул иргэдийг цуглуулахад бараг 50 хувь нь Хушаатын иргэд байсан.

Өнөө жил сумаа байгуулагдаад очиход 2 автобус хөгшчүүл очиж нутаг усандаа майхан платкатай очиж, өнжиж хоножбайсан.

Ийм учраас ер нь одоо сумыг нийлүүлэх, устгах асуудал ямар хор холбогдолтой вэ гэдгийг эндээс хэлж болох юм.

Нөгөө талаар би тэр газрын талаар нэг зүйл хэлье гэж бодож байна. Манай орны газар шороо, бэлчээр, тариалангийн талбай бол дэлхий дээр маш их өвөрмөц цаг уурт оршиж байна гэж би үзэж байна. Өөрөөр хэлбэл би үүнийг юу хэлж байна вэ гэхээр маш их хатуу ширүүн цаг уурт, оршиж үүнээс болж салхи, усаа элэгдэх, мөн бэлчээр маань талхиагдаж мэрэгчдэд хүртэл сүйтгэгдсэн ийм бэлчээр асар их байгаа. Бид ер нь одоо тариалангийн талбай, бэлчээрийг анхнаас нь эхлээд систем муутай эдэлж байгаа. Ялангуяа ойжуулах, хөрс хамгаалах ийм ажлууд найдвартай ийм хамгаалалт хийж чадаагүй. Хөрсний үржил шим хүртэл харилцан адилгүй байгаа. Тийм учраас үүнийг хэрвээ түрээсээр өгнө гэж үзэх юм бол манай монголын хамгийн их үржил шимтэй, энэ Сэлэнгэ, Булган хаанах ч байдаг юм бэ? энэ хангай үржил шимтай хөрс рүү бүх хүн дайрах болов уу гэж бодож байна.

Нөгөө талаар манайд газар, эзэмшиж байсан уу гэвэл байсан шүү дээ. Манжийн үед тухайлбал 50-60-аад оны үед хятадын иргэд их хэмжээний газар эзэмшиж байсан. Тэд үхдэг нь үхээд, явдаг нь явсан. Одоо юу үлдсэн бэ? гэхээр аалзны шүлс шиг баахан усалгааны суваг шуудуу, шарилжинд элэгдсэн шархадсан газар л үлдсэн. Энэ шархадсан газрыг бид эдгээх гэж зовж байгаа шүү дээ. Үүнийг газар тариалан хөгжсөн зарим сангийн аж ахуйнууд сайн мэдэх байхаа. Тэгэхээр үүнийг би юу гэж үзэж байна вэ гэхээр ер нь Үндсэн хуулиар газрыг түрээсээр олгоно, хувьд өмчлүүлнэ гэж ингэж баталгаажуулж болохгүй байхаа. Үүнийг бусад хуулиар зохицуулж болох байх. Гэлээ гэхдээ газрыг бас шууд түрээслүүлж болохгүй, гадаадын иргэдэд эзэмшүүлж болохгүй, хувьд өгч болохгүй гэж бас туйлширч болохгүй байх.



Бэлтгэлийг хангасны дараа тодорхой цаг хугацаанд үүнийг өгч болох байх гэж бодож байна. Жишээлбэл, Солонгос, Япон, Хятад улс шиг бага оврын техниктэй ийм техник нэвтэрсэн үед бол хувьд өгч болох юм.Өөрөөр хэлбэл бидний энэ дээр хэлдэг шиг ингэж элэгдэж эвдэрсэн газрыг сэргээгээд авч чаддаг тийм юунд нийтийн хэрэгцээний газрыг гадаадын хүмүүсүүдэд түрээсээр өгч болох юмаа гэсэн ийм санал байна.

Дөрөвдүгээрт нь би, хүний эрхийн талаар эрх тусгагдсан нь үнэн.Гэлээ гэхдээ үүрэг нь бага байгаа гэдгийг ч зөвшөөрч байна.Гэхдээ энд ганцхан санал хэлэхэд хүний эрүүл мэнд,

эд хөрөнгөнд хохирол учруулсан ийм хүн зөвхөн ялаа эдлээд хохирлоо төлөхгүй байгаа талаар сая II дүгээр сарын эхээр телевизийн нэвтрүүлэг явна билээ.Үүнийг анхаарч үзэх зүйл юмаа гэж үзэж байна.Тийм учраас иргэн хохирсон хохирлоо нөхүүлэх эрхтэй болгох ийм саналыг Үндсэн хуульдаа оруулъя гэж бодож байна.

Хамгийн сүүлд хэлэхэд Ерөнхийлөгчийн насыг 40-өөс дээш байлгах саналтай байна.

Засаглалын хувьд нийтийн саналтай нэг адил байна. Гэхдээ доод танхимд байгаа хүмүүсийн нас үнэхээр 25 гэдэг бол нийцэхгүй байна.Үүнийг ядахдаа 28-аас дээш настай хүн доод танхимд орох хүмүүсийн насыг ингэж тогтоож өгөх нь зүйтэй юм гэсэн ийм санал байна.

Ж.Уртнасан: Одоо өнөөдөр та бидний сонорт сонордуулахаар ирүүлсэн олон захидал, мэдээллүүд байна.Орлогч дарга Батбаяр сонсоно.

Н.Батбаяр:/Ардын Их Хурлын орлогч дарга/

Ардын Их Хурлын II хуралдааны нэр дээрбайгууллага,иргэдээс өнөөдөр бичгээр 20, цахилгаанаар 5, утсаар 44, хүлээн авах байраар 23 хүн ирж санал хүсэлт тавьсныг тоймлон дурдая.

Сүхбаатарын районы 28 дугаар хорооны өндөр настан Дамдиндорж утсаар: Депутатууд Монголын ард түмний нийтлэг эрх ашгийг анхааран өөр өөрийнхөө намын хуралд сууж байгаа юм шиг байж болохгүй. Депутатуудын зарим нь ард түмний нэр бариад хувийнхаа бодлыг ярьж байна. Нэг депутат бол ард түмний нэг хэсгээс сонгогдсон хүн, нийт ард түмнээс сонгогдоогүй гэдгээ ойлгох нь зүйтэй. Их цаазын төсөл хэлэлцэхэд хөх өнгөнөөс цэрвэж болохгүй.

Дархан хотын Найрамдах хорооны өндөр настан, Дорлиг утсаар:

Монголчууд 21 дүгээр зуунд капитализмыг энхрийлэн тэврэх хуультай байх уу? эсвэл тусгаар тогтнол, бие даасан байдлаа хангаж ажиллах уу?

Улаанбаатар хотын 5 дугаар тойргийн депутат Занаа утсаар:

Ардын Их Хурлын депутатууд манай улсад бүх хууль хэрэгтэйг анхаарах, аливаа нэг хуульгүйгээс болж эрх зүйн зөрчил гарч байна. Ардчиллыг хөгжүүлбэ гэвэл хууль хэрэгтэй, хуулийн өмнө иргэн бүр тэгш эрхтэй, тэгш эрхтэй үүрэгтэй байх. Энд газар өмчлөлийн болон цагаачлалын хуулийг гаргах <sup>хэрэгтэй</sup> . Ер нь бүх хуулиа гаргаж мөрдөх нь хэрэгтэй.

Их цааз урт настай 30-300 жил байх ёстой. Хэрэв 3,4 жилийн настай хууль гаргачих юм бол депутат та нөхөд хариуцлага хүлээнэ шүү.

Хөдөө аж ахуйн их сургуулийн багш, профессор С.Балдан:

Хурал сайхан болж байгаа ч , үүний хажуугаас сэтгэл түгшээсэн зүйлүүд их гарч байна. Сэтгэлийнхээ хөөрөлд автсан асуудлыг гуйвуулсан, зарим талаар ард түмнийг доромжилсон зүйл ч гарч байна.

Жишээлбэл депутат Одончимэд гадагшаа анхаарах гэж Үндсэн хуулиа өөрчилж байгаа юм уу гэж асуулаа. II дүгээр сарын 13-ны өглөө радиогоор нэг депутат ярихдаа нийслэлийнхэн сольж өмсөх хоёр хувцасгүй байж, улсынхаа нэрийг солих гэлээ гэж ярилаа. Мөн зарим депутат асуулт, хариулт өгөхөд та нар семинар өгч байна гэж байлаа. Үүнээс үзэхэд болчимгүй үгтэй хүмүүс их байна.

Завхан аймгийн Их-Уул сумын МАХН-ын дарга Дашдаржаа:

Улсын нэр, сүлд, далбааг өөрчлөх эсэх асуудлыг нухацтай хэлэлцэж, өөрчлөх цаг хугацаа болсон эсэхийг анхаарах.

Засгийн газрыг огцруулах, Улсын Бага Хурлыг тараах саналыг зөвшөөрөхгүй, үр дүнг харъя. гэсэн зүйл байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн багш Цэдэндорж, Цэрэндорж нарын 3 хүн:

Ардын Их Хурлын депутатууд нь Улсын Бага Хурлын гишүүдийн мэдлийн түвшинд хүртэл бэлтгэгдээгүйг анхаарах. Улсын Бага Хурлын гишүүд бол олон хууль боловсруулж, хэлэлцсэн, үүний тулд нэлээн юм уншиж судалсан хүмүүс шүү дээ.

Улсын Бага Хурлын дарга Гончигдоржийн санал, тайлбарыг хүлээж авах нь зүйтэй. Депутатууд үндсэн хуулийн төслийг урьдчилан сайн судлаагүй бололтой байна. Зарим депутатууд сонгогчдын бодол гэж их ярьж байна.

Сүхбаатарын район 9 дүгээр хорооны иргэн Баттулга утсаар:

Хөдөөгийн депутатууд сонгогчдын нэр барьж их ярьж байгааг их анхаарах. Дорнод аймгийн хивсний комбинатын ҮЭ-ийн хороон дарга Готов утсаар:

Улсын Бага Хурал, Засгийн газрын тайланг бүрэн эхээр нь нэвтрүүлж өгнө үү.

Октябрийн районы 26 дугаар хорооны иргэн Хайдав:

Депутатуудын өгсөн саналыг хэвлэлд нийтлүүлмээр байна. Хэн ямар санал өгснийг ард түмэн мэдэх хэрэгтэй.

Сүхбаатарын районы 9 дүгээр хорооны өндөр настан Банзрагч:

Депутат нөхөд өө, энэ 70 жилийнхээ дотор бүү эргэлдээч. Өнгөрсөнөө эргэн харж, ирээдүй рүүгээ тэмүүлэх цаг болжээ.

Сүхбаатарын районы 20 дугаар хорооны өндөр настан

Цэгмид:

Хөдөөнөөс ирсэн зарим депутатууд буруу ярьж байна. Эрдэмтэд, мэргэжлийн хүмүүсийн үгийг сайн сонсох, ард түмэн бид нарийн учрыг мэдэхгүй шүү дээ.

Октябрийн районы 19 дугаар иргэн Рэгзэн: Сэтгүүлчид депутатуудыг харааж байна. Учир нь ард түмэнд ойлгуулан тайлбарлахын оронд бараг Засгийн газрын бодлогын эсрэг юм ярьж байна. Депутатуудын үгийг сэтгүүлчийн тайлбар, орчуулгагүйгээр бид ойлгож байна.

Октябрийн районы 10 дугаар хорооны иргэн Олзвой:

Ардын Их Хурлын орлогч дарга нар ээлжээр эргэлтээр хүлээн авах байраар уулзах хэрэгтэй. Үнэн сонинг хавчиж байгааг Их Хурал анхаарч, гардаг дугаарыг нь хугацаанд нь гаргадаг боломж бүрдүүлж өгөх.

Сүхбаатарын районы 6 дугаар хорооны иргэн Ваанчиг:

Ерөнхийлөгчийн ажлын тайланг Их Хурлын хуралдаанд сонсох.

Сүхбаатарын районы II дүгээр хорооны иргэн Адъяа:

Их цаазын төслийг манай орны шилдэг хуульчид, эрдэмтэн мэргэдүүд боловсруулж сурталчлах, санал авч Улсын Бага Хурал

хэлэлцээд Их Хуралдаа өргөн барьсан. Гэтэл депутатууд маань энэ талаар ухаалаг хандахгүй, маргаж, цаг их зарцуулж, санаа бодлоо тулгаж байна.

Депутатууд ямар зардлаар хуралдаж байгаагаа анхаарч үзэх.

Октябрийн районы 10 дугаар хорооны өндөр настан Дорлиг, Сүхбаатарын районы 3 дугаар хорооны Бавуу нар утсаар:

Эрхэм депутат та бүхэн төрийн сүлдийг өөрчлөх тухай ширүүн маргалдсаар байна. Бид төрийнхөө сүлдэнд залбирсаар 60 нас насаллаа. Гэвч төрийн сүлд өршөөсөнгүй. Энэ сүлд нь байгаагүй, байгууллагагүй, байх учиргүй, социализмыг байгуулагчид, дарангуйлагчид, хэлмэгдүүлэгчид, захиргаадагчдынх байсан билээ. Баримт нь 1960 онд Үндсэн хуулинд төрийн сүлдэнд байсан морьтой хүний уургыг малын дүрстэй хамт хурааж авсан нь малчдын малыг хураагаад хоосруулсны бэлгэ тэмдэг байлаа.

Октябрийн районы IV хорооны Доржсүрэн, Амар нарын 5 хүн болон 80 дугаар сургуулийн багш Донтор, Монголын хараагүй дүхий иргэдийн нийгэмлэгийн дэргэдэх Энэрэлт үйл эмнэлгийн бариагч Дамдинжав, Дархан хотын Нэгдүгээр хорооны иргэн Өлзийбадрах, Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын ажилтан, ахмад Баатар нар:

Төрийн сүлд, далбаа, дууллыг битгий өөрчлөөч, өөрчлөх саналтай байгаа депутатуудыг нэрээр нь сонгогчдод мэдээлэх.

Энх тайван найрамдлын байгууллагуудын гүйцэтгэх хорооны ажилтан Жаргалсайхан:

Төслийг бүхэлд нь дэмжиж байна. Нийгмийн хөгжлийг дагаж өөрчлөх нь зүйн хэрэг. Энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахдаа, өөрчлөхгүй гэсэн хүмүүсийн саналыг давамгайлаад байгааг анхаарах.

Октябрийн районы 37 дугаар хорооны иргэн Бат-Эрдэнэ:  
Улсын нэрийг Монгол улс, хуулийн нэрийг Их засаг гэж  
нэрлэх, сүлдийг хэвээр байлгах, далбааг 9 гүн цэнхэр өнгөтэй,  
дээр нь соёмботой байлгах.

Дархан хотын Найрамдал хорооны өндөр настан Дорлиг:

Улс, хуулийн нэрийг хэвээр байлгах, төрийн сүлд нь мон-  
гол морио бэлгэдэж болдоггүй юм бол махчин шувууны оронд  
Монгол хоточ нохой дээр.

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрт ажилтай  
Янжив:

Хуулийн нэрийг хэвээр байлгах.

Өвөрхангай аймаг, Арвайхээр хотын I дүгээр хорооны иргэн  
Нямсүрэн:

Улсын нэрийг Монгол улс гэж нэрлэх, эзэн чингидийн  
үед хэрэглэж байсан энэ нэрийг сэргээх түүхэн үүрэг өнөөгийн  
бидэнд хувь заяа болон ноогджээ. Хэрэв ингэж өөрчлөхгүй бол  
түүх биднийг уучлахгүй. Их зохиолч Нацагдорж монгол гэдэг нэр  
ертөнцийн чихнээ дурсгалтай гэсэн билээ.

БНМАУ гэхэд 3 секунд, Монгол улс гэхэд I секундын хугацаа  
орж байна. Иймд их хэмжээний цаг, цаас хэмнэнэ. Монгол улс  
гэсэн нэр нь өвөр монгол, буриад, монгол, тува зэрэг монголоо  
гэсэн үндэстэн бүрийн өлгий мэт дотно сонсогдоно.

Сүхбаатарын районы 9 дүгээр хорооны иргэн Баттулга:

Үндсэн хуульд гадаад олон уг орныг монголчлох саналыг  
урьд нь өгсөн боловч хэрэгжсэнгүй. Иймд субъект, медаль, дипло-  
мат, техник, прокурор, акт, депутат, комисс зэрэг үгнүү-  
дийг болвол монголчилмоор байна.

II.

Тун болдоггүй км бол шалтгааныг Ардын эрх сониноор дамжуулж тайлбарламаар байна. Ялангуяа комисс гэдэг үгнээс хүмүүс их сэжиглэдэг.

Төр, нийгмийн судлалын академийн жижүүр Зоригтбаатар:

Монгол бичиг, төрийн бичиг болох саналыг дэмжиж байна.

Сэлэнгэ аймгийн Ойн мэргэжлийн үйлдвэр сургалтын төвийн ажилчин Дхамсүрэн:

Улсынхаа нэрийг монгол улс гэж нэрлэх, газрыг хувьчлах, хошуу, баг, Их цааз гэж байх, сүлдийг Тэнгисболдын хувилбараар батлахаар Улсын Бага Хурлаас оруулсан саналыг дэмжиж байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.11.16.  
Кассет № III-25  
18.50-19.05.

-Сэлэнгэ аймаг, Сүхбаатар хотын 5-р хорооны иргэн Базар, Дорлиг нараас:

-Улсынхаа нэрийг Монгол <sup>улс</sup> гэж нэрлэх, сүлд тэмдгийг төсөлд зааснаар газрыг хувьд байлгах, Их цаазын цэц бодгох зэрэг саналыг дэмжиж байна.

Өвөрхангай аймгийн Дэлгээн хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа /цахилгаан/

-Улс орныхоо тулгуур хуулийг хэлэлцэж батлах хариуцлагыг чуулганд оролцож байгаа депутат бүхэн ухамсарлаж, Их Хуралдаа ажил, хэрэгч, идэвхтэй байр сууринаас оролцохыг хүсч, улсын нэр, сүлд, соёмбыг өөрчлөх хэрэггүй. Хуулиа Үндээн хууль гэж нэрлэх, газрыг хувьчлахгүй байх, харин зөвхөн өөрийн иргэдэд түрээслүүлж болох юм.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Батбэх, Наранхүү, Гантогоо нараас:

-Монгол улсынхаа Их цаазыг батлах түүхэн хариуцлагатай үед зарим депутат ард түмний нэрийг барьж сонгогчдын захиа даалгавар гэгчээр халхавчлан өөрсдийн үзэл бодлыг ярьж байна. Улсын Бага Хурлаас Их Хуралд оруулсан төрийн сүлд, далбаа, улсын нэрийн талаарх саналыг дэмжиж байна.

Газрын бодлогын хүрээлэнгийн мэргэжилтэн Дүгэрсүрэн, Амарбат, Цэнд нарын 7 хүн бичгээр.

I.БНМАУ-ыг хойшид Монгол улс, хуулиа Их засаг гэж нэрлэе. Төрийн бэлэг тэмдэг, төрийн сүлд, төрийн далбаа, сүлд дуулыг өөрчлөх нь зүйтэй. Төр нь эргэдгээ эргэчихээд байхад хуучин унасан төрийн бэлэг тэмдэгүүдийг дээдлэж явсаар шинэ зорилготоо хүрч чадах уу.



2.

2. Монгол улсын иргэн газар өмчлөх эрхтэй байх нь зүйтэй. Гэхдээ энэ асуудлыг Их засаг хуульдаа ерөнхийд нь тусгаад, баталгаажуулаад, ямар ямар төрлийн, ямар хэмжээний газрыг ямар журмаар өмчлөх вэ гэдгийг Газрын тухай хуульд тодорхой тусгая.

3. Манай улс нээлттэй эдийн засгийн бодлого явуулж байгаа бол гадаадын иргэдэд, байгууллагуудад газрыг тодорхой хугацаа, төлбөртэйгээр түрээслүүлвэл хэрэгтэй. Манай хуулинд ийм заалт байгаагүйгийн харгайгаар олон зуун мянган га газар нутаг, бэлчээрээ харийн цэргээр хэдэн арван жил талхлуулчихаад сохор зоосны ч татаасавалгүй салав. Эрдэнэт, Ерөө, дөрвөнт, Мардайг ашиглуулсны газрын түрээс, төлбөр юу ч аваагүй. Хувь нийлүүлсэн төмөр замын доор манай талаас эзэмшүүлж байгаа газрын төлбөр, түрээс гэсэн зүйл авдаг юм уу? Одоо Улаанбаатарт хэдэн мянган хятад, Зүүнхараа, Сүхбаатар хотод хэдэн зуун орос иргэд хувийн хашаа байшинтай, ногооны газартай, сохор зоосны төлбөр, түрээс өгөлгүй явж байна. Байдал ийм байхад газрыг түрээслүүлэхгүй гэж байгаа депутатууд маань дээрх гадаадын байгууллага, иргэдийг яая гэж бодож байна вэ, бүгдийг нь хөөж зайлуулах уу, манай улсад дан гадаадын болон манай талтай хамтарсан ганц ч үйлдвэр, аж ахуйн газар байгуулахгүй байх уу, энэ асуудалд тодорхой хариулт өгөх байдлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэхийг та нөхдөөс хүсье.

Октябрийн районы 24-р хорооны иргэн Дамба, мөн дүүргийн 23-р хорооны иргэн Батцэцэг, Найрамдлын дүүргийн 16-р хорооны иргэн Мөнхжаргал, Сүхбаатарын районы 3-р хорооны иргэн Даваажав нараас.

Хуулиа Их цааз, эсвэл Их засаг гэх. Улсаа Монгол улс гэж нэрлэх. Ерөнхийлөгчид Монгол улсын уугуул иргэн, наад зах нь 50 нас хүрсэн хүнийг сонгох, Ерөнхийлөгчийн зааглалтай байх. Онц байдал тогтоох Ерөнхийлөгчийн эрхийн бүрэлдэхүүнд зарим орон нутагт үүсэж болох ноцтой байдлыг

## 3.

арилгах зорилгоор тухайн нутаг орны засаглалыг тарааж, оронд нь амбан захирагч, тохоон томилож байх онцгой эрхийг Ерөнхийлөгчид эдлүүлэх, Монгол улсын Ерөнхийлөгч гурван үе дамжсан уугуул иргэн байна гэсэн заалт оруулах гэж байна.

Шашны асуудалд нухацтай, бодлоготой хандах, шаардлагатай. Буддын шашныг улсын албан ёсны цорын ганц шашин болохыг хүлээн зөвшөөрч тунхаглах, Персийн булангийн дайн, уулын Карабахын хэрэг, Армен, Азербайжаны сэргэлдөөн, Югославт болж буй зэвсэгт мөргөлдөөнүүд нь улс төр, нутаг дэвсгэрийн шинжтэй ч нэг үндэстэн дотроо өөр өөр шашинтай байдгийн уршигтай ихээхэн холбоотой. Иймд Монголчуудыг зөвхөн буддын шашинтай байлгахад онцгой анхаарах, Соёл, урлаг, хүмүүжил, гүн ухаан, байгаль хамгааллын ихээхэн ач холбогдолтой, бурхны шашныг дэмжих, ард түмнийхээ сүшэг бидрэлийг хүндлэхдээ төрийн бодлогын үүднээс тодорхой байр суурьтай хандах учиртай. Жалгын нэг дуган, өрх бүр хуврагтай болвол юу болохыг бодох нь зүйтэй.

Газрыг өмчлүүлж хэрхэвч болохгүй. Харин тодорхой хэмжээний 005 метр кв газрыг зөвхөн орон сууц, хашаа хороо барих, ногоо тарьж ургуулж амьдралаа тэтгэхэд нь зориулж жил бүр гэрээ байгуулах замаар эзэмшүүлж болох юм.

Газрын болон цагаачлалын хуулийг яаравчлан авч хэлэлцэх шаардлагагүй.

Дорнод аймаг, Хөлөнбуйр сумын төвд суудаг өндөр настан Даваа, Өмнөговь аймгийн Ардын Хурлын ажилтан Цоож, Дархан хотын иргэн Одон, Баян-Өлгий аймгийн Өлгий хотын ОСГ-ны 4-р хорооны иргэн өндөр настан, ахмад дайчин Нэхийт, Эрдэнэт хотын Сангидорж нараас.

Үндсэн хууль нь бүх хуулиудын үр үндэс болох тул нэрийг нь хэвээр нь батлана уу. БНМАУ-ын нэр, төрийн сүлд, тугаа хэвээр үлдээх гэж байна.

4.

Сүхбаатарын районы 4-р хорооны иргэн Лхагваа, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын төвд суудаг өндөр настан Даваа нараас.

Газрыг хувьд өмчлүүлэхгүй, улсын өмч хэвээр нь байлгах.

Баян-өлгий аймгийн Өлгий хотын ОСТ-ны 4-р хорооны иргэн өндөр настан Нэхийтээс

Хуучин Монгол бичгийг төрийн бичиг болгох асуудлыг хэтэрхий яарч шийдсэн мэт санагдана. Ихээхэн зардал, мөнгө, хүч, хөдөлмөр шаардах нүсэр их ажил болох тул эдийн засгийн хямралтай байгаа одоо үед үүнийг харгалзан бодож үзэх нь зүйтэй байна.

Мөн өнөөдөр үдийн завсарлагаагаар ЗХУ-аас тус улсад суугаа элчин сайд Ситников, ЗСБНХОУ-ын дээд зөвлөлийн дарга Хасбулатовын явуулсан цахилгааныг Ардын Их Хурлын дарга Уртнасан гуайд гардуулсан байна. Үүнийг уншиж сонсоё.

БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга Жамбалдоржийн Уртнасан танаа. Эрхэм хүндэт Жамбалдоржийн Уртнасан.

БНМАУ-ын Ардын Их Хурлын даргад таныг сонгосон явдалд баяр хүргэе. ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөл орос, монголын бүх талын найрсаг харилцааг манай орнуудын ард түмний тусын тулд хөгжүүлэхэд тууштай талархан дэмждэг юм.

Манай орнуудын харилцаа цаашдаа улам бэхжиж, хөгжинө гэдэгт итгэл төгс байна. Монголын ард түмэнд энх амгалан, сайн сайхны ерөөл дэвшүүлж байгааг минь хүлээн авч соёрхоно уу.

ЗСБНХОУ-ын дээд зөвлөлийн дарга Хасбулатов гэжээ.

Ардын Их Хурлын даргын нэр дээр бас цахилгаан ирсэн байна.

Депутат нөхөр Цэен-Ойдов намайг ах дүүгийнхээ нөлөөнд автаж, буруу шалгасан гэж ямар ч үндэсгүйгээр Ардын Их Хурлын чуулган дээр гүтгэж, орон даяар нэвтрүүлээ. Би энэ асуудлыг аймгийн прокурортой хамтран түүний удирдлагын дор шалгасан. Бид сонгуулийг зөвхөн хууль ёсны дагуу явагдсан эсэхийг шалгасан. Түүнээс биш Цэен-Ойдовтой холбогдсон ямар нэгэн асуудлыг шалгаж шийдвэрлээгүй, сонгуулийн явцад зарим зүйл дээр хууль зөрчигдсэн байсныг баримттайгаар тогтоож Их Хуралд илтгэсэн. Төрийн хуулийн биелэлтэнд хяналт тавьж, үнэнчээр хөдөлмөрлөж яваа жирийн хуульч намайг албан тушаалаа ашиглан, Ардын Их Хурлын чуулган дээр нэр заан бүдүүлгээр гүтгэсэнд туйлын их гомдолтой байна. Миний гомдлыг хянаа үзэж, үнэн зөв хариуг депутатуудад болон хөдөлмөрчдэд Их Хурлын идрээс албан ёсоор өгөхийг хүсье.

Булган аймаг, туслах прокурор Хадбаатар гэсэн байна.

Бас нэг хүсэлт ирсэн байна. Дархан хилийн төлөө хөдөлгөөнөөс депутатуудад сонордуулсан сонордуулга иржээ. Эндээс тоймлон уншъя.

Их цааз гэсэн нэрийг хэвээр хадгалах. Хоёрдугаар санаа нь эх болсон энэхүү гал голомтоо Монгол улс хэмээн нэрлэх нь үеийн үед монголчуудын үндэсний бахархалын дөл болох зорилгыг агуулж байна. Монгол гэдэг нэр аль ч талаараа бахархал болж зайлшгүй чадах бөгөөд бид Монголоороо бахархаж байж улс орноо сэргээн мандуулах ёстой гэж үзэж байна. Монгол улс гэсэн нэртэй болсноороо бид юуг ч алдахгүй бөгөөд, харин Монгол улс гэсэн нэрнээс айдаг колоничлогчдын гинжнээс өөр юуг ч алдахгүй. Ерөнхийлөгчийн хугацаан дээр санал өгсөн байна.

Парламентын БНУ-тай болно гэсэн саналыг дэмжсэн байна.

Зураач Тэнгисболдын оруулсан төрийн бэлэгдлийг дэмжсэн байна.

Газар нутгийн талаар тодорхой санал оруулсныг уншъя.

6.

Газрыг зөвхөн Монгол улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлий болон тухайн газрын гол баялгийг эзэмшихэд өмчлөхөд хамаарахгүй гэж тусгах. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд түрээсээр, түүнчлэн хуульд заасан бусад болзол, хэлбэрээ эзэмшүүлэн эдлүүлж болно гэдэг нь туйлын чухал юм. Харин хил орчмын сум, хошууны нутгийг зэргэлзээ улсын иргэд, харьяатгүй хүнд аль ч хэлбэрээр эзэмшүүлж, эдлүүлж болохгүй. Үүнийг хуульчлан батлах нь чухал.

Монголчууд газрын өрөөсөө өмчлөж байгаагүй. Тийм уламжлал байхгүй гэж нэлээд депутатууд ярьж байна. Ийм яриаг шийдвэртэй няцаахгүй байгаа нь нэгийг бодогдуулж байна. Монголчууд газрыг нүүдэлчдийн соёл иргэншил, нүүдлийн мал ажахуйн онцлогтой тохирсон маш өвөрмөц маягаар өмчлөж байсан. Эртний хүннү улсын үеэс эхлэн газраа өмчлөж, газрын зураг тойм үйлдэж, цэс зохиож, хуваарьтай ашиглаж, тэмдэглэл хөтлөж, нэрлэж байсан баримт бий бөгөөд түүнийг шууд үргэлжлүүлэх нэгэн бээр тухайлбал Халхын цэцэн хан аймгийн То ван толгох төрийн газар өмчлөлийн хэлбэр байсан юм. Үүнийг тодруулвал хошууны ардын аж ахуйтнууд хувийн өмчийн малаа эзэн ноёны газар дээр, хошууны нутаг дотор хуваасан тодорхой заагт нэлээд өргөн уудам нутаг дэвсгэр дээр адгуулан маллаж байсан. Энэ нь европын болон газар тариалан эрхлэгч бусад улсын тухайн үеийн феодалын гэгдэх газар өмчлөлийн эрх зүйн харилцааны шинж чанараас ихээхэн онцлогтой байлаа.

Үүн дээр манай газар нутагтай холбоотой зүйлүүдийг ярьсан байна. Хойт талаар, Монгол улсын төр, эрт үеэс түүхэн хилээсээ нааш хил орчмын газарт ( ) онцгой анхаарал тавьж харуул айлуудад хил хамгаалах, аж ахуйгаа эрхлэн хөтлөх, хууль цааз сахиулах, өмчлөх, эзэн болох эрх чөлөөг нь баталгаажуулах үндсийг тавих замаар харуулын нутаг бий болгох, зөвхөн хойт хилд 30-40 эрх айл бүхий 76 харуултай байсаар 1921 онтой

7.

зогложээ. Эд хааясан бэ? Яагаад ингэж асуух болов оо!  
 Хойт талд Тагны нурууны оройгоос эхлэн Харуул хайчийн  
 зам, харуулын нутаг, Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Тэс, Давст,  
 Зүүнговь <sup>сумын</sup> нутаг бууц, малын бэлчээр, өнөөгийн Давст уул,  
 Увс нуурын хэсэг, Тэсийн голын хэсэг, Нарийний голын 130 га  
 газар, Жангастайд, Монголын шарын даваа болон Силхамын  
 нурууны 3 хэсэг газраас эхлэн нэр бүхий 18 хэсэг газарт  
 нийтэд нь хамарсан 30 гаруй мянган кв метр бүхий нутаг,  
 Өмнө талд Тоотогосын буюу Хүрэнтийн чиглэл, Булган голын  
 чиглэл, Байдаг уулсын чиглэл, Хавтаг уулсын чиглэл, Говь, хонин  
 усны чиглэл г.м. 15 хэсэг газар, Засагт хан аймгийн Өлзий,  
 Жаргалант уулсын хошууны нутаг, Халхын баруун өмнөт овоо,  
 Бурхан буудай уулсын хошууны нутаг, Соёолц уулсын хошууны  
 нутаг, Халхын сүм, Шинэ халхын голын буриадын хошуу, нутаг  
 зэргийг хамарсан 100 гаруй мянган кв метр газар нутаг хүнийх  
 болжээ. Үүнийг бид газар нутгийн маргаан болох утгаар та бү-  
 хэнд сонсгохыг хүссэнгүй. Бусдаас газар, нутаг авч өгөлдсөн  
 тухай ярьдаг логик хир үндэслэлтэй байна вэ, нэгийг бодох  
 болжээ гэсэн утгаар хэлж байгаа юм.

Гол алдаа нь юунаас болов. Хил хязгаарт олон зууны турш  
 амьдарч байсан харуульхнийг татан буулгаж, цаанаасаа түрж  
 нутаглах, газар эзэмших бололцоог олгосон. Хилээс нааш бүр гүнд  
 сум, нэгдэл байгуулж төвлөрөл бий болгож, сум, нэгдэл бараа-  
 дуулсан, мал аж ахуйгаас хөндийрүүлсэн. Бусад улсууд ардуу-  
 даа түрж нутаглуулж байхад манайх нутгийн ардуудаа хилээс  
 хөөж, гүн рүүгээ шахсан. Элдэв хууль, заавар гаргаж, хил,  
 газраа мэдэхгүй хүнгүй болгосон. Угсаа залгамжилсан ноёдоос  
 газрыг нь хурааж, малыг нь хурааж улсын болгосон тул хил  
 орчмын газар эзэнгүйдсэн. Хил хамгаалах зорилготой хилийн  
 цэргийг тухайн газарт цэрэг, офицергүй, түр зуур алба хаадаг  
 болгож, хамгаалах газраа тоот өндөрлөг, дугаар, завтав, дундын  
 овгоор тэмдэглэдэг болгосон нь хил орчмын газар нутаг, уул  
 усны нэрийг мартагдуулсан төдийгүй нууцаар газар нутаг алдах,  
 нэрийг нь өөрчлөх, домгыг нь гуйвуулах үндсийн үндэс болсон  
 юм.

Иймээс ялангуяа хил орчмын газар нутгийг хил орчмын ард иргэдэд өмчлүүлэх нь хил хамгаалалтанд оролцуулах нь уул, усны нэрийг сэргээх, домгыг тодотгох, үндэсний хэлбэртэй барилга, соёл, шүтлэгийн байгууламж барих, уул, овоогоо тахих, эв модны наадам хийх, улсын хилийг дархлах болон товчоор хэлэхэд хойт үедээ газар нутгийг нь бүрэн бүтнээр нь хүлээлгэж өгөхөд бэлтгэхийн тулд бүхнийг хийж эхлэх ёстойг та бүхэнд эхний дугаарт сонсохыг чухалчлав. Дээрх ёсон зүйлийн саналыг зохих ёсоор шийдэх нь Монголын ард түмний язгуур эрх ашигт нийцэх бөгөөд, та бүхний хуран чуулсан түүхэн үүрэг нэр төртэй биелэгдэх боломжтой амой. Хүндэтгэн ёсолсон Дархан хилийг хамгаалах хөдөлгөөний гүйцэтгэх зөвлөлийн тэргүүлэгч Пүрэв-Ойдовын Давааням гэжээ.

Ж.Уртнасан -Дэгийн дагуу бид завсарлах ёстой болж байна. Тэгэхдээ товчхон мэдээлэл хийе. Нэг их цаг идэхгүй. Өнөөдрийн байдлаар 86 хүн үг хэллээ. Өчигдөр, өнөөдөр хоёр нийлээд, 101 хүн бичгээр саналаа ирүүлээ. 16 депутат Ерөнхий санал шүүмжлэлийг таслахыг санал хураалгаж өгөөч гэсэн хүсэлт ирүүлж байна. Түүнээс гадна хоёр өдрийн дотор 7 бүлэг байгуулагдлаа. Эмэгтэйчүүдийн бүлэг, Ардчилсан намын бүлэг, Монгол ардын хувьсгалт намын бүлэг, Хөдөө аж ахуйн нэгдэл, хоршооллын байгууллагуудын бүлэг, Залуучууд ардчиллын төлөө залуучуудын бүлэг, Монголын үндэсний дэвшлийн намын бүлэг, Булган аймгийн нутаг дэвсгэрийн депутатуудын бүлэг гэсэн 7 бүлэг байгуулагдаад байна. Найм дахь бүлэг байгуулах саналаа өдөр 27-р тойргийн депутат Пүрэвдорж ирүүлсэн юм. Бид санаа нийлсэн : депутатын нэрийн өмнөөс нэг товчхон мэдээлэл хиймээр байна.

Бид Их Хурлыг эвсэлдүүлэх зорилготой депутатуудын бүлэг байгуулсан юм. Тэгээд депутатуудад хандаж уриалах юм гэсэн зарлал ирсэн. Та бүхний анхаарлыг сарниулахгүй хэлэлцэх асуудал дээрээ төвлөрье гэж бодож хагас өдрийн турш үүнийг барьлаа. Депутатууд хэрэв хүсвэл 27-р тойргийн депутат Пүрэвдорж мэдээлэл хийж болохоор байна.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн

*Ц.Баярмаа*

Ц.БАЯРМАА

Бичсэн С.ТУУЛ

Кассет 26  
1991-ХТ-16  
19.05-19.09

Ардын Их Хурлын 27 дугаар тойргийн депутат Л.Пүрэвдорж:  
-Эрхэм хүндэт Их Хурлын дарга, орлогч дарга, эрхэм

хүндэт депутатууд аа. Та бид шинэчлэл ардчиллын замыг сонгон  
аваад эхний алхмаа хийж байгаа, туурга тусгаар монгол улсынхаа  
хувь заяаны түүхэн учир холбогдолтой, туйлын хариуцлагатай  
хийгээд бахархалтай үйл хэргийг шийдвэрлэх ажилд ухаан боцол,  
санаа сэтгэлээ зориулж байна. Монгол улсын Их цааз бидний  
зүрх сэтгэлд ингэж бууж байна. Энэ эрхэм үүргийг бид бид  
хүсэл боцол, санаа сэтгэлээрээ эвсэлдэн нэгдэж, зөвшилцөн  
тохирох аргаар л амжилттай шийдвэрлэж чадна. Үүнийг улс гэрийн  
маань, ард түмний маань хувь заяа та биднээс шаардаж байна.  
Та бид хэтэрхий намархан булагнах юм уу, нутаг дэвсгэрийн  
явцуу хүрээнд эргэлдэн нэг нэгнээсээ цэрвэн хөндийрэх хэрэг-  
гүй юм аа. Чухам иймийн учир Монголын ардчилсан нам, Монголын  
социал демократ нам, Монголын үндэсний дэвшил намын гишүүн  
депутатууд, МАХН-ын гишүүн зарим депутат, мөн аль ч намын  
гишүүн бус хэсэг депутат Монгол улсын Их цаазын зарчмын үнд-  
сэн асуудлуудаар санаа нийлэн нэгдэж Ардын Их Хурлын II хурал-  
дааны дэгийн 6 дугаар зүйлийн нэгийг үндэслэн ардчилсан  
эвсэл бүлэг байгуулснаа мэдээлж байна.

Бүлгийн гол зорилго бол Монгол улсад ардчилал, хүний  
эрх, энэрэнгүй ёсыг баталгаажуулсан Их цааз буюу Үндсэн  
хуулийг батлан гаргахад хамтын бүтээлч чармайлтаараа тус  
лөхөм үзүүлэх, асуудлыг нухацтай хэлэлцэх, хурлын ажиллагааг  
хөнгөвчлөх үүднээс чөлөөт цагтаа санаа нэгдэж хуралдаанд  
бүлгийн өмнөөс төлөөлсөн цөөн хүн уг хэлэх явдал юм аа. Энэ  
бүлэгт нэгдсэн бид намын болон нутаг дэвсгэрийн бүлэгтээ  
зохих үүргийн дагуу хамаарагдах болно. Манай бүлгийн хаалга  
нээлттэй учир үзэл боцол нэгтэн депутатууд бидэнтэй нэгдэж  
болно. Их цаазаа тунгаан хэлэлцэж батлан гаргахдаа төрийн  
мэргэн ухаанаар хандахыг та бүхэнд уриалж байна. Далан  
хэдэн депутат нэгдсэн юм. Хэрэв энэнийг сонирхвол хэлж болох  
байна. Ийм л мэдээллийг хийх гэсэн юм аа.



Ардын Их Хурлын 24 дүгээр тойргийн депутат Р.Хатанбаатар:- Юүний өмнө юу гэхлээр ноднин жилээс хойш анхдугаар чуулган дээр байгуулагдсан Монголын социал демократ намын бүлэг бол оршин тогтнож байгаа.Ийм учраас би бол энэнийг энэ жилийн хувьд заавал албан ёсоор бүртгүүлэх албагүй гэж үзэж байна.Энэ бол байж байгаа бүлэг учраас би албан ёсоор бүртгүүлэхгүй.Угаасаа ноднин анхдугаар чуулган дээр байсан бүлэг нэгдүгээрт.

Хоёрдугаарт, би зүгээр, манай Монголын социал демократ намын депутатууд яагаад саян энэ Пүрэвдорж генералийн уншсан энэ бүлэгт нэгдсэн байгаагаа товчхон тайлбарлая. Энэ бол миний өөрийн эрхийн асуудал.Яагаад энэнийг тайлбарлах болов гэхлээр депутатууд сонгогчид болон ард түмний нэрийг барин ярьж байгаа боловч ярьж байгаа юм нь үнэн хэрэг дээрээ ихэнх тохиолдолд одоо энэ бол Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны тэргүүлэгчдээс МАХН-ын гишүүн депутатад толилуулах лавлагаа гэж лавлагаан дээр байгаа хэдэн юмыг л дахин дахин үгчлэн давтаж яриад байна.Энэнийгээ бид нар жаахан товчилъё.Энэ лавлагааг, товчлох юм бол яах гэж байна гэхлээр, үүний тулд яах ёстой вэ гэхлээр...Сонсохгүй байж болно. Үүнийг би радио, телевиз, хэвлэлээр гаргачихъя.Та нар битгий сонс.

Ж.Уртнасан:-Маргааш бидний амралтын өдөр. Энэ бүлгүүдээс хүсэлт ирүүлэхдээ зарим бүлгүүд ажиллана, чөлөө олгож өгөөч гэж, бид санал онолоо нэгтгээ гэсэн энэнийг зөвшөөрч байгаа.Хоёрдугаарт техникийн үйлчилгээтэй учраас маргааш ерөнхийдөө амралтын өдөр гэж ойлгож болно.Баярлалаа.Сайхан амраарай.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ  
НИЙЛСЭН



П.ТӨМӨРБААТАР

Бичээч Л.Хорлоо

1991.11.16.  
Кассет № III-69  
13.05-13.40

-Цаг хэмнэх, санаа давтахгүйн үүднээс Хуралд оролцож байгаа хүмүүсээ танилцуулаад, хурлынхаа ажиллагааг эхлээ. Энэ хуралд Ардын Их Хурлын дарга, эрхэм ноён Уртнасан, Их Хурлын дарга нарын зөвлөх бөгөөд Бага Хурлын хуулийн зөвлөхүүдийн ахлагч С.Төмөр, ажлын хэсгийн ахлагч Л.Ганбаатар нар энэ ажилд оролцож байгаа. Сонирхож байгаа бүх зүйлүүдээ асууж болно. Нөгөө талаас Ардын Их Хурлын хуралдааны ажлын хэсгээс иймэрхүү хуралдааны үйл ажиллагааны явц, байдлын талаар тогтмол мэдээлэл өгч байна гэж бид нар төлөвлөж байгаа юм. Голдуу манайд суугаа гадаадын сурвалжлагч нарт тийм мэдээлэл хийж байна.

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Эрхэм та бүгдэд БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны талаар товч мэдээлэл өгье гэж бодож байна. Манай хуралдаан 1991 оны II дүгээр сарын II-ний өдөр эхэлсэн. Одоо 6 дахь өдөртөө явж байна. Манай хуралдаанд 12-р чуулганаас сонгогдсон 427 депутат ирэх учиртай. Гадаадад явж байгаа, мөн өвчтэй байгаа 8 депутат хуралдаанд оролцож чадахгүй байна. Өдөр бүрийн хуралдаан 90-ээс дээш хувийн ирцтэй хуралдаж байна.

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Чуулганаар хэлэлцэх хэд, хэдэн асуудлын төлөвлөгөөг депутатууд хэлэлцэж баталсан. Бидний энэ чуулганаар хэлэлцэх хамгийн гол асуудал бол Үндсэн хууль буюу Их цаазыг хэлэлцэж батлах гол асуудал байгаа юм. Үүний дараагаар Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг бид шүүж хэлэлцэх учиртай юм.

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Дөрөв дэх асуудал, бусад асуудал гэсэн нээлттэй хэсэг үлдэж байгаа юм. Үүн дээр бид улс эх орны ач холбогдолтой гэж үзэж байгаа зарим асуудлуудыг оруулж хэлэлцэх юм.

/Англи орчуулга явсан/

2.

Ж. Уртнасан - Чуулганы үргэлжлэх нийт хугацааг одоогоор 21 хоногоор төлөвлөж байна.

/Англи орчуулга явсан/

Ж. Уртнасан - Үндсэн хуулийн хамт мөн Үндсэн хуулийн хавсралт хуулийг хэлэлцэж батлана.

/Англи хэлний орчуулга/

Ж. Уртнасан - Манай депутатууд энэ хуулийг үндсэндээ шилжилтийн үеийн хууль гэж томъёолж байна.

/Англи орчуулга явсан/

Ж. Уртнасан - Та бүхнээс асуух асуулт байвал асуухыг хүсч байна.

/Англи орчуулга явсан/

"Ассосейшн" прессын сурвалжлагч:

-Хэлэлцэх хэргийн төлөвлөгөөний бусад зүйлүүд гэсэн ангилал орж байна. Тэр зүйл болон мөн Засгийн газар, Бага Хурлын илтгэлийг Их Хурлаар зөвхөн авч хэлэлцэх юм уу, эсвэл санал хурааж, хүнээс ямар нэгэн шийдвэр гарах уу?

Ж. Уртнасан - Бусад гэсэн хэсэгт бидний төлөвлөж байгаагаар Монголын эмэртэйчүүдийн байгууллагаас хүүхэд, залуучуудын асуудлаар Их Хуралд мэдээлэл хийх төлөвтэй байна. Прокурор, хуулийн байгууллагуудын мэдээллийг мөн сонсоно. Энэ Хурлаар Бага Хурлын илтгэлийг зөвхөн авч үзэх төдий биш, Бага Хурлаас эрхлэж байгаа албан үүргийнхээ дагуу Бага Хурлаас чөлөөлөгдөх зарим гишүүд бий. Эрхийг нь түдгэлзүүлсэн гишүүд байгаа. Ер нь гишүүдийн бүтэц, бүрэлдэхүүний талаар хэлэлцэж, Бага Хуралд гишүүн сонгох, нэмж сонгох асуудал мөн хэлэлцэгдэнэ.

\* \* \*

"Ассосейшн пресс" агентлагийн сурвалжлагч:

- Прокурор, шүүхийн байгууллагаас мэдээлэл сонсоно гэсэн. Энэ нь яг ямар тоцодрхой асуудлуудаар мэдээлэл хийх юм бэ?

-Ж.Уртнасан - Энэ нь Дээд шүүхийн мэдээлэл юм. Үүний шалтгаан нь АИХ-аас сонгогдсон Дээд шүүх, улсын прокурорын өнгөрсөн нэг жилийн хугацаанд хийсэн ажлын тухай сонсох явдал юм.

"Асс.пресс":

Одоо бага хурлаар томилогдсон комисс ажиллаж байгаа. Гадаад валютын алдагдалтай холбогдолтой асуудлыг АИХ-д зориуд мэдээлэл хийх үү, эсвэл зөвхөн авч хэлэлцэх үү, эсвэл АИХ-с ямар нэгэн шийдвэр гарах уу?

Ж.Уртнасан -Энэ асуудлыг Засгийн газрын тайлангийн хүрээнд сонсоно гэж бид найдаж байна. Манай Засгийн газрын нэг жилийн ажлын тайланг сонсоно. Манай депутатууд энэ асуудлыг нилээд сонирхож байгаа. Тийм учраас бид үүнд анхаарлаа хандуулж хэлэлцэж эхлэх байх. Бид нар энэ асуудлыг нэгэнт хэлэлцэх учраас шийдвэр гаргана. Чухам ямар шийдвэр гаргахыг одоогоор хэлж мэдэхгүй байна.

\* \* \*

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Манай хурал асуудлыг нэлээд нухацтай хэлэлцэж байна. Тухайлбал та бидэнд сонирхуулж хэлэхэд өнөөдрийн байдлаар хурал үргэлжлээд дэгээ баталлаа. Хэлэлцэх асуудалдаа.

3.

ороод явж байна. Үндсэн хуулийн ерөнхий хэлэлцүүлэг, санал солилцох шарандаа явж байна. Өнөөдрийн байдлаар гэхэд 59 депутат бичгээр саналаа ирүүлээ. 54 депутат уг хэлээд байна. Ерөнхий санал солилцох асуудал үргэлжлэж байгаа юм.

/Англи орчуулга явсан/

"Синхуа" агентлагийн сурвалжлагч:

-Улсын Их цаазын тухай хэлэлцүүлэг бараг 3-4 хоног болсон байна. Түүний үйл явц нь хир зэрэг байгааг та тодорхой ярьж өгөхгүй юу? Депутатууд янз бүрийн санал хэлж, ярьж байгаа. Тэр улсын нэр, засаглалын талаар депутат нар голдуу ямар санал илүү хэлсэн бэ? Одоогийн улсын нэрийг хадгалах уу, эсвэл Монгол гэж ихэнх санал зөнхилож байна уу? Нөгөө талаар саяхан "Ил товчоо" сонин мэдээлсэн байна. Валютын алдагдал, диллер янз бүрийн шуугиан байна. Саяхан Засгийн газрын мэдээний дотор зөвхөн хэдэн <sup>диллерийн тухай</sup> + ярьсан байна. Үүний цаана нь Засгийн газрын зарим том дарга, шадар сайдууд байгаа гэж ярьж байсан. Тэд одоогийн Засгийн газар үүнд өөрөөсөө зайлуулах, бүх бурууг хуучин Засгийн газарт, хэдэн диллерт түлхэж байна... гэсэн санал, бодол танай сонинд шүүмжилсэн байна. Ардын Их Хурал үүнд яаж хандах вэ?

Ж. Уртнасан -Тэхээр үндсэн гурван асуулт байна гэж ойлгож байна. Нэгдүгээрт Үндсэн хуулийг ард түмнээр нэг жилийн турш хэлэлцлээ. Үр дүнгийн нь Бага Хурал Их Хуралдаа оруулж хэлэлцүүлж байна.

/Англи орчуулга явсан/

Ж. Уртнасан -Энэ талаар манай Ерөнхийлөгч дэлгэрэнгүй тайлан тавьсан. Үүнийг та бүхэн мэдэж байгаа. Өнөөдрийн хурлын уур амьсгалаас үзвэл депутатуудын санал, цөөн хэдэн асуудал дээр таарж байна. Таны асуусан ялан хуулийн нэр Үндсэн хууль гэж бичих үү, Их цааз гэж бичих үү, Улсын маань нэр БНМАУ гэж байх уу, эсвэл Монгол улс гэж байх уу, эсвэл

4.

зөвхөн Монгол гэж нэрлэх үү. Төрийн бэлэгдэл болсон далбаа, сүлд, төрийн сүлд дууллаа бид өөрчлөх үү, хэвээр байлгах уу гэсэн гол голцоо хэдэн асуудлууд дээрээ эргэлдэж байна. Урьдчилан хэлэхэд хэцүү. Хөдөө орон нутгаас ирсэн ихэнх депутатуудын одоогийн гарч байгаа санал дээр тулгуурлаж үзвэл одоохондоо бид нэр томъёо, төрийн бэлэгдлийг өөрчлөх шаардлага байна уу даа, үгүй юу гэдэг дээр олон депутатууд санал солилцож байна. Ингээд депутатууд ерөнхий хэлэлцүүлгээ дуусаад, зүйл тус бүрээр хэлэлцэж, эцсийн дүнгээ гаргана. Энэ үед тодорхой болох байх.

/Англи орчуулга явсан/

Хоёрдугаар асуулт валютын алдагдлын тухай асуулаа. Энэ нь үнэхээр манай ард түмний сэтгэлийг эмзэглүүлж орон даяар анхаарал татаж байгаа асуудал энэ юм. Валютын алдагдлын асуудал Засгийн газрын тайланд тодорхой орох байх. Үүнтэй холбогдуулж мөн гурав дахь асуудал гарч ирнэ. Тэнд шинэ Засгийн газар, зарим сайдуудын нэр оршилцож байна. Хуучин засгийн газрын хэрэг биш үү гэж үзэж байна гэж байна. Тэхээр үүнийг Засгийн газрын тайлан бидэнд тодорхой тоо, баримттайгаар танилцуулна. Депутатууд шүүж хэлэлцэнэ. Үүний дараа зохих шийдвэр гарна гэдэгт бид найдаж байна.

/Англи орчуулга явсан/

Дашрамд хэлэхэд валютын хэрэг буюу диллерийн хэрэг, алтны хэрэг гэж яригдаад байгаа энэ асуудлын талаар Бага Хурлаас томилогдсон тусгай комисс ажиллаж байгаа.

Засгийн газар илтгэлээ тавих үед энэ комиссын хавсралт мэдээлэлийг Их Хуралд бид сонсоно.

/Англи орчуулга явсан/

"Синхуа" сонины сурвалжлагч:

-Уучлаарай, бас нэг зүйлийг асууя. Засгийн газрын 20-р тогтоолтой холбогдсон Улсын Бага Хурлын гишүүд хичнээн байна. Энэ нууцыг задалсан, бас өөрийн ашиг, хонжоо хөөцөлдсөн Улсын

5.

Бага Хурлын гишүүдийг бүгдийг нь сольж өөрчлөх үү?

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Одоо бидний мэдэж, хэвлэлмэдээллийн хэрэгслэлээр мэдээлж бидний мэдэж байгаагаар Бага Хурлын гишүүдээс 13 хүн энэ хэрэгт оролцож байгаа юм. Бага Хурлын тайлан хэлэлцэх үед энэ асуудал бидэнд тодорхой болно.Бага Хурлын гишүүдийг өөрчлөх, солих, татах тухай асуудлыг/Бага Хурлын суудлууд бол намын суудлууд/ тиймээс намууд энэ санаачлагыг гаргах байх. Өөрийнхээ Бага Хуралд сууж байгаа гишүүдийг татах буюу өөрчлөх тухай асуудлыг намын санаачилгаар Их Хурал шийдвэрлэнэ гэж бодож байна.

/Англи орчуулга явсан/

МОНЦАМЭ-гийн сурвалжлагч:

-Синхуа-гийн сурвалжлагчийн асуултанд гарлаа л даа. Бага Хурлын 20-р тогтоолтой холбогдсон нэр орооцолдсон гишүүдийн тухай асуудал дээр. Тэхээр Ерөнхийлөгч хавар зарлиг гаргасан байгаа юм. Тэр асуудал нь энэ асуудлыг хэлэлцэх явцад сөхөгдөж тавигдах байх л даа. Ерөнхийлөгчийн зарлигийн талаар та өөрийн бодлоо хэлж өгөхгүй юу?

Хоёрдугаарт Их Хурлаас ноднин сонгогдсон байгууллагад дийлэнх нь Засгийн газар, Дээд шүүх, Бага Хурал нь сонгогдож, томилогдоод Их Хурлаас гарсан байгаа юм. Эд нар ямар нэгэн байдлаар тайлангаа тавих юм шиг байна. Ерөнхийлөгч бас анхны Их Хурлын анхны сонгууль байсан. Ноднингийн хуралдаанаас жил тойрлоо, төрийн нэрийн өмнөөс төрийн нэрээр ажиллалаа. Ерөнхийлөгчийн тайлангийн асуудал нь таны бодлоор сөхөгдөж тавигдах учиртай болов уу, үгүй бол уу, Ерөнхийлөгч ажлаа тайлагнаж илтгэх ёстой болов уу, үгүй юу?

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Засгийн газрын 20-р тогтоолтой холбогдуулж Ерөнхийлөгчийн гаргасан зарлигийн талаар ард түмний уур амьсгал санал сэтгэгдлийг авч шүүж, тунгааж үзэхэд санал зөрөлдөөнтэй байна. Нэг хэсэг нь энэ нь зөв зүйтэй, 20-р тогтоолыг

залруулсан зөв зүйтэй арга хэмжээ боллоо гэж үзэж байгаа юм. Нөгөө хэсэг нь ийм зарлиг гаргах хэрэггүй байсан юм гэсэн сэтгэгдэлтэй байдаг. Энэ санал зөрөлдөөнтэй асуудлыг санал хураалтын дүн, Засгийн газрын тайланд бид тодорхой авч хэлэлцэж зохих шийдвэр гаргана. Энэ нь Засгийн газрын тайлан хэлэлцэх үед улам тодорхой болох асуудал.

/Англи хэлний орчуулга/

Ерөнхийлөгчийн нэг жилийн үйл ажиллагааны тайланг хөндөж байна. Манай Их Хурлын хоёрдугаар хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцэнэ гэж бид төлөвлөөгүй. Ер нь Засгийн газар, Бага Хурлын тайланг хэлэлцсэн нөхцөлд олонхийн саналаар Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг авч хэлэлцье гэсэн олонхийн санал гарвал бид Ерөнхийлөгчийн мэдээлэл, тайланг авч хэлэлцэж болох юм.

/Англи орчуулга явсан/

С.Төмөр —Үүн дээр тодруулах зүйл байна. Ардын Их Хурлын хоёрдугаар хуралдаанаар хэлэлцэх хэргийн төлөвлөгөөг Улсын Бага Хурлын чуулганаар хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнийг хэлэлцэж байх явцад Улсын Бага Хурлаас түүнчлэн Ардын Их Хурлын өмнөх нэгдүгээр хуралдаанаар сонгогдсон Ардын Их Хурлын удирдлагын зөвлөлөөс Ерөнхийлөгчийн тайлан ч юм уу, мэдээллийг сонсоё гэсэн санал гараагүй юм. Тийм учраас энэ асуудал нь Ардын Их Хурлын хоёрдугаар хуралдаанд албан ёсоор орж тавигдаагүй.

Хоёрдугаарт саяны өнгөрсөн 6 хоногийн хугацаанд Ерөнхийлөгчийн тайлан, мэдээллийг сонсох тухай асуудал, хэлэлцэх хэргийн төлөвлөгөөг хэлэлцэж байх явцад мөн нэгэн адил тавигдаагүй гэдгийг Уртнасан дарга нэгэн адил хэлсэн.

Д.Сүхжаргалмаа — <sup>Ерөнхийлөгчийн</sup> Хэвлэл мэдээллийн албаны хүний хувьд би бас нэг ийм зүйлийг хэлэх гэсэн юм. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дарга байсан. Ерөнхийлөгчөөр сонгогдоод зөвхөн нэг жил болж



7.

байна. Улс төрийн тогтолцоо маань бий болоод мөн нэг жил болж байна. Ерөнхийлөгчийн хувьд ч тэр, төрийн тэргүүний хувьд ч, мөн комиссын даргын хувьд ч хамгийн гол ажил нь энэ хугацаанд Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажил байсан болов уу, үүнийг л авч хэлэлцэх төлөвлөгөөтэй байсан л даа.

/Англи орчуулга явсан/

"Синхуа" агентлагийн сурвалжлагч:

-Шинэ үндсэн хуулийг батласны дараа одоогийн төсөлд ирэх жилийн сонгууль хэзээ болох вэ? Мөн шинэ Үндсэн хуулийг хэзээнээс эхлэж мөрдөж хэрэгжүүлэх вэ?

/Англи орчуулга явсан/

Ж.Уртнасан -Тэхээр энэ нь одоо хэлэлцэж байгаа асуудал юм. Үндсэн хууль батлагдвал, танхимын уур амьсгалаас харахад зарим санал гарч байгаагаас үзэхэд 3-р сард сонгууль явуулъя гэсэн саналтай депутатууд байна. Мөн 6-р сард сонгууль дахин явуулъя гэсэн саналтай депутатууд байна. Ер нь 1992 онд сонгууль явуулах шаардлагагүй гэсэн депутатууд байх шиг байна. Гэхдээ манай Үндсэн хууль батлагдсны дараа Үндсэн хуулийн хавсралт хуулийн дагуу бид Их цаазын дагуу 1991 оны 12-р сарын төдний өдөр батлагдснаас хойш 1 сарын дараа энэ асуудлыг шийдвэрлэнэ гэсэн нээлттэй хүчин төгөлдөр байхаар үздэж байгаа юм. Тэхээр бид Их цааз/Үндсэн хууль/-аа батлаад, хавсралт хуулиа хэлэлцэж байж тодорхой төвлөсөн хугацаа хэлнэ. Үүгээр одоохондоо сонирхуулахад депутатууд гурван хувилбар саналтай байх шиг байна. Зарим хэсэг нь энэ Үндсэн хуулиа батлаад, яаралтай сонгууль явуулах шаардлагатай гэж үзэж байна. Зарим нь хагас жилийн дараа, зарим нь ер нь сонгууль явуулах шаардлагагүй гэсэн бодолтой депутатууд байна.

/Англи орчуулга явсан/

С.Төмөр -Би тодруулах маягаар нэг хариулт хэлмээр байна. Улсын Бага Хурал нь Үндсэн хуулийн төслийг боловсруулах комиссын оруулсан саналын үндсэн дээр Улсын Бага Хурлаас

8.

хэрвээ Үндсэн хууль II-р сард батлагдвал жишээ нь II-р сарын 26-нд баталлаа гэж үзэхэд нэг сарын дараагаар өөрөөр хэлбэл 1991 оны 12-р сарын 26-нд хүчин төгөлдөр болж үйлчлэхээр төсөл оруулсан. Хоёрдахь асуултын хувьд гэвэл Улсын Бага Хурлаас санал болгож оруулж байгаа санал нь 1992 оны 6-р сард багтааж сонгууль явуулах санал оруулж байгаа юм.

/Англи орчуулга явсан/

Японы Элчин сайдын яам:

-II-р сарын II-нд нээгдсэн хоёрдахь удаагийн Их Хурал нь дэгийн <sup>тухай</sup> их яригдсан гэж сонин дээр байсан. Дэгийн тухай 12-ны өдөр, 13-ны орой дэгийн агуулгыг тогтоосон гэж байна. Энэ нь хоёр дахь удаагийн Их Хурлын дэг үү, эсвэл гурав дахь удаагийн Их Хурал ирэх жил болохоор одоо тогтоосон дэг бас хүчин төгөлдөр үү?

/Англи хэлний орчуулга/

Ж.Уртнасан -Тэхээр бидний хоёр өдөр хэлэлцэж батласан энэ дэг нь зөвхөн энэ хуралдааны дэг юм. Яагаад гэвэл бид хэлэлцэж байгаа асуудалтайгаа буюу энэ дэгийг боловсруулахдаа Үндсэн хуулийг хэлэлцэх асуудалтайгаа холбогдуулж гаргаж байгаа дэг юм. Өөрөөр хэлбэл бид Үндсэн хуулийнхаа анмны хэлэлцүүлгийг ингэж явуулъя, хоёрдахь хэлэлцүүлгээ ингэж явуулъя. Үндсэн хуулиа хэлэлцэхэд ийм зарчим баримтлаа гэж ихэнх дэг журам маань Үндсэн хуультай холбогдож гарсан учраас энэ нь зөвхөн энэ хуралдааны дэг юм. Дашрамд хэлэхэд мэдээж хэрэг Их Хуралдаан дээр уг хэлэх, дахин уг хэлэх г.м. ерөнхий зарчмууд дараагийн хуралдаанд мэдээж өвлөгдөн үлдэх боломжтой юм.

/Англи орчуулга явсан/

Д.Сүхжаргалмаа -Энэ хуралдаан явагдаж байгаа болохоор хүмүүс хурлын удирдлагууд нь зав багатай байгаа юм. Хэрэв асуулт байхгүй бол энэ хурлаа дуусгая. Ирсэнд их баярлалаа, дараагийн хурал хүртэл.

Соронзон хальстай  
тулгаж нийлсэн  
Бичээч

*С.Туул*  
С.ТУУЛ

Ц.БАЯРМАА